



АГУУЛГА

ОРШИЛ	13
I. ХАНБОГД СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ	15
1.1. ХАНБОГД СУМЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	16
1.2. БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА, БОДЛОГО	18
1.2.1. “Байгалийн баялаг, сайн засаглал хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020):	18
1.2.2. Өмнөговь аймгийн “Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө” 2014-20	
1.2.3. Ханбогд сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн стратеги төлөвлөгөө (2014-2021 он)	20
1.3. НУТГИЙН ИРГЭД, ОЛОН НИЙТЭЭС ТӨЛӨВЛӨГӨӨНД ӨГСӨН САНАЛ	21
II. ГЕОЛОГИ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ НӨХЦӨЛ	23
2.1. УУР АМЬСГАЛ	24
2.1.1 Агаарын температур	24
2.1.2. Хур тунадас	25
2.1.3. Агаарын даралт	26
2.1.4. Агаарын чийгшил	27
2.1.5. Нарны цацраг	28
2.2. ГАЗАРЗҮЙН БАЙРШИЛ, ТОГТОЦ	28
2.3. ГАЗРЫН ГАДАРГА	30
2.3.1. Уулзүй	30
2.3.2. Өндөржилт	31
2.3.3. Гадаргын налуу	33
2.3.4. Гадаргын зүг зовхис	34
2.3.5. Ханбогд сумын хиймэл дагуулын зураг	35
2.4. ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ	36
2.4.1. Хөрсний чулуулаг	40
2.4.2. Хөрсний хэв шинж	41



2.4.3. Хөрсний механик бүрэлдэхүүн	43
2.5. УРГАМАЛЖИЛТ	44
2.5.1. Өмнөговь аймгийн Ханбогд сумын бэлчээрийн ургамалжилт	44
2.5.2. Ургамалжилт, төрөл	75
2.5.3. Сумын бэлчээрийн ургамалжилтын төрх байдал, доройтол	77
2.6. ОЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	78
2.6.1. Ойн нөөц	78
2.6.2. Ойн төлөв байдал	79
2.7. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ	80
2.7.1. Гадаргын ус	80
2.7.2. Газрын доорх ус	82
2.8. ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ	86
2.8.1. Инженер геологийн нөхцөл	86
2.8.2. Инженер геологийн үйл явц, үзэгдэл, газар чичирхийлэл	90
2.8.3. Цэвдэгийн тархалт	91
2.8.4. Геоморфологийн тогтоц	92
2.9. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ	97
2.9.1. Хүн амын одоогийн байдал	97
2.9.2. Мал аж ахуйн судалгаа	99
III. ГАЗАР, БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	103
3.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САН	104
3.2. СУМЫН ГАЗАР АШИГЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ	106
3.2.1. Хот суурин газрын ашиглалт	106
3.2.2. Бэлчээр ашиглалт	108
3.2.3. Тариалангийн газрын ашиглалт	134
3.2.4. Ойн сан бүхий газрын ашиглалт	135
3.2.5. Уул уурхайн ашиглалт	135
3.2.6. Зам шугам сүлжээний газар	137



1.2.7. Усны сан бүхий газар	138
3.2.6. Тусгай хамгаалалттай газар	138
3.2.7. Түүх соёлын дурсгалт газар	142
3.2.8. Ан амьтны тархалт	144
3.3. АЖ АХУЙН ТӨРӨЛЖИЛТИЙН СУДАЛГАА	149
IV. СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	150
4.1. СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	151
4.2. БЭЛЧЭЭРИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	153
4.2.1. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ	154
4.2.2. Сумын бэлчээрийн газрын экологийн чадавхи	163
4.2.3. Бэлчээрийн газрын эдийн засгийн үнэлгээ тооцох арга зүй	166
4.2.4. Бэлчээрийг улирлаар сэлгэн ашиглах төлөвлөгөө	179
4.2.5. Бэлчээр ашиглалтын хэсэг	180
4.2.5. Бэлчээрийн усжуулалт	181
4.2.6. Газар тариалан, мал аж ахуй, /хосолсон/ эрчимжсэн фермерийн аж ахуйн төлөвлөлт	183
4.3. ТАРИАЛАНГИЙН ГАЗРЫН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	184
4.4. УУЛ УУРХАЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	187
4.5. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	190
4.6. ХОТ СУУРИН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	194
4.7. ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	199
4.8. ОЙН САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	202
4.9. УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	205
4.10. ГАЗАР, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	207
4.11. ГАЗАР, БАЙГАЛИЙН НӨӨЦ ЭДЭЛБЭРИЙН ЗҮЙ ЁСНЫ ЭРХ	210
4.12. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	211
АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ	212
ХАВСРАЛТ	215

**ЗУРАГ ТӨСЛИЙН АЖЛЫН ИЖ БҮРДЭЛ****Зургийн жагсаалт**

ЗУРАГ 1. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ТӨВ	16
ЗУРАГ 2. АГААРЫН ДУНДАЖ ТЕМПЕРАТУРЫН ЗУРАГ	25
ЗУРАГ 3. ХУР ТУНАДАСНЫ ЗУРАГ	26
ЗУРАГ 4. АГААРЫН ДАРАЛТЫН ЗУРАГ	27
ЗУРАГ 5. ЧИЙГИЙН ЗУРАГ.....	27
ЗУРАГ 6. НАРНЫ ЦАЦРАГИЙН ЗУРАГ	28
ЗУРАГ 7. ХАНБОГД СУМЫН БАЙРШИЛ.....	29
ЗУРАГ 8. СУМЫН ХИЛИЙН ЦЭСИЙН ЗУРАГ	30
ЗУРАГ 9. ГАЗРЫН ГАДАРГЫН ЗУРАГ	31
ЗУРАГ 10. СУМЫН ӨНДӨРШИЛТИЙНЗУРАГ	32
ЗУРАГ 11. ГАДАРГЫН НАЛУУЖИЛТЫН ЗУРАГ.....	34
ЗУРАГ 12. ЗҮГ ЗОВХИСЫН ЗУРАГ	35
ЗУРАГ 13. ЛАНДСАТ 8 ХИЙМЭЛ ДАГУУЛЫН ЗУРАГ	36
ЗУРАГ 14.ХӨРС ҮҮСГЭГЧ ЧУЛУУЛГИЙН ЗУРАГ	41
ЗУРАГ 15. ХӨРСНИЙ ХЭВШИНЖ	42
ЗУРАГ 16. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЗУРАГ	44
ЗУРАГ 17. БАГЛУУР-МОНГОЛ ӨВСТ, БАГЛУУР-БУДАРГАНАТ БҮЛГЭМДЭЛ	48
ЗУРАГ 18. БАГЛУУР-МОНГОЛ ӨВСТ, ТЭСЭГТЭЙ, ШАР МОДОТ БЭЛЧЭЭР.....	50
ЗУРАГ 19. ХАЗААР ӨВС-ТЭСЭГТ, ТЭСЭГ-ХОЙРГОТ БЭЛЧЭЭР	50
ЗУРАГ 20. ШАР МОД-БАГЛУУРТ БЭЛЧЭЭР	52
ЗУРАГ 21. ГАЛБЫН ГОВЬД БАГЛУУРТ ЦӨЛ	53
ЗУРАГ 22. ШАР МОД –БАГЛУУРТ НОМГОН УУЛ	55
ЗУРАГ 23. АРЗГАР ҮРТ ХАРМАГТ ТАЛ.....	57
ЗУРАГ 24.ТООРОЙН ТӨГӨЛ.....	58
ЗУРАГ 25. УРГАМАЛЖИЛТЫН ЗУРАГ	75
ЗУРАГ 26. БЭЛЧЭЭРИЙН ТӨРХ БАЙДЛЫН ЗУРАГ	77
ЗУРАГ 27. ШАВАРТАЙ ЗАГ, ХАР ЗАГТ ЗАГАН ОЙ ТАРХСАН НУТАГ	79
ЗУРАГ 28.ОЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЗУРАГ.....	80
ЗУРАГ 29. ГАДАРГЫН УСНЫ ЗУРАГ.....	81
ЗУРАГ 30. ГАЗРЫН ДООРХ УСНЫ ЗУРАГ	86
ЗУРАГ 31. ГЕОЛОГИЙН ЗУРАГ	90
ЗУРАГ 32. ГАЗАР ЧИЧИРХИЙЛЭЛИЙН ЗУРАГ	91
ЗУРАГ 33. ЦЭВДЭГИЙН ТАРХАЛТЫН ЗУРАГ	92
ЗУРАГ 34. ГЕОМОРФОЛОГИЙН ЗУРАГ	96
ЗУРАГ 35. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ЗУРАГ	104
ЗУРАГ 36. ГАЗАР АШИГЛАЛТЫН НЭГДСЭН ЗУРАГ.....	106
ЗУРАГ 37. ХОТ, ТОСГОН БУСАД СУУРИНЫ ГАЗРЫН ЗУРАГ.....	107
ЗУРАГ 38. БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ЗУРАГ	109
ЗУРАГ 39. БЭЛЧЭЭРИЙН УСЖУУЛАЛТЫН ЗУРАГ	111
ЗУРАГ 40. ЦООНОГИЙГ БИТҮҮМЖИЛСЭН БАЙДАЛ.....	113
ЗУРАГ 41. ТАРИАЛАНГИЙН ГАЗРЫН АШИГЛАЛТЫН ЗУРАГ.....	134
ЗУРАГ 42. ЗАГАН ОЙ ТАРХСАН ГАЗАР НУТГИЙН ЗУРАГ	135



ЗУРАГ 43. Уул уурхайн газрын ашиглалтын зураг	135
ЗУРАГ 44. Зам шугам сүлжээний газрын ашиглалт	137
ЗУРАГ 45. Усан сангийн газрын ашиглалт	138
ЗУРАГ 46. Улсын тусгай хамгаалалттай газрын зураг	139
ЗУРАГ 47. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын зураг	139
ЗУРАГ 48. Ховор ан амьтан	148
ЗУРАГ 49. Амьтны тархалтын зураг	149
ЗУРАГ 50. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг	154
ЗУРАГ 51. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд адуунд тохирох бэлчээр	155
ЗУРАГ 52. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд үхэрт тохирох бэлчээр	156
ЗУРАГ 53. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд хонинд тохирох бэлчээр	157
ЗУРАГ 54. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг	158
ЗУРАГ 55. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд тэмээнд тохирох бэлчээр	159
ЗУРАГ 56. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд адуунд тохирох бэлчээр	160
ЗУРАГ 57. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг	161
ЗУРАГ 58. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд хонинд тохирох бэлчээр	162
ЗУРАГ 59. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд ямаанд тохирох бэлчээр	163
ЗУРАГ 60. Бэлчээрийн чадавхийн зураг	164
ЗУРАГ 61. Багуудын бэлчээрийн даац ашиглалт	179
ЗУРАГ 62. Бэлчээр сэлгэн ашиглах төлөвлөгөөний зураг	179
ЗУРАГ 63. Бэлчээр ашиглалтын хэсгийн төлөвлөлт	180
ЗУРАГ 64. Бэлчээр ашиглалтын хэсгийн даац	180
ЗУРАГ 65. Усжуулах шаардлагатай бэлчээрийн төлөвлөлтийн зураг	181
ЗУРАГ 66. Усжуулах шаардлагатай бэлчээрийн гүний усны нөхцөлийн зураг	183
ЗУРАГ 67. Эрчимжсэн мал аж ахуйн төлөвлөлтийн зураг	184
ЗУРАГ 68. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	185
ЗУРАГ 69. Уурхайн нөлөөллийн бүс	189
ЗУРАГ 70. Аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	191
ЗУРАГ 71. Аялал жуулчлалын газрын төлөвлөлтийн зураг	193
ЗУРАГ 72. Шинээр хот, суурин байгуулахад тохиромжтой газар	195
ЗУРАГ 73. Сумын төвийн газар ашиглалтын бүсчлэлийн зураг	196
ЗУРАГ 74. Цагаан хад суурин газар нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцаж байгаа байдлын зураг	197
ЗУРАГ 75. Цагаан хад суурингийн газар ашиглалтын бүсчлэлийн зураг	198



ЗУРАГ 76. АВТО БОЛОН ТӨМӨР ЗАМЫН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХ ГАЗРЫН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЗУРАГ	200
ЗУРАГ 77. АВТО ЗАМЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗУРАГ	201
ЗУРАГ 78. ОЙН САНГИЙН ТОХИРОМЖТОЙ ГАЗРЫН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ	204
ЗУРАГ 79. ХАМГААЛАХ ОЙ БҮХИЙ ГАЗАР	205
ЗУРАГ 80. УСАН САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗУРАГ	206
ЗУРАГ 81. ХАДГАЛАН ХАМГААЛАХ ГАЗРЫН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЗУРАГ	207
ЗУРАГ 82. НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ ГАЗАР	208
ЗУРАГ 83. ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗУРАГ	209
ЗУРАГ 84. ЗҮЙ ЁСНЫ ЭРХ	210
ЗУРАГ 85. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ГАЗАР	211

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Нутгийн ард, иргэдээс өгсөн санал	21
Хүснэгт 2. Багуудын талбайн хэмжээ, эзлэх хувь	30
Хүснэгт 3. Өндөржилтийн хэмжээ, талбайн хэмжээ	32
Хүснэгт 4. Газрын хэвгийн хэмжээ, эзлэх талбай, хувь	34
Хүснэгт 5. Зүг зовхисын градус, талбайн хэмжээ	35
Хүснэгт 6. Ухаа гүвээ, толгодын шавранцар, карбонатлаг, цайвар бор хөрсний гол үзүүлэлт	37
Хүснэгт 7. Гүвээ, толгодын элсэнцэр, чулуурхаг, карбонатлаг, цайвар бор хөрсний гол үзүүлэлт	37
Хүснэгт 8. Хайргархаг шаварлаг, карбонатлаг, цайвар бор хөрсний гол үзүүлэлт	38
Хүснэгт 9. Хайргархаг, элсэнцэр, карбонатлаг, давсархаг говийн цайвар бор хөрс	38
Хүснэгт 10. Элсэн хучаас бүхий давсархаг, говийн цайвар бор хөрс	38
Хүснэгт 11. Чулуурхаг, карбонатлаг, давсархаг, хээршсэн нугат-цайвар бор хөрс	39
Хүснэгт 12. Хайргархаг нугын хээршсэн цайвар бор хөрсний гол үзүүлэлт	39
Хүснэгт 13. Сумын хөрс үүсгэгч эх чулуулаг, талбайн хэмжээ	41
Хүснэгт 14. Хөрсний хэв шинжийн ангилал, талбайн хэмжээ	42
Хүснэгт 15. Хөрсний механик бүрэлдэхүүний төрөл, талбайн хэмжээ	44
Хүснэгт 16. Хээрийн судалгааны явцад материал цуглуулсан судалгааны цэгийн солбицол	44
Хүснэгт 17. Ханбогд суман дах бэлчээрийн ургамалжилтын бичиглэл	47
Хүснэгт 18. Баглуур-Монгол өвст, Баглуур-бударганат бэлчээрийн ургамлын бүрхэц /хувиар/	48
Хүснэгт 19. Баглуур-Монгол өвст, Баглуур-бударганат бэлчээрийн ургац	49
Хүснэгт 20. Баглуур-Монгол өвст, тэсэгтэй, шар модот бэлчээрийн ургамлын бүрхэц/хувиар/	49
Хүснэгт 21. Баглуур-Монгол өвст, тэсэгтэй, шар модот бэлчээрийн ургац	50
Хүснэгт 22. Хазаар өвс-тэсэгт бэлчээрийн ургамлын бүрхэц /хувиар/	51
Хүснэгт 23. Хазаар өвс-тэсэгт бэлчээрийн ургац	51
Хүснэгт 24. Шар мод-баглуурт бэлчээрийн ургамлын бүрхэц /хувиар/	52
Хүснэгт 25. Шар мод-баглуурт бэлчээрийн ургац	52
Хүснэгт 26. Галбын говьд баглуурт цөлийн ургамлын бүрхэц /хувиар/	53



Хүснэгт 27. Галбын говьд Баглуурт цөлийн ургац.....	54
Хүснэгт 28. Шар мод –баглуурт бэлчээрийн ургамлын бүрхэц /хувиар.....	55
Хүснэгт 29. Шар мод –баглуурт бэлчээрийн ургац.....	56
Хүснэгт 30. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт бүртгэсэн ургамлын ангилал..	60
Хүснэгт 31. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт бүртгэсэн ургамлын зонхилох овгууд.....	60
Хүснэгт 32. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт ургаж байгаа зүйлийн бүрдлийн бүтэц	61
Хүснэгт 33. Монгол улсын нэн ховор, ховор ургамлыг бүртгэсэн бүтээлүүд.....	62
Хүснэгт 34. Ханбогд суманд бүртгэсэн хамгаалалтанд авах шаардлагатай зүйлийн бүрдлийн бүтэц	65
Хүснэгт 35. Өмнөговь аймгийн Ханбогд сумын ургамлын аймагт бүртгэсэн нэн ховор ургамлын хамгаалал	65
Хүснэгт 36. Өмнөговь аймгийн Ханбогд сумын ургамлын аймагт бүртгэсэн ховор ургамлын хамгаалал	68
Хүснэгт 37. Ханбогд сумын малын тоо, хонин толгойд шилжүүлснээр	74
Хүснэгт 38. Сумын бэлчээрийн ургамлын анги, төрөл зүйл, эзлэх талбай.....	76
Хүснэгт 39. Бэлчээрийн төлөв байдал, талбайн хэмжээ	78
Хүснэгт 40. Сумын нутаг дэвсгэрт тархсан ойн төрөл.....	79
Хүснэгт 41. Ойн төлөв байдал, талбайгаар	80
Хүснэгт 42. Газрын доорх усны нөөц баялгийн нөхцөлийн шалгуур.....	84
Хүснэгт 43. Сумын хүн амын тоо	97
Хүснэгт 44. Сумын хүн ам /багуудаар/	99
Хүснэгт 45. Малын тоо, багаар	99
Хүснэгт 46. Сумын малын тооны өөрчлөлт /сүүлийн 5 жилээр/	101
Хүснэгт 47. Газрын нэгдмэл сангийн ангилал	104
Хүснэгт 48. Хот суурины газар ашиглалтын зориулалт, талбайн хэмжээ	107
Хүснэгт 49. Бэлчээрийн даац, багаар	110
Хүснэгт 50. Гүний усны нөөц, тархалт.....	111
Хүснэгт 51. Битүүмжилсэн цооногууд	113
Хүснэгт 52. “Оюутолгой” төслийн усны эрэл хайгуул, усны мониторингийн зорилгоор өрөмдсөн цооногуудын дэлгэрэнгүй /2003-2004 он/.....	114
Хүснэгт 53. “Оюутолгой” ХХК төслийн усны эрэл хайгуул, усны мониторингийн зорилгоор өрөмдсөн цооногуудын дэлгэрэнгүй /2007 он/.....	119
Хүснэгт 54. Ашиглалтын худаг	121
Хүснэгт 55. “Оюутолгой” ХХК-ний төслийн усны эрэл хайгуул, усны мониторингийн зорилгоор өрөмдсөн цооногуудын дэлгэрэнгүй /2011-2012 он/.....	122
Хүснэгт 56. Ундайн гол дагуух задгай уст цэгүүдийн одоогийн байгаа байдал.....	127
Хүснэгт 57. Ашиглалтын зөвшөөрөлтэй талбай	136
Хүснэгт 58. Хайгуулын зөвшөөрөлтэй талбай	136
Хүснэгт 59. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд.....	140
Хүснэгт 60. Уул уурхайн зөвшөөрлийн хүснэгт	141
Хүснэгт 61. Түүх соёлын дурсгалт газрын судалгаа	142
Хүснэгт 62. Түүх соёлын дурсгалт газрын тоо	144
Хүснэгт 63. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийн эрсдлийн зэрэглэл	147



Хүснэгт 64. Сумын SWOT шинжилгээ.....	152
Хүснэгт 65. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун- намрын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн талбай	155
Хүснэгт 66. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун- намрын улиралд адуунд тохирох бэлчээрийн талбай	155
Хүснэгт 67. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун- намрын улиралд үхэрт тохирох бэлчээрийн талбай	156
Хүснэгт 68. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун- намрын улиралд хонинд тохирох бэлчээрийн талбай	157
Хүснэгт 69. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун- намрын улиралд ямаанд тохирох бэлчээрийн талбай.....	158
Хүснэгт 70. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл- хаврын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн талбай.....	159
Хүснэгт 71. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл- хаврын улиралд адуунд тохирох бэлчээрийн талбай.....	160
Хүснэгт 72. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл- хаврын улиралд үхэрт тохирох бэлчээрийн талбай.....	161
Хүснэгт 73. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл- хаврын улиралд хонинд тохирох бэлчээрийн талбай.....	162
Хүснэгт 74. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл- хаврын улиралд ямаанд тохирох бэлчээрийн талбай	163
Хүснэгт 75. Бэлчээрийн газрын талбайн хэмжээ /багуудаар/	165
Хүснэгт 76. Бэлчээрийн чадавхи	166
Хүснэгт 77.Бэлчээрийн даац	166
Хүснэгт 78. Бэлчээрийн газрын жилийн нийт ургац (в)-ыг дараах хүснэгтээр тооцно.167	
Хүснэгт 79. Малын бэлчээрээс өдөрт идэх өвсний хэмжээ улирал тус бүрээр	167
Хүснэгт 80. Нядалгааны гарц тооцох хүснэгт	168
Хүснэгт 81. Монгол хонины махны гарц	168
Хүснэгт 82. Хонин сүргийн зохистой харьцаа	168
Хүснэгт 83. Хонины махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцож гаргавал дараах байдалтай байна.....	169
Хүснэгт 84. Хонины сүү бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцов.	169
Хүснэгт 85. Хонины ноос бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцов.	169
Хүснэгт 86. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг дараах хүснэгтээр тооцов.	170
Хүснэгт 87. Нядалгааны гарц тооцох хүснэгт	171
Хүснэгт 88. Монгол ямааны махны гарц.....	171
Хүснэгт 89. Ямаан сүргийн зохистой харьцаа	172
Хүснэгт 90. Ямааны махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцож гаргавал дараах байдалтай байна.....	172
Хүснэгт 91. Ямааны сүү бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцно.	173
Хүснэгт 92. Ямааны ноолуур бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцно.	173
Хүснэгт 93. Бэлчээрийн газрын газрын бүтээгч чадавхийг дараах хүснэгтээр тооцов.	173
Хүснэгт 94. Тэмээн сүргийнбүтэц.....	174
Хүснэгт 95. Тэмээний ноолуурын дундаж гарц /нас, хүйсээр/	174



Хүснэгт 96. Ингэний сүүний эдийн засгийн үнэлгээ	175
Хүснэгт 97. Нийт ямаан сүргийн тоо, толгой /2016 оны эцсийн байдлаар/	176
Хүснэгт 98. Ямааны мах бэлтгэсэн хэмжээ болон орлогыг зах зээлийн ханшаар тооцов.	177
Хүснэгт 99. Ямааны сүү нөөц, чадавхийг доорх хүснэгтээр тооцов.....	177
Хүснэгт 100. Ямааны ноолуур бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцов.....	178
Хүснэгт 101. Ямаан сүргээс олох орлогын нийт нөөцийг дараах хүснэгтээр тооцов. 178	
Хүснэгт 102. Усжуулах шаардлагатай бэлчээр	181
Хүснэгт 103. Усжуулах шаардлагатай, ашиглалт багатай бэлчээрийн гүний усны нөхцөл.....	182
Хүснэгт 104. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ	186
Хүснэгт 105. Жилийн хүнсний хэрэгцээ.....	187
Хүснэгт 106. Аялал рекреацийн тохиромжтой байдлын үнэлгээ	191
Хүснэгт 107. Ханбогд сумын дэд бүсэд хөгжүүлэх жуулчлалын замнал аялал жуулчлалын газрыг төлөвлөв.....	193
Хүснэгт 108. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ.. 195	
Хүснэгт 109. Цагаан хад суурингийн газар ашиглалтын бүсчлэлийн талбайн хэмжээ	198
Хүснэгт 110. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ.....	200
Хүснэгт 111. Ойн сангийн тохиромжтой газрын талбайн хэмжээ	204
Хүснэгт 112. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ.....	208
Хүснэгт 113. Хамгаалалтын бүсийн хэмжээ, талбайн хэмжээ	209
Хүснэгт 114. Бий болох зүй ёсны эрх	210
Хүснэгт 115. Дүйцүүлэн хамгаалах газар	211

Диаграм, схемийн жагсаалт

Диаграм 1. Гадаргын гистометрийн зүсэлт	33
Диаграм 2. Газрын төлөв байдал.....	46
Диаграм 3. Ургамлын амьдралын хэлбэр	61
Диаграм 4. Нэн ховор, ховор, унаган, үлдэц ургамал.....	63
Диаграм 5. Хүн амын тоо (сүүлийн 5 жилээр)	97
Диаграм 6. Сумын хүн амын тоо /сүүлийн 5 жилээр /	98
Диаграм 7. Хунамын өсөлт (хүйсээр).....	98
Диаграм 8. Сумын хүн ам, өрхийн тоо, багуудаар /ГРАФИК/	99
Диаграм 9. Сум, багийн сүргийн бүтэц, хувиар	100
Диаграм 10. Малын тоо, толгой (сүүлийн 5 жилээр)	101
Диаграм 11. Сумын малын тоо	102
Диаграм 12. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд	154
Диаграм 13. Ингэний саалийн хугацааны хуанли	175
Диаграм 14. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд.....	185
Диаграм 15. Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын схем.....	190



ДИАГРАМ 16. ШУГАМАН БАЙГУУЛАМЖИЙН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ СХЕМ	200
ДИАГРАМ 17. ОЙ ТАРЬЖ УРГУУЛАХАД ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ СХЕМ.....	203

**ЗУРГИЙН МАСШТАБ**

Дугаар	Зургийн нэр	Масштаб
Зураг 2	Агаарын дундаж температурын зураг	1:600000
Зураг 3	Хур тунадасны зураг	1:600000
Зураг 4	Агаарын даралтын зураг	1:600000
Зураг 5	Чийгийн зураг	1:600000
Зураг 6	Нарны цацрагын зураг	1:600000
Зураг 7	Ханбогд сумын байршил	1:600000
Зураг 8	Сумын хилийн цэсийн зураг	1:750000
Зураг 9	Газрын гадаргын зураг	1:650000
Зураг 10	Сумын өндөршилтийн зураг	1:600000
Зураг 11	Гадаргын налуужилтын зураг	1:600000
Зураг 12	Зүг зовхисын зураг	1:600000
Зураг 13	Ландсат 8 хиймэл дагуулын зураг	1:600000
Зураг 14	Хөрс үүсгэгч чулуулгийн зураг	1:600000
Зураг 15	Хөрсний хэв шинж	1:600000
Зураг 16	Хөрсний механик бүрэлдэхүүний зураг	1:600000
Зураг 25	Ургамалжилтын зураг	1:650000
Зураг 26	Бэлчээрийн төрх байдлын зураг	1:600000
Зураг 28	Ойн төлөв байдлын зураг	1:600000
Зураг 29	Гадаргын усны зураг	1:600000
Зураг 30	Газрын доорх усны зураг	1:600000
Зураг 31	Геологийн зураг	1:600000
Зураг 32	Газар чичирхийллийн зураг	1:600000
Зураг 33	Цэвдэгийн тархалтын зураг	1:600000
Зураг 34	Геоморфологийн зураг	1:600000
Зураг 35	Газрын нэгдмэл сангийн зураг	1:700000
Зураг 36	Газар ашиглалтын нэгдсэн зураг	1:600000
Зураг 37	Хот, тосгон бусад суурины газрын зураг	1:15000
Зураг 38	Бэлчээр ашиглалтын зураг	1:600000
Зураг 39	Бэлчээр усжуулалтын зураг	1:600000
Зураг 42	Тариалангийн газрын ашиглалтын зураг	1:600000
Зураг 43	Заган ой тархсан газар нутгийн зураг	1:600000
Зураг 44	Уул уурхайн газрын ашиглалтын зураг	1:600000
Зураг 47	Улсын тусгай хамгаалалттай газрын зураг	1:600000
Зураг 48	Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын зураг	1:600000
Зураг 50	Амьтны тархалтын зураг	1:600000
Зураг 51	Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг	1:600000
Зураг 52	Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврынулиралд адуунд тохирох бэлчээрийн зураг	1:600000
Зураг 53	Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврынулиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг	1:600000
Зураг 54	Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд хонинд тохирох бэлчээрийн зураг	1:600000



Зураг 55	Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг	1:600000
Зураг 56	Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрынулиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг	1:600000
Зураг 57	Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрынулиралд адуунд тохирох бэлчээрийн зураг	1:600000
Зураг 58	Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг	1:600000
Зураг 59	Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд хонинд тохирох бэлчээрийн зураг	1:600000
Зураг 60	Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг	1:600000
Зураг 61	Бэлчээрийн чадавхийн зураг	1:600000
Зураг 62	Багуудын бэлчээр даац ашиглалт	1:600000
Зураг 63	Бэлчээр сэлгэн ашиглах төлөвлөгөөний зураг	1:600000
Зураг 64	Бэлчээр ашиглалтын хэсгийн төлөвлөлт	1:600000
Зураг 65	Бэлчээр ашиглалтын хэсгийн даац	1:600000
Зураг 66	Усжуулах шаардлагатай бэлчээрийн төлөвлөлтийн зураг	1:600000
Зураг 67	Усжуулах шаардлагатай бэлчээрийн гүний усны нөхцөл	1:600000
Зураг 68	Эрчимжсэн мал аж ахуйн төлөвлөлтийн зураг	1:600000
Зураг 69	Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	1:600000
Зураг 70	Уурхайн нөлөөллийн бүс	1:600000
Зураг 71	Аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	1:600000
Зураг 72	Аялал жуулчлалын төлөвлөлтийн зураг	1:600000
Зураг 73	Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	1:600000
Зураг 74	Ханбогд сумын төвийн төлөвлөлтийн зураг	1:600000
Зураг 75	Цагаан хад суурингийн төлөвлөлтийн зураг	1:20000
Зураг 76	Авто болон төмөр замын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	1:600000
Зураг 77	Авто замын төлөвлөлтийн зураг	1:600000
Зураг 78	Ойн сангийн тохиромжтой газрын нэгдсэн үнэлгээ	1:600000
Зураг 79	Хамгаалах ой бүхий газар	1:600000
Зураг 80	Усан сан бүхий газрын төлөвлөлтийн зураг	1:600000
Зураг 81	Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ	1:600000
Зураг 83	Хамгаалалтын бүсийн төлөвлөлтийн зураг	1:600000
Зураг 84	Зүй ёсны эрх	1:600000
Зураг 85	Дүйцүүлэн хамгаалах газрын төлөвлөлт	1:600000

ОРШИЛ

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын зорилго нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрийн газар ашиглалт, байгалийн нөөц, нөхцөлийн онцлогийг бүрэн тодорхойлсны үндсэн дээр нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлогыг дэмжсэн, иргэд, олон нийтийн оролцоо, тэдний санал санаачилга, орон нутагтаа баялаг бүтээх боломжийг бүрдүүлсэн цогц үйл ажиллагааг төлөвлөх явдал юм.

Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын А/200 тоот тушаалаар батлагдсан “Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх аргазүй, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны А/278 тоот тушаалаар батлагдсан “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй болон бусад төлөвлөлттэй холбоотой стандарт, заавар журмын дагуу, бодлогын баримт бичгүүд, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнүүдтэй нягт уялдуулан, тэнд тусгагдсан бодлогын чанартай асуудлуудыг тусган боловсруулав.

Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим, арга зүйн асуудлууд:

1. Монгол улсын Үндсэн хууль, Газрын тухай багц хууль болон бусад хууль эрх зүйн баримт бичигтэй бүрэн нийцсэн байх.
2. Байгаль, эдийн засгийн нөөц, нөхцөлийг тооцон, газар, байгалийн нөөц ашиглалтыг түүнд зохицуулах.
3. Газар, байгалийн нөөц ашиглалт нь нэгдмэл, бие биенээсээ харилцан хамааралтай байх.
4. Газар, байгалийн нөөц ашиглалт нь төлөвлөгөөний дагуу, төрийн болон олон нийтийн хяналтад явагдах нөхцөлийг хангах.
5. Байгалийн унаган төрхийг хадгалан газар, байгалийн нөөц ашиглах зарчим баримтлан боловсруулах.
6. Говийн бүсийн болон аймгийн хэтийн хөгжлийн чиг хандлага, хүн ам, хөрөнгө санхүү, техникийн нөөцтэй уялдсан байх.

Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахдаа Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Өмнөговь аймгийн хөгжлийн хөтөлбөр, Өмнөговь аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Хөгжлийн хөтөлбөр /2010-2020/, Өмнөговь аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө, Ханбогд сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэгтэй нийцүүлэн, аймаг, сум, орон нутгийн байгууллага, мэргэжилтнүүд, иргэдийн саналуудыг тусган, нийгэм эдийн засгийн асуудлуудын хэрэгцээний дагуу ойрын 3-5 жилийн дотор газар, байгалийн нөөцийн эрэлт хэрэгцээ, ашиглалт, хамгаалалтыг урьдчилан тооцож төлөвлөв.

Мөн газрыг бүсчлэн хуваарилах аргаар сумын газар ашиглалтын бүсүүдийг тодорхойлов.

Төлөвлөсөн, санал болгосон арга хэмжээг объект бүрээр түүний байршил, тархацыг 1:100000 масштабтай байр зүйн зургийн нарийвчлалаар зураглав.

Төлөвлөгөөний зургуудийг дараах ГМС-ын программ хангамжуудыг ашиглан боловсруулав. Үүнд:

- ArcGIS 10.5,
- AutoCAD 2015,
- ENVI 5.3,
- Erdas Images 2014,

Сумын нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын төлөвлөлт нь

- 1) Өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл
- 2) Геологи, хүрээлэн буй орчны нөхцөл
- 3) Газар, байгалийн нөөц ашиглалтын өнөөгийн байдал
- 4) Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө гэсэн үндсэн 4 бүлгээс бүрдэнэ.

Дараах эрхзүйн баримт бичгүүдийг үндэслэн боловсруулсан.

Үүнд:

- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зургийн таних тэмдгийн стандартууд MNS 6315:2012, MNS 6316:2012, MNS 6317:2012;
- ГХГЗЗГ-ын 2016 оны А/22 тоот тушаалаар батлагдсан “Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг зориулалтаар нь бүртгэн баталгаажуулах түр заавар”;
- “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” УБ, 2011 он;
- Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм;
- Монгол улсын стандарт MNS 4628-98 “Шатахуун түгээх станц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага” УБ, 1998 он;
- “Харилцаа холбооны тухай хууль” 2001 он;
- "Авто замын тухай хууль"-ийн 12.2 зүйл;
- “Ойн тухай хууль” шинэчилсэн найруулга, 2012 он;
- “Аялал жуулчлалын тухай хууль” 2000 он;



I. ХАНБОГД СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ

1.1. ХАНБОГД СУМЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Өмнөговь аймгийн Ханбогд сум нь 1924 онд Хаданхошууны Хар овооны бууц гэдэг газар “Галба” нэртэйгээр анх байгуулагджээ. Галба сум 1941 оноос нэрээ сольж Ханбогд хайрханыхаа нэрээр нэрлэгдэн, 80 гаруй жилийн түүхэн замналыг туулж ирсэн түүхтэй. Ханбогд сум нь урд талаараа БНХАУ-тай, баруун, хойд талаараа өөрийн аймгийн Манлай, Цогтцэций, Баян-овоо сумдтай, зүүн талаараа Дорноговь аймгийн Хатанбулаг, Мандах сумдтай хил залган оршдог ба хээр тал, говь цөл хосолсон, Ундайн говь, Байшин цав, Чингисийн уурганы нүх, Хөдөлдөг цохио, Мэлхий хад, Гурван зээрдийн агуй, 3000 хайлааст, Сэвхүүлийн элс, Хаалгын рашаан, алдарт Галбын говь зэрэг байгалийн үзэсгэлэнт газар бүхий 1515.2километр квадрат нутаг дэвсгэртэй. Газрын хөрсөндөө алт, зэсийн арвин баялаг нөөцтэйгээс гадна эрт галавын үеийн аварга гүрвэл, мөлхөгчдийн үлдэгдэл, чулуужсан мод зэрэг ховор олдвортой. Дуу түүхэнд мөнхөрсөн Галба нутагт Ноён хутагт Данзанравжаагийн байгуулсан алдарт гурван хийдийн туурь, Цогцолын хийдийн туурь, Алтангэрэлийн дугуй, Ловончомбын баяжуулдаг Хан Чавгын агуй, Ходоод, нүдний рашаан, элэг цөсний чулуу зэрэг байгаль түүхийн сонин тогтоц бүхий газруудтай.

Улаанбаатар хотоос 650 км, аймгийн төв Даланзадгад хотоос 250 км алслагдсан байгалийн үзэсгэлэнт газар ихтэй, цаашид аялал жуулчлал хөгжих бүрэн боломжтой.

Зураг 1. Өмнөговь аймгийн Ханбогд сумын төв



Газар нутгийн онцлог: Газарзүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаарах бөгөөд газарзүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр Э.М.Мурзаев цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтаан үзжээ. Хуурай сайраар хэрчигдсэн, үнэмлэхүй өндөр нь 900-1100 м, орой хяр нь хавтгай ба бөмбөгөр хэлбэртэй, хажуу нь налуу хад асга багатай цав толгод болон ухаа гүвээт тал зонхилдог. Ханбогд сум нь Монголын говь цөлийн бүсийн өмнөд хэсэгт байрладаг ба Ханбогд уулын орчимд орших говийн намхан толгодоос тогтдог. Говийн бүсдээ харьцангуй өндөрт тооцогдох уулуудтай ба үүнд Ханбогд уул (д.т.д 1350 м), Бумбат

задгайн хяр (д.т.д 1233.3 м), Жавхлант уул 1295 м (д.т.д), Далайн Дуулга (д.т.д 1240 м) зэрэг уулс орно. Төсөл хэрэгжих дэвсгэр нь жижиг уулс, толгодоор хүрээлэгдсэн өргөн хөндийн төвд оршино.

Хүн ам: Өмнөговь аймаг нь 2016 оны жилийн эцэст 6368 хүн амтай. Нийт хүн амын 50.2 хувь нь эрэгтэйчүүд, 49.8 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна.

Цаг уурын нөхцөл: Цөл газрын халуун, дулаан хуурай уур амьсгалтай. Жилийн дундаж агаарын температур 2-3.7⁰С, хамгийн дулаан долоо, найман сард 38.4-43.5⁰С, хамгийн хүйтэн 1-р сард -30.4-34.4⁰С хүртэл хүйтэрдэг. Хамгийн их халуун нь зундаа 50⁰С, хамгийн их хүйтэн нь өвөлдөө -39⁰С хүрдэг. Агаар мандалын тунадасны жилийн дундаж тоо хэмжээ 113.1 мм, хамгийн их тунадас нь 7 ба 8-р сард унадаг. Агаарын чийг маш бага, 6-7 сард 65.0 хувь байна. Салхи голдуу хойноос ба баруун хойноосоо чиглэлтэй. Хаврын саруудад, ялангуяа 3-4 сард хүчтэй салхитай байдаг. Ханбогд суманд жилд дунджаар 95.3 мм хур тунадас ордог. Үүний улмаас ургамалжилтын түвшин бага, чийгшил өчүүхэн, гүний усны ундарга хязгаартай, зундаа ууршилт ихтэй. Жилийн дотор болон жил хооронд уур амьсгал ихэд хувьсамтгай байх нь хэвийн үзэгдэл. Ус цаг уур, орчны шинжилгээний газраас тодорхойлсоноор 1940 оноос хойш агаарын температур 2⁰С-аар дулаарч, цэвдэг хайлан хур тунадасны хэмжээ хувьсч, хатуу ширүүн ган зуд болж уур амьсгал эрс өөрчлөгдөж байна. 1960-2013 онд 6,7,8 саруудын тоо мэдээнээс хугацааны турш дах зуны хур тунадасны хэмжээг маш нарийн тодорхой харж болохоор байна. Ялангуяа ургамал, малын өвс тэжээл ургахад хур тунадасны цаг хугацаа маш чухал ач холбогдолтой. 2016 оны 5,6 сард хэдэн өдөр бороо орсон нь /64 мм/ бэлчээрийн гарцад нөлөөлсөн байна.

Тааламжтай нөхцөлүүд

Тус суманд үйл ажиллагаа явуулдаг Оюутолгойн бүлэг ордуудын геологийн нийт нөөц нь хүдрээр 6451511.0 мян.тн, зэсээр 45032 мян.тн, алтаар 1838 тн, мөнгөөр 12049 тн, молибденоор 157 мян.тн байгаа ба үүнээс үр ашигтай нөөц нь 2675617 мян.тн хүдэр, 25368 мян.тн зэс, 1028 тн алт, 6144 тн мөнгө, 81.6 мян.тн молибдени болж байна.

Тус суманд зэс, алт, төмрийн орд байхаас гадна дэлхийд ховор Армострон болон Монголит гэдэг газрын ховор элементүүд, барилгын материал, палеонтологийн олдвороор элбэг юм. Сумын нутаг дэвсгэрт багтах Гашуун Сухайтын боомт нь ард иргэдэд ойр учраас зах зээл хөгжиж аж ахуйн амьдралд нь эерэг нөлөө үзүүлж байгаа сумын нэг юм.

Галба нутагт Ноён хутагт Данзанравжаагийн байгуулсан алдарт гурван хийдийн туурь, Цогцолын хийдийн туурь, Алтангэрэлийн дугуй, Ловончомбын баяжуулдаг Чавгын агуй, ходоод, нүдний рашаан, элэг цөсний чулуу зэрэг байгаль түүхийн сонин тогтоц бүхий газар нутаг нь аялал жуулчлалын бүс болон хөгжих боломжтой.

Тааламжгүй нөхцөлүүд

Ханбогд сум нь Монголын өмнөд хэсгийн дэд бүтэц муу хөгжсөн бүс нутагт байрладаг. Уурхай болон баяжуулах үйлдвэрийг барих, тэдгээрийг тасралтгүй ажиллуулах, ажиллах хүчээр хангахын тулд томоохон хэмжээний дэд бүтэц байгуулах шаардлагатай.

Нутаг дэвсгэрийн байгаль цаг уурын ерөнхий нөхцөлийн хувьд төвөөс алслагдмал хур тунадасны хэмжээ бага, хөрсний хуурайшилт, салхины нөлөөлөл ихтэй, ган зуд элбэг тохиолддог, гадаргын усны нөөц бага, цөлжих үйл явц идэвхжиж байгаа зэрэг байгалийн гамшгийн эрсдэл ихтэй.

Говийн гандуу хуурай хөрс нь салхинд элэгдэхээс гадна автомашины хөдөлгөөн ихэссэнээр, хөрс талхлагдаж, агаар дах тоосжилтын хэмжээ ихсэж, бэлчээрийн доройтол нэмэгдэж, уламжлалт мал аж ахуй эрхлэхэд хүндрэлтэй болж байна. Мөн эдгээр шалтгааны улмаас ургамалжилтын олон янз байдал цөөрч, экологийн бүтэц өөрчлөгдөж, бэлчээрийн үржил шимт байдал буурахад хүргэж байна.

Уул уурхайн үйл ажиллагааны явцад, хүчил үүсгэх бололцоо бүхий чулуулгийн хаягдлаас бий болох тоос нь уурхайн талбай болон түүний ойр орчмын нутаг дэвсгэрийн хөрс, ургамлын химийн шинж чанарт тодорхой нөлөө үзүүлж байна.

Уул уурхайн компани, Засгийн газар аль аль нь уурхайн олборлолт бэлчээрийн даац болон усан хангамжийн хомсдол, орон нутгийн иргэдийн амьдрал ахуй, хүрээлэн буй орчинд хэрхэн нөлөөлж байгаа талаар бодлогын хүрээнд дорвитой арга хэмжээ авахгүй байсаар байна.

1.2. БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА, БОДЛОГО

1.2.1. “Байгалийн баялаг, сайн засаглал хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020):

Уг хөтөлбөрийн зорилго нь иргэдийн оролцоотойгоор орон нутагт тулгамдаж буй асуудлууд хэрэгцээ шаардлагад нь суурилан сумын дунд хугацааны хөгжлийн стратегийг төлөвлөх, орон нутгийнхаа уул уурхайн нөөц боломжид тулгуурлан хөгжих, бизнесийн таатай орчин бүрдүүлж өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх бодлогыг цогц баримт бичгийн байдлаар тодорхойлоход оршино.

Хүн амын суурьшил, хот байгуулалт болон уул уурхайн үйлдвэрлэлийг түшиглэсэн бизнес хөгжихийн зэрэгцээ, богино хугацаанд эрчимтэй явагдах хүн амын төвлөрлийг даган нийгмийн үйлчилгээний хүртээмж муудах, хүн амын зохистой бүтэц алдагдах шинж ажиглагдаж байгаа бөгөөд байгаль орчныг хамгаалах, түүнийг тэтгэх талаар ч ихээхэн анхаарал хандуулах шаардлагатай байна.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үүднээс авч үзвэл уугуул иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, орлого хуваарилалтын ялгааг арилгах, хүний хөгжлийг

хангах талаар зохистой бодлого боловсруулж хэрэгжүүлэх нь тулгамдсан асуудал болсон талаар уг баримт бичигт дурьдсан байна.

Өмнөговь аймаг нь Монголын Говийн бүсийн төв болон хөгжих ирээдүйтэй. Иймд бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийг цаг хугацааны хувьд гурван түвшинд төлөвлөжээ.

Нэг. 2010-2015 онд уул уурхайн орд газруудыг ашиглах төслүүдийн бүтээн байгуулалт, суурь дэд бүтцийг байгуулах ажлыг хот байгуулалтын оновчтой бодлоготой уялдуулан хийж, хүн амын эрчимтэй төвлөрөл бүхий сууринд нийгмийн суурь үйлчилгээг хүргэх, орон нутгийн боломжит бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр хэрэглээг хангахад чиглэгдсэн бэлтгэл ажлууд голлон хийгдэнэ.

Хоёр. 2015-2020 онд уул уурхайн боловсруулах аж үйлдвэрлэл явагдахын хажуугаар бусад салбарт боломжит бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх замаар биеэ дааж, нийгмийн үйлчилгээний чадавхи сайжран, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах ажлууд хийгдэнэ.

Гурав. 2020 оноос хойш уул уурхайгаас бусад байгаль орчинд ээлтэй салбаруудын нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэл эдийн засгийн бүтцэд голлох байрыг эзэлж, бие даан баялгийг бий болгож, хүний хөгжлийг хангахад чиглэгдсэн ажлууд хийгдэнэ.

Өмнөговь аймгийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, түүний зарчмуудад үндэслэн гурван бичил бүсэд авч үзсэн. Бичил бүсүүдийн хөгжлийн загварууд нь харилцан адилгүй байх боловч нийтлэг шинжүүдээр нь авч үзвэл эдийн засгийн бүтэц болон бүс дэх үндсэн үүргүүдээрээ ялгагдана.

Өмнөговь аймгийн Төвийн бүс:

Төвийн бүсийн тулгуур төв нь Даланзадгад хот байх бөгөөд тус хот бол Монголын Говийн бүсийн тулгуур төв хот байж нийгмийн суурь үйлчилгээний төв байхын зэрэгцээ соёлын болон оюуны томоохон төв болон хөгжих боломжтой. Төвийн бүс нь эдийн засгийн бүтцийн хувьд ногоон үйлдвэрлэл, аялал жуулчлал, түүнд зориулсан дэд бүтэц, эрчимжсэн мал аж ахуйн бүс болгохоор төлөвлөсөн. Уул уурхайн үйл ажиллагааг нэмэгдүүлэхгүй байхын хамтаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх бодлого баримтлахаар төлөвлөж байна.

Өмнөговь аймгийн Зүүн бүс:

Зүүн бүс нь уул уурхайн томоохон бүсчлэл болон хөгжинө. Бүлэг суурингийн таталцлын үүднээс авч үзвэл Өмнөговь аймгаас гадна Дорноговь аймагтай таталцалд орно. Зүүн бүс нь Цогтцэций, Ханбогд гэсэн хоёр тулгуур төвтэй байхаар төлөвлөсөн. Тус бүсийн эдийн засгийн бүтэц нь уул уурхай, түүнд түшиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, уул уурхайн боловсруулах үйлдвэрлэл зонхилон хөгжинө.

Өмнөговь аймгийн Баруун бүс:

Баруун бүс нь уул уурхай ба аялал жуулчлалын хослон хөгжинө. Баруун бүсийн нутаг дэвсгэрийн хойд хэсэг нь байгалийн цогцолбор газар бөгөөд түүнийг дагасан аялал жуулчлал хөгжүүлнэ. Харин өмнөд бүс нутаг нь ашигт малтмал олборлох, боловсруулах чиглэлээр ялгаран хөгжинө. Бэлчээрийн мал аж ахуй зонхилж байсан бүс нутагт хүч түрэн орж ирж байгаа уулуурхайн салбар, түүнийг түшиглэсэн эдийн засгийн бүтэц бий болох нь тодорхой болж байгаа энэ үед эдийн засгийн бүтцийг сайжруулах үзэл баримтлалыг томъёолохдоо уул уурхайн хөгжлөөс ногоон үйлдвэрлэл, аялал жуулчлал, эрчимжсэн мал аж ахуй руу чиглүүлэхээр төлөвлөсөн.

Түүнчлэн Өмнөговь аймгийн “Байгаль орчны мастер төлөвлөгөө”, Өмнөговь аймгийн “Ус” дэд хөтөлбөр болон бусад орон нутгийн бодлого, шийдвэрүүд нь бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийн байгаль орчныг хамгаалах бодлогын үндэслэл болсон. Байгаль орчны орон нутгийн удирдлагын загвар нь төрөөс экологийн талаарх баримтлах бодлогод тулгуурлах бөгөөд экологи, эдийн засгийн, засаг захиргааны бүсчлэл болон тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг харгалзан байгалийн төрөл бүрийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны унаган төрхийг хамгаалах асуудлыг бүс нутгийн хүрээнд цогцолбороор шийдвэрлэхэд чиглэсэн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, хяналт шинжилгээ, мэдээлэл ил тод байдлын иж бүрэн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдэнэ гэжээ.

1.2.2. Өмнөговь аймгийн “Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө” 2014

Бүсчлэн хөгжих хөтөлбөр

1. Байгаль орчинд ээлтэй аялал жуулчлал, уул уурхайн салбарыг тэргүүлэн хөгжүүлнэ.
2. Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлнэ.
3. Гадаад дотоод нэгдсэн сүлжээнд холбогдох замаар дэд бүтцийг хөгжүүлнэ.
4. Зах зээлийн эрэлт хэрэгцээ, бүс нутгийн боломжинд түшиглэсэн өмчийн олон хэлбэрт жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлнэ.
5. Экологийн тэнцвэрт байдлыг хангах, газрыг нөхөн сэргээх хамгаалахад нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
6. Хүний хөгжлийг дэмжиж төрийн албаны оновчтой бүтцийг бий болгоно.

1.2.3. Ханбогд сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн стратеги төлөвлөгөө (2014-2021 он)

Эрүүл, соёл боловсролтой, хүмүүнлэг төлөвшсөн иргэдтэй төрийн шуурхай үйлчилгээтэй, уламжлалт, эрчимжсэн хөдөө аж ахуй, орон нутгийн нөөц баялаг боломжид суурилсан хариуцлагатай уул уурхай, үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлалын салбарыг үр ашигтай хөгжүүлэн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлж эдийн засгийг нэмэгдүүлнэ.

Сум хөгжүүлэх тэргүүлэх чиглэл

- Уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуйг үр ашигтай хөгжүүлэх асуудлыг хөгжлийн тэргүүлэх чиглэл гэж үзнэ.
- Орон нутгийн уул уурхай болон байгалийн, бусад нөөцөд суурилсан аялал жуулчлал, жижиг, дундүйлдвэрлэлийг сумын хөгжилд чухалчилна. Үүнд:
 1. Хариуцлагатай уул уурхайн салбарын үр ашигтай хөгжүүлэх;
 2. Жижиг дунд үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх;
 3. Аялал жуулчлалыг хөгжүүлэх түүнд түшиглэсэн байгальд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ, байгаль хамгаалах стратегийн чиг хандлагыг томъёолох;
 4. Орон нутгийн уламжлалт ёс заншил, соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх үзэл баримтлалыг тодорхойлох;
 5. Иргэдийн оролцоог шийдвэр гаргах түвшинд хүргэж, төрийн байгууллагуудын чадавхийг өндөржүүлж, төрийн удирдлагын залгамж чанар, ажлын уялдаа холбоог сайжруулах хүрээний үйл ажиллагааг иж бүрэн байдлаар тодорхойлох

1.3. НУТГИЙН ИРГЭД, ОЛОН НИЙТЭЭС ТӨЛӨВЛӨГӨӨНД ӨГСӨН САНАЛ

Нутгийн иргэдийн төлөвлөгөөнд өгсөн саналыг агуулгаар нь төрөлжүүлэн үзүүлэв. Иргэдийн өгсөн саналд ихэвчлэн ашиглалт, хайгуулын лицензтэй талбайд байрладаг айлуудын малын бэлчээр хомсдож, байгаль орчны тэнцвэрт байдал алдагдаж, усны хомсдолд орж, амьдрах орчин нөхцөлгүй болж байгааг шийдвэрлэж өгөх талаар саналууд байлаа.

Хүснэгт 1. Нутгийн ард, иргэдээс өгсөн санал

№	Саналын агуулга	Төрөл	Авах арга хэмжээ	Байршил /Төстэй саналын тоо/
1	Уурхайн нөлөөнөөс гадаргын ус ширгэж, ургамлын гарц муудаж, тоосжилт, дуу чимээ их гардаг болсноос бэлчээр хомсдож мал аж ахуй эрхэлж амьдрах боломжгүй болж байна.	Уул уурхайн олборлолтын нөлөө	Мал аж ахуй, газар тариалангийн талбай, бэлчээрийн газрын зохицуулалт, малын бэлчээр, хадлан хадах талбай бодит боломжийг тогтоох зохицуулах, нөөц боломж байна.	Гавилуут, Жавхлант
2	Олон салаа зам гарч газрын хөрсийг талхлагдуулж байна.	Зам	Олон салаа замыг цөөрүүлж нэг замтай болгох	Гавилуут, Жавхлант, Номгон
3	Сумын төвөөс уурхай хүрэх мөн аймгийн төв рүү засмал зам тавьж замын тоосжилтоос хамгаалах	Зам	Засмал зам тавих талаар төлөвлөх	Гавилуут, Жавхлант
4	Хилийн бүс рүү мал ороход ангийн дарга хөөдөг	Малын бэлчээр	Бэлчээрийн газрыг нэмэгдүүлэх	Жавхлант, Номгон



5	Тариалан, бэлчээрийн газрын зааг ялгааг гаргах шаардлагатай байна.	Тариалан, бэлчээр	Тариалангийн газрын хамгаалалтын бүсийг тогтоох	4 багаар
6	Бэлчээр ашиглалт давхцалтай, бэлчээрийн даац хэтэрсэн. Үүнийг зохицуулах	Бэлчээр	Бэлчээрийн газрын давхцалыг арилгах	Гавилуут, Баян
7	Тэжээлийн ургамал, мод тарих, бэлчээр хаших	Зүй ёсны эрх	Эдгээр зориулалтаар зүй ёсны эрхийг баталгаажуулах	Гавилуут, Жавхлант
8	Уул уурхайн олборлолт хийгдээгүй газар нутгийг хамгаалж дахин ашиглалт, хайгуулын лиценз олгохгүй байх	Зүй ёсны эрх, бэлчээр	Мал аж ахуйг бодлогоор дэмжих, уул уурхайн олборлолтыг хязгаарлаж газар, байгалийн унаган төрхийг хадгалах	Гавилуут, Жавхлант
9	Бэлчээрийн газарт худаг гаргуулах	Ус	Худаг гаргах боломжтой эсэх, гаргасны дараах нөлөөллийг тооцох	Баян, Номгон
10	Газар нутагтаа эзэн нь болж байгалийн баялаг, булаг шанд, ан амьтнаа хамгаалах	Зүй ёсны эрх	Эдгээр зориулалтаар зүй ёсны эрхийг баталгаажуулах	Жавхлант, Номгон
11	Отрын нөөц нутаг, бод малын бэлчээр бий болгох	Бэлчээр	Бэлчээр зохион байгуулалт хийх	Гавилуут, Баян

Иргэдээс өгсөн саналыг амьдралд шууд нөлөөлж байгаа чухал шаардлагатайгаар нь эрэмбэлж үзэхэд уул уурхайн нөлөөнд өртөж мал аж ахуй эрхлэн амьдрах боломжгүй болж амьтан ургамал, булаг шанд устаж үгүй болсон учраас уул уурхайн үйл ажиллагааг дахин явуулахгүй болгох талаарх санал дийлэнх хувийг эзлэж байна.

Иргэдээс өгсөн дараагийн чухал санал бол тус бүс нутагт сүүлийн жилүүдэд ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа өргөжиж байгаагаас бэлчээр доройтож, тоосжилтоос шалтгаалан хүн, малын өвчлөл нэмэгдэх, амьсгалын замын өвчлөл ихсэх хандлага ажиглагддаг тул уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахдаа хүнийэрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах талаар тодорхой арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлэх талаар байв.



II. ГЕОЛОГИ, ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ НӨХЦӨЛ

2.1. УУР АМЬСГАЛ

Говийн хахир хатуу уур амьсгалын нөхцөл байдал нь сумын нийгэм, эдийн засагт ихээхэн хамааралтай. Температурын хазайц хэтэрхий эрс тэс, өвөлдөө хамгийн бага температур -34°C -ээс бага, зуны улиралд ихэвчлэн 40°C -аас давж хална. Ханбогд суманд өвөлдөө Монгол орны хойд хэсгийн нутагтай харьцуулахад арай богино өдрүүдтэй. Оюутолгойн ордын орчмын задгай тал хээр, хөндий, нам дор газар нь өвөлдөө хүйтэн, хур тунадас багатайн зэрэгцээ салхи ихтэй байдаг. Говьд их хуурайшилтай байдгаас тус газар нутагт цас бага унана. Өвлийн цагт агаарын температур -5°C -аас -34°C хооронд хэлбэлзэнэ. Хамгийн хүйтэн сар болох нэгдүгээр сард дундаж температур -12°C , үнэмлэхүй бага температур -34°C хүрнэ. Цас унавал ихэнхдээ 5 см зузаантай байна.

Ханбогд сумын чийг дулааны горим нь Монгол орны бусад бүсээс чийг бага, дулааны нөөц ихтэйгээрээ онцлог юм. Уул нуруудаар хүрээлэгдсэний улмаас чийглэг агаар орж ирэх нь ховор, үүнээс гадна салхины хурд ихтэй, үүний улмаас ховор ургамлын бүрхэвч сийрэг, газрын гадарга өдрийн цагт эрс халж, шөнө хөрч, температурын хоногийн хэлбэлзэл ихтэй. Тус сум нь уур амьсгалын хувьд хуурай мужид хамаардаг, хуурайдуу халуун зунтай, салхи шуурга ихтэй. Хавар зуны улиралд халуун салхитай, шороон шуурга ихтэй. Жилийн дундаж температур олон жилийн дунджаас илүү нэмэгдэж, хуурай болон хагас хуурай цаг агаар зонхилох болсон.

Ханбогд сумын агаарын чанар болон ургамлан бүрхэвчид нөлөөлж буй гол хүчин зүйл нь салхи юм. Түүнчлэн салхиар үлээгдсэн тоос шороо газрын гадарга, хэв маягийг өөрчилж, улмаар говийн бүс нутгийн цөлжилтийн хэмжээнд хувь нэмэр оруулж байна. Өвөлдөө (I дүгээр сар) салхины дундаж хурд Ханбогд суманд 1.7-4.4 м/сек байна. Хавар IV дүгээр сард салхины дундаж хурд 3.9-5.6 м/сек байна. Тус сум нь зөөлөн салхи (1.0-5.99 м/сек) давамгайлах боловч, арай хүчтэй салхи тохиолдох нь бий. Энэ үед салхины хурд 6.0-11.99 м/сек хүрнэ. Салхины хурд 12.0-19.99 м/сек байх үе 3, 4, 6, 9, 10 дугаар саруудад тохиолдоно.

Хөрсний өнгөн давхаргын жилийн дундаж температур 8.8°C байдаг ба зөвхөн өвлийн саруудад тэг градусаас доошилдог байна. 11 дүгээр сараас 2 дугаар сар хүртэл хөрсний дундаж температур -3.6°C -аас -13.2°C хүртэл буурдаг ба 3 дугаар сараас 10 дугаар сар хүртэлх хугацаанд $+0.3^{\circ}\text{C}$ -аас $+29^{\circ}\text{C}$ хүрдэг. Зуны их халуун саруудад хөрсний гадаргуугийн температур $+65^{\circ}\text{C}$ хүрдэг. Өвлийн цасан бүрхүүлтэй, хүйтэн өдрүүдэд хөрсөн дээр хамгийн бага температур -37°C хүрдэг.


2.1.1 Агаарын температур

Ханбогд сумын бэлчээр нь эмзэг бөгөөд бэлчээрийн талхлагдалд хялбар өртөх боломжтой. Иймээс энэ газар нутаг хүчтэй салхи шуурганд өртөмтгий. Суурь судалгаагаар

хамгийн хүчтэй салхи 3 дугаар сарын сүүлээс 4 дүгээр сарын турш хойноос чиглэлтэй тохиолдоно. Салхины дундаж хурд 4 дүгээр сард 5.5 м/сек. хүрч, жилийн бусад хугацаанд 4-6м/с-н хооронд хэлбэлзэнэ.

Агаарын жилийн дундаж температур 3-8°C, нэгдүгээр сарын агаарын дундаж температур -14.3°C, долоодугаар сарын агаарын дундаж температур +22-24°C. Их хүйтэн өдрийн тоо нутгийн ихэнхи хэсгээр 10-20 өдөр, хойд хэсгээр 20-30 өдөр -30°C ба түүнээс доош температуртай өдрийн тоо 10 хоног байна. Харин их халуун өдрийн тоо нутгийн хойд хэсгээр 20-30 өдөр, өмнөд хэсэгтээ 38-аас дээш хоног үргэлжилдэг. 30°C ба түүнээс дээш температуртай өдрийн тоо 40 хоног, нэгдүгээр сарын агаарын үнэмлэхүй бага температурын дундаж нь -30°C, долоодугаар сарын агаарын үнэмлэхүй их температурын дундаж 40°C. Хүйтрэлтгүй үеийн үргэлжлэх хугацаа нутгийн өмнөд хэсгээр 150-аас дээш бусад хэсгээр 130-150 өдөр үргэлжилдэг байна. Газар нутгийн байршлын хувьд хаана, хэдэн градус байгааг доорх зургаас харж болно.

Зураг 2. Агаарын дундаж температурын зураг




2.1.2. Хур тунадас

Ханбогд нь хуурай уур амьсгалтай бөгөөд энэ нутагт жилд унах хур тунадасны дундаж хэмжээ 80 мм байдаг ба үүний 90.0 хувь нь дулаан улиралд бороо хэлбэрээр орох бөгөөд үлдэх 10.0 хувь нь цас хэлбэрээр өвөл ордог. Бороо нь түр зуур хугацаанд ховор орох 7, 8 дугаар сард дийлэнх нь ордог. Бороо орох үед салхитай байвал салхины идэвхжлийн улмаас түр зуурын бага хэмжээний бороо тухайн нутаг дэвсгэрийн аль ч хэсэгт орж болно. Зуны хүчтэй салхитай бороо орсны дараа үер болж, хөрс ихээр эвдрэх шалтгаан болно түр

зуурын хамгийн ихдээ 43 мм хүртэл бороо орох бөгөөд жилд дунджаар ердөө 25-28 өдөр бороо орох магадлалтай, 10-15 өдөрт нь цас орно. Агаарын чийг их дутмаг, хаврын улиралд 36.0 хувь борооны саруудад 57.0 хувь чийгшилтэй болно. Ханбогд сум нь манай орны хамгийн хуурай уур амьсгалтай говийн бүст оршдог.

Хур тунадасны жилийн дундаж хэмжээ нь нутгийн өмнөд хэсгээр 50мм, төвийн болон хойд хэсгийн ихэнхи нутгаар 100-150мм байна. Хүйтний улиралд орох хур тунадасны жилийн нийлбэр хэмжээ нь өмнөд хэсгээр 5мм-ээс доош, хойд хэсгээр 5-10мм. Харин жилдээ дунджаар 10 хоног л цас ордог. Дулаан улирлын хур тунадасны жилийн нийлбэр нь өмнөд хэсэгтээ 50-аас доош бусад хэсгээр 50-100 мм, 5 мм ба түүнээс илүү хур тунадастай өдрийн тоо жилд дунджаар 10 өдөр байдаг. Тогтвортой цасан бүрхүүл үүсэх хугацаа 12 дугаар сарын 10-наас хойш тогтдог ба хоёрдугаар сарын 10-наас өмнө цасан бүрхүүл нь ханзарч эхэлдэг.


Зураг 3. Хур тунадасны зураг



2.1.3. Агаарын даралт

Агаарын даралт дунджаар 850-900 гПа, нутаг дэвсгэрийн дийлэнх хэсэгт 850-900 гПа даралттай байна. Ашигтай дулааны нийлбэр 1800-2200 хэм, хүйтрэлтгүй хоногийн тоо 90-100 хоног. Жилийн дундаж салхины хурд 4-5 м/сек, салхины хамгийн их хурд нь 40 м/сек, салхигүй өдрийн тоо 20 хоног юм. Нэгдүгээр сарын агаарын дундаж даралт 852-854 гПа, долоодугаар сарын агаарын дундаж даралт 844 гПа-аас дээш байна.

Зураг 4. Агаарын даралтын зураг




2.1.4. Агаарын чийгшил

Нэгдүгээр сарын агаарын харьцангуй чийгийн дундаж нь 39.0 хувиас доош, долоодугаар сарын агаарын харьцангуй чийгийн дундаж нь 37.0 хувиас доош байна. Харин гантай зуны давтагдал 35 хувиас дээш, газар нутгийн нийт чийгшил нь нутгийн өмнөд хэсэгт 50-100 мм, төвийн хэсэгт 150-200 мм байдаг.

Хур тунадасны жилийн дундаж хэмжээ нь нутгийн өмнөд хэсгээр 50мм, төвийн болон хойд хэсгийн ихэнхи нутгаар 100-150мм байна. Хүйтний улиралд орох хур тунадасны жилийн нийлбэр хэмжээ нь өмнөд хэсгээр 5мм-ээс доош, хойд хэсгээр 5-10мм.


Зураг 5. Чийгийн зураг



2.1.5. Нарны цацраг

Жилд нар гийгүүлэх хугацаа нутгийн өмнөд хэсгээр 3200 цагаас дээш, нутгийн төв хэсгээр 3100-3200 цаг, Жавхлант багийн зарим нутгаар 3225 цагаас дээш, хамгийн бага нь 3150-3200 Гавилууд, Баян багууд байна. 3200-аас их цаг нар тусдаг газрын хэмжээ 769419.78 мян.га, 3000-3100 цаг нар тусдаг газрын хэмжээ 61298.01 мян.га, 3100-3200 цаг нар тусдаг газар нутаг 1969367.3 мян.га байна.

Зураг 6. Нарны цацрагийн зураг



2.2. ГАЗАРЗҮЙН БАЙРШИЛ, ТОГТОЦ

Газарзүйн байрлал

Газарзүйн байршлын хувьд Ханбогд сум нь Монголын говь цөлийн бүсийн өмнөд хэсэгт байрладаг. Тус сумын нутагт Галбын говь байдаг Монгол улсдаа тэмээнийхээ тоогоор 1-рт ордог. Галбын улаан угшлын тэмээг өсгөдөг. Хээр таль, говь цөл хосолсон Ундайн говь, Байшин цав, Чингисийн уурганы нүх, Хөдөлдөг цохио, Мэлхий хад, Гурван зээрдийн агуй, 3000 хайлааст, Сэвхүүлийн элс, Хаалганы рашаан, Галбын говь зэрэг байгалийн үзэсгэлэн бүрдсэн 1515.2 кв.км нутаг дэвсгэртэй.


Үнэмлэхүй байрлал

Ханбогд сум нь Говь-Алтайн нурууны өмнөд хэсэгт оршдог. Сумын төв цэг нь $43^{\circ}11'46''$, $68^{\circ}107'11'56.13''$ солбицолд оршино. Сумын төв нь далайн төвшнөөс дээш 1114 м өндөрт, солбицолд байрладаг.

Харьцангуй байрлал

Ханбогд сум нь урд талаараа БНХАУ-тай, баруун, хойд талаараа өөрийн аймгийн Манлай, Цогтцэций, Баян-овоо сумдтай, зүүн талаараа Дорноговь аймгийн Хатанбулаг, Мандах сумдтай хил залган оршдог. Улаанбаатар хотоос 650 км, аймгийн төв Даланзагад хотоос 250 км алслагдсан байгалийн үзэсгэлэнт газар ихтэй, цаашид аялал жуулчлал хөгжих бүрэн боломжтой.

Зураг 7. Ханбогд сумын байршил



Тус сум нь Монгол улсын өмнөд хилээс 130 км, аймгийн төвөөс 252 км алслагдсан бөгөөд өмнө талаараа БНХАУ-тай, баруун талаараа Баян-Овоо, хойд талаараа Манлай, Цогтцэций, зүүн талаараа Дорноговь аймгийн Хатанбулаг сумтай хил залгана. Сумын нутаг дэвсгэрт Ханбогд, Жавхлант, Алагбаян, Сангастай, Хоёрхасар, Галба, Гавилуут зэрэг өндөрлөг бэсрэг уул нуруудтай, 100-130 км үргэлжилсэн Галбын говь, Дайчингийн говь, Сэвхүүлийн хоолойн элсэн далан, заган шугуй, Уртын гол, Ундайн гол, Халзан хайлаастын гол гэх зэрэг хайлаасан зурвасуудтай, янз бүрийн хэлбэр дүрс бүхий боржин чулуун цохиотой. Тогоо, Гурван зээрд, Ухаа аргалантын агуйнууд зэрэг байгалийн өвөрмөц тогтоц бүхий газруудтай.


Хилийн цэс

Тус сумын хамгийн их газар нутагтай баг нь Жавхлант, хамгийн бага нь Гавилууд багууд юм. Сумын хилийн шугамны нийт урт 1002.1 км байна.

Хүснэгт 2. Багуудын талбайн хэмжээ, эзлэх хувь

№	Багын нэр	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь	Хилийн урт, км
1	Баян баг	248239.9	16.6	220.0
2	Номгон баг	482888.2	32.3	302.9
3	Гавилууд баг	198989.8	13.3	186.0
4	Жавхлант баг	531472.7	35.5	293.3
5	Сумын хэмжээгээр	1496322.6	100	501.3

Зураг 8. Сумын хилийн цэсийн зураг




2.3. ГАЗРЫН ГАДАРГА

2.3.1. Уулзүй

Газарзүйн байршлын хувьд Ханбогд сум нь Монголын говь цөлийн бүсийн өмнөд хэсэгт байрладаг ба Ханбогд уулын орчимд орших говийн намхан толгодоос тогтдог. Тухайн сум нь говийн бүсдээ харьцангуй өндөрт тооцогдох уулуудтай ба үүнд Ханбогд уул (д.т.д 1350 м), Бумбат задгайн хяр (д.т.д 1233.3 м), Жавхлант уул 1295 м (д.т.д), Далайн Дуулга (д.т.д 1266 м) зэрэг уулс орно.


Зураг 9. Газрын гадаргын зураг



2.3.2. Өндөржилт

Ханбогд сумын нутагт 1400 метрээс дээш өндөртэй уулс оршино. Сумын баруун хойд хэсэг нь тэгш тал, түүнээс ялимгүй урд хэсгээр цав толгод байдаг. Голын хурдаст тал нь нутгийн хойд хэсгийн багахан нутгаар зурвас байдлаар оршино. Нутгийн өмнөд хэсгийн нилээдгүй талбайд жижиг толгод бүхий нам уулстай.


Зураг 10. Сумын өндөржилтийн зураг



Хүснэгт 3. Өндөржилтийн хэмжээ, талбайн хэмжээ

№	Өндөржилт	Талбай/га/	Эзлэх хувь
1	914	238044.8605	15.9
2	967	328762.4586	22.0
3	1023	271749.4784	18.2
4	1083	208740.7344	14.0
5	1146	173230.1908	11.6
6	1216	154475.2502	10.3
7	1301	91791.85782	6.1
8	1460	29393.3354	2.0
Нийт		1496188.166	100.0

Диаграм 1. Гадаргын гистометрийн зүсэлт




Сумын нутаг дэвсгэрийн баруун хойд цэг (Шавагийн толгой)-ээс зүүн урд цэг (Шаруул) хүртэл 165 км, зүүн хойд цэг (Баруун хонгилухаа)-ээс баруун урд цэг (Олон хайлаастын сайр) хүртэл 176.39 км, хойд цэг (Талын бор толгой)-ээс урд цэг (Хуц уул) хүртэл 120.7 км зайтай бөгөөд газрын гадаргын зүсэлт хийж үзэхэд нутгийн зүүн хойд хэсэгт уул нуруудтай, баруун тийшээ намсан намуулын тогтоцтой байна.

2.3.3. Гадаргын налуу

Энэ сумын нутгийн газрын хэвгийн зонхилох өнцөг нь Цагаан толгой уул очмоор 1-2°, Шавагт уул орчмоор 5-6°-аас дээш, Ханбогд 1-2° уул очмоор байх ба бусад нутгаар 3-4° байдаг. Үүнээс үзэхэд байшин барилга, зам тээвэр хөгжүүлэхэд гадаргын хувьд таатай нөхцөлтэй юм.

Зураг 11. Гадаргын налуужилтын зураг



Хүснэгт 4. Газрын хэвгийн хэмжээ, эзлэх талбай, хувь


№	Гадаргын хэвгий	Талбай/га/	Эзлэх хувь
1	1	425478.82	28.6
2	2	427728.95	28.7
3	3	324005.23	21.7
4	4	179931.09	12.1
5	5	83918.92	5.6
6	7	33505.51	2.2
7	10	10452.61	0.7
8	16	3765.78	0.3
9	42	1012.72	0.1
Нийт		1489799.62	100.0

2.3.4. Гадаргын зүг зовхис

Гадаргын зүг зовхисыг тооцож гаргаснаар түүнийг тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөлтөнд ашиглах ба нийгэм, эдийн засгийн тодорхой ач холбогдолыг агуулж байдаг. Сумын нутаг дэвсгэрийн 12.7 хувийг хойд буюу 337.5-360 градусын зүг зовхис, 12.8 хувийг урд буюу 157.5-202.5 градусын зүг зовхис, 14.5 хувийг зүүн буюу 67.5-112.5 градусын зүг

зовхис, 10.2 хувийг баруун буюу 247.5-292.5 градусын зүг зовхис бүхий газрын гадарга эзэлж байна.

Зураг 12. Зүг зовхисын зураг




Хүснэгт 5. Зүг зовхисын градус, талбайн хэмжээ

№	Зүг зовхис (градус)	Талбай/га/	Эзлэх хувь
1	Тэгш(-1)	7648.62	0.5
2	Хойд(0-22.5)	113472.22	7.6
3	Зүүн хойд(22.5-67.5)	200763.79	13.4
4	Зүүн (67.5-112.5)	216411.53	14.5
5	Зүүн урд (112.5-157.5)	212541.82	14.2
6	Урд (157.5-202.5)	191307.15	12.8
7	Баруун урд(202.5-247.5)	157906.43	10.6
8	Баруун(247.5-292.5)	152906.42	10.2
9	Баруун хойд (292.5-337.5)	166851.97	11.2
10	Хойд(337.5-360)	76372.15	5.1

2.3.5. Ханбогд сумын хиймэл дагуулын зураг

Энэхүү зураг Ландсат 8 хиймэл дагуулын 30 м-ийн нарийвчлалтай 2015 оны 8 дугаар сарын зураг бөгөөд уг хиймэл дагуулын мэдээний 4, 3, 2 дугаар сувгуудын мэдээг ашиглан байгалийн өнгөөр харуулсан болно.

Зураг 13. Ландсат 8 хиймэл дагуулын зураг



2.4. ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ

Ханбогд сум нь говийн бор хөрс, цөлийн бор саарал хөрсний бүст хамрагдана. Тус сумын нутаг дэвсгэрийн хөрс нь үндсэндээ сул хөгжилтэй, говийн сийрэг тархсан (бүрхэц 8-25хувь) ургамлан нөмрөгийн дор бүрэлдэн тогтсон хөрс зонхилно. Хөрсөн дэх органик бодисын агууламж нь 1.0 хувиас бага, сул шүлтлэг, шүлтлэг чанар нь кальци, магнийн катионуудын концентрациас хамаарч, хөрсний давхарга бүрт харилцан адилгүй байна.

Цөлийн бор саарал хөрс бүрэлдэх явц нь бусад төрлийн хөрснүүдээс ялгаатай байдаг. Учир нь говийн хуурай цаг уур болон ховор тохиолдох хур тунадас зэргээс шалтгаалж, хөрсний 80.0 хувь нь эрдэсжсэн байдаг. Хөрсний шинж чанар нь натрийн карбонат, бусад хэлбэрийн карбонат, ууссан давс, шохойлогтой эсэхээс хамаарч тодорхойлогдоно. Судлаачид говийн хөрс тогтворжиход хөрсний чийгийн горим их нөлөө үзүүлсэн гэж үздэг. Түүний нөлөөгөөр хөрсний өнгөн хэсэг дээр карбонат, биокарбонат хуримтлагдаж, давс агуулсан нимгэн шаварлаг үе бий болдог.

Говийн хөрс нь өвлийн цагт өнгөн хэсэгтээ 1-1.5 м гүнд хүртэл хөлдөнө. Улирлаас хамааран жилд 6-7 сарын турш урт удаан хугацаанд хөлдөнө. Дулааны улиралд бороо чийг ихтэй үед хөрсөн дэх биологийн идэвхи ихээхэн дээшилдэг. Давсны өндөр агууламж, органик бодисын бага агууламж, хөрсний шүлтлэг чанар нь хөрсийг салхи, усны элэгдэлд амархан өртөх болон хурдан тархахад хүргэдэг. Энэ нь тухайн нутаг дэвсгэр элэгдэл, эвдрэлд өртөхөд голлох нөлөө үзүүлэх хүчин зүйл болно.

Бороо ороход борооны ус 20-25 см гүн хүртэл нэвчих ба нэвчилт ихтэй газрууддаа 25 см-ээс ч илүү гүнд нэвчдэг. Энэхүү борооны дараах газрын гүнд нэвчсэн чийг нь тухайн нутаг дэвсгэрийн ургамлан бүрхэвчийн ургах нөхцөлийг хангахад чухал байдаг. Тухайн тэгш газарт говийн цайвар бор хөрсний 7 төрөл, ухаа, гүвээ толгодын цайвар бор хөрсний 3 төрөл, нугат чийглэг цайвар бор хөрсний 2 төрлийн хөрс тархана. Хөрсний төрлүүдэд хийсэн шинжилгээний үр дүнг дор тодорхойлов:

Толгодын шавранцар, карбонатлаг, цайвар бор хөрс

Тухайн нутгийн ухаа гүвээ толгодын хөрс нь цөлийн хөрсний шинжийг агуулсан байдаг. “Оюутолгой” ХХК-ны орчмын гүвээ толгод нь дунджаар д.т.д 1142-1194м буюу ойролцоогоор 1100-1200м өндөрт байрлана. Тэнд ургамлан нөмрөг хомс бөгөөд делювийн карбонатлаг хурдас дээр зөвхөн хуурай хээрийн ургамал ургасан байдаг.

Хөрс өнгөн гадарга дээрээ нимгэн шаварлаг үетэй. А давхрага нь 3см зузаантай цайвар бороос саарал өнгөтэй, органик бодисгүй байх нь элбэг. Энэ нь В давхрагаас эрс ялгагдах бөгөөд В давхрага нь нягт, маш хуурай, улаавтар туяатай өнгөтэй юм.

Хүснэгт 6. Ухаа гүвээ, толгодын шавранцар, карбонатлаг, цайвар бор хөрсний гол үзүүлэлт

No	Хөрсний зузаан	Шаварлагийн агууламж, хувь	рН	100 г хөрсөнд агуулагдах агууламж	
				Фосфор	Кали
1	3-5 см	24	7.9-8.2	1.3 мг	20 мг

Гүвээ, толгодын элсэнцэр, чулуурхаг, карбонатлаг, цайвар бор хөрс

Энэ төрлийн хөрсний гарал үүсэл, тархалт нь дээр дурдсан хөрстэй төсөөтэй бөгөөд харин механик бүрэлдэхүүнээрээ өөр өөр байдаг. Наангилаг нарийн ширхэгтэй хэсгийн эзлэх хувь 10-20 хувийн хооронд хэлбэлзэнэ.

Хөрс шүлтлэг орчинтой. Хөдөлгөөнт хэлбэр дэх фосфорын хэмжээ 1.2мг, хөдөлгөөнт кальцийн катион ихээхэн хэмжээтэй юм. Гүвээ толгодод тархсан хөрс нь газар тариаланд, ХАА-д төдийлөн тохиромжгүй бөгөөд харин түр зуурын бэлчээрт ашиглаж болох юм.

Хүснэгт 7. Гүвээ, толгодын элсэнцэр, чулуурхаг, карбонатлаг, цайвар бор хөрсний гол үзүүлэлт

No	Хөрсний зузаан	Шаварлагийн агууламж, хувь	рН	100 г хөрсөнд агуулагдах агууламж	
				Фосфор	Кали
1	5-7 см	10-20	8.2	1.2 мг	17 мг

Хайргархаг шаварлаг, карбонатлаг, цайвар бор хөрс

Энэ хэв шинжийн хөрсөнд хог ургамал зонхилсон өвслөг ургамал ургах бөгөөд карбонатлаг байранд хурдсын өгөршлийн үйрмэг чулуу нэлээд агуулагдана. Хөрсний гадаргыг 0.3-0.6см зузаантай нарийн ширхэгтэй шавар бүрхэн хучсан байдаг. Энэ нимгэн үеийн доор нь тод өнгийн 12см зузаантай, хуурай, нягт А давхарга залган оршино. Энэ

давхарга нь бөөмөрхөг бүтэцтэй ба ихэнхдээ үндэсгүй байдаг. В давхарга нь маш нягт, хатуу бөгөөд улаан өнгөтэй.

Хүснэгт 8. Хайргархаг шаварлаг, карбонатлаг, цайвар бор хөрсний гол үзүүлэлт

No	Хөрсний зузаан	Шаварлагийн агууламж, хувь	pH	100 г хөрсөнд агуулагдах агууламж	
				Фосфор	Кали
1	5-7 см	10-20	8.5-9.2	1.2 мг	21 мг

Хайргархаг, элсэнцэр, карбонатлаг, давсархаг говийн цайвар бор хөрс

Энэ хэв шинжийн хөрс нь өмнө бичсэн хэв шинжийн хөрснүүдийн гарал үүсэл, тархацтай төстэй боловч гадарга дээрээ үйрмэг чулуу ихтэй, нэлээд элэгдэж эвдэрсэнээрээ ялгаатай юм. Шингээгдсэн сууриудын нийлбэр 27.2-34.5мг/100 г-экв хүрэх бөгөөд кальци магнийн эзлэх хувь нь бараг ижил байдаг. Элсний агуулагдах хэмжээ 13.2-19.2хувь хүрнэ. Нийт азотын хэмжээ 0.01-0.09хувь байгаа нь энэ хөрс ялзмагийн агууламж нэн багатайг харуулна.

Хүснэгт 9. Хайргархаг, элсэнцэр, карбонатлаг, давсархаг говийн цайвар бор хөрс

No	Ялзмагт үеийн зузаан	Ялзмагийн агууламж, хувь	pH	100 г хөрсөнд агуулагдах агууламж	
				Фосфор	Кали
1	12 см	0.58-0.67	8.2-8.4	1.0 мг	17 мг

Элсэн хучаас бүхий давсархаг, говийн цайвар бор хөрс

Энэ хэв шинжийн хөрсний тархсан байдал нь өмнө дурдсан хөрсүүдээс ихээхэн ялгаатай. Энэ хөрс нь голын хөндийд нэлээд их өвс ургамал, бут сөөгтэй газарт тархдаг. Хөрсний гадарга дээр нарийн ширхэгтэй, шаварлаг бүрхээгүй байдаг. Энэ хөрс нь элснээс бүрдсэн 10см зузаан А үе давхаргатай. Хөрсний өнгөн хэсэгт 10хувь давсны хүчилд бургихгүй, харин хөрсний доод шороолог хэсэгт бургина. Энэ хөрс бага зэрэг шүлтлэг. Ялзмагийн хэмжээ хөрсний өнгөн хэсэгт бага бөгөөд доошлох тутам нэмэгдэнэ.

Хүснэгт 10. Элсэн хучаас бүхий давсархаг, говийн цайвар бор хөрс

No	Хөрсний зузаан	Шаварлагийн агууламж, хувь	pH	100 г хөрсөнд агуулагдах агууламж	
				Фосфор	Кали
1	10 см	10-20	8.2	1.2 мг	21 мг

Чулуурхаг, карбонатлаг, давсархаг, хээришсэн нугат-цайвар бор хөрс

Хээришсэн нугат цайвар бор хөрс нь салхи усны нөлөөгөөр тогтворжсон хөрсний хэвшинжид багтах бөгөөд түр зуурын голын сайрын аллювын ба бэлийн хурдастай газарт тархсан байдаг. Ийм хөрс тархсан газарт өвслөг бут сөөг зонхилон ургана. Хөрсний гадарга дээр 3-8см зузаантай аллювын элсэн хучаас, мөн 2-3см зузаантай нарийн ширхэгт шаварлаг хучаас тогтсон байдаг. Ялзмагт А давхрагад карбонатлаг давсны ба зосорхог улаан төмрийн ислийн толбууд ажиглагдана. Ялзмагт үе давхарга 10-12см зузаан, ялзмагийн хэмжээ ялзмагт өнгөн хэсэгт 0.56-0.67хувь, нийт азот 0.08-0.16.0 хувь хүрнэ. Хөрсний урвалын орчин

pH=8.0-8.1 байна. Шингээгдсэн сууриудын хэмжээ үе давхарга бүрт өөр өөр бөгөөд 15.0-36.0мг-экв/100г-ийн хооронд хэлбэлзэнэ. Энэ хэв шинжийн хөрс тогтворжилт нь хур борооны байдлаас ихээхэн шалтгаалдаг.

Хүснэгт 11. Чулуурхаг, карбонатлаг, давсархаг, хээршсэн нугат-цайвар бор хөрс

No	Хөрсний зузаан	Шаварлагийн агууламж, хувь	pH	100 г хөрсөнд агуулагдах агууламж	
				Фосфор	Кали
1	10-12 см	0.56 – 0.67	8.0-8.1	1.2 мг	21 мг

Элсэн манхан доорх үйрмэг чулуутай, карбонатлаг, давсархаг, хээршсэн нугат-цайвар бор хөрс

Энэ хэв шинжийн хөрс нь 10см-ээс илүү зузаантай элсэн хучаастай байдаг. Энэ элс нь ихээхэн хөдөлгөөнтэй нүүдэг бөгөөд элсний зузаан нь хавар, намрын салхины чиглэлээс шалтгаалан ихээхэн хэлбэлзэнэ. Энэ хэв шинжийн хөрс нь бүтэц тааруу, шим тэжээлийн бодис багатай тул үржил шимээр бага хөрсөнд тооцогдоно. Шал хөрсний тархац, шинж чанар нь ихээхэн онцлогтой. Шал хөрс нь хөндийн голдирол, хотос, нам хэсэгт тааралдана. Шал хөрсний гадарга нь хавар зуны халиа, шар усанд байнга өртөж байдаг бөгөөд энэ нь уул хөрс бүрэлдэн тогтох гол хүчин зүйл болж өгдөг. Шал хөрсөнд хөрсний үе давхрагууд байдаггүй юм. Шал хөрстэй газар нь эрт дээр үед ургамалд тэжээл, байгалийн бордоо болж өгдөг байв. Харин одоо тэнд давс их, шим тэжээлийн бодис багатай болсны улмаас түүнийг ашиглах нь ховор болсон. “Оюутолгой” ХХК-ны орчим дах ийм шал хөрс нь NaCl, CaCl₂, MgCl₂, FeCl₃, AlCl₃ зэрэг хлорт нэгдэл агуулдаг.

Хүснэгт 12. Хайргархаг нугын хээршсэн цайвар бор хөрсний гол үзүүлэлт

No	Хөрсний зузаан	Шаварлагийн агууламж (хувь)	pH	100 г хөрсөнд агуулагдах агууламж	
				Фосфор	Кали
1	1-3 см	0.65	8.4-9.2	1.2 мг	21 мг

Эх үүсвэр:

1. 2003 оны 7,8 дугаар сард хийсэн Оюутолгойн төслийн хөрсний хээрийн судалгаа.
2. 2003 оны хээрийн судалгааны үе давсан Оюутолгойорчмын хөрсний дээжийн лабораторийн шинжилгээ.

Хөрс нь уур амьсгалын онцлогтой холбогдон нимгэн, хуурай, элсэрхэг байдгаас гадна шим тэжээл муутай, салхины үйлдлээр хөрсний нарийн ширхэгээр тоос хийсч, хайр,сайр, чулуулгаар бүрхээстэй байна. Үржил шим багатай учраас газар тариаланд тохиромж муутай.

Говийн гандуу хуурай хөрс нь салхинд элэгдэхээс гадна малын хөл болон машин замд сүйтгэгдэнэ. Элэгдлээс болж хөрс хомсдох нь ургамалжилтын олон янз байдал хомсдож, экологийн бүтэц өөрчлөгдөж, бэлчээрийн үржил шимт байдал буурахад хүргэнэ. Энэ асуудал

машин унаа явах зассан зам байхгүй, мөн бэлчээр ихээр талхлагдсан тус газар нутагт хурцаар тавигдаж байна.

Цөлийн бор саарал хөрсний гадаргуу дээр үүссэн нарийн ширхэг бүхий лаг шавар давхарга нь салхины элэгдлээс хамгаалах хуяг болж өгдөг. Энэхүү гадаргын хуяг нь газрын өнгөн давхаргын хязгаарлагдмал органик бодисуудыг тогтоон барьдаг. Энэхүү өнгөн хөрсний хуягийг сүйтгэх нь салхины элэгдлийн үед дэд хөрс ил гарч, органик болон тэжээлийн агууламж багасч, хөрсний бүтэц алдагдахад хүргэдэг. Үр, үндэс нь ил гарснаас болж ургамалжилтын нөхөн төлжих чадавхи салхины элэгдлийн үед мөн хомсдоно.

Хөрсөнд бэлчээрийн талхлагдлаас хурдассан говийн бүсийн цөлжих процесс ихээр нөлөөлж байна. Ханбогд суманд мал ихээр бөөгнөрсөн нь бэлчээрийн даац 3 дахин хэтэрсэн байна. Мөн хүнд даацын автомашинууд олон салаа зам гаргаж газрын хөрсийг доройтуулж байна. Уурхайн хайгуулын орчмын талбайд урьд өмнө нь үүссэн машин зам болон хаа сайгүй гаргасан шинэ зам бүхий хөрс нь хавар, намрын хүчтэй салхинд овойж өргөгдөж хөрс сүйтгэгдэж байна. Тухайлбал өрөмдлөгийн газраас КЭМП-д хүрэхэд 13 хүртэл салаа зам гарсан байна.

Ундай, Будаа, Мааньт голын голдирол нь цөлийн нүцгэн талын элсэрхэг өнгөц хөрсийг элэгдүүлж байна. Цөлийн цайвар бор хөрс нь түр зуурын бага хэмжээний борооны дараа усны элэгдэлд өртөмтгий болдог. Хөрс нь сүйтгэгдсэн болон ургамлан бүрхэвч багатай газарт усны элэгдэл эрчимтэй явагдаж байна.

2.4.1. Хөрсний чулуулаг

Сумын нутаг дэвсгэрийн нилээд хувийг буюу 56.0 хувьд нь делювийн хурдас, чулуулаг эзэлж байна.

Аллювийн хурдас: нийт нутгийн 7.0хувьд тархсан байна Энэ хурдасын гарал үүсэл нь дээрх хурдсуудаас өөр байдаг. Энэ хурдас усны нөлөөгөөр үүсч, чулуурхаг хэсгүүд нь бөөрөнхий, хурц ирмэггүй байх бөгөөд нам дор, чийглэг газраар ихэвчлэн үүснэ.

Делювийн хурдас нь: Уул толгодын хоорондох өргөн, нарийн хөндий, уулын хормой бэл, хужирлаг мараат нуга зэрэг газраар тархана. Энэ хурдас нь байгалийн янз бүрийн хүчин зүйлийн /салхи, ус, газар хөдлөлт/ нөлөөгөөр нэг байрнаас нөгөө байранд шилжин гулсах замаар анхныхаа байршлыг өөрчилдөг онцлогтой. Хурдсын бүрэлдэхүүнд элс хайрга, шавар жижиг чулуу, хурц ирмэг бүхий чулуулгууд хамрагдана.

Делювийн хурдас гол төлөв карбонатлаг шинж чанартай байхаас гадна түүний орчин нь гол төлөв шүлтлэгдүү байна. Энэ хурдсан дээр ихэнх тохиолдолд цайвар хүрэн, цөлөрхөг хээрийн бор, цайвар бор, цөлийн бор саарал нугын хөрсний янз дүрсүүд тархжээ. Механик бүрэлдэхүүний хувьд тоос ба элс давамгайлсан шавранцар эсвэл элсэрхэг ба элсэнцэр байдаг.

Ийм хурдас нь нилээд зузаантайгаар хотгор газраар тархах ба голдуу карбонатлаг байна. Карбонат дах нүүрс хүчлийн агууламж үлэмж их.


Элюви-делювийн хурдас нь: нийт нутгийн 27.5 хувьд тархсан байна. Делювийн болон элювийн процессын хосолмол үр дүнд үүссэн ба үе давхаргын зузаан харьцангүй богино, голдуу элс давамгайлсан элсэнцэрээс хөнгөн шавранцар заримдаа үйрмэг чулуутай холимог элсэн механик бүрэлдэхүүнтэй.

Эоловийн хурдас нь: нутгийн 13.6 хувьд тархжээ. Эоловийн элс саарлавтар шар өнгөтэй, сийрэг, нарийн ширхэгтэй элснээс үүснэ. Зарим газраар 15-20 м зузаан байх бөгөөд шингээх сууриудын эзэлхүүн маш бага байна.

Хүснэгт 13. Сумын хөрс үүсгэгч эх чулуулаг, талбайн хэмжээ

№	Код	Хөрс үүсгэгч эх чулуулаг	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь
1	801	Аллювийн хурдас	97278.8	7.0
2	802	Делювийн хурдас	879924.15	59.0
3	804	Элюви-делювийн хурдас	94357.3	6.0
4	808	Элювийн хурдас	292306.4	20.0
5	809	Эоловийн хурдас	132184.6	9.0
Нийт			1496051.25	100.0

Зураг 14. Хөрс үүсгэгч чулуулгийн зураг




2.4.2. Хөрсний хэв шинж

Сумын хөрсөн бүрхэвчийн хувьд хамгийн түгээмэл тархсан хөрс нь цөлийн бор саарал хөрс 54.77 хувь, хээржүүцөлөрхөг хээрийн бор хөрс 13.33 хувь, цөлөрхөг хээрийн нугат далд глейрхэг бор хөрс 6.67, нугын хужир /Чийгт хэлбэрийн хужир/ хөрс 0.03, уулын цөлийн бор саарал хөрс 22.74 хувийг эзэлж байна.

Хүснэгт 14. Хөрсний хэв шинжийн ангилал, талбайн хэмжээ

№	Хөрсний код	Хөрсний нэр	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь
1	1601	Уулын цөлөрхөг хээрийн бор хөрс	35994.5	2.47
2	1602	Уулын цөлийн бор саарал хөрс	331695.1	22.74
3	2301	Цөлөрхөг хээрийн бор хөрс	194521	13.33
4	2303	Цөлөрхөг хээрийн нугат далд глейрхэг бор хөрс	97278.8	6.67
5	2305	Цөлийн бор саарал хөрс	798946.8	54.77
6	3302	Нугын хужир /Чийгт хэлбэрийн хужир/ хөрс	401.8	0.03
Нийт			1458838	100

Зураг 15. Хөрсний хэв шинж



Цөлийн бор саарал хөрс:

Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 1149232.0 га буюу нутаг дэвсгэрийн 41.04 хувийг эзлэн тархсан байна. Тус хөрс нь цайвар бор өнгөтэй, сулхан нягтарсан, ихээхэн хуурай, тоосонцор хэврэг бөөмөнцөр бүтэцтэй ургамлын үндсээр сийрэг, жижиг үйрмэг сайр

чулуу ихтэй, маш их карбонатлаг механик бүрэлдэхүүн нь элсэнцэр шилжилт тод ажиглагддаг.

Ялзмагт үедээ физик шаврын агууламж 10.3-13.12 хувь буюу дунджаар 11.71 хувь ялзмаг 0.7-1.6 хувь буюу дунджаар 1.1 хувь, ерөнхий азот 0.03-0.05 хувь буюу дунджаар 0.04 хувь, 100 гр хөрсөнд фосфор 0.8-1.04мг буюу дунджаар 0.92 мг, кали 8.86-19.19 мг буюу дунджаар 14.02 мг бөгөөд байгалийн үржил шимээр ядмаг байна.

Хээржүү цөлийн цайвар бор хөрс:

Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 1135345.5 га буюу нутаг дэвсгэрийн 40.5 хувийг эзлэн тархсан байна.

Цайвар бор өнгөтэй, тоосорхог элсэнцэр механикийн бүрэлдэхүүнтэй, маш хэврэг бөөмөрхөг маягийн бүтэцтэй, сийрэгдүү тогтоцтой, ургамлын үндэс маш бага, карбонаттай, бага зэрэг чулуурхаг, чийг бага дараагийн В давхрагадаа өнгөөрөө тод шилжинэ. В үе давхрагадаа шаргал туяатай бор өнгөтэй, элсэнцэр механикийн бүрэлдэхүүнтэй, бөөмөн маягийн бүтэцтэй, нягтавтар тогтоцтой, карбонаттай, ургамлын үндэс маш бага, бага зэрэг чулуурхаг.

Ялзмаг 0.7-1.0 хувь буюу дундажаар 0.8 хувь, ерөнхий азот 0.03-0.07 хувь буюу дундажаар 0.05 хувь, 100 гр хөрсөнд фосфор 0.76-1.44 мг буюу дунджаар 1.17 мг, кали 12.24-20.04 мг буюу дундажаар 16.47 мг, кальци магнийн нийлбэр 25.5-91.8 мг/экв буюу дунджаар 65.02 мг/экв байгаа нь байгалийн үржил шимээр ядмаг байна.

Уулын цөлийн бор саарал хөрс:

Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 372858.3 га буюу нутаг дэвсгэрийн 13.3 хувийг эзлэн тархсан байна.


Бор сааралдуу цайвар өнгөтэй, сийрэг хуурай, ургамлын үндэс бага, механик бүрэлдэхүүн элсэнцэр, дараагийн үед өнгөөрөө аажим шилжинэ. В үе давхрага нь цайвар бор өнгөтэй, хуурайвтар ургамлын үндэс бага, хөнгөн шавранцар, давсны хүчилд буцална. Дараагийн үед өнгөөрөө тод шилжинэ.

Механикийн бүрэлдэхүүн буюу физик шаврын агууламж нь дээд үедээ 20.6-27.0 хувь буюу дунджаар 14.75 хувь, хөрсний орчин РН 7.9, ялзмагийн агууламж 0.4-0.8 хувь буюу дунджаар 0.6 хувь, ерөнхий азот 0.0-0.015 хувь, 100 гр хөрсөнд дунджаар солилцох кали 19.44 мг, хөдөлгөөнт фосфор 199мг, шингээгдсэн сууриудын нийлбэр 76.43мг/экв байна. Энэ хөрс агрохимийн шинж чанараараа үржил шимийн хувьд маш ядуу доогуур байна.

2.4.3. Хөрсний механик бүрэлдэхүүн

Ханбогд сумын нутаг дэвсгэрийн 43.64хувь элсэнцэр, 2.49хувь элс, 53.85хувь хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнээр эзлэн тархсан байна.

Зураг 16. Хөрсний механик бүрэлдэхүүний зураг



Хүснэгт 15. Хөрсний механик бүрэлдэхүүний төрөл, талбайн хэмжээ

№	Код	Төрөл	Талбайн хэмжээ /га/	Нийт нутаг дэвсгэрт ЭЗЛЭХ ХУВЬ
1	64	Хөнгөн шавранцар	805586.36	53.85
2	65	Дунд шавранцар	404.89	0.03
3	66	Элсэнцэр	652850.05	43.64
4	67	Элс	37213.6	2.49
Нийт			1496054.9	100.0

2.5. УРГАМАЛЖИЛТ

2.5.1. Өмнөговь аймгийн Ханбогд сумын бэлчээрийн ургамалжилт

Судалгааны материал.

Бид 2017 оны 7 сарын сүүлийн 10 хоногт Ханбогд сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд хээрийн судалгаагаар 39 цэгт зүйлийн бичиглэл хийж, нийт 161 зүйл ургамлын фото зургаар баталгаажуулсан материал цуглуулсан.

Хүснэгт 16. Хээрийн судалгааны явцад материал цуглуулсан судалгааны цэгийн солбицол

1	N43°09'22.4" E 106°32'38.8", h 1297	Ханбогд орох замд
2	N43°02'25.6" E 106°43'07.6", h 1247	Оюутолгойн баруун толгод
3	N43°03'36.2" E 106°44'51.0", h 1219	Оюутолгойн дэргэд хөндий




4	N43°04'59.9" E 106°52'45.6", h 1211	Оюутолгой орчим
5	N43°06'31.7" E 106°54'06.9", h 1187	Оюутолгой орчим
6	N43°11'39.3" E 107°01'41.4", h 1136	Оюутолгой орчим
7	N43°11'39.2" E 107°01'41.6", h 1187	Дэмчог хийд
8	N43°07'12.9" E 107°00'35.5", h 1186	Хийдээс баруун
9	N42°52'05.4" E 107°10'20.1", h 1040	Оюутолгойгоос урагш зам дагуу
10	N42°51'11.2" E 107°17'37.7", h 1995	Оюутолгойгоос урагш зам дагуу
11	N42°52'26.2" E 107°20'07.2", h 982	Галбын говь
12	N42°53'03.9" E 107°22'47.0", h 968	Галбын говь
13	N42°53'05.5" E 107°23'07.3", h 968	Галбын говь
14	N42°53'59.9" E 107°23'04.2", h 973	Хайлаасан төгөл
15	N42°53'11.6" E 107°24'31.8", h 969	Баг мод
16	N42°49'57.8" E 107°26'18.6", h 957	уул уруу явах замд
17	N42°49'33.6" E 107°29'20.2", h 937	Номгон уулын ар хөндий
18	N42°48'08.8" E 107°40'50.7", h 961	Толгод
19	N42°47'34.2" E 107°41'33.4", h 956	Номгон уулын ар хормой
20	N42°46'31.5" E 107°43'56.6", h 1057	Номгон уул
21	N42°45'34.8" E 107°40'46.5", h 975	Номгон уулын баруун хөндий
22	N42°36'00.2" E 107°32'46.4", h 1002	Цагаан хад
23	N42°35'59.2" E 107°32'45.9", h 887	Ханбогд, Булан сухайт
24	N42°32'22.5" E 107°11'18.5", h 932	Мөндөрт цохиулсан заган ой
25	N42°34'31.3" E 107°11'40.9", h 926	Дайчингийн загийнзүүн хоолой
26	N42°36'04.5" E 107°08'50.0", h 951	Баглуурт цөл
27	N42°35'08.1" E 107°06'46.9", h 942	Тойром
28	N42°34'57.2" E 107°06'21.9", h 949	Нуур үүссэн
29	N42°34'09.1", E 107°03'12.8", h 950	Үерт автсан газар дуусав.
30	N42°33'53.3" E 107°02'02.4", h 953	Хайлаастай
31	N42°32'04.3" E 107°54'41.9", h 934	Шинэ усны худаг, Дайчингийн заг
32	N42°32'02.9" E 107°54'32.9", h 935	<i>Zygophyllum potaninii</i>
33	N42°31'47.2" E 106°49'58.2", h 915	Дайчингийн загийн зүүн хэсэг
34	N42°32'58.9" E 106°40'12.7", h 943	шар мод-холимог сөөгт
35	N42°34'06.2" E 106°38'36.8", h 949	Дайчингийн загийн баруун хойд хэсэг
36	N42°37'38.0" E 106°39'48.5", h 988	Баян-Овоо

37	N42°37'42.2" E 106°40'06.2", h 1019	Баян-Овоо, уулын гаралтай сайр, хайлаастай
38		Уртын голын тооройн бүрд

Газрын төлөв байдал. Өмнөговь аймгийн Ханбогд сум 1496441.3 га талбайтай, газар нутгийн ихэнх хэсгийг говь (56.6%), уул толгод (25.3%), хужир мараатай хотос (1.6%), элс (3.7%), Заг (9.7%) эзэлдэг бөгөөд Өмнөговь аймгийн хэмжээнд газрын төлөв байдлыг ерөнхийд нь төлөөлж чадахуйц нутаг юм.

Диаграм 2. Газрын төлөв байдал



Ургамал газар зүйн мужлалын хувьд Ханбогд сумын нутгийн ургамлын аймгийн хувьд баруун хойд хэсэг нь Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт үлдсэн ихэнх хэсэг нь Алашаа говийн цөлийн тойрогт хамаарагдана [17].

Уг сумын нутгийн бэлчээрийн ургамалжилт Зэрэгцээ толгой, Их Хонгор уул орчимд Баглуур-Монгол өвст, Баглуур-бударганат, цөлжилтийн нөлөөтэй уулсаар (Дэмчог хийд орчим, Ханбогд уул, Дөрвөлжин Толгой орчимд) болон цөлийн уулсаар (Номгон уул) Шар мод- баглуурт хэвшил зонхилно. Таван толгойн талаар Баглуур-Монгол өвст, тэсэгтэй, шар модот, Хээгийн элс, Гүний элсэн талаар Хазаар өвс-тэсэгт, Тэсэг-хойргот хэвшилтэй бол Галбын говиор Баглуурт цөл, Арзгар хамрагт цөл зонхилно. Уртын гол, Бага мод, Умдайн сайр, Цагаан Хад, Дайчингийн заг зэрэг нэн ховор, ховор, унаган, эмийн ашигт ургамал ихтэй газрууд олон байдаг байна.

Ханбогд сумын ургамлын аймагт 2017 онд бид 35 овог, 100 төрөл, 161 зүйл бүртгэсэн нь цөл судлаач Санчидын бүртгэсэн 242 зүйл ургамлын 66.5% болж байна.

Дээрх бүлгэмдлүүдэд 10м² талбайдаа 8-35 зүйлтэй, 1м² талбайд 3-10 зүйл ургамалтай, Баглуур, шар мод, хотир, Монгол өвс, таана, бударгана, тэсэг зонхилсон, доройтсон бэлчээртээ Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Mey.), Харлаг үмхий өвс

(*Peganum nigellastrum* Vge.), Толгодын бударгана (*Salsola collina* Pall.), Ktze.), бусад хөл газрын ургамал түрж ургасан төрхтэй байна.

Ургамалжлын хувьд ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 11.6-39.6%, халцгай газар 18.8-63.2% эзэлж, ургац 0.82-1.142 ц/га болсон байна (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Ханбогд суман дах бэлчээрийн ургамалжилтын бичиглэл

№	Газар усны нэр	Хэв шинж	Ургамлан нөмрөгийн төрх байдал						
			Зүйлийн тоо (10м ² талбайд)	1 м ² талбайд зүйлийн тоо	Ургамлын бүрхэлц, %	Олцрогч ургамлын бүрхэлц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Ургац, ц/га
1	Зэрэгцээ толгой, Их Хонгор уул	Баглуур-Монгол өвст, Баглуур-бударганат	30	4-6	21.4	6.2	63.2	15.4	0.878
2	Таван толгойн талаар	Баглуур-Монгол өвст, тэсэгтэй, шар модот	15	3-6	15.4	1.8	62.0	22.6	1.006
3	Хээгийн элс, Гүний элсэн талаар	Хазаар өвс-тэсэгт, Тэсэг-хойргот	8	3-5	39.6	7.6	59.8	0.6	0.806
4	Дэмчог хийд орчим, Ханбогд уул, Дөрвөлжин Толгой орчимд	Шар мод-баглуурт	28	4-8	11.6	0.2	58.4	30	1.068
5	Галбын говьд	Баглуурт цөл, Арзгар хармагт цөл	17	4-8	27.2	8.2	37.2	35.6	0.82
6	Номгон уул	Шар мод- баглуурт	35	4-10	19.0	4.0	18.8	62.2	1.142
7	Дайчингийн заг	Заган ой							
8	Уртын гол	Тооройн баяннбүрд							
	Дундаж ургац, ц/га								0.95

Бичиглэл 1.Цэг 1.Зэрэгцээ толгой, Их Хонгор уул **Баглуур-Монгол өвст, Баглуур-бударганат** бэлчээрт энд Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* C.A.Meу.), Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Зүүнгарын улаан бударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.) зонхилж, Төлөгчдүү боролз (*Ajanina acheleoides* (Turcz.) Poljak.), Говийн тост (*Brachanthemum gobicum* Krasch.), Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), Нарийн бэрмэг (*Limonium tenellum* (Turcz.) Ktze.), Бариулт бүйлээс (*Amygdalus pedunculata* Pall.), Хулан хойрго (*Potaninia mongolica* Maxim.), Хуурамч дэрэвгэр хависгана (*Scorzonera pseudodivariata* Lipsch.), Монгол шар далан (*Tugarinovia mongolica* Iljin.), Хойрог харгана (*Caragana brachypoda* Poljak.), Зээрэнцэг борлон (*Cancrinia discoidea* (Ldb.) Poljak.), Толболт ба шар бэрээмэг (*Arnebia guttata* Vge.), Шинэсэрхүү бударгана (*Salsola laricifolia* Turcz.ex Litv.), Бор бударгана (*Salsola passerina* Vge.), Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), Намхан гишүүнэ (*Rheum nanum* Sievers.), Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* Vge.), Сибирь хармаг (*Nitraria sibirica* Pall.), Сөөгөн эмгэн шилбэ (*Atraphaxis frutescens* (L.) K.Koch), Ямаан ангалзуур (*Lagochilus ilicifolius* Vge.), Хөндийн

хунчир (*Astragalus vallestis* R.Kam.), Улбар хунчир (*Astragalus miniatus* Bge.), Бүнгийн хавраг (*Ferula Bungeania* Kitag.), Аалзны хуш-өвс (*Micropeplis arachnoidea* (Моq.) Bge.), Цэх ноцоргоно (*Lappula stricta* (Ldb.) Gurke), Өргөст бударгана (*Salsola pestifera* Nels.), Сибирь шорной (*Atriplex sibirica* L.), Толгодын бударгана (*Salsola collina* Pall.), Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Mey.) Ktze.), Монгол хамхуул (*Corispermum mongolicum* Пjin.), Регелийн шар мод (*Sympegma Regelii* Bge.), Хавиргалаг гиш (*Vicia costata* Ldb.), Шүлхий шарилж (*Artemisia pectinata* Pall.) нийт 15 овог, 32 төрөл, 35 зүйл ургамал бүртгэв. 1м²-д 4-6 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 21.4%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 6.2%, нийт гадаргын бүрхэцэд хайрга чулуу 15.4%, хагдгүй, халцгай газар 63.2% байна (17 –р зураг, 18, 19 -р хүснэгт).

Хүснэгт 18. Баглуур-Монгол өвст, Баглуур-бударганат бэлчээрийн ургамлын бүрхэц /хувиар/

Ургамлын нэр	Давталт,%					Дундаж,%
	1	2	3	4	5	
Ургамлын нийт бүрхэц	20	19	22	26	20	21.4
Үүнээс: Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц	9	11	3	4	4	6.2
Хагд	-	-	-	-	-	-
Хайрга, чулуу	18	13	12	18	16	15.4
Халцгай газар	62	68	66	56	64	63.2



Зураг 17. Баглуур-Монгол өвст, Баглуур-бударганат бүлгэмдэл
N 43°12'55.1" E 106°19'12.1" h 1377

Баглуур-Монгол өвст, Баглуур-бударганат бэлчээрийн га –ийн ургац **0.878** цн, үүнээс баглуур 0.558 цн, бударгана 1.142 цн, Монгол өвс 0.148 цн байна.

Хүснэгт 19. Баглуур-Монгол өвст, Баглуур-бударганат бэлчээрийн ургац

Зонхилох ургамал	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Баглуур	5.1	5.5	6.1	5.4	5.8	27.9	5.58	0.558
Бударгана	1.2	1.5	1.4	1.3	1.7	7.1	1.42	0.142
Монгол өвс	1.7	1.5	1.6	1.4	1.2	7.4	1.48	0.148
Нэг настан	0.2	0.1	0.3	0.8	0.1	1.5	0.3	0.03
Нийт	8.2	8.6	9.4	8.9	8.8	43.9	8.78	0.878

Бичиглэл 2.Цэг 2, 3, 4, 5, 6 цэг.Таван толгойн талаар Баглуур-Монгол өвст, тэсэгтэй, шар модот төрлийн бэлчээртэй, энд Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* С.А.Мей.), Сайрын хялгана (*Stipa glareosa* Р.Смирн.), Регелийн шар мод (*Sympegma Regelii* Вге.), Орог тэсэг (*Eurotia ceratoides* (L.) С.А.Мей.) зонхилж, Хулан хойрго (*Potaninia mongolica* Maxim.), Зээрэнцэг борлон (*Cancrinia discoidea* (Ldb.) Poljak.), Толболт ба шар бэрээмэг (*Arnebia guttata* Вге.), Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), Сибирь шорной (*Atriplex sibirica* L.), Толгодын бударгана (*Salsola collina* Pall.), Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Mey.) Ktze.), Зузаан навчит багдай (*Dontostemon crassifolius* Вге.), Ганцнавчит хунчир (*Astragalus monophylla* Вге.), Гмелиний тайжинс (*Echinops Gmelinii* Turcz.), Феддийн аргамжин цэцэг (*Cistanche feddeana* Нав.), Бунгийн цахилдаг (*Iris Bungei* Maxim.), Баг хуш-хамхаг (*Halogeton glomeratus* (М.В.)С.А.Мей.), Ухмал иршимбэ (*Scrophularia incisa* Weinm.), Бага таван салаа (*Plantago minuta* Pall.), Сиверсийн шарилж (*Artemisia Sieversiana* Willd.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.), Дэгнүүлт шарилж (*Artemisia caespitosa* Ldb.) нийт 13 овог, 18 төрөл, 20 зүйл ургамал бүртгэв. 1м²-д 3-6 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 15.4%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 1.8%, нийт гадаргын бүрхэцэд хайрга чулуу 22.6%, хагдгүй, халцгай газар 62.0% байна (18 –р зураг, 20, 21 –р хүснэгт)

Хүснэгт 20. Баглуур-Монгол өвст, тэсэгтэй, шар модот бэлчээрийн ургамлын бүрхэц/хувиар/

Ургамлын нэр	Давталт,%					Дундаж,%
	1	2	3	4	5....	
Ургамлын нийт бүрхэц	15	18	9	13	22	15.4
Үүнээс: Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц	2	1	1	3	2	1.8
Хагд	-	-	-	-	-	-
Хайрга, чулуу	24	21	14	34	20	22.6
Халцгай газар	61	61	77	53	58	62



Зураг 18. Баглуур-Монгол өвст, тэсэгтэй, шар модот бэлчээр

N 43°02'25.6" E 106°43'07.6" h 1247

Баглуур-Монгол өвст, тэсэгтэй, шар модот бэлчээрийн га –ийн ургац **1.006** цн, үүнээс баглуур 0.552 цн, монгол өвс 0.392 цн байна.

Хүснэгт 21. Баглуур-Монгол өвст, тэсэгтэй, шар модот бэлчээрийн ургац

Зонхилох ургамал	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Баглуур	5.9	5.1	5.5	5.5	5.6	27.6	5.52	0.552
Монгол өвс	2.7	5.1	2.5	3.2	6.1	19.6	3.92	0.392
Цөөн настан	0.7	0.2	1.0	1.1	0.1	3.1	0.62	0.062
Нийт	9.3	10.4	9.0	9.8	11.8	50.3	10.06	1.006

Бичиглэл 3. Цэг 7, 8. Хээгийн элс, Гүний элсэн талаар Хазаар өвс-тэсэгт, Тэсэг-хойргот төрлийн бэлчээртэй, энд Зүүнгарын хазаар өвс (*Cleistogenes songorica* (Roshev.) Ohwi.), Хулан хойрго (*Potaninia mongolica* Maxim.), Орог тэсэг (*Eurotia ceratoides* (L.) C.A.Mey.) зонхилж, Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* Bge.), Толгодын бударгана (*Salsola collina* Pall.), Услиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Mey.) Ktze.), Зузаан навчит багдай (*Dontostemon crassifolius* Bge.), Баг хуш-хамхаг (*Halogeton glomeratus* (M.B.)C.A.Mey.), Говийн шарилж (*Artemisia gobica* (Krasch.) Grub.), Утсан навчит улалж (*Carex stenophylloides* V.Krecz.), Нарийн цахилдаг (*Iris tenuifolia* Pall.) нийт 7 овог, 9 төрөл, 10 зүйл ургамал бүртгэв. 1м²-д 3-5 орчим зүйл тааралдаж байв. Тусгаг бүрхэц 39.6%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 7.6%, нийт гадаргын бүрхэцэд хайрга чулуу 0.6%, хагдгүй, халцгай газар 59.8% байна (19 –р зураг, 22. 23 –р хүснэгт).



Зураг 19. Хазаар өвс-тэсэгт, Тэсэг-хойргот бэлчээр

N 43°11'39.3" E 107°01'41.4" h 1136

Хүснэгт 22. Хазаар өвс-тэсэгт бэлчээрийн ургамлын бүрхэц /хувиар/

Ургамлын нэр	Давталт,%					Дундаж,%
	1	2	3	4	5....	
Ургамлын нийт бүрхэц	42	36	40	37	43	39.6
Үүнээс: Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц	11	5	6	10	6	7.6
Хагд	-	-	-	-	-	-
Хайрга, чулуу	0	2	1	0	0	0.6
Халцгай газар	58	62	59	63	57	59.8

Хазаар өвс-тэсэгт бэлчээрийн га-ийн ургац 0.806 цн, үүнээс үетэн 0.134 цн, үетэн 0.636 цн байна.

Хүснэгт 23. Хазаар өвс-тэсэгт бэлчээрийн ургац

Зонхилох ургамал	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн	1.0	1.1	1.5	1.5	1.6	6.7	1.34	0.134
Тэсэг	15.6	0.0	16.2	0.0	0.0	31.8	6.36	0.636
Цөөн настан	0.2	0.7	0.5	0.3	0.1	1.8	0.36	0.036
Нийт	16.8	1.8	18.2	1.8	1.7	40.3	8.06	0.806

Бичиглэл 4. Цэг 9, 10. Дэмчог хийд орчим, Ханбогд уул, Дөрвөлжин Толгой орчимд **Шар мод-баглуурт** бүлгэмдэлтэй, энд Регелийн шар мод (*Sympegma Regelii* Bge.), Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* С.А.Мей.) зонхилж, Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Зүүнгарын улаан бударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.), Говийн тост (*Brachanthemum gobicum* Krasch.), Хуурамч дэрэвгэр хависгана (*Scorzonera pseudodivaricata* Lipsch.), Монгол шар далан (*Tugarinovia mongolica* Iljin.), Хойрог харгана (*Caragana brachypoda* Pojark.), Шинэсэрхүү бударгана (*Salsola laricifolia* Turcz.ex Litv.), Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), Намхан гишүүнэ (*Rheum nanum* Sievers.), Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* Bge.), Ямаан ангалзуур (*Lagochilus ilicifolius* Bge.), Толгодын бударгана (*Salsola collina* Pall.), Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Mey.) Ktze.), Баг хуш-хамхаг (*Halogeton glomeratus* (M.B.)C.A.Mey.), Зэлэн буюу нохойн зангуу (*Tribulus terrestris* L.), Потанины хотир (*Zygophyllum Potaninii* Maxim.), Төвд заантаваг (*Erodium tibetanum* Edgew.), Ганцнавчит хунчир (*Astragalus monophylla* Bge.), Олон наст багдай (*Dontostemon perennis* С.А.Мей.), Өтлүүн багдай (*Dontostemon senilis* Maxim.), Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex Rgl.), Гялгар дэрс (*Achnatherum splendens* (Trin.) Nevski), Хувьсанги хунчир (*Astragalus variabilis* Bge.ex Maxim.), Сөөгөн сэдэргэнэ (*Convolvulus fruticosus* Pall.), Амманы сэдэргэнэ (*Convolvulus Ammanii* Desr.), Сибирь

эргүүлгэн цэцэг (*Tournefortia sibirica* L.), Толболт ба шар бэрээмэг (*Arnebia guttata* Bge.), Ямаан шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit.), Монгол догар (*Caryopteris mongolica* Bge.), Үсхий нохойн хэл (*Panzeria lanata* (L.) Bge.), Хар шарилж (*Artemisia santolinifolia* Turcz. ex Bess.) нийт 17 овог, 27 төрөл, 30 зүйл ургамал бүртгэв. 1м²-д 4-8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 11.6%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 0.2%, нийт гадаргын бүрхэцэд хайрга чулуу 58.4%, хагдгүй, халцгай газар 30.0% байна (20-р зураг, 24, 25 -р хүснэгт).

Хүснэгт 24. Шар мод-баглуурт бэлчээрийн ургамлын бүрхэц /хувиар/

Ургамлын нэр	Давталт,%					Дундаж,%
	1	2	3	4	5...	
Ургамлын нийт бүрхэц	6	12	12	11	17	11.6
Үүнээс: Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц	0	0	0	0	1	0.2
Хагд	-	-	-	-	-	-
Хайрга, чулуу	55	63	66	57	51	58.4
Халцгай газар	39	25	22	32	32	30



Зураг 20. Шар мод-баглуурт бэлчээр
N 43°12'55.1" E 106°19'12.1" h 1377

Шар мод-баглуурт бэлчээрийн га-ийн ургац 1.068 цн, үүнээс баглуур 0.324 цн, шар мод 0.744 цн байна.

Хүснэгт 25. Шар мод-баглуурт бэлчээрийн ургац

Зонхилох ургамал	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Шар мод	20.4	0.0	16.8	0.0	0.0	37.2	7.44	0.744
Баглуур	4.4	3.1	2.3	3.2	3.2	16.2	3.24	0.324
Нийт	24.8	3.1	19.1	3.2	3.2	53.4	10.68	1.068

Бичиглэл 5.Цэг 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19. Галбын говьд Баглуурт цөл үргэлжилдэг, энд Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* C.A.Mey.) зонхилж, Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Зүүнгарын улаан бударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.) зонхилж, Бүдүүн хялгаст хунчир (*Astragalus macrotrichus* Peter-Stib.), Зээрэнцэг борлон (*Cancrinia*

discoidea (Ldb.) Poljak.), Толболт ба шар бэрээмэг (*Arnebia guttata* Bge.), Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Mey.) Ktze.), Баг хуш-хамхаг (*Halogeton glomeratus* (M.B.)C.A.Mey.), Сөөгөн сэдэргэнэ (*Convolvulus fruticosus* Pall.), Чөдөр буюу хөдөөгийн сэдэргэнэ (*Convolvulus arvensis* L.), Говийн тост (*Brachanthemum gobicum* Krasch.), Хойрог харгана (*Caragana brachypoda* Rojark.), Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* Bge.), Төвд заантаваг (*Erodium tibetanum* Edgew.), Хувьсанги хунчир (*Astragalus variabilis* Bge.ex Maxim.), Хойрог харгана (*Caragana brachypoda* Rojark.), Цэх ноцоргоно (*Lappula stricta* (Ldb.) Gurke.), Грубовын ортууз Грубовын ортууз (*Oxytropis Grubovii* Ulzj.) нийт 11 овог, 17 төрөл, 18 зүйл ургамал бүртгэв. 1м²-д 4-8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 27.2%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 8.2%, нийт гадаргын бүрхэцэд хайрга чулуу 35.6%, хагдгүй, халцгай газар 37.2% байна (21 –р зураг, 26, 27 -р хүснэгт).

Хүснэгт 26. Галбын говьд Баглуурт цөлийн ургамлын бүрхэц /хувиар/

Ургамлын нэр	Давталт,%					Дундаж,%
	1	2	3	4	5....	
Ургамлын нийт бүрхэц	25	30	26	21	34	27.2
Үүнээс: Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц	1	13	8	9	10	8.2
Хагд	-	-	-	-	-	-
Хайрга, чулуу	42	32	24	48	32	35.6
Халцгай газар	33	38	50	31	34	37.2



Зураг 21. Галбын говьд Баглуурт цөл
N 42°49'33.6" E 107°29'20.2" h 937

Галбын говьд Баглуурт цөлийн га–ийн ургац 0.82 цн, үүнээс баглуур 0.646 цн байна.

Хүснэгт 27. Галбын говьд Баглуурт цөлийн ургац

Зонхилох ургамал	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Баглуур	7.7	7.5	6.5	5.1	5.5	32.3	6.46	0.646
Үетэн	1.3	1.5	1.1	1.5	1.4	6.8	1.36	0.136
Цөөн настан	0.5	0.6	0.5	0.2	0.1	1.9	0.38	0.038
Нийт	9.5	9.6	8.1	6.8	7.0	41.0	8.2	0.82

Цэг 15. Ханбогд сумын Бага модны төгөлд Одой хайлас (*Ulmus pumila* L.), Танамал махирс (*Lucium truncatum* Wang), Эгэл нишингэ (*Phragmites communis* Trin.), Мөлхөө улалж (*Carex reptabunda* (Trautv.) V.Krecz.), Холимог хэлбэрт багваахай (*Taraxacum commixtiforme* Soest.), Марцны цэгээлж (*Glaux maritima* L.), Турьхан цэцэгт зурман сүүл (*Puccineillia tenuiflora* (Griseb.) Scribn.et Merr.), Гялгар дэрс (*Achnatherum splendens* (Trin.) Nevski), Нүцгэн ортууз (*Oxytropis glabra* (Lam.)DC.), Улаан үндэст бэрмэг (*Limonium erythrorhizum* Ik. -Gal. ex Lincz.), Сибирь ерөндгөнө (*Vincetoxicum sibiricum* (L.) Desne.), Ноорхой ерөндгөнө (*Cynanchum pubescens* Bge.), Татаар зираа (*Lactuca tatarica* (L.) C. A. Mey.), Ороолдоо зогдор өвс (*Clematis intricata* Bge.) бүртгэв.

6. Цэг 20, 21. Номгон уул Шар мод-баглуурт, хормойгоороо сийрэг бударганат бүлгэмдэлтэй. Энд Регелийн шар мод (*Sympegma Regelii* Bge.), Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* C.A.Mey.) зонхилж, Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Зүүнгарын улаан бударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.), Дагуур хошоонбут (*Lespedeza dahurica* (Laxm.) Schingdl.), Аркалын хунчир (*Astragalus arcalycensis* Bge.), Шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.), Сөөгөн зогдор өвс (*Clematis fruticosa* Turcz.), Үслэг навчит хэрээн нүд (*Asparagus trichophyllus* Bge.), Тайрлиг ажигана (*Stellaria gypsophiloides* Fenzl.), Дэвүүрт хотир (*Zygophyllum pterocarpum* Bge.), Пеллитын шивэлз (*Ptilagrostis Pelloitii* (Danguy) Grub.), Өргөст эмгэн шилбэ (*Atraphaxis pungens* (M.B.) Jaub.et Spach), Монгол хависгана (*Scorzonera mongolica* Maxim.), Зэлэн буюу нохойн зангуу (*Tribulus terrestris* L.), Ногоон хоног будаа (*Setaria viridis* (L.) P.B.), Цагаан лууль (*Chenopodium album* L.), Бор бударгана (*Salsola passerina* Bge.), Толгодын бударгана (*Salsola collina* Pall.), Регелийн будараа (*Iljinia Regelii* (Bge.) Kogov.), Говийн тост (*Brachanthemum gobicum* Krasch.), Нарийн бэрмэг (*Limonium tenellum* (Turcz.) Ktze.), Хуурамч дэрэвгэр хависгана (*Scorzonera pseudodivaricata* Lipsch.), Монгол шар далан (*Tugarinovia mongolica* Iljin.), Хойрог харгана (*Caragana brachypoda* Pojark.), Туулайн хунчир (*Astragalus laguroides* Pall.), Толболт ба шар

бэрээмэг (*Arnebia guttata* Vge.), Шинэсэрхүү бударгана (*Salsola laricifolia* Turcz.ex Litv.), Бор бударгана (*Salsola passerina* Vge.), Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), Толгодын бударгана (*Salsola collina* Pall.), Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Mey.) Ktze.), Өтлүүн багдай (*Dontostemon senilis* Maxim.), Шаргал шарилж (*Artemisia rutifolia* Steph. ex Spreng.), Данхар хависгана (*Scrozonera capito* Maxim.), Налчигар сүүт өвс (*Euphorbia humifusa* Willd.), Хөх ногоон зээргэнэ (*Ephedra glauca* Rgl.), Нэг наст бивлэнцэр (*Schizonepeta annua* (Pall.) Schischk.), Говийн ганга (*Thymus gobicus* Tschern.), Сөөгөн боролз (*Ajania fruticulosa* (Ldb.) Poljak.) нийт 20 овог, 33 төрөл, 39 зүйл ургамал бүртгэв. 1м²-д 4-10 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 19.0%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 4.0%, нийт гадаргын бүрхэцэд хайрга чулуу 62.2%, хагдгүй, халцгай газар 18.8% байна (22 –р зураг, 28, 29 -р хүснэгт).

Хүснэгт 28. Шар мод –баглуурт бэлчээрийн ургамлын бүрхэц /хувиар

Ургамлын нэр	Давталт,%					Дундаж,%
	1	2	3	4	5....	
Ургамлын нийт бүрхэц	20	19	17	23	16	19
Үүнээс: Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц	3	3	4	4	6	4
Хагд	-	-	-	-	-	-
Хайрга, чулуу	67	62	65	60	57	62.2
Халцгай газар	13	19	18	17	27	18.8



Зураг 22. Шар мод –баглуурт Номгон уул
N 42°46'25.4" E 107°44'08.8" h 1088

Шар мод –баглуурт бэлчээрийн га –ийн ургац 1.142 цн, үүнээс шар мод 0.84 цн байна.

Хүснэгт 29. Шар мод –баглуурт бэлчээрийн ургац

Зонхилох ургамал	Дундаж					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Шар мод	20.1	0.0	0.0	0.0	21.9	42.0	8.4	0.84
Баглуур	3.6	2.5	2.8	2.6	2.1	13.6	2.72	0.272
Нэг настан	0.2	0.1	0.3	0.5	0.4	1.5	0.3	0.03
Нийт	23.9	2.6	3.1	3.1	24.4	57.1	11.42	1.142

Цэг 23. Цагаан хад орчимд Намхан гичгэнэ (*Potentilla supina* L.), Гмелиний тайжинс (*Echinops Gmelinii* Turcz.), Марцны зоосонцэцэг (*Inula salsoloides* (Turcz.) Osten.), Үнэгэн сүүлхэй лидэр (*Sophora alopecuroides* L.), Урал чихэр өвс (*Glycyrrhiza uralensis* Fisch.), Гоолиг бадаргана (*Kalidium gracile* Fenzl.), Сибирь ерөндгөнө (*Cynanchum sibiricum* Willd.), Феддийн аргамжин цэцэг (*Cistanche feddeana* Hao), Одой хайлас (*Ulmus pumila* L.), Олон цэцэгт сухай (*Tamarix ramosissima* Ldb Сибирь хармаг (*Nitraria sibirica* Pall.), Үмхий шимэлдэг (*Dracocephalum foetidum* Bge.) бүртгэв.


Цэг 24 бичиглэл. Булан сухайт орчимд Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), Мөлхөө ягаан толгой (*Acroptilon repens* (L.) DC.), Стефаны заан таваг (*Erodium Stephanianum* Willd.), Хуурамч дэрэвгэр хависгана (*Scorzonera pseudodivaticata* Lipsch.), Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), Хошоон хунчир (*Astragalus melilotoides* Pall.), Сибирь эргүүлгэн цэцэг (*Tournefortia sibirica* L.), Мөчирлөг түнгэ (*Leymus racemosus* (Lam.) Tzvel.), Гмелиний тайжинс (*Echinops Gmelinii* Turcz.), Үнэгэн сүүлхэй лидэр (*Sophora alopecuroides* L.), Урал чихэр өвс (*Glycyrrhiza uralensis* Fisch.), Гоолиг бадаргана (*Kalidium gracile* Fenzl.), Гоолиг сухай (*Tamarix gracillis* Willd.), Сибирь хармаг (*Nitraria sibirica* Pall.), Хувьсанги хунчир (*Astragalus variabilis* Bge.ex Maxim.), Эгэл нишингэ (*Phragmites communis* Trin.), Гялгар дэрс (*Achnatherum splendens* (Trin.) Nevski), Татаар зираа (*Lactuca tatarica* (L.) C. A. Mey.), Олон цэцэгт сухай (*Tamarix ramosissima* Ldb.), Бүнгийн хавраг (*Ferula Bungeania* Kitag.), Нангиад ороонго (*Cuscuta chinensis* Lam.), Шардуу шарилж (*Artemisia globosoides*), Намгийн шарилж (*Artemisia palustris* L.) бүртгэв.

Цэг 25. Арзгар үрт хармагт талд Арзгар үрт хармаг (*Nitraria sphaerocarpa* Maxim.), Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* C.A.Mey.), Цацагт ба хөх бэрээмэг (*Arnebia fimbriata* Maxim.), Бүдүүн хялгаст хунчир (*Astragalus macrotrichus* Peter-Stib.), Цэх ноцоргоно (*Lappula stricta* (Ldb.) Gurke.), Хулан хойрго (*Potaninia mongolica* Maxim.), Грубовын хунчир (*Astragalus Grubovii* Sancz.) Павловын хунчир (*Astragalus Pavlovii* B.Fedtsch.et Basil.) бүртгэв.



Зураг 23. Арзгар үрт хармагт тал
N 42°35'59.2" E 107°32'45.9" h 901

Бичиглэл 6. Цэг 26, 27, 28, 29, 30. Дайчин говийн заган шугуйд Заг (*Haloxylon ammodendron* (С.А.Мей.) Вге.), Зэлэн буюу нохойн зангуу (*Tribulus terrestris* L.), Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Мей.) Ktze.), Гмелиний тайжинс (*Echinops Gmelinii* Turcz.), Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), Сөөгөн сэдэргэнэ (*Convolvulus fruticosus* Pall.), Шивүүрт цулихир (*Agriophyllum pungens* (Vahl) Link ex.A. Dietr.), Потанины хотир (*Zygophyllum Potaninii* Maxim.), Бүнгийн хавраг (*Ferula Bungeana* Kitag.) бүртгэв.



15, 16-р зураг. Дайчингийн загийн судалгаа

N 42°32'04.3" E 106°54'41.9" h 934

Бичиглэл 7. Цэг 35, 36, 37, 38. Шандын овоо, Хацагчийн уул орчимд Шар мод-баглуурт бүлгэмдэлтэй, сайраар хайлаасан төгөлтэй, энд Цагаалин галуун таваг (*Chiazospermum lactiflorum* Kar.et.Kir.), Төв Азийн лавай (*Asterothamnus centrali-asiaticus* Novopokr.), Монгол бүйлээс (*Amygdalus mongolica* Maxim.), Говийн хэрээн нүд (*Asparagus gobicus* Ivanova.ex Grub.), Элдэв навчит улиас (*Populus diversifolia* Schrenk.), Наранцэцгийн гувшаахай (*Orobancha cumana* Wallr.), Пржевальскийн зээргэнэ (*Ephedra Przewalskii* Stapf.), Дэрэвгэр хависгана (*Scorzonera divaricata* Turcz.), Нарийн ишт юнги (*Youngia tenuicaulis* (Babc.et Stebbins) Czer.) зэрэг зүйл нэмэж бүртгэв.



17, 18-р зураг. Хайлаасан сайр

N 42°37'42.1" E 106°40'06.2" h 958

Цэг 39. Ханбогд сумын Уртын голын зүүн салаанд тооройн төгөл бүхий баянбүрдэд 200 ширхэг Тоорой буюу Элдэв навчит улиас (*Populus diversifolia* Schrenk.) ургаж байв. Энд Согсооторхуу лавай (*Asterothamnus heteropappoides* Novopokr.), Эгэл нишингэ (*Phragmites communis* Trin.), Зүүнгарын зогдор өвс (*Clematis songarica* Bge.), Шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.), Говийн хотир (*Zygophyllum gobicum* Maxim.), Дэвүүрт хотир (*Zygophyllum pterocarpum* Bge.), Зүүнгарын улаан бударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.), Марцны зоосонцэцэг (*Inula salsoloides* (Turcz.) Ostenf.), Урал чихэр өвс (*Glycyrrhiza uralensis* Fisch.) Алтан бэрмэг (*Limonium aureum* (L.) Hill ex Ktze.), Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* (*Rheum nanum* Sievers.), Марцны хоржигнуур (*Sphaerophysa salsula* (Pall.) DC.), Бөндгөр шарилж (*Artemisia sphaerocephala* Krasch.), Шар шарилж (*Artemisia xanthochroa* Krasch.), Карелинийн сухай (*Tamarix Karelinii* Bge.), нэг ба хоёр настанаас Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Монгол хамхуул (*Corispermum mongolicum* Iljin.), Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch. et Mey.) Ktze.), Гмелиний тайжинс (*Echinops Gmelinii* Turcz.), Өргөст бударгана (*Salsola pestifera* Nels.), Толболт ба шар бэрээмэг (*Arnebia guttata* Bge.), Цацагт ба хөх бэрээмэг (*Arnebia fimbriata* Maxim.), Нарийн цагаан суль (*Elymus angustus* Trin.) зэрэг 11 овог, 16 төрөл 19 зүйл ургамал бүртгэв.



Зураг 24. Тооройн төгөл



Өмнөговь аймгийн Ханбогд сумын байгалийн ургамлын аймаг

Өмнөговь аймгийн Ханбогд сумын байгалийн ургамлын аймгийн мужлал. Өмнөговь аймгийн Ханбогд сум байгаль ургамал газар зүйн тархацын мужлалын хувьд А.А.Юнатовын (1952) ангиллаар Евро-Азийн хээрийн мужийн **Умард говийн цөлийн хээрийн провинцийн** Дорнод говийн цөлийн хээрийн тойргийн Цогтцэцийн район, **Азийн цөлийн мужийн Умард говийн провинцийн:** Алашаа говийн цөлийн тойргийн Галбын говийн районуудад хамаарна. **Дорнод говийн цөлийн хээрийн тойрог.** Ханбогд сумын Галбын говиос баруун ба зүүн хойт чигт үргэлжилсэн уудам хотгор нь Дорноговийн цөлийн хээр юм.

Цогтцэцийн район нь цав толгод уулс зонхилсон харьцангуй нам (үнэмлэхүй өндөр 1100-аас 1300) нутаг юм. Бэсрэг уулсуудын дунд богиновтор нурууд, Ханбогд уул, Хулстай хар уул, Замын хөх толгой, Бүст уул, Тахилга уул, Сангастай уул, Сухайн хар уул, Оцонгийн шийр уул, Дөрвөлжин толгод, Таван Тахил уул, Жавхлант уул зэрэг цухуйж байдаг. Гэвч цав толгодын хоорондох хөндий, тэгш газар хувийн жингээр илүү юм. Хотгор хонхор харьцангуй цөөн. Энэ районд баглуур-монгол өвст хулуурхаг цөлийн хээр ихээхэн түгээмэл тааралдана. Мөн нам хөндийрүү бударгана-монгол өвст хээрт шилждэг хазаар өвс-монгол өвст, таана-монгол өвст хээр элбэг. Нутгийн өмнө талруу цөлийн нөлөө улам их болно. Энд тэгш тал газраар хэсэг хэсэг бор бударгана-баглуурт цөл тааралддаг. Хөндийн ёроол, сайр дагуу ба хонхор хотсын захаар дэрс ихтэй. Багавтар элснүүд харгана, тэсгээр хучигдсан байна.

Алашаагийн говь. Энэ тойрогт Монголын өмнөт хил дагуу Ханбогдын цав толгодорхог өндөрлөгөөр хашигдсан Галбын уудам тал нутаг хамаарна. Энэ нутаг хойноосоо урагш Монгол улсын хил нэвтэртэл нам болдог бөгөөд Номгон зэрэг бэсрэг уулсуудтай хоршин тааралддаг нугачаа гүвээ бүхий хэвгий уудам тал газар юм.

Галбын говийн район. Уг район нь өмнө зүг намссан их бага хэмжээний бэсрэг уулстай, уулссаараа шармод-баглуурт, хормойгоороо бударганат цөлтэй, хөндийгөөрөө баглуурт цөл үргэлжилдэг.

Ханбогд сумын байгалийн ургамлын зүйлийн бүтэц бүрэлдэхүүн

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт нийт 35 овог, 100 төрөл, 161 зүйл бүртгэв

Ургамлын ангиллын үндсэн бүлгийн задлаг. Уг нутагт бүртгэгдсэн зүйл ургамлын ангиллын үндсэн бүлгүүдийн бүтцийг авч үзэхэд ойм, шивэрсэн, шилээн хүрээний зүйл ургамалгүй, нүцгэн үртэний хүрээний 2 зүйл, далд үртэний хүрээний 159 зүйл (үүнээс нэг талтан 24 зүйл, хос талтан 135 зүйл) байна (хүснэгт 30).

Хүснэгт 30. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт бүртгэсэн ургамлын ангилал

Ангиллын үндсэн бүлгүүд	Овгийн тоо	Төрлийн тоо	Зүйлийн	
			Тоо	Эзлэх хувь (%)
Нүцгэн үртэний хүрээ	1	1	2	1.2
Далд үртэний хүрээ	29	99	159	100.0
Үүнээс:				
а. Нэг талт үрт ургамлын анги	5	18	24	14.9
б. Хос талт үрт ургамлын анги	24	81	135	83.9


Энд бүртгэгдсэн ургамлаас голгэсэртэн, лууль, буурцагтан, үетэн, уруул цэцэгтэн, тоонолжинцэцэгтэн, сарнай, сонгино, цахилдаг, улалж, сараана, иршимбэ, ноцоргонын овгууд нь төрөл, зүйлийн тоогоор эхний 15–д жагсаж байгаа [9, 10] бөгөөд бусад овгууд нэгээс хоёр зүйлтэй байна. Эхний 15 овогт багтах зүйл ургамлууд Ханбогд сумын нутагт бүртгэсэн бүх зүйлийн ихэнхийг буюу 82.8% -ийг бүрдүүлж байна (Хүснэгт 31).

Хүснэгт 31. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт бүртгэсэн ургамлын зонхилох овгууд

№	Овог	Төрлийн тоо	Зүйлийн тоо	Эзлэх хувь, %
1	<i>Asteraceae</i> Dumort. -Гол гэсэртэний овог	15	32	19.9
2	<i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог	14	20	12.4
3	<i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог	8	20	12.4
4	<i>Gramineae</i> Juss.-Үетэний овог	14	16	9.9
5	<i>Zygophyllaceae</i> R. Вг. -Хотирын овог	4	8	5.0
6	<i>Labiaceae</i> Lindl.- Уруул цэцэгтэний овог	5	5	3.1
7	<i>Boraginaceae</i> Juss. - Ноцоргонын овог	4	5	3.1
8	<i>Rosaceae</i> Juss. -Сарнайн овог	3	5	3.1
9	<i>Polygonaceae</i> Juss. - Тарнын овог	3	4	2.5
10	<i>Tamaricaceae</i> Link. - Сухайн овог	2	3	1.9
11	<i>Orobanchaceae</i> Vent. -Гувшаахайн овог	2	3	1.9
12	<i>Ranunculaceae</i> Juss. - Холтсонцэцгийн овог	1	3	1.9
13	<i>Cruciferae</i> Juss. - Тоонолжинцэцэгтэний овог	1	3	1.9
14	<i>Plumbaginaceae</i> Juss. - Хорголжингийн овог	1	3	1.9
15	<i>Convulvulaceae</i> Juss. - Сэдэргэнийн овог	1	3	1.9
	Бүгд	78	133	82.8

Ургамлын амьдралын хэлбэр. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт ургаж байгаа 161 зүйл ургамлын амьдралын хэлбэрээр ялгахад 34 зүйл нэг ба хоёр наст өвслөг ургамал (21.1%), 75 зүйл олон наст өвслөг ургамал (46.6%), 45 зүйл сөөг, сөөгөнцөр ургамал (27.9%), 4 зүйл шарилж шимэгч ургамал (2.5%), 3 зүйл модлог ургамал (1.9%) бүртгэгдээгүй болно.

Диаграм 3. Ургамлын амьдралын хэлбэр



Ургамлын ач холбогдол ба хор холбогдол. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт ургаж байгаа бүх зүйл ургамлаас 25 овог, 87 төрлийн 127 зүйл бэлчээр тэжээлийн ач холбогдолтой ургамал (78.9%), 21 овог, 35 төрөл, 46 зүйлийн (28.6%), 10 овог, 24 төрлийн 34 зүйл (21.1%) ургаж байна [9, 16, 18, 30, 31] (хүснэгт 32).

Хүснэгт 32. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт ургаж байгаа зүйлийн бүрдлийн бүтэц

Ач холбогдол ба хор холбогдол				Эзлэх хувь
	Овог	Төрөл	Зүйл	
Бэлчээр тэжээлийн ургамал	25	87	127	78.9%
Эмийн ашигт ургамал	21	35	46	28.6%
Хөл газрын ургамал	10	24	34	21.1%
Хорт ургамал	4	6	7	4.3%

Бэлчээрийн ургамлаас малд сайн идэмжтэй Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Пеллитын шивэлз (*Ptilagrostis Pelloitii* (Danguy) Grub.), Гялгар дэрс (*Achnatherum splendens* (Trin.) Nevski.), Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Үсхий суль (*Psammochloa villosa* (Trin.) Bor.), Зүүнгарын хазаар өвс (*Cleistogenes songorica* (Roshev.) Ohwi.), Мөчирлөг ба Нангиад түнгэ (*Leymus racemosus* (Lam.) Tzvel., *Leymus chinensis* (Trin.) Tzvel.), Нарийн цагаан суль (*Elymus angustus* Trin.) зэрэг үетэн, таана, хөмөл зэрэг сонгинолог ургамал, лууль болон Орог тэсэг (*Eurotia ceratoides* (L.) C.A.Mey), бударгана, баглуур зэрэг луультаг, Алтан ба хойрог харгана (*Caragana leucophloea* Pojark., *Caragana brachypoda* Pojark.) болон хунчир, ортууз, хошоон бут, гиш, Урал чихэр өвс (*Glycyrrhiza uralensis* Fisch.) зэрэг буурцагтан, Төлөгчдүү ба сөөгөн боролз (*Ajania acheleoides* (Turcz.) Poljak.), цагаан, шар, хар шавагнууд (*Artemisia xerophytica* Krasch., *Artemisia caespitosa* Ldb., *Artemisia gobica* (Krasch.) Grub.,

Artemisia globosoides, *Artemisia sphaerocephala* Krasch., *Artemisia santolinifolia* Turcz. ex Bess) байна.

Мал идвэл хорддог хортой ургамал Пржевальскийн зээргэнэ (*Ephedra Przewalskii* Stap.), Говийн хэрээн нүд (*Asparagus gobicus* Ivanova.ex Grub.), Марцны хоржигнуур (*Sphaerophysa salsula* (Pall.) DC.), Шүдэн цагаан буюу цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.), Хатингар буюу Хувьсанги хунчир (*Astragalus variabilis* Bge.ex Maxim.), Зэлэн хор буюу нүцгэн ортууз (*Oxytropis glabra* (Lam.)DC.), Сибирь тэмээн хөх (*Vincetoxicum sibiricum* (L.) Desne.) зэрэг ургамал тааралдав.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын ургамлын аймагт бүртгэсэн нэн ховор, ховор, унаган ба үлдэц ургамал, тэдгээрийн хамгааллын асуудал

Ургамал судлаач У.Лигаа, Ш.Дариймаа, П.Цэрэннадмид, төслийн багийн гишүүд Н.Жанчивдорж, У.Сарангэрэл, Б.Бат-Энэрэл нарын хамт (2008 онд) Монгол орны нэн ховор ургамлын зурагт лавлахад 53 овог, 99 төрлийн 133 зүйл ургамал орсон байна [20].

2009 онд У.Лигаа ахлагчтай судлаач Ш.Дариймаа, Н.Жанчивдорж, У.Сарангэрэл, Х.Жамъяндорж, Б.Бат-Энэрэл нар Монгол орны ховор ургамлын зурагт лавлахад 355 зүйл ховор ургамлын ангилал зүй, таних шинж, тархац, ургах орчин, үржил, нөөц хомсдох шалтгаан, хамгаалах арга хэмжээ зэргийг бичсэн байдаг [21].

Хүснэгт 33. Монгол улсын нэн ховор, ховор ургамлыг бүртгэсэн бүтээлүүд

У.Лигаа, Ш.Дариймаа, ба бусад, 2008	У.Лигаа, Ш.Дариймаа, ба бусад, 2009	Монгол улсын улаан ном, 2013	Монгол улсын байгалийн ургамлын тухай хуулийн хавсралт, 1995	Монгол улсын Улаан данс, 2012
Монгол орны нэн ховор ургамал	Монгол орны ховор ургамал	52 зүйл нэн ховор, 83 зүйл ховор	133 зүйл нэн ховор, 355 зүйл ховор	16 зүйл устаж байгаа, 39 зүйл устаж болзошгүй, 55 зүйл эмзэг, 22 зүйл ховордож болзошгүй, 10 зүйл анхааралд өртөхөөргүй, 4 зүйл мэдээлэл дутмаг, 2 зүйл үнэлэх боломжгүй
133 зүйл	355 зүйл	135 зүйл	488 зүйл	148 зүйл

Монгол орны ургамлын аймгийг бүрдүүлэгч цоргот дээд ургамал 2014 оны бүртгэл бичигт бүртгэгдсэнээр 112 овгийн 683 төрлийн 3127 зүйл, үүний дотор Монгол орноос өөр нутагт ургадаггүй Монголын унаган ургамал 150 гаруй зүйл, хөрш зэргэлдээ хэл залгаа оронд ургадаг боловч тархацын зах сэжүүр нь манай оронд орж ирсэн завсрын унаган ургамал 200 гаруй байгаа нь Монголын ургамлын аймгийн 11.6 орчим % эзэлж байна [17].

Дээрх судлаачдын бүтээлийн дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт ургаж байгаа нэн ховор, ховор, унаган, үлдэц ургамлын бүртгэлийг гаргахад 11 зүйл нэн ховор, 13 зүйл ховор, 26 зүйл Монголын унаган ургамал (эндемик), 25 зүйл Монголд байгаа завсарын унаган ургамал, 11 зүйл үлдэц (реликт) ургамал ургаж байна.

Диаграм 4. Нэн ховор, ховор, унаган, үлдэц ургамал



Үүнээс:

1.

Өмнөговь аймгийн Ханбогд суманд Элдэв навчит улиас (*Populus diversifolia* Schrenk.), Регелийн будараа (*Ijinia Regelii* (Bge.) Korov.), Алтан бэрмэг (*Limonium aureum* (L.) Hill ex Ktze.), Толболт ба шар бэрээмэг (*Arnebia guttata* Bge.), Төв Азийн лавай Төв Азийн лавай (*Asterothamnus centrali-asiaticus* Novopokr.), Грубовын ортууз (*Oxytropis Grubovii* Ulzj.), Говийн тост (*Brachanthemum gobicum* Krasch.), Элдэв навчит улиас (*Populus diversifolia* Schrenk.), Хойрог харгана (*Caragana brachypoda* Rojark.), Хулан хойрго (*Potaninia mongolica* Maxim.), Потанины хотир (*Zygophyllum Potaninii* Maxim.), Монгол шар далан (*Tugarinovia mongolica* Pjin.), Шар шарилж (*Artemisia xanthochroa* Krasch.), 8 овог, 12 төрөл, 12 зүйл нэн ховор ургамал ургаж байна.

2. Өмнөговь аймгийн Ханбогд суманд Үнэгэн сүүлхэй лидэр (*Sophora alopecuroides* L.), Эгэл нишингэ (*Phragmites communis* Trin.), Говийн хотир (*Zygophyllum gobicum* Maxim.), Шаргал шарилж (*Artemisia rutifolia* Steph. ex Spreng.), Хар шарилж (*Artemisia santolinifolia* Turcz. ex Bess.), Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), Сибирь тэмээн хөх (*Vincetoxicum sibiricum* (L.) Desne.), Феддийн аргамжин цэцэг (*Cistanche feddeana* Hao.), Шивүүрт цулихир (*Agriophyllum pungens* (Vahl) Link ex A. Dietr.), Урал чихэр өвс (*Glycyrrhiza uralensis* Fisch.), Монгол бүйлээс (*Amygdalus mongolica* Maxim.), Танамал махирс (*Lycium truncatum* Wang.) зэрэг 10 овог, 12 төрөл, 13 зүйл ховор ургамал ургаж байна.

3. Өмнөговь аймгийн Ханбогд суманд Пеллитын шивэлз (*Ptilagrostis Pelloitii* (Danguy) Grub.), Улаан үндэст бэрмэг (*Limonium erythrorhizum* Ik. -Gal. ex Lincz.), Шинэсэрхүү бударгана (*Salsola laricifolia* Turcz. ex Litv.), Регелийн шар мод (*Sympegma Regelii* Bge.), Цөлийн тайр

(*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl.), Олон наст багдай (*Dontostemon perennis* С.А.Мей.), Хулан хойрго (*Potaninia mongolica* Maxim.), Монгол бүйлээс (*Amygdalus mongolica* Maxim.), Хойрог харгана (*Caragana brachypoda* Pojark.), Грубовын хунчир (*Astragalus Grubovii* Sancz.), Павловын хунчир (*Astragalus Pavlovii* В. Fedtsch. et Basil.), Хөндийн хунчир (*Astragalus vellestris* R. Kam.), Хувьсанги хунчир (*Astragalus variabilis* Bge. ex Maxim.), Грубовын ортууз (*Oxytropis Grubovii* Ulzj.), Шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.), Монгол догар (*Caryopteris mongolica* Bge.), Говийн ганга (*Thymus gobicus* Tschern.), Монгол шар далан (*Tugarinovia mongolica* Iljin.), Говийн тост (*Brachanthemum gobicum* Krasch.), Төлөгчдүү боролз (*Ajania acheleoides* (Turcz.) Poljak.), Говийн шарилж (*Artemisia gobica* (Krasch.) Grub.), Шар шарилж (*Artemisia xanthochroa* Krasch.), Хуурамч дэрэвгэр хависгана (*Scorzonera pseudodivariata* Lipsch.), Монгол хависгана (*Scorzonera mongolica* Maxim.), Холимог хэлбэрт багваахай (*Taraxacum commixtiforme* Soest.), 10 овог, 22 төрөл 26 зүйл Монголын унаган ургамал ургаж байна.

4. Өмнөговь аймгийн Ханбогд суманд Үсхий суль (*Psammochloa villosa* (Trin.) Bor.), Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Говийн хэрээн нүд (*Asparagus gobicus* Ivanova. ex Grub.), Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex Rgl.), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), Бунгийн цахилдаг (*Iris Bungei* Maxim.), Монгол хамхуул (*Corispermum mongolicum* Iljin.), Шөвгөр бадаргана (*Kalidium cuspidatum* (Ung.-Sternb.) Grub.), Гоолиг бадаргана (*Kalidium gracile* Fenzl.), Бор бударгана (*Salsola passerina* Bge.), Өтлүүн багдай (*Dontostemon senilis* Maxim.), Зузаан навчит багдай (*Dontostemon crassifolius* Bge.), Ганцнавчит хунчир (*Astragalus monophylla* Bge.), Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* Bge.), Говийн хотир (*Zygophyllum gobicum* Maxim.), Потанины хотир (*Zygophyllum Potaninii* Maxim.), Арзгар үрт хармаг (*Nitraria sphaerocarpa* Maxim.), Цацагт ба хөх бэрээмэг (*Arnebia fimbriata* Maxim.), Ямаан ангалзуур (*Lagochilus ilicifolius* Bge.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.), Дэгнүүлт шарилж (*Artemisia caespitosa* Ldb.), Бөндгөр шарилж (*Artemisia sphaerocephala* Krasch.), Данхар хависгана (*Scorzonera capito* Maxim.), Дэрэвгэр хависгана (*Scorzonera divariata* Turcz.), 14 овог, 19 овог 25 зүйл Монголд байгаа завсарын унаган ургамал ургаж байна.

5. Өмнөговь аймгийн Ханбогд суманд эртний цөлийн үлдэц унаган ургамал Пржевальскийн зээргэнэ (*Ephedra Przewalskii* Stapf.), Хулан хойрго (*Potaninia mongolica* Maxim.), Шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.), Зүүнгарын улаан бударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.), Регелийн шар мод (*Sympegma Regelii* Bge.), Регелийн будараа (*Iljinia Regelii* (Bge.) Kogov.), гуравдагчийн голын татмын ойн үлдэц ургамал Элдэв навчит улиас буюу тоорой (*Populus diversifolia* Schrenk.), Одой хайлас (*Ulmus pumila* L.), Олон цэцэгт сухай (*Tamarix ramosissima* Ldb.), эртний саваннын үлдэц ургамал Грубовын

ортууз (*Oxytropis Grubovii* Ulzj.) зэрэг 9 овог, 11 төрлийн 11 зүйл ургамал ургаж байгаа нь нийт ургамлын 54.0% нь хамгаалалтанд авах шаардлагатай байна (хүснэгт 34).

Хүснэгт 34. Ханбогд суманд бүртгэсэн хамгаалалтанд авах шаардлагатай зүйлийн бүрдлийн бүтэц

Ургамал хамгааллын статус	Ангилал зүй			Эзлэххувь
	Овог	Төрөл	Зүйл	
Нэн ховор ургамал	8	12	12	7.5%
Үлдэц ургамал	9	11	11	6.8%
Ховор ургамал	10	12	13	8.1%
Монголын унаган ургамал	10	22	26	16.1%
Монголд байгаа завсрын унаган ургамал	14	19	25	15.5%
Нийт				54.0%

Нэн ховор ургамлын ховордох шалтгаан. Судалгаанаас харахад ган, хэт хуурайшил, уулын үер, цөлжилт, салхи зэрэг байгаль цаг уурын нөлөөнөөс болж байгалийн жамаар нөхөн сэргэж ургах чадваргүй болох болон эмнэлэг, хүнс, түлш, малын бэлчээр, уул уурхайн үйлдвэрлэл зэрэг хүний хэрэглээний хүчин зүйлээс болж тархац нөөц хомсдон жилээс жилд улам ховордсоор улмаар устаж үгүй болох аюулд хүрэх магадлалтай юм. Тиймээс нэн ховор ургамлын ховордож байгаа шалтгаан, хамгаалалтанд авсан байдал, цаашид уг ургамлыг хамгаалах арга хэмжээ зэргийг тодруулж доорх хүснэгтээр харуулав (хүснэгт 35).

Хүснэгт 35. Өмнөговь аймгийн Ханбогд сумын ургамлын аймагт бүртгэсэн нэн ховор ургамлын хамгаалал

№	Ургамлын овог, төрөл, зүйлийн нэршил	Тархац	Нөөц хомсдох шалтгаан	Хамгаалсан байдал	Хамгаалах арга хэмжээ
1	<i>Salicaceae</i> Mirb. - Бургасны овог				
1	<i>Populus</i> L				
1	<i>Populus diversifolia</i> Schrenk.- Элдэв навчит улиас	Уртын гол	Олон жил дараалан ган болж хөрсний чийг багасаж хуурайшилт ихсэж байгаагаас үрээр үржих нь саатаж байна. Мөн түлшинд хэрэглэх, гэр ахуйн модон эдлэл хийхэд ашиглаж байна.	БНМАУ-ын улаан ном 1987, Монгол улсын улаан ном, 1997, 2015	Баянбүрдийг улсын тусгай хамгаалалтанд авах, үрээр, үндэсний ичмэл нахиагаар үржүүлэх шаардлагатай.
2	<i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог				
2	<i>Iljinia</i> Korov.				
2	<i>Iljinia Regelii</i> (Vge.) Korov.-	Номгон уул	Тархацын хүрээ багатай, байгалийн зохисгүй	БНМАУ-ын улаан ном 1987 онд ховор	Байгаль дээрээс түүж ашиглахыг



	Регелийн будараа		нөхцөлөөс болж үржиж чадахгүй тайван байдалд ордог.	зүйл, Монгол улсын улаан ном 1997 онд ховор зүйл, 1995 оны хавсралтаар нэн ховор зүйл, улаан ном 2015 онд нэн ховор зүйл	хориглох
3	Rosaceae Juss. -Сарнайн овог				
3	<i>Potaninia Maxim.</i>				
3	<i>Potaninia mongolica Maxim.-</i> Хулан хойрго	Номгон уулын ар хөндий, Дайчингийн заг,	Хуурайшлын улмаас сэргэн ургалт муудсан, цэцэглэдэг боловч үрээ өгөхгүй байна.	БНМАУ-ын улаан ном 1987, Монгол улсын улаан ном, 1997, 2015	Байгаль дах популяцийг нөхөн сэргэх нөхцөлийг судлах, тарьмалжуулах боломжийг эрж хайх, үрийг генийн санд хадгалах
4	Leguminosae Juss. - Буурцагтаны овог				
4	<i>Caragana Lam.</i>				
4	<i>Caragana brachypoda</i> Pojark.- Хойрог харгана	Дэмчог хийд, Оцон Мааньт ууланд.	Хуурайшилт болон мал, амьтан идэж нөхөн сэргэлт, цэцэглэж үрлэхийг саатуулдаг.	Монгол улсын улаан ном, 1997-д ховор зүйл, 1995 оны хавсралтаар нэн ховор, улаан ном 2015	Тарималжуулах боломж эрэлхийлэх
5	<i>Oxytropis DC.</i>				
5	<i>Oxytropis Grubovii</i> Ulzj.- Грубовын ортууз	Галбын говь	Нөхөн сэргэлт удаан, тархац хомс.	Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн хавсралт цэсэнд нэн ховороор бүртгэгдсэн (1995).	Үрийн генийн сантай болох, тарималжуулах шаардлагатай.
5	Zygophyllaceae R. Br. -Хотирын овог				
5	<i>Zygophyllum L.</i>				
5	<i>Zygophyllum Potaninii Maxim.-</i> Потанины хотир	Галбын говь	Цас, борооны үерийн усаар үндсээрээ сугаран урсах, гэмтэх, эмийн зориулалтаар түүх зэргээс болж хомсдсон.	Ботаникийн хүрээлэн, Хэрлэн Баян Улаанд тарималжуулж байгаа.	Тарьж ургуулах, түүж ашиглахыг хориглох
6	Plumbaginaceae Juss. - Хорголжингийн овог				
6	<i>Limonium Mill.</i>				

6	<i>Limonium aureum</i> (L.) Hill ex Ktze.- Алтан бэрмэг	Ханбогд сумын Бага мод	Үндэсийг эмийн зориулалтаар түүж бэлтгэх, гоёл чимэглэлийн зориулалтаар цэцэг бүхий салаатай ишийг хэрэглэх, удаан хугацаагаар мал бэлчээж доройтуулах, ширүүн бороо, мөндөрт цохиулах, арви буурах зэргээр устаж болзошгүй.	Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн хавсралт цэсэнд нэн ховороор бүртгэгдсэн (1995).	Цэцэрлэгт хүрээлэн, парк, сургалтын талбай, эмнэлгийн дэргэд эмийн зориулалтаар тариалах
7 Boraginaceae Juss. - Ноцоргонын овог					
7 Arnebia Forsk.					
7	<i>Arnebia guttata</i> Bge.- Толболт ба шар бэрээмэг	Галбын говь	Нөөц ихтэй боловч хэт хуурай жил ургадаггүй.	Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн хавсралт цэсэнд нэн ховороор бүртгэгдсэн (1995).	Гоёл чимэглэлийн зориулалтаар тарималжуулах
8 Asteraceae Dumort. -Голгэсэртэний овог					
8 Asterothamnus Novopokr.					
8	<i>Asterothamnus centrali-asiaticus</i> Novopokr.- Төв Азийн лавай	Бага мод, Уртын гол	Түлээнд ашиглах, мал, амьтны хөлд нэрвэгдэх зэргээс ховордож болзошгүй.	Монгол улсын улаан ном, 1997, Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн хавсралт цэсэнд нэн ховороор бүртгэгдсэн (1995).	Түүж ашиглахыг хориглох, үрээр тарималжуулах
9 Tugarinovia Iljin.					
9	<i>Tugarinovia mongolica</i> Iljin.- Монгол шар далан	Ханбогд сумын Номгон уул	Цөлийн бүсийн хуурай, хурц нартай, чийг дутагдалтай гандуу хахир нөхцөлд ургадгаас нөхөн төлжих боломж хязгаарлагдмал. Хүний нөлөөгөөр нөөц багассаар байгаа.	Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн хавсралт цэсэнд нэн ховороор бүртгэгдсэн (1995).	Үндсэн нөөц нутгийг тусгай хамгаалалтнад авах, зориудаар тарьж ургуулах
10 Brachanthemum DC.					



10	<i>Brachanthemum gobicum</i> Krasch.- Говийн тост	Ханбогд	Олон жил дараалан ган тохиолдон ус чийгийн хамгамж хомсдон өсөлт хөгжилт зогсонги байдалд орох, ургах чадвар доройтох, нахиа найлзуурыг мал, амьтан идэж гэмтээх зэргээс болж устаж болзошгүй.	Монгол улсын улаан ном, 1997, 2015	Баянзаг орчмыг тусгай хамгаалалтаанд авах, тарималжуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.
11	<i>Artemisia L.</i>				
11	<i>Artemisia xanthochroa</i> Krasch.-Шар шарилж	Ханбогд	Бэлчээрийн чухал ургамал учраас малд хэт идэгдсэнээс хомсдож болзошгүй.	Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн хавсралт цэсэнд нэн ховороор бүртгэгдсэн (1995).	Генийн санг хамгаалах, тарималжуулах хэрэгтэй байна.
8 овог, 11 төрөл, 11 зүйл					

Ховор ургамлын ховордсон шалтгаан. Ховор ургамлын зүйлүүдийг олон чиглэлийн зориулалтаар түүний нөөц, тархац, нөхөн сэргэх, үржих чадварыг харгалзахгүйгээр ихээр бэлтгэж ашиглаад байвал нэн ховор ургамлын ангилал руу шилжих, улмаар устаж мөхөх аюулд хүрэх болно. Тиймээс Өмнөговь аймгийн Ханбогд суманд бүртгэсэн ховор ургамлын ховордож байгаа шалтгаан, хамгаалалтанд авсан байдал, цаашид уг ургамлыг хамгаалах арга хэмжээ зэргийг тодруулж дараагийн хүснэгтээр харуулав.

Хүснэгт 36. Өмнөговь аймгийн Ханбогд сумын ургамлын аймагт бүртгэсэн ховор ургамлын хамгаалал

№	Ургамлын овог, төрөл, зүйлийн нэршил	Тархац	Нөөц хомсдох шалтгаан	Хамгаалсан байдал	Хамгаалах арга хэмжээ
1	<i>Gramineae</i> Juss. Үетэний овог				
1	<i>Phragmites</i> Adans.				
1	<i>Phragmites communis</i> Trin.- Эгэл нишингэ	Тооройн бүрд	Хүн болон мал амьтаны нөлөөнөөс болж ховордоно	Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор энэ зүйлийг ховор ургамлын жагсаалтанд оруулж байгаль дээр нь хямгадах, улмаар зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх, ургаж	Өсөлт, хөгжил, үржлийн болон нөхөн сэргэлтийн биологи, ургахуйн хамгийн тохиромжтой нөхцөл, тархац, нөөцийг нарийвчлан



				буй талбайг дархан газрын сүлжээнд оруулан хамгаалахын чухлыг заажээ	судлалж, байгаль дээрээ нөхөн төлждөг жамыг тогтоож, хадгалагдаг ургах, нөхөн арвижих боломжийг буй болгох
2	<i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог				
2	<i>Agriophyllum</i> M. B.				
2	<i>Agriophyllum pungens</i> (Vahl) Link ex.A. Dietr.- Шивүүрт цулихир	Элсэнд	Нөөцгүй, олон жил үргэлжилсэн ган, хуурайшил, хүчтэй аадар бороо, мөндрөөс улбаалсан усны үер, ширүүн салхи зэрэг байнга тохиолддог байгалийн гамшигт үзэгдлийн нөлөөгөөр энэ зүйлийн тархцын хүрээ хумигдаж, тоо ширхэг нь цөөрч нэн ховор болох буюу их хомсдон устах магадлалтай	Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор энэ зүйлийг ховор ургамлын жагсаалтанд оруулж байгаль дээр нь хямгадах, улмаар зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх, ургаж буй талбайг дархан газрын сүлжээнд оруулан хамгаалахын чухлыг заажээ	Өсөлт, хөгжил, үржлийн болон нөхөн сэргэлтийн биологи, ургахуйн хамгийн тохиромжтой нөхцөл, тархац, нөөцийг нарийвчлан судалж байгаль дээрээ нөхөн төлждөг жамыг тогтоож, хадгалагдаг ургах, нөхөн арвижих боломжийг буй болгох
3	<i>Rosaceae</i> Juss. -Сарнайн овог				
3	<i>Amygdalus</i> L.				
3	<i>Amygdalus mongolica</i> Maxim.-Монгол бүйлээс	Уртын гол	Уул уурхай, түлш, эмэнд хэрэглэх, үр түүх, малын хөлөөр зэрэг хүний үйл ажиллагаанас болж хомсдож байгаа	Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор энэ зүйлийг ховор ургамлын жагсаалтанд оруулж байгаль дээр нь хямгадах, улмаар зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх, ургаж буй талбайг дархан газрын сүлжээнд	Эрдэм шинжилгээний байгууллага, компанийн цэцэрлэг, парк, бага, дунд, их, дээд сургуулийн сургалтын талбайд зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх



				оруулан хамгаалахын чухлыг заажээ	арга хэмжээ авах
4	Leguminosae Juss. - Буурцагтаны овог				
4	<i>Sophora L.</i>				
4	<i>Sophora alopecuroides L.</i> - Үнэгэн сүүлхэй лидэр	Ханбогд, Цагаан хад	Уул уурхай, түлш, эмэнд хэрэглэх, үр түүх, малын хөлөөр зэрэг хүний үйл ажиллагаанаас болж хомсдож байгаа	Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор энэ зүйлийг ховор ургамлын жагсаалтанд оруулж байгаль дээр нь хямгадах, улмаар зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх, ургаж буй талбайг дархан газрын сүлжээнд оруулан хамгаалахын чухлыг заажээ	Өсөлт, хөгжил, үржлийн болон нөхөн сэргэлтийн биологи, ургахуйн хамгийн тохиромжтой нөхцөл, тархац, нөөцийг нарийвчлан судалж байгаль дээрээ нөхөн төлждөг жамыг тогтоож, хадгалагдаг ургах, нөхөн арвижих боломжийг буй болгох
4	<i>Oxytropis DC.</i>				
4	<i>Oxytropis aciphylla Ldb.</i> - Өргөст ортууз	Галбын говь	Нөөцгүй, олон жил үргэлжилсэн ган, хуурайшил, хүчтэй аадар бороо, мөндрөөс улбаалсан усны үер, ширүүн салхи зэрэг байнга тохиолддог байгалийн гамшигт үзэгдлийн нөлөөгөөр энэ зүйлийн тархцын хүрээ хумигдаж, тоо ширхэг нь цөөрч нэн ховор болох буюу их хомсдон устах магадлалтай	Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор энэ зүйлийг ховор ургамлын жагсаалтанд оруулж байгаль дээр нь хямгадах, улмаар зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх, ургаж буй талбайг дархан газрын сүлжээнд оруулан хамгаалахын чухлыг заажээ	Эрдэм шинжилгээний байгууллага, компанийн цэцэрлэг, парк, бага, дунд, их, дээд сургуулийн сургалтын талбайд зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх арга хэмжээ авах

4	<i>Glycyrrhiza</i> L.				
4	<i>Glycyrrhiza uralensis</i> Fisch.- Урал чихэр өвс	Цагаан хад, Уртын гол	Нөөцгүй, олон жил үргэлжилсэн ган, хуурайшил, хүчтэй аадар бороо, мөндрөөс улбаалсан усны үер, ширүүн салхи зэрэг байнга тохиолддог байгалийн гамшигт үзэгдлийн нөлөөгөөр энэ зүйлийн тархцын хүрээ хумигдаж, тоо ширхэг нь цөөрч нэн ховор болох буюу их хомсдон устах магадлалтай	Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор энэ зүйлийг ховор ургамлын жагсаалтанд оруулж байгаль дээр нь хямгадах, улмаар зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх, ургаж буй талбайг дархан газрын сүлжээнд оруулан хамгаалахын чухлыг заажээ	Өсөлт, хөгжилт, үржлийн болон нөхөн сэргэлтийн биологи, ургахуйн хамгийн тохиромжтой нөхцөл, тархац, байршлыг нарийвчлан судалж байгаль дээрээ нөхөн төлждөг жамыг тогтоож, хадгалагдан ургах, нөхөн арвижих боломжийг буй болгох
5 <i>Zygophyllaceae</i> R. Br. -Хотирын овог					
5	<i>Zygophyllum</i> L.				
5	<i>Zygophyllum gobicum</i> Maxim. - Говийн хотир	Хилийн орчимд	Нөөцгүй. Олон жил давтагдаж буй ган хуурайшлын улмаас өсөлт, хөгжилт, цэцэглэх үрлэх нь саатах юмуу зогсох, ширүүн хүчтэй салхи бүхий асгарсан бороонд цэцэг, боловсроогүй үр гэмтэх, салж унах, боловсорсон үр нь үерт урсаж соёолох ургахуйн зохистой бус орчинд очин байрлах зэрэг шалтгаанаар тархацын хүрээ нь хумигдаж, тоо ширхэг нь цөөрч	Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор энэ зүйлийг ховор ургамлын жагсаалтанд оруулж байгаль дээр нь хямгадах, улмаар зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх, ургаж буй талбайг дархан газрын сүлжээнд оруулан хамгаалахын чухлыг заажээ	Эрдэм шинжилгээний байгууллага, компанийн цэцэрлэг, парк, бага, дунд, их, дээд сургуулийн сургалтын талбайд зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх арга хэмжээ авах



			нэн ховор ургамлын дансанд бүртгэгдэх магадлалтай зүйл		
6	<i>Asclepiadaceae</i> R. Br. - Ерөндгөнийн овог				
6	<i>Vincetoxicum</i> N. M. Wolf.				
6	<i>Vincetoxicum sibiricum</i> (L.) Decne. - Сибирь тэмээн хөх	Бага мод	Үр жимс, үрийг ихээр түүж хэрэглэснээр устаж болзошгүй.	Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн хавсралт цэсэнд нэн ховороор бүртгэгдсэн (1995).	Аймгийн цэцэрлэгт хүрээлэн, сумдын сургуулийн сургалтын талбайд ургуулах, генийн санг хадгалах
7	<i>Solanaceae</i> Juss. - Чэсэнцэрийн овог				
7	<i>Lycium</i> L.				
7	<i>Lycium truncatum</i> Wang - Танамал махирс	Бага мод	Нөөцгүй. Олон жил дараалан болж буй ган гачиг, хуурайшлаас шалтгаалан цөлийн нуга, цөлийн хээр болох, бэлчээрийн малын хөлд гишгэгдэх гэмтэх, ширүүн мөндөрт цохигдож цэцэг юмуу дутуу боловсорсон үр нь унаж сарних зэрэг шалтгаанаар нэн ховор ургамлын жагсаалтанд орох магадлалтай зүйл	Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор энэ зүйлийг ховор ургамлын жагсаалтанд оруулж байгаль дээр нь хямгадах, улмаар зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх, ургаж буй талбайг дархан газрын сүлжээнд оруулан хамгаалахын чухлыг заажээ	Эрдэм шинжилгээний байгууллага, компанийн цэцэрлэг, парк, бага, дунд, их, дээд сургуулийн сургалтын талбайд зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх арга хэмжээ авах
8	<i>Orobanchaceae</i> Vent. - Гувшаахайн овог				
8	<i>Cistanche</i> Hoffm. et Link.				

8	<p><i>Cistanche feddeana</i> Нао - Феддийн аргамжин цэцэг</p>	<p>Оюутолгой орчимд</p>	<p>Нөөцгүй, олон жил үргэлжилсэн ган, хуурайшил, хүчтэй аадар бороо, мөндрөөс улбаалсан усны үер, ширүүн салхи зэрэг байнга тохиолддог байгалийн гамшигт үзэгдлийн нөлөөгөөр энэ зүйлийн тархцын хүрээ хумигдаж, тоо ширхэг нь цөөрч нэн ховор болох буюу их хомсдон устах магадлалтай</p>	<p>Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор энэ зүйлийг ховор ургамлын жагсаалтанд оруулж байгаль дээр нь хямгадах, улмаар зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх, ургаж буй талбайг дархан газрын сүлжээнд оруулан хамгаалахын чухлыг заажээ</p>	<p>Өсөлт, хөгжил, үржлийн болон нөхөн сэргэлтийн биологи, ургахуйн хамгийн тохиромжтой нөхцөл, тархац, нөөцийг нарийвчлан судалж байгаль дээрээ нөхөн төлждөг жамыг тогтоож, ургах, нөхөн арвижих боломжийг буй болгох</p>
9 Asteraceae Dumort. -Голгэсэртэний овог					
9	<i>Artemisia L.</i>				
9	<p><i>Artemisia santolinifolia</i> Turcz. ex Bess.- Хар шарилж</p>	<p>Уулын гаралтай сайраар</p>	<p>Нөөцгүй, олон жил үргэлжилсэн ган, хуурайшил, хүчтэй аадар бороо, мөндрөөс улбаалсан усны үер, ширүүн салхи зэрэг байнга тохиолддог байгалийн гамшигт үзэгдлийн нөлөөгөөр энэ зүйлийн тархцын хүрээ хумигдаж, тоо ширхэг нь цөөрч нэн ховор болох буюу их хомсдон устах магадлалтай</p>	<p>Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор энэ зүйлийг ховор ургамлын жагсаалтанд оруулж байгаль дээр нь хямгадах, улмаар зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх, ургаж буй талбайг дархан газрын сүлжээнд оруулан хамгаалахын чухлыг заажээ</p>	<p>Өсөлт, хөгжил, үржлийн болон нөхөн сэргэлтийн биологи, ургахуйн хамгийн тохиромжтой нөхцөл, тархац, нөөцийг нарийвчлан судалж байгаль дээрээ нөхөн төлждөг жамыг тогтоож, хадгалагдаг ургах, нөхөн арвижих боломжийг буй болгох</p>
9	<p><i>Artemisia rutifolia</i> Steph. ex Spreng.- Шаргал шарилж</p>	<p>Номгон, Ханбогд уул</p>	<p>Хүн, мал, амьтаны нөлөө болон байгалийн янз бүрийн сөрөг нөлөөнөөс болж</p>	<p>Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор энэ зүйлийг ховор</p>	<p>Тархац, байршилыг нарийвчлан судалж байгаль дээрээ нөхөн төлждөг жамыг тогтоож,</p>



			ховордож болзошгүй	ургамлын жагсаалтанд оруулж байгаль дээр нь хямгадах, улмаар зориуд ургуулан генийн санг хадгалан үлдээх, ургаж буй талбайг дархан газрын сүлжээнд оруулан хамгаалахын чухлыг заажээ	хадгалагдан ургах, нөхөн арвижих боломжийг буй болгох, зориуд ургуулж генийн санг хадгалан үлдээх.
9 овог, 12 төрөл, 13 зүйл					

Өмнөговь аймгийн Ханбогд сумын бэлчээрийн даац, багтаамж

Ханбогд сум нь нийт 1496441.4 га бэлчээрийн талбайтай, 1 га-ийн дундаж ургац 95.0 кг/га байна. Бэлчээрийн талбайн нийт нөөцийг тооцоход 142161933кг/га буюу малд идэгдэх бодит нөөц нь 71080967кг/га, хонин толгойд шилжүүлснээр 149801.83 хонь бэлчээрлэх боломжтой байна. Бэлчээрийн даац багтаамж нь бэлчээрийн төлөв байдал, ашиглалтын эрчимд үнэлгээ өгөхөд чухал үзүүлэлт болдог бөгөөд цаашид бэлчээрт авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн суурь нь юм. Ханбогд сумын 2016 оны байдлаар бэлчээрт буй малын тоог дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 37. Ханбогд сумын малын тоо, хонин толгойд шилжүүлснээр

д/д	Малын төрөл	Малын тоо	Хонин толгойд шилжүүлснээр
1	Хонь	41916	41916
2	Ямаа	71228	64105.2
3	Үхэр	4368	21840
4	Адуу	8290	49740
5	Тэмээ	25644	179508
Нийт		151446	357109.2

2016 онд Ханбогд сумын мал эмнэлэг үржлийн албаны мэдээгээр нийт 151446 толгой буюу хонин толгойд шилжүүлснээр 357109.2 толгой мал бэлчээрлэж байгаа бөгөөд бэлчээрийн бодит чадавхитай харьцуулахад 238.4 хувийг нь ашиглаж байгаа нь тус сумын бэлчээрийн даац 138.4% буюу 1.3 дахин хэтэрсэн байна. Говийн бүсийн бэлчээрийн ургамлан бүрхэвч сийрэг, хөрсний бүтэц сул хөгжилтэй, хур тунадас бага ордог зэргээс шалтгаалан бэлчээр доройтох бэлчээрийн ачаалал хэтрэх нөхцөл бүрддэг тул цаашид мал

сүргийн тоог барьж бэлчээрийн ачааллыг энэ түвшинд нь хадгалахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх нь чухал юм.


Ханбогд сумын мал эмнэлэг үржлийн албаны мэдээгээр нийт 133013 толгой буюу хонин толгойд шилжүүлснээр 317415.3 толгой мал бэлчээрлэж байгаа бөгөөд бэлчээрийн бодит чадавхитай харьцуулахад 64.91 хувийг нь ашиглаж байна. Судлаач Н.Лхагжавын тодорхойлсноор бэлчээр ашиглалтын эрчим 45.0 -60.0 хувь байх нь тохиромжтой бэлчээрийн ургамал байгалийн аясаар нөхөн төлжих нөхцөл бүрддэг гэдгийг тодорхойлсон байдаг.

Эндээс үзэхэд Ханбогд сумын даац хэтрээгүй, бэлчээрийн ачаалал багатай. Цаашид мал сүргийн тоог барьж бэлчээрийн ачааллыг энэ түвшинд нь хадгалахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх нь чухал юм. Говийн бүсийн бэлчээрийн ургамлан бүрхэвч сийрэг, хөрсний бүтэц сул хөгжилтэй, хур тунадас бага ордог зэргээс шалтгаалан бэлчээр доройтох бэлчээрийн ачаалал хэтрэх нөхцөл бүрддэг.

2.5.2. Ургамалжилт, төрөл

Ханбогд сумын гадарга нь өөр хоорондоо ялгаа бүхий ландшафттай бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 31.0 хувийг бүс дундын голийн хөндий, нам хотсын бэлчээрийн ургамал, 24.0 хувийг дундаж өндөр ба нам бэсрэг уул ургамлын бэлчээр, 10.0 хувийг заган ой, 11.0 хувийг говь цөлийн бэлчээрийн ургамал, 23.0 цөлөрхөг хээрийн бэлчээрийн ургамал тархсан байна.

Зураг 25. Ургамалжилтын зураг





Хүснэгт 38. Сумын бэлчээрийн ургамлын анги, төрөл зүйл, эзлэх талбай


Зураг дээрх индекс	Ангилалын шифр	Бэлчээр хадлангийн анги, бүлэг төрөл, төрлүүдийн нэр	Талбай
У-VII		Анги: Уулын бор, бор саарал хөрстэй говь цөлийн бэлчээр	
76a	У-VII-2-3	Холимог сөөгт сул талхлагдал	94496.85135
76-246	У-VII-2-3-БТ-2	Холимог сөөгт-Хад, цохио, аслагдах	6919.94875
76	У-VII-2-3	Холимог сөөгт	5123.963207
75a-145a	У-VII-Б-2	Шар мод сул- Монгол өвс - шавагт	20780.34436
74*232	У-VII-2-1-Н-IV-2-1	Тэсэг - боролзой - шавагт-шавагт	17325.50437
74	У-VII-2-1	Тэсэг - боролзой - шавагт	29187.94376
73-167	У-VII-1-3-Ц-I-1-5	Бударгана-монгол өвст-Бударгана	4165.61975
73-145	У-VII-1-3-ЦХ-I-1-4	Бударгана-монгол өвст-Монгол	12130.15612
62	У-VI-1-5	Монгол өвс - шавагт	4661.95939
61	У-VI-1-5	Монгол өвс - таанат	14412.58583
Н-V		Анги:Уулын бэл хормойн гуу жалгын бүрдэлтэй сайр	
248+184	БТ-4+Ц-II-1-3	Элс-Үетэн-агь-алаг өвст	3414.471885
248*184	БТ-4+Ц-II-1-3	Элс-Үетэн-агь-алаг өвст	16296.30687
244	Н-V-3-2	Сийрэг заг-зээргэнэт	3936.117063
243с	Н-V-3-1с	Холимог сөөгт хүчтэй талхл	33257.30669
243	Н-V-3-1	Холимог сөөгт	48850.35896
242a	Н-V-2-1	Шарилж - шавагт сул талхлаг	19879.78449
242	Н-V-2-1	Шарилж - шавагт	19281.49774
239	Н-IV-3-2	Сийрэг загт	12416.26562
238	Н-IV-3-1	Хармагт	9701.836272
237-72	Н-IV-2-6-У-V-1-2	Бударгана-хармагт-Баглуурт	13390.161
237	Н-IV-2-6	Бударгана-хармагт	7358.254536
236	Н-IV-2-5	Бударгана-дэрст	252653.6105
235	Н-IV-2-4	Бударганат	12174.19507
232	Н-IV-2-1	Шар бударгана-дэрст	4230.351184
231	Н-IV-1-2	Шарилж шаваг-бударганат	27209.58381
Ц-II		Анги: Говь товцог бөөрөг элсний сул бэхжсэн элсний бэлчээр	
184*248	Ц-II-1-3	Үетэн-агь-алаг өвст-Элс	1077.22605

183	Ц-II-1-2	Суль-элсний шарилжит	2099.438472
180	Ц-I-2-8	Холимог сөөгт	26640.11944
169	Ц-I-1-7	Сийрэг бударганат	27158.13579
168+169	Ц-I-1-6	Улаан бударгана- бударганат-	46701.76987
168	Ц-I-1-7	Улаан бударгана- бударганат	56608.96126
167	Ц-I-1-5	Бударгана-монгол өвс - таана	1757.617946
ЦХ-I		Гүвээрхэг болон тэгшивтэр хөндийн цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээр	
158с	ЦХ-I-2-2	Таана-монгол өвст хүчтэй талхлагдсан	49591.84415
158	ЦХ-I-2-2	Таана-монгол өвст	2929.533106
154	ЦХ-I-2-13	Хазаар өвс- таана- жигжиг алаг өвст	5708.240521
149	ЦХ-I-1-8	Монгол өвс-баглуурт	91041.6511
148	ЦХ-I-1-7	Монгол өвс-таана- бударгана	129568.9623
146с	ЦХ-I-1-5	Монгол өвс - харганат хүчтэй талхлагдсан	50138.23937
145-76	ЦХ-I-1-4	Монгол өвс - шавагт- Холимог	4860.684321
145	ЦХ-I-1-4	Монгол өвс - шавагт	1835.619655
143	ЦХ-I-1-2	Монгол өвс - хазаар өвст	8349.222211
190	ЦХ-II-4-3	Заган ой	149772.6346

2.5.3. Сумын бэлчээрийн ургамалжилтын төрх байдал, доройтол

Сумын нийт нутаг дэвсгэрийн бэлчээрийн төрх байдлын 35.7 хувийг сөөгтэй бэлчээр, 27.3 хувийг чулуутай бэлчээр, 9.3 хувийг заган ойтой бэлчээр тус тус эзэлж байна.

Зураг 26. Бэлчээрийн төрх байдлын зураг



Хүснэгт 39. Бэлчээрийн төлөв байдал, талбайн хэмжээ

№	Экологийн төрөл	Талбайн хэмжээ /га/	Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь
1	Сумын төв	76.8	0.005
2	Нуур	401.2	0.027
3	Ой	140560.7	9.391
4	Үйлдвэр уурхай	8512.8	0.569
5	Цэвэр бэлчээр	358279.6	23.938
6	Чулуутай бэлчээр	408616	27.301
7	Сөөгтэй бэлчээр	535248.9	35.762
8	Довонтой бэлчээр	44989	3.006
Нийт		1496685	100.0

2.6. ОЙН ТӨЛӨВ БАЙДАЛ


2.6.1. Ойн нөөц

Ойн сан бүхий газар тус сумын хувьд заган ой, түүний эзэлж буй талбайн цоорхой, мод үржүүлгийн талбай, ойн аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд олгосон газар зэргээс бүрдэнэ. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд 2016 онд хоолой суурилуулах шаардлагын улмаас тодорхой хэмжээний заг бүхий талбай хөндөгдсөн. Иймээс “Оюутолгой” ХХК ойн нөхөн сэргээлтийн ажлыг 2013 оноос тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлж ирсэн. Нийт 6.6 га талбайд 10677 ширхэг загийн бортоготой суулгац тарьснаас 79.9 хувийн амьдралтай буюу өвлийг даван ургасан. Мөн дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд 15 га загийн суулгац тарьхаар төлөвлөсөн. Заган ойн фондын газар Ханбогд суманд нийт заган ойн сан бүхий газрын 68.2 хувь нь байгаа юм.

Тухайн сумын хэмжээнд хаягдсан далангийн тоо 190, үүнээс нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн 148, хүлээлгэж өгөөгүй 52, ашиглаж байгаа 44 байна. 2016 оны эцсийн байдлаар 1522.83 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгээд байна.

Ханбогд сумын нутаг дэвсгэрийн 9.3 хувьд ой тархсан. Ойн талбайн дийлэнх хэсгийг заган ой эзэлж байна.

Зураг 27. Шавартай заг, хар загт заган ой тархсан нутаг




Хүснэгт 40.Сумын нутаг дэвсгэрт тархсан ойн төрөл

№	Ойн төрөл	Талбай, га	Эзлэх хувь
1	Заган ой	116554.5	98.9
2	Заггүй талбай	1291.16	1.1
Нийт		117845.66	100

2.6.2. Ойн төлөв байдал

Сумын ойн талбайн 33.4 хувийг ойгоор бүрхэгдээгүй буюу тармаг заг эзэлж байгаа бол 59.6 хувийг болц гүйцсэн заган ой тус тус эзэлж байна.

Зураг 28. Ойн төлөв байдлын зураг



Хүснэгт 41. Ойн төлөв байдал, талбайгаар

№	Ойн төлөв байдал	Талбайн хэмжээ /га/	Нийт ойн талбайд эзлэх хувь
Ойгоор бүрхэгдсэн			
1	Болц гүйцсэн заг	70231.2	59.6
2	Болц гүйцэж буй заг	573.1	0.5
3	Заг түүсэн талбай	587.3	0.5
4	Хатсан заг	727.6	0.6
5	Дунд насны заг	2924.03	2.5
6	Залуу заг	2410.7	2.0
7	Заггүй талбай	1071.4	0.9
8	Тармаг заг	39320.1	33.4


2.7. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ

2.7.1. Гадаргын ус

Сумын хэмжээнд 365 худаг, өрөмдмөл 8, богино яндант 12, энгийн худаг 340, инженерийн хийцтэй худаг 2438, гар худаг 78, рашаан булаг 44 байна. Тухайн сумын хэмжээнд 67 голын эх үүсвэртэй байна. Үүнээс 69.0 хувь нь гүехэн гар худаг, 80.0 хувь нь 2 м хүрэхгүй гүнтэй, 21.0 хувь нь гүний худаг, 85.0 хувь нь цоожтой. Устай 22 булаг, ус багатай 14, ширгэсэн 20 гаруй булаг байна. Жавхлант, Гавилууд багуудад худгийн ундарга

удаан, тогтоол ус, задгай ус ширгэсэн, Гавилуудад ажиллагаатай худаг байхгүй болсон байна. Баян, Номгон багуудад бэлчээр сайтай газруудад худаг хангалтгүй, өндөрлөг газруудад ус хомс байна. Халив-Дугатын голдирлыг өөрчилснөөс болж хэд хэдэн усны голдирол өөрчлөгдөж, бэлчээрийн талхлагдалд нөлөө үзүүлж байна. Иймээс цаашид тухайн голын голдирлын бүрэн бүтэн байдлыг сайжруулах хэрэгтэй.

Зураг 29. Гадаргын усны зураг



Ханбогд сумын хойд болон өмнөд талаар орших Хараат уул, Гурван хараат уул, Ханбогд зэрэг уулсуудаас орж ирэх түр зуурын урсгал усны голдирлуудаар зун намрын эрчимтэй орсон борооны үед гадаргын урсац орж ирж жижиг тойрмуудыг үүсгэдэг. Харганатын хоолой, Шунхтын хоолой, Халивын хөндий, Таван модны хөндий, Галбын говь зэрэг томоохон хөндийгөөр хур борооны дараа түр зуурын урсац үүсэж, зарим үед гол хэлбэртэй тодорхой хугацаанд урсадаг. Ийм голуудын тоонд Харганатын гол, Ухаа загийн гол, Баян сухаан гол, Бага булгийн, Их булгийн голууд орно. Ханбогд болон Шавагтай, Халзан овоо, Алаг баян зэрэг уулсаас хур тунадас ихтэй жилүүдэд уулын тодорхой талбайд ус цугларан түр зуурын булаг үүсч, тодорхой хугацаанд урсац үүсгэдэг. Ийм булгийн тоонд Ханбогд уулаас хойш чиглэж урсадаг Их, Бага булаг, Баянгийн задгай, Ухаа загийн булаг зэргийг нэрлэж болно. Эдгээрээс хамгийн том нь сумын төвийн урд талаар урсадаг Их булаг бөгөөд түүний урсацын хэмжээ нь дунджаар 1.3-6 л/с, урсацын өргөн 0.4-1 м хүрдэг. Бага булгийн хувьд Ханбогд сумын төвийн баруун талд түүнээс 12 км зайтай, дээд хэсэгт нь 35 м голчтой жижиг нуур байдаг бөгөөд энэ нь хур бороо орсны дараа тэр орчмын усаа цуглуулан

хамгийн гүн газартаа 5 м хүртэл гүнтэй болдог. Ус нь харьцангуй цэнгэг, зөөлөн бөгөөд ихээхэн гантай жилээс бусад жилүүдэд байнга шахам байдаг. Энэхүү нуурын түвшин нь ихсэхээр түүнээс Бага булаг эх аван тухайн орчны түр зуурын урсацыг нэгтгэдэг.

Шүүрэлттэй цооногуудыг хаах, битүүмжлэх үйл ажиллагаагаар гүний хоолой, Галбын говьд 2003-2004, 2007 онуудад усны эрэл, хайгуулын зориулалтаар өрөмдсөн нийт 43 цооногуудад дурангийн судалгааг 2012, 2014 онуудад явуулж 2012 онд (GHW4x6, GHW5x1, GHW6x1, GHW14x1, GHEB-08, GHEB-02) 6 цооног, 2014 онд (GGW6, GGW19) 2 цооног дотоод мониторингийн үр дүнгээр (GHEB-01) 1 цооног нийт 9 цооногийг гоожилттой болохыг нь тогтоосон. Сав газрын захиргаанаас мониторингийн багаж төхөөрөмж суурилуулан мониторингийн зориулалтаар ашиглаж байна. Үлдсэн 32 цооногт ямар нэг байдлаар шүүрэл явагдаагүй (2012, 2014 хийсэн цооногийн дурангийн судалгаагаар тогтоосон) боловч дээрх цооногууд нь битүүмжилсэн 9 цооногтой ижил бүтэцтэй тул Галба-Өөш Долоодын говийн сав газрын зөвлөмжийн дагуу жил болгон шат дараалалтайгаар битүүмжлэн орон нутагт хүлээлгэн өгөх ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. 2016 онд Галбын говьд артезийн даралттай уст үед өрөмдсөн GGW47, GGW20 дугаартай цооногуудыг мал услах зориулалтаар тоноглоон орон нутагт актаар хүлээлгэн өгсөн. Артезын цооног тохижуулан хүлээлгэн өгөх “Оюутолгой” ХХК-ны 2003-2004 онд хийсэн газар доорх усны хайгуул судалгааны үед Галбын говьд GGW20 болон GGW47 гэсэн хоёр артезын цооног (газрын гадаргад ус оргилон гардаг цооног)-ийг өрөмдсөн бөгөөд орон нутгийн ард иргэдийн хүсэлтийн дагуу эдгээр цооногуудад крант суурилуулан засвар үйлчилгээг нь 2005-2014 оны хооронд хийж ирсэн. Эдгээр оргилдог цооногуудын ашиглах, тохижуулж өгөх тухай хүсэлтүүд малчдын зүгээс удаа дараа ирдэг байсан бөгөөд 2016 онд дээрх 2 цооногийг тохижуулан сумын орон нутагт хүлээлгэн өгсөн.

2.7.2. Газрын доорх ус

Сумын гидрогеологийн нөхцөл:

Ханбогд сумын нутагт толгойн зэс алтны орд нээгдсэнтэй холбоотой Галбын говь, Гүний хоолойн зэрэг гидрогеологийн бассейнуудад судалгаа эрчимтэй явагдаж байна. Галбын говийн хотгор урд захаараа Даланшар (1113.6м), Шовын хүрэн (1165.8м), Номгонуул (1161.0м) орчмын бөмбөгөрдүү оройтой аажим налуу гадаргуутай нам уулсаар (гидрогеологийн массивуудаар), гүний хоолой хойд захаараа Улаануул, зүүн талаараа Алаг баян зэрэг нам уулс, бие биенээсээ тусгаарлагдсан багавтар өргөгдлүүдээр хүрээлэгджээ. Ханбогдын өргөгдөл гүний хоолойн хөндийтэй нилээд огцом байдлаар нийлдэг. Уг хөндийн урд жигүүрээр 70 гаруй км үргэлжилэх томоохон сайр хөндийн суналын дагуу үргэлжилдэг ба уг сайраас хойш тэгшивтэр долгиолог гадаргуу зонхилж, идэгдэх угаagdлын мөргөцөг бүхий тэгшрэлийн үлдэц ухаа цав, толгод гадаргын өвөрмөц бичил хэв шинжийг бүрдүүлнэ.

Уг хөндий нь зүүн хойт чигт төлөгийн талын үргэлжилтэй нийлэх ба зүүн чигт Цовчирын говийн чигт үргэлжилнэ. Гадаргуугын өндөршлийн хувьд Галбын говийн хөндийгөөс харьцангуй өндөр байрлалтай ба зүүн урагш аажим намсдаг. Гадаргын хамгийн нам цэгийн үнэмлэхүй өндөр 930-940 м. Галбын говийн бассейн төв хэсгээрээ 870-940 м үнэмлэхүй өндөртэй, нуурын тэгш ёроолт хотгор түүнээс дээш нам уулсын чигт аажим шатлан өндөрсөх (980м) тэгшрэлийн үлдэц бүхий элэгдэл хуримтлалын гадаргуутай баруун талаараа Заг сүүжийн говь зүүн, зүүн хойш Дуутын ойрмын чигт 150-170 км орчим үргэлжилдэг.

Галбын говь ба Гүний хоолойн гидрогеологийн бассейнүүдэд газрын доорх усны тархалт, хөдөлгөөн хуримтлалын онцлогууд, ус агуулагч чулуулгийн литологи-петрографийн найрлага, давхарга зүйн ангиллыг харгалзан дараах уст үе давхарга, цогцолборуудыг ялгаж болно. Үүнд:

1. Дээд дөрөвдөгч сэвсгэр хурдас дах уст үе давхарга (Q ii-iv)
2. Дунд-дээд дөрөвдөгчийн сэвсгэр хурдас дах алаг цоог тархалттай газрын доорх ус (Q ii-iii)
3. Дээд цэрдийн Баянзаагийн давхаргадсын тунамал хурдасны уст үе давхарга (K2 bz)
4. Дээд цэрдийн Баянширээгийн давхаргадсын тунамалхурдасныустүедавхарга (K2bs)
5. Дээд цэрдийн Сайншандындавхаргадсынтунамалхурдасныустүедавхарга.(K2ss)

Доод цэрдийн Хөх тээгийн давхаргадсын тунамал хурдасны зузаалаг дах алаг цоог тархалттай газрын доорх ус (K1ht) Судалгаагаар Галбын говийн гидрогеологийн бассейнд газар доорх усны ордыг илрүүлэн ашиглалтын таамаг нөөцийг 31967 м³/хон, Гүний хоолойн гидрогеологийн бассейнд С, зэрэглэлээр 53136 м³/хон нөөцтэй газар доорх усны ордыг илрүүлж, цаашид нарийвчилсан гидрогеологийн судалгаа явуулах нь зүйтэй юм.

Хүснэгт 42. Газрын доорх усны нөөц баялгийн нөхцөлийн шалгуур

Далайн түвшнээс дээших өндөр, м	Хотгор гүдгэрийн дундаж хэвгий	Геологи-тектоникийн тогтоц /давамгайлах төрлөөр нь /	Хур тунадас, мм	Гадаргуугийн урсац /олон жилийн дундаж/, мм	Газрын доорх урсац /жилийн дундаж/, мм	Газрын доорх усны нөхөн сэргээгдэх чадвар	Зонхилон тархсан уст үеийн				Ашиглалтын нөөцийн модуль л/с.км ²	Газрын доорх цэнгэг усны нөөцийн хангамшлын нөхцөл
							үндсэн төрөл	Усжилт л/с	Уст үеийн зузаан, м	Ус дамжуулах чадвар, м/хон		
1000-1500	1.5-3.0	Хотгор р kz-Q	155-200	5-10	30-50	Дунд	Q-kz-н ул хөрсний Mz-Kz н үе	0.5-5.0	5-30	200-300	20-3	сайн
1500-2000	3.0-6.0	Q-н элс хайргын хуримтлал	200-225	10-50	50-100 >100	Сайн	Q-н зузаан ул хөрсний	1-20.0	10-50	100-500	>3-4	Нэн сайн
2000-5000	6.0-12.0	Q-н хуримт-лал, kz-өргөгдөл	225-250	50-100	20-50	Дунд	Q-н ба ан цавт ул хөрсний	0.5-10.0	1-10	50-100	2-3	Дунд
2500-3000	12.0-20.0	Kz-Mz өргөгдөл	250-300	100-200	20-10	Дунд	Q-н ба цавт ул хөрсний, тектоник хагарал, судлын	0.1-5.0	2.5	20-50	0.5-1.0	Дунд юм уу муу
3000-4000	20.0	PZ-Mz-Kz өргөгдөл	300-400	200-300	<10	Муу	Ан цавт ул хөрсний, тектоник хагарал судлын	0.1-3.0	1-5	5-20	0.5-аас бага	Муу, маш муу

Гидрогеологийн райончлол, гидродинамикийн нөхцөл, газрын доорх усны баялаг үүсэн бүрэлдэх ерөнхий зүй тогтол

Гидрогеологийн райончлол нь газрын доорх усны үүсэн бүрдэлт тархалтын ерөнхий зүй тогтлын талаархи судалгааны материал, онолын дүгнэлтүүдийг нэгтгэн үнэлдэг, гидрогеологийн зураглалын үндсэн элементүүдийн нэг юм. Региональ гидрогеологийн 2 үндсэн чиглэл зонхилж байна. Нэг дэх нь аналитик арга буюу чөлөөт гадаргатай түрэлтэд усны тусад нь райончлох арга юм. Энэ аргыг санаачлагчид чөлөөт гадаргатай ус нь ландшафт-газарзүйн түрэлтэд ус нь геологи структурын бүсжилтэнд хамаарагдах учраас райончлол нь

харилцан өөр зарчмаар явагдах ёстой гэж үздэг. Нөгөө хоёр дах арга нь синтетик арга буюу чөлөөт гадаргатай, түрэлтэд усыг нэгтгэн үздэг. Энэ арга нь райончлолын бүхий л хүчин зүйлүүдийг харилцан уялдаатай нэгдмэл байдлаар авч үздэгээрээ давуу юм. Монгол Алтайн ба Говь - Тянь - Шанийн атираат уулсын гидрогеологийн район нь зураглалын талбайн хойт, дунд өмнөд хэсгийн 14,650 км талбайг хамааран орших ба уул зүйн хувьд Монгол Алтайн нурууны салбар уулсын дунд хэсэг юм. Геоморфлогийн хувьд районы дунд хэсэг буюу Алтан уул, Нэмэгт, Гилбэнт сэврэйн 2273-2632.0 м үнэмлэхүй өндөрлөг уулсын эрчимтэй хэрчигдсэн бага буюу эгц налуутай рельеф хөгжсөн болон талбайн дунд хэсэг буюу Монгол Алтайн салбар уулсын 2 дах эгнээнд багтах, Гостын нуруу, Хүрэн ханангийн нурууны 2047-2397.0 м үнэмлэхүй өндөртэй бага налуутай рельеф хөгжсөн бол талбайн зүүн доод өнцөгт 1261-1511.0 м өндөртэй намхан уулсаас тогтсон сэврэн хадат гүвээ толгодорхог структур зөөгдлийн төрлийн рельеф үлэмж хөгжсөн байдаг. Энэхүү район нь геологи структурын хувьд доод давхар болох интрузив чулуулгийн гидрогеологийн массив (ГМи), галт уулын чулуулгийн адмассив (ГАМэф), терриген чулуулгийн антиклиналь атираат адмассив (ГАМт), терриген чулуулгийн синтиклиналь атираат интермассив гэсэн структуруудын нэгдэл юм. Интрузив чулуулгийн гидрогеологийн массив нь хожуу перм, эхэн ба хожуу чулуун нүүрсний, түрүү чулуун нүүрсний, дээд девоны - түрүү чулуу нүүрсний насны янз бүрийн найрлагатай гүний чулуулгуудаас бүрдэх бөгөөд ан цав - ан цав судлын төрлийн коллектор зонхилдог. Монгол - Алтайн ба Говь - Тянь Шанийн атираат уулсын гидрогеологийн районы гидродинамик нөхцөлд гидрогеологийн структурын тогтоц, цаг уур, рельефийн нөхцөл, гол нөлөө үзүүлдэг. Бүс нутгийн хэмжээнд авч үзвэл гидродинамикийн хоёр бүс ялгаж үзэх боломжтой юм. Гидродинамикийн дээд бүс буюу усан солилцооны эрчимтэй бүс нь өгөршлийн ан цавын дээд хэсэг болох 50-60 м-ийн гүнийг хамарна. Үүнээс цааш ан цав нь маш бага, бараг цул болж усан солилцооны эрчим буурдаг. Гагцхүү их гүнд ан цавшил, бутралт үүсэх усжилт бий болох, тектоник, ан цавуудтай холбоотой юм. Тектоник хагарлын бүсийн дагуу усжилт нь нэмэгдэх, тухайн бүс нутагт түгээмэл ашиглагдах бөгөөд ус дамжуулалт нь өгөршлийн региональ ан цавуудад 10-50 м/хон байхад хагарлын бүсүүдэд илүү их байна.

Гидродинамикийн дээд бүсийн хэмжээнд сүүлийн хоёр хүчин зүйл нь голлох үүрэгтэй. Дээрх районы өндөр уулсын хэсэгт унах хур тунадасны хэмжээ их, ууршилт бага зэргээс хамааран газрын доорх усны нийт баялагийн ихэнх нь энэ хэсэгт бий болдог.

Судалгааны талбайн хэмжээнд:

- **Неопротерозой (NP)**
- **Палеозойн (PZ)**
- **Мезозойн (MZ)**
- **Кайнозой (KZ)**

эриний тунамал, вулканоген, интрузив чулуулгууд тус тус тархсан байдаг ба эдгээрийг галав бүрээр нь чулуулгийн литологи онцлог байдлаар тусд нь доорх байлаар бичлээ.

Неопротерозой (NP):

Протерозой (PR₁): Гантиг, гялтгануурт-плагиоклазат талст занар, боржин-гнейс, гранодиорит-гнейс, диорит-гнейс, хааяа мигматит хамаарна.

Доод-дунд Рифей (R₁₋₂): Хувирмал занар, хоёр гялтгануурт кварцит, гантигийн үе агуулсан кварц-серицитит занар, хувирмал элсэн чулуу, цахиурлаг алевролит.

Дунд-дээд Рифей (R₂₋₃): Гантигжсан цахиурлаг шохойн чулуу, кварцит, гантиг элслэг шохойн чулуу, элсэн чулуу, цахиурлаг алевролит, конгломератын мэшил.

Палеозойн PZ:

Венд кембрий (Y-E): Ногоон чулууны хувиралд автсан базальт, андезибазальт тэдгээрийн туф, туф элсэн чулуу, цахиурлаг алевролит, элсэн чулуу, андезидацит, риодацит, ховроор гантигжсан шохойн чулуу.

Түрүү-дунд Силурын Төмөртийн давхаргадас (S_{1-2 tm}): Ягаан хүрэн, хөх, хүрэн, саарал өнгийн конгломерат, гравелит, занаржсан элсэн чулуу, алевролит, алевропелит шаварлаг занар, туффит, хааяа кварцит, шохойн чулууны мэшилүүд.

Түрүү Девоны Эхийн голын давхаргадас (D_{1eg}): Андезидацит, андезибазальт, дацит, риолоит, тэдгээрийн туф, туффит, туфосилицит, туфотерриген чулуулаг, хааяа шохойн чулуу, хасын мэшилүүд.

Түрүү Карбоны Сайнианд худгийн давхаргадас (C_{1 sh}): Туф элсэн чулуу, туфоалевролит, андезит, андезидацит, литокласт, кристаллокласт, үнсэрхэг туфууд, туффит, конгломерат, гравелит, микститийн үеүд, хааяа шохойн чулууны мэшил.

Түрүү-хожжуу Карбоны Мөрөгцөгийн давхаргадас (C_{1-2mr}): Андезидацит, андезибазальт, тэдгээрийн туф, туфоконгломерат, туф элсэн чулуу, туфоалевролит, туффит, хааяа элсэн чулуу, алевролитын үеүдтэй.

Хожжуу Карбоны Цохиотын давхаргадас (C_{2ch}): Андезидацит, андезибазальт, риодацит, риолоит, тэдгээрийн туф, туф элсэн чулуу, туфоалевролит, туффит, хааяа элсэн чулууны мэшил, конгломерат.

Хожуу Карбон-Түрүү Пермийн Агуй уулын давхаргадас (C-P_{1au}): Шохойн чулуу, аркозын элсэн чулуу, занаржсан элсэн чулуу, калькаренит.

Түрүү-дунд Пермийн Хэц уулын давхаргадас (P_{1-2hu}): Базальт, андезибазальт, тэдгээрийн туф, гиалокластит, туффит, туфосилицит, конгломерат, элсэн чулуу, алевролит, олистостромьын үетэй.

Түрүү-дунд Пермийн Ангилагдаагүй доод-дээд нэгтгэл (P₁₋₂): Риолит, дацит, андезибазальт, андезит, андезидацит, тэдгээрийн туф, конгломерат, элсэн чулуу, игнимбрит, диабаз, хааяа шохойн чулууны мэшилтэй.

Дунд Пермийн Жирэмийн давхаргадас (P_{2jr}): Ногоон саарал, алаг өнгийн конгломерат, элсэн чулуу, алевролит, хүчиллэг эффузив, туф, шохойн чулуу.

Дунд-хожуу Пермийн Луугийн голын давхаргадас (P_{1-3 lg}): Доод зузаалаг нь конгломерат, том ба бул чулуун хайрга, элсэн чулуу, гравелит, алевролит, хааяа шохойн чулууны мэшилтэй. Дунд зузаалаг нь хар саарал, хар, саарал, дунд-жигжиг ширхэгтэй элсэн чулуу, алевролит, шаварлаг занар. Дээд зузаалаг нь ногоон саарал, хар саарал өнгөтэй элсэн чулуу, хааяа шохойлог гравелитийн үетэй.

Түрүү Цэрдийн Цагаан цавын давхаргадас (K_{1cc}): Элсэн чулууны мэшил ба үеүдтэй конгломерат, элсэн чулуу, туфоалевролит, андезибазальт.

Түрүү Цэрдийн Хөх тээгийн давхаргадас (K_{1kt}): Элсэн чулуу, алевролит, аргиллит, гравелит, конгломерат, шавар, нүүрслэг аргиллит, хааяа шохойлог элсэн чулуу.

Хожуу Цэрдийн Баянширээгийн давхаргадас (K_{2bs}): Цайвар саарал өнгийн конгломерат, гравелит, элсэн чулуу, үлэг гүрвэлийн яс агуулсан цагаан элсэн чулуу, базальт.

Хожуу Цэрдийн Баянзагийн давхаргадас (K_{2bz}): Улаан, улаан хүрэн элс, элсэн чулуу, алевролит, шаварлаг аргиллит, шавар, шохойлог элсэн чулуу, базальт.

Кайнозой(KZ):

Олигоцен-миоцены (E₃-N₁): Бул чулуу, хайрга, гравелит, конгломерат, шохойлог элсэн чулуу, шар, шар саарал, ягаан, шаргал, улаан өнгийн шавар, шавранцар, элс.

Дунд-дээд дөрөвдөгч (Q_{II-III}): пролюв-делювийн, делювийн бул, хайрга, пролюви, аллюви, аллюви-пролювийн элс, элсэнцэр, хайрга, бүтэн ба хагас мөлгөр хайрга.

Дээд дөрөвдөгч (Q_{III-IV}): Орчин үеийн аллюви-пролювийн, пролюв-делювийн, делювийн хайрга, элс, элсэнцэр, шавар шавранцар, сэвсүүл элс.

(Q_{IV}): Орчин үеийн аллюви, пролювийн хайрга, элс, элсэнцэр, шавар шавранцар, нуурын элс, шавар, сэвсүүл элс.

Гүний чулуулгууд

Судалгааны талбайн 20 орчим хувийг гүний чулуулаг эзэлдэг. Гүний чулуулаг нь тектоник, магмын үйл ажиллагаа, үүссэн геодинамик нөхцөл, цаг хугацаа, хөгжлөөрөө

ялгаатай дараах бүрдэлүүдэд ангилагдана. **Үүнд:** 1. Дунд-хожуу Девоны ($\lambda, l\gamma D_{2-3 c}$) Цагаан суварга бүрдэл, Түрүү-дунд Карбоны ($\gamma\delta_2 C_{1-2 bh}$) Бага хачигийн бүрдэл, Дунд-хожуу Карбоны ($\gamma\delta_2 C_{2-3 m}$) Могойт бүрдэл, Түрүү Пермийн ($\xi\delta-\mu\lambda P_{1h}$) Ханбогд бүрдэлээс тус тус бүрдэнэ.

Дунд-хожуу Девоны ($\lambda, l\gamma D_{2-3 c}$) Цагаан суварга бүрдэл:

I –фаз нь Габбро, монцонит, кварцат монцонит, монцодиорит

II –фаз нь Биотитэт-эвэр хуурмаг сиенит, кварцат

III –фаз нь Хагас шүлтлэг лейкократ гранит, биотитэт лейкократ гранит, пегматитлэг гранит, гранодиорит

Дэл судлын чулуулаг нь дацит-порфир, граносиенит, гранодиорит-порфир, аплитүүд, риодацит, сиенит-порфир, кварцат монцонит-порфир зэргээс бүрдэнэ.

Түрүү-дунд Карбоны ($\gamma\delta_2 C_{1-2 bh}$) Бага хачигийн бүрдэл:

I –фаз нь Дунд, дунд-том, дунд-жигжиг ширхэгтэй кварцат диорит, диорит, биотитэт гранодиорит

II –фаз нь Төрөл бүрийн гранит, Биотитэт-эвэр хуурмагт гранит, биотитэт гранит, аляскит-гранит, том-дунд-жигжиг ширхэгтэй лейкократ гранит, гранодиорит

Дэл судлын чулуулаг нь кварцат сиенит-порфир, кварцат диорит-порфир, спессартин, аплитүүд, гранит-порфир зэргээс бүрдэнэ.

Дунд-хожуу Карбоны ($\gamma\delta_2 C_{2-3 m}$) Могойт бүрдэл:

I –фаз нь Кварцат диорит, дунд том ширхэгтэй гранодиорит

II –фаз нь Дунд-том ширхэгтэй Биотитэт гранит, эвэр хуурмагт гранит

III –фаз нь Хагас шүлтлэг гранит, жигжиг ширхэгтэй биотитэт гранит

Дэл судлын чулуулаг нь риолит, риодацит, андезит, андезидацит, андезит-порфир, аплит, пегматит, гранит порфир, гранодиорит-порфир зэргээс бүрдэнэ.


Түрүү Пермийн ($\xi\delta-\mu\lambda P_{1h}$) Ханбогд бүрдэл:

I –фаз нь Том -дунд ширхэгтэй лейкогранит, граносиенит

II –фаз нь Дунд-жигжиг ширхэгтэй шүлтлэг гранит, пантеллерит

Дэл судлын чулуулаг нь аплит, шүлтлэг гранит, монцонит, граносиенит, трахилипарит, пантеллерит, экерит порфир, комендит зэргээс бүрдэнэ.

Зураг 31. Геологийн зураг



2.8.2. Инженер геологийн үйл явц, үзэгдэл, газар чичирхийлэл

Сумын нутаг дэвсгэрт түр зуурын урсгал усны угаагдлын үйл явц хамгийн элбэг явагддаг томоохон сайр, хөндий түүнээс салбарласан олон тооны гуу жалга ажиглагдана. Хур борооны улиралд ул хөрс шингэрэх буюу намагжих үйл явц эрчимжих бөгөөд голын гольдрол, татмаар намаг элбэг тохиолдоно. Физик геологийн үйл явц үзэгдлийг нарийвчлан судлах шаардлагатай.

Газар чичирхийлэл:

Ханбогд сумын нийт нутаг дэвсгэрийг газар чичирхийллийн 5-9 баллын 3 мужид хуваасан байна.


- 9 баллын газар чичирхийллийн мужид Номгон уул, Агуй уул орчмын нутаг хамаарна.
- 6 баллын газар чичирхийллийн мужид Их шанхын нурууны өвөр, Хэрсэнгийн тал, Эргэнэ Усны, Ханбогд уул, Улаан уул хэсэгт хамаарна.
- 5 баллын газар чичирхийллийн мужид Эмээлтийн толгой, Үзүүр хөх толгой, Халзан уул орчмын нутаг хамаарна.

1963-2008 онд Агуйн ууланд $4.5 > M_s > 3.5$ хэмжээтэй газар чичирхийлэл хамгийн өндөр байна. Галбын говь, Шивээ уул, Халзан уул, Үзүүр хөх толгой гэсэн газруудад

3.5>Ms>2.5 газар чичирхийлэл болсоныг тогтоосон. Ханбогд суманд газар чичирхийллийн мужийн 6 баллын шатлалд хамаарагдана боломжтой бүсэд хамаарч байна.

Ханбогд сум нь Өмнөд Сибирээс Говь хүртэл үргэлжлэх Монгол алтайн тектоникийн идэвхитэй уулын бүсэд оршдог. ШУА-ийн Одон орон геофизикийн судлагааны төвийн судалгаагаар Ханбогд орчимд газар хөдлөх магадлал 475 жилд нэгд удаа тохиолдох ба 50 жилд тутамд 10.0 хувь өснө гэж тооцоолжээ.


Зураг 32. Газар чичирхийлэлийн зураг



2.8.3. Цэвдэгийн тархалт

Өмнөговь аймгийн Ханбогд сум нь цэвдэгийн тархалтын хувьд улирлын цэвдэг үүсдэг бүслүүрт хамаарагдах ба улирлын гэсэлтийн гүн ойролцоогоор 2.0-4.1 м гүн бол хөлдөлтийн гүн 1.5-4.0 метрийн хооронд байна.

Зураг 33. Цэвдэгийн тархалтын зураг



2.8.4. Геоморфологийн тогтоц

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг нь Говь-Алтайн нурууны зүүн урд шувтарга үзүүр районд хамаарагдана. Судалсан нутагт гадаргуугийн хэлбэр дүрс бүрэлдэн тогтоход геологийн гадаад, дотоод хүчин зүйл, тэр дундаа хамгийн гол шинэхэн тектоник хөдөлгөөн голлох нь нөлөөтэй юм. Судалсан нутгийн газрын хэлбэр дүрс бүрэлдэн тогтоход хуримтлалын, идэгдлийн болон элэгдлийн үйл ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэжээ. Дор дурьдсан газрын хэлбэр дүрсүүдийг бүрдүүлэгч үйл ажиллагаа нь газар бүр харилцан адилгүй эрчимтэй явагдсаны үр дүнд дараах хэв шинжийн гадаргуунууд бүрэлдэн бий болсон байна. Үүнд:

1. Тектоник элэгдлийн гадаргуу
2. Элэгдлийн гадаргуу
3. Элэгдэл-идэгдлийн гадаргуу
4. Идэгдлийн гадаргуу
5. Элэгдэл хуримтлалын гадаргуу
6. Хуримтлалын гадаргуу

2.8.4.1. Тектоникийн элэгдлийн гадаргуу

Судалж буй талбайн тектоник элэгдлийн гадаргууг үнэмлэхүй өндөр болон үүсгэж буй хэлбэр дүрсээр Бага өргөгдсөн намхан уулс (үнэмлэхүй өндөр 1200-1500 м) байна. Тектоник элэгдлийн гадаргуу нь судалж буй талбайн Ханбогд уул (К-48-35) 1351м, Их

хонгор уул (К-48-34) 1337м, Гурван гавлууд уул 1422м (К-48-34), Элгэн уул (К-48-34) 1320м, Жавхлант уул (К-48-46) 1295м зэрэг газруудаар тархсан байна.

Бага өргөгдсөн намхан уулсыг үүссэн онцлог шинж чанараар нь гурван төрөл болгон хуваалаа. 1). Хагарлын бүс дагасан шовх оройтой хүчтэй хэрчигдсэн рельеф 2). Дунд зэрэг хэрчигдсэн толгодорхог рельеф 3). Үндсэн чулуулаг дах шугаман структур бүхий рельеф.

1). Хагарлын бүс дагасан шовх оройтой хүчтэй хэрчигдсэн рельеф нь судалж буй талбайн баруун хойд хэсгээр Их хонгор уул (К-48-34) 1337м, Гурван гавлууд уул (К-48-34) 1422м өндөрлөг бүхий рельеф нь дунд зэргийн өндөртэй хүчтэй хэрчигдсэн олон тооны зууван дугуй эсвэл сунасан хэлбэрийн толгодоос тогтох бөгөөд тэдгээр нь жалга гангаар гуривлагдсан бөгөөд аажимаар сийрэгжиж тэгш талын гадаргууд шилжинэ.

2). Дунд зэрэг хэрчигдэлтэй толгодорхог рельеф нь талбайн төв хэсгээр Ханбогд уул (К-48-35) 1351м өндөрлөг зэрэг газруудаар тархсан байна. Дунд зэрэг хэрчигдэлтэй толгодорхог рельеф нь үндсэн чулуулгаас тогтсон бүнхэр болон шовх оройтой, гадаргуу нь олон тооны зууван дугуй сунасан хэлбэрийн толгодоос тогтоно. Толгод нь хадан гаршийн үлдэц элбэгтэй хажуу хяр нь олон тооны жижиг жалга судгаар хэрчигдсэн байдаг. Саланги болон бүлэг хэсэг толгод нь хоорондоо түр зуурын урсгалтай хуурай сайр хэдэн арван метрээс хоёр км өргөнтэй хөндий маягийн хотгоруудаар зааглагдах бөгөөд толгодын үнэмлэхүй өндөр 1500-2000м, харьцангуй өндөр 50- 80м хүрнэ.

3). Энэ төрлийн үндсэн чулуулаг дах шугаман структур бүхий рельеф нь судалж буй талбайн зүүн урд хэсгээр буюу Агуйт уул (К-48-60) 1277м, Жавхлант уул (К-48-46) 1295м үнэмлэхүй өндөртэй, харьцангуй өндөр нь 20- 40м хүрнэ. Энэ рельеф нь бага талбайд тархсан шугаман структур бүхий рифей, девон, карбоны тунамал-тиериген хурдас, интрузив чулуулагтай холбоотой. Уг гадаргуугийн гол онцлог нь нэг чиглэлд тасралтгүй сунаж тогтсон, хоорондоо 10-15м өргөнтэй хөндий маягийн хотгоруудаар зааглагдсан зэрэгцээ олон гүвээнүүдээс тогтоно.

2.8.4.2. Элэгдлийн гадаргуу

Элэгдлийн гадаргуу нь судалж буй талбай маш өргөн тархсан ба элэгдлийн гадаргууг дотор нь:

1. Сэвсгэр болон сул барьцалдсан хурдсаас тогтсон нам долгиолог тэгш тал
2. Шовх оройтой үндсэн чулууулгийн цухуйцтай долгиолог тэгш тал гэж хоёр төрөл хуваалаа.

1. Сэвсгэр болон сул барьцалдсан хурдсаас тогтсон нам долгиолог тэгш тал нь талбайн төв, урд хэсгээр Ханбогд уул (К-48-35)–ын урдуур, зүүн урдуур Жавхлант уул (К-48-46) 1295м өмнүүр зэрэг талбайд үнэмлэхүй өндөр 1000-1400м, харьцангуй өндөр нь 10-

25м хүрнэ. Уг төрлийн гадаргуу нь бага зэрэг долгиолог, тайван жигд талархаг гадаргуу бүхий шинж байдлаараа ялгагдах бөгөөд дотроо өргөн хавтгай оройтой 5-10м харьцангуй өндөртэй бөөрөг мөн налуу хажуутай өргөн хөндийнүүдэд хуваагдана. Сэвсгэр болон сул барьцалдсан хурдсаас тогтсон долгиолог тэгш тал нь олон тооны жижиг сайруудаар хэрчигдсэн Девон, карбон, пермийн интрузив, вулканогены бага зэрэг өгөршсөн чулуулгууд тархсан талбайд голлон тогтжээ.

2. Шовх оройтой үндсэн чулуулгийн (цухуйцтай) долгиолог тэгш тал нь сумаас зүүн хойш Улаан уул 1026м, Даригаатын уул 1242м уул зэрэг газруудаар бага хэмжээтэй ажиглагдана. Үнэмлэхүй өндөр 1250м орчим, жалга сайраар дунд зэрэг хэрчигдсэн элсээр хучигдсан жижиг толгод хадан гаршийн үлдэгдэл чулуулгийн дэл судал зэрэг чулуулгийн үлдэц цухуйцтай талаас бүрдэнэ. Уг гадаргуу нь өндөр уулын бэл хормой захын хэсгүүдээр эмх замбараагүй байрласан жижиг толгодын дунд хэсгээр ажиглагдах бөгөөд зарим газраа бүнхэрдүү хааяа шовх оройтой жижгэвтэр толгод уг гадаргууд бага хэмжээгээр ажиглагдана. Мөн эдгээр толгод нь жалга гангаар гуривлагдсан хүчтэй өгөршиж элэгдэж аажимдаа талархаг шинжтэй болсон нь ажиглагдана.

2.8.4.3. Элэгдэл идэгдлийн гадаргуу

Элэгдэл идэгдлийн гадаргуу нь талбайн төв хэсэгт Ханбогд сумын орчмоор (К-48-35), Дөрвөлжин тээг толгой (К-48-48, 59) зэрэг газруудаар голлон ажиглагдана. Элэгдэл идэгдлийн гадаргууг дотор нь 1.Цувраа болон эмх замбараагүй байрласан хүчтэй хэрчигдсэн толгод. 2.Ухаа толгодлог хэрчигдэл багатай рельеф гэж ангиллаа.

1.Цувраа болон эмх замбараагүй байрласан хүчтэй хэрчигдсэн толгод нь талбайн нилээд хэсгийг эзлэх бөгөөд энэ төрлийн толгод хадан гаршийн үлдэц элбэгтэй, толгодын хажуу хэсэг нь олон тооны жижиг жалга судгаар гуривлагдсан байдаг. Энэ төрлийн гадаргуу нь саланги болон бүлэг хэсэг толгодуудаас тогтох ба толгодууд нь хоорондоо хэдэн арван метрээс 1-2 км өргөнтэй хөндий хотгоруудаар зааглагдсан том жижиг олон сайраар хэрчигдсэн байдаг. Толгод нь шовхдуу оройтой хаяа бүнхэр оройтой, үнэмлэхүй өндөр нь 900-1250м, харьцангуй өндөр 20-60м хүрнэ.

2. Ухаа толгодлог хэрчигдэл багатай рельеф талбайн зүүн урд хэсэгт Хонгор толгой (К-48-48), Овоо толгой (К-48-48), Майхан улаан уул (К-48-46) зэрэг газруудаар бага талбайд тархсан. Энэ гадаргуу нь жалга судгаар дунд зэрэг гуривлагдсан бүнхэр оройтой ихэндээ саланги ганц нэгээрээ байх бөгөөд тэдгээр нь жижиг сайраар тусгаарлагдсан байна. Үнэмлэхүй өндөр нь 900-1150м харьцангуй өндөр нь 10-30м байх бөгөөд элэгдэл идэгдлийн түвшинээс хадгалагдан үлдсэн хадан гарш том оорцог толгод үлджээ.

2.8.4.4. Идэгдлийн гадаргуу

Идэгдлийн гадаргууг үүссэн нөхцөл рельефийн онцлогоос нь хамааруулж гурван төрөл болгон хувааж үзэж байна. 1.Үндсэн чулуулаг дах тэгш бэгэлзэг (лато). 2.Хүчтэй хэрчигдсэн жижиг толгод бүхий (бедленд) цав. 3.Сэвсгэр ба сул барьцалдсан хурдас бүхий сул хэрчигдсэн тэгш толгодлог рельеф.

3. Үндсэн чулуулаг дах тэгш бэгэлзэг (лато). Энэ төрлийн гадаргуу нь судалж буй талбайд төв болон зүүн хойд хэсгээр Агуй уулын зэрэг газруудаар ажиглагдана, Үндсэн чулуулаг дах тэгш бэгэлзэг нь жижиг хуруу жалгуудаар бага зэрэг хэрчигдсэн, үнэмлэхүй өндөр нь 1250 м орчим, харьцангуй өндөр 10-30 м үлдмэл хадан гарштай харьцангуй тэгш талаас бүрдэнэ. Уг гадаргуу нь карбон, цэрдийн , дөрөвдөгчийн хурдас чулуулгаас тогтоно.

4. Хүчтэй хэрчигдсэн жижиг толгод бүхий (бедленд) цав Уг гадаргуу нь судалж буй талбайн баруун мөнАлаг баян толгой (К-48-24) 1012 м, уулынурдуур багахан зэрэг газруудаар багахан талбайд тархсан байна. Хүчтэй хэрчигдсэн жижиг толгод бүхий цав нь бүнхэр оройтой жижиг толгодтой тэдгээр нь идэгдлийн процесст маш хүчтэй автсан, түр зуурын урсгал усны үйл ажиллагаанд автсан огцом гүн гүнзгий хэрчигдсэн байдаг.

5. Сэвсгэр ба сул барьцалдсан хурдас бүхий сул хэрчигдсэн тэгш толгод рельеф, Энэ гадаргуу нь судалж буй талбайн төвийн хэсгүүдээр их тархсан ба бусад газруудаар жигдхэн тархсан гадаргуу юм. Уг гадаргуу нь ерөнхийдөө тэгш боловч жижиг толгодтой тэдгээр нь хавтгайдуу бүнхэр оройтой жижиг жалга судгаар бага хэрчигдсэн, үнэмлэхүй өндөр нь 800-1100 м, харьцангуй өндөр 30-80м байна. Эдгээр тэгш толгод рельеф нь цэрдийн настай элсэнцэр, дайрга ба конгломератын суларсан гальк зэргээс тогтоно.

2.8.4.5. Элэгдэл хуримтлалын гадаргуу

Нам дор тэгш бага зэрэг долгиолог дөрөвдөгчийн хурдас. Энэ төрөлд дөрөвдөгчийн элэгдэл-хуримтлалын гадаргуу багтах бөгөөд өмнөх гадаргуугаас доод түвшинд хучигдсан нам дор тэгш тал бүхий гадаргуу нь судалсан талбайд их өргөн тархсан гадаргуу юм. Энд зарим газраа цэрд палеоген-неогений хурдас дах гадаргуудад гүн гүнзгий цөмөрч орсон угаагдлын хөндийнүүд бүхий хотгор угаагдалгүй үлдсэн довцог толгод орно. Эрт төрмөлийн чулууулгийн үлдэгдэл орчимд дөрөвдөгчийн хуримтлалын тэгш тал үүссэн байна. Үндсэн чулуулаг дах хөндийнүүд ерөнхийдөө тэгш гадаргуутай боловч саланги том биш толгод гүвээ, хадан гарш бүхий байна. Элэгдэл хуримтлал тархсан талбайд элэгдэл, элэгдэл-идэгдлийн, идэгдлийн адил төрлийн биетүүд тохиолдоно.

2.8.4.6. Хуримтлалын гадаргуу


Энэ төрлийн гадаргуу судалсан талбайд хамгийн өргөн тархалттай. Дунд төрмөлийн хонхруудын хэмжээнд идэгдлийн хөндийнүүдийн хотос захын хэсгүүдэд тохиолдоно.

Хуримтлалын буюу хурман гадаргуу нь бэл хормойн, хормойн хажуугийн тэгш тал, нуурын (орчин үеийн нуурын ёроол) гаралтай хурдас тархсан нутагт тохиолдоно. Хурман гадаргуугийн гол онцлог нь жигд тэгш ялимгүй налуу гадаргуутай байдаг. Тэгш талын захууд нь элэгдэл идэгдлийн мөрүүд үүсгэсэн, доод түвшиний тэгш талруугаа шилжсэн налуу хажуугаар дуусдаг.

Гол бэл хормойн тэгш тал нь судлагдсан талбайд их өргөн тархсан байна. Эдгээр нь хэдэн зуун метрээс 3-4км хүртэл өргөнтэй, хэдэн зуун метрээс 40-50 км хүртэл урттай байдаг. Нилээд урт гольдрол хөндий нь талбайн ерөнхий налуутай ижил байдаг. Хормойн хажуугийн тэгш тал нь дээд-дөрөвдөгч орчин үеийн хурдас хуримтлалын явцтай нягт холбоотой юм. Эдгээр тэгш тал нь түр зуурын урсгал усны гольдрол, хөндий нуурын шалнаас дээш 1-5м өндөртэй дэнж үүсгэсэн байдаг.

Нуурын шал талбайд өргөн тохиолдоно. Галбын говийн шал, Ханбогд уулын баруун хойд хэсэг, бусад талбайгаар жижиг тойрмууд оршино. Эдгээр нь хэдхэн зуун метрээс 10-12 км² талбайтай байна. Тэдгээр нь 800-1120м үнэмлэхүй өндөртэй дөрөвдөгчийн элэгдэл-хуримтлалын тэгш талуудад голлон тархжээ. Уулс хоорондын хөндий, хотос, хонхруудад түр зуурын тунадасны үйлчлэлээр нуур, тойром тогтох бөгөөд ихэнх тохиолдолд говийн нөхцөлд ууршилт явагдаж түрхэн зуурын хугацаанд хуурайшиж нуурын шал. Нуур тойром тогтсон газруудад усны ууршилт болж хуурайшилт явагдсаны дараа ихээхэн хэмжээний шаварлаг тойром үүсгэдэг.

Зураг 34. Геоморфологийн зураг



2.9. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ


2.9.1. Хүн амын одоогийн байдал

Тус сум нь 2016 оны байдлаар 6387 хүн ам, 1.734 өрх айл байгаагаас нийт хүн амын 53.28 хувь нь сумын төвд, 46.72 хувь нь хөдөөд амьдарч байна.


Хүснэгт 43. Сумын хүн амын тоо

Хүн амын үзүүлэлт		Хугацаа, оноор				
		2012	2013	2014	2015	2016
Сумын нийт хүн ам		4300	4712	5057	5563	6387
Үүнээс	Сумын төвийн хүн ам	1721	1845	2077	2005	2120
	Хөдөөгийн хүн ам	2579	2867	2980	3558	4267
Нийт өрхийн тоо		1450	1590	1659	1669	1768
Үүнээс	Төвийн өрх	1065	1223	1295	1301	1387
	Малчин өрх	385	367	364	368	381
Төрөлт		103	146	161	144	149
Нас баралт		12	16	19	23	33

Диаграм 5. Хүн амын тоо (сүүлийн 5 жилээр)




Диаграм 6. Сумын хүн амын тоо /сүүлийн 5 жилээр /



Багуудаар харьцуулж үзэхэд Жавхлант багийн нутагт сумын төв болон байрладаг бөгөөд хамгийн их буюу 1795 хүн амтай учир хүн амын нягтаршлаар хамгийн бага буюу 1 км.мв талбайд 0.34 хүн ноогдож байна. Харин хамгийн бага газар нутгийг хамарсан Номгон баг нь хамгийн бага 1440 хүн амтай буюу 1 км.кв талбайд 0.30 хүн ноогдож, нягтшил хамгийн бага байна.

Диаграм 7. Хүн амын өсөлт (хүйсээр)




Графикаас харахад Ханбогд суманд эрэгтэйчүүдийн тоо өссөн нь уул уурхайн үйлдвэрлэлээс бий болсон ажлын байртай холбоотой байна.

Хүснэгт 44. Сумын хүн ам /багуудаар/

Багийн нэр	Багын талбай /км ² /	Хунам	Хүн амын нягтаршил	Өрхийнтоо
Баян баг	2842.39	1549	0.54	296
Гавилууд баг	1989.89	1603	0.81	398
Жавхлант баг	5314.72	1795	0.34	540
Номгон баг+ Хайрхан баг	4828.88	1440	0.30	386

Багуудаар харьцуулж үзэхэд Жавхлант баг хамгийн их буюу 1795 хүн амтай учир хүн амын нягтаршлаар хамгийн бага буюу 1кв² талбайд 0.34 хүн ноогдож байна.

Диаграм 8. Сумын хүн ам, өрхийн тоо, багуудаар /график/








2.9.2. Мал аж ахуйн судалгаа

Сумын хэмжээнд 2016 оны байдлаар нийт 150702 толгой мал байгаагаас 70903 толгой буюу хамгийн их 47.0 хувийг хонь, 41506 толгой буюу 27.5 хувийг тэмээ, 25664 толгой буюу 17.0 хувийг ямаа, 8282 толгой буюу 5.9 хувийг адуу, 4347 толгой буюу хамгийн бага 2.8 хувийг үхэр тус тус эзэлж байна.

Хүснэгт 45. Малын тоо, багаар

Баг/хороо	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Баян	35530	1918	578	7858	14718	10458
Гавилууд	49722	3464	987	17985	22517	4769
Жавхлант	40280	1411	1357	10084	21909	5519
Номгон	25370	1489	1425	5579	11759	4918
Сумын нийт	150702	8282	4347	41506	70903	25664


Диagram 9. Сум, багийн сүргийн бүтэц, хувиар



Хүснэгт 46. Сумын малын тооны өөрчлөлт /сүүлийн 5 жилээр/


Малын төрөл	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Адуу	5878	6403	6561	7082	8290
Үхэр	2982	3304	3486	3745	4368
Хонь	33685	34596	34048	36434	41916
Ямаа	60427	60478	59717	62377	71228
Тэмээ	20389	21222	22655	23375	25644
Нийт	123291	126003	126467	133013	151446

Диаграм 10. Малын тоо, толгой (сүүлийн 5 жилээр)



Тус сумын хамгийн олон малтай баг нь Гавилууд, хамгийн цөөн малтай баг нь Номгон баг байна. Диаграмаас харахад сүүлийн 5 жилд тус сумын нийт малын тоо, толгой тогтмол өсч байна.

Диagram 11. Сумын малын тоо






III. ГАЗАР, БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

3.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САН

2016 оны байдлаар Ханбогд сумын нутаг дэвсгэрийн хэмжээ 1515054.72 га бөгөөд 76.9 хувийг хөдөө аж ахуйн газар, 13.6 хувийг тусгай хэрэгцээний газар, 8.7 хувийг ойн сан бүхий газар, 0.2 хувийг хот суурин газар, 0.6 хувийг зам шугам сүлжээний газар, 0.05 хувийг усны сан бүхий газар тус тус эзэлж байна.

Улсын тусгай хэрэгцээний газраас бусад ангиллын газрын эзлэх талбайн хэмжээ 201666.3 га бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 13.6 хувийг эзэлж байна. Тусгай хэрэгцээний газар болон бусад ангиллын газрын дэлгэрэнгүй ангиллыг дараах зургаар харуулав.

Зураг 35. Газрын нэгдмэл сангийн зураг



Хүснэгт 47. Газрын нэгдмэл сангийн ангилал

Үндсэн ангилал	Ангилалын түвшин 1	Ангилалын түвшин 2 / ашиглалтын зориулалт /	Талбайн хэмжээ /га/
Хөдөө аж ахуйн газар	Бэлчээр	Өвөл-хаврын	447007.66
		зун-намрын	657620.67
	ХАА-н барилга байгууламжийн газар	Өвөлжөө, хаваржаа	187.46
		МАА-н үйлдвэрлэлийн зориулалттай газар	387.46
	Тариалангийн газар	ХАА-н үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар	0.500
	Тариалангийн газар	Төмс хүнсний ногоо тариалсан талбай	35.5




		Атаршсан газар	1
	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	59916
Хот, тосгон бусад суурины газар	Барилга байгууламжийн дэвсгээр газар	Иргэн аж ахуй нэгж , байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтанд байгаа барилга, байгууламжийн доорх газар	240.4
		Амралт рашаан сувилал	14
	Суурьшлын газар	Гэр орон сууцны хашааны газар	463.28
	Үйлдвэрийн газар	Үйлдвэрийн газар	3339
	Нийтийн эдэлбэрийн газар	Гудамж талбай замын газар	26.1
		Хогийн цэг	4.8
		Оршуулгын газар	0.9
Уурхайн газар	Ашиглалт, олборлолт явуулж буй талбай	165.9	
Зам шугам сүлжээний газар	Авто зам газар	Орон нутгийн чанартай	679
		Аж ахуй нэгж байгууллагын дотоодын зориулалттай	1391.06
		Авто тээврийн барилга байгууламж, зогсоолын талбай	44.4
	Төмөр замын газар	Төмөр замын далангийн талбай, хамгаалалтын зурвас газар	2479.6
		Өртөө зөрлөгийн барилга, байгууламжын талбай	400
	Агаарын тээврийн газар	Нислэгийн аюулгүй байдлыг хамгаалах бүсийн газар	295
	Шугам сүлжээний газар	Холбооны шугам, холбооны мэдээлэл хүлээн авах станцын эзлэх талбай	36.5
		Эрчим хүчний шугам, станцын эзлэх талбай	301.33
		Ус, дулаан дамжуулах хоолойн эзлэх талбай	4639.9
	Ойн сан бүхий газар	Ой модоор бүрхэгдсэн газар	Заган ойгоор бүрхэгдсэн
Усны сан бүхий газар	Гол мөрөний эхлэх газар	Гол мөрөн	41
	Горхи булаг шандын эзлэх талбай	Горхи, булаг, шанд	34
	Нуур, цөөрөм, тойромын эзлэх талбай	Нуур, цөөрөм, тойром	732
Улсын тусгай хэрэгцээний газар	Дархан цаазат газар	Дархан цаазат газар	142662
	Улсын хилийн зурвас газар	Улсын хилийн зурвас газар	59000

	<p>Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай</p>	<p>Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай</p>	<p>4.3</p>
<p>Нийт</p>			<p>1515054.7 25</p>

3.2. СУМЫН ГАЗАР АШИГЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

Ханбогд сум нь бэлчээрийн мал аж ахуй давамгайлдаг учраас хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаж байгаа газар нийт сумын нутаг дэвсгэрийн 76.9 хувийг, хот, тосгон бусад суурины газар 0.2 хувь, усан сан бүхий газар 0.05 хувь, ойн сан бүхий газар 8.7 хувийг эзэлж байна.


Зураг 36. Газар ашиглалтын нэгдсэн зураг



3.2.1. Хот суурин газрын ашиглалт

Сумын хэмжээнд 11118.9 га газрыг хот сууринд ашиглаж байна. Хот суурин газрын нийт талбай 4268.6 га, барилга байгууламжийн дэвсгэр газар 115.0, нийт эдэлбэрийн газар 37.1 га, үйлдвэрийн газар 111.1 га, уурхайн дэвсгэр газар 3570.5 га байна.

Зураг 37. Хот, тосгон бусад суурины газрын зураг



Хүснэгт 48. Хот суурины газар ашиглалтын зориулалт, талбайн хэмжээ

№	Ангилал	Газар ашиглалтын зориулалт	Талбайн хэмжээ /м2/
1	Барилга, байгууламжийн газар	Төрийн захиргааны байгууллага	2974.83
2		Урлаг, соёлын байгууллага	1360.13
3		Боловсролын байгууллага	36988.5
4		Эрүүл мэндийн байгууллага	1938.68
5		Банк, санхүүгийн байгууллага	1502.61
6		Нам, олон нийтийн байгууллага	53.08
7		Сүм, хийд, шашны байгууллага	133.58
8		Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	15598.96
9		Дэд бүтцийн байгууллага	790.02
10		Шатах, тослох материал түгээгүүрийн газар, агуулах, ШТС	357.57
11		Ус түгээх цэг	91.43
12		4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц	11555.02
13		Гэр, орон сууцны хашааны газар	568525.97
14	Үйлдвэрийн газар	Үйлдвэрийн албан контор	1260.37




15		Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	3917.7
16	Нийтийн эдэлбэрийн газар	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамирын зориулалтын газар	8505.48
17		Нэрэмжит талбай, хөшөө, дурсгалын газар	1011.88
18		Эзэмшил, ашиглалтанд олгогдоогүй сул чөлөөтэй газар	9480152.85
19		Хогийн цэг	374684.64
20		Оршуулгын газар	85671.91
21		Нурсан барилга, балгас	592.41
22	Шугам, сүлжээний газар	Эрчим хүч, дамжуулах шугам, станц	70.46
23	Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	520497.76
24	Шинжлэх ухаан, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	Шинжлэх ухаан, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	712.27

Тус суманд орших ОюутолгойХХК мөн тус боомтоор нэвтрүүлэх чадвар, зам тээврийн нөхцөл сайжирсан нөхцөлд нүүрсний экспортын 70.0-80.0 хувь, зэсийн баяжмалын 70.0 хувийг экспортлох юм.

3.2.2. Бэлчээр ашиглалт

Өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны байршил: Сумын хэмжээнд нийт 671 өвөлжөө, хаваржаатай бөгөөд зарим өвөлжөө, хаваржааны газар жилийн 4 улиралд ашиглагдаж байна.

Зураг 38. Бэлчээр ашиглалтын зураг



Газар нутгийн хэмжээ том хэдий ч малын бэлчээр хязгаарлагдмал байна. Учир нь уур амьсгалын өөрчлөлт, ган, зуд, бэлчээрийн усан хангамжийн дутагдал, ашигт малтмалын олборлолт зэрэг олон хүчин зүйлээс хамаарч малын бэлчээр хомсдож, доройтож байна. Үүний дотроос мал аж ахуй эрхлэхэд хамгийн ихээр хүндрэл учруулж байгаа хүчин зүйл нь ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа бөгөөд тэд ашигт малтмал олборлож газрын хөрсийг сэндийлж, ургамал ургах боломжгүй болгож, гадаргын ус ширгээж байна. Энэ нь бэлчээрийн газрыг сэлгээгүй ашиглах нөхцөлийг бүрдүүлж байна.

3.2.2.1. Бэлчээрийн даац

Бэлчээрийн даацыг бэлчээрийн нийт нөөцийг нэг хонин толгойн жилд идэх өвсний хэмжээнд харьцуулж тодорхойлов.

Тус сумын нийт 2791981.82 га бэлчээрийн эдэлбэртэй үүнээс 1369330.82 га нь алслагдсан бэлчээр байна. Бэлчээрийн даацыг тооцоходоо нийт бэлчээрийн эдэлбэр газрын хэмжээгээр тооцсон болно.

Хүснэгт 49. Бэлчээрийн даац, багаар

Баг	Хонин толгой, нийт	Талбай, га	Га-ийн ургац, цн	Тэжээлийн нөөц, цн	Хонь жилд идэх өвс, цн	Багтаамж, хонин толгой	Даац, хувь	Даац хэтэрсэн хувь
1-р баг, Номгон	100714	314912.9	0.81	255079.473	1.1	231890.4	43.43	0.43
2-р баг, Гавилууд	95015.3	187714.3	0.92	172697.138	1.1	156997.4	60.52	0.61
3-р баг, Жавхлант	203388.1	276987.6	0.88	243749.07	1.1	221590.1	91.79	0.92
4-р баг, Баян	140600.2	125714.8	0.82	103086.144	1.1	93714.68	150.03	1.50
	539717.6	905329.6	0,86	774611.826	1.1	704192.6	76.64	0.77

Одоо ашиглаж байгаа бэлчээрийн хэсгээр даацыг тооцож үзэхэд Гавилууд баг 60.5 хувь, Баян баг 100 хувь, Жавхлант 91.0 хувь, Номгон баг 43.3 хувийг ашиглаж байна. Усны хомсдол, ургамлын гарц, төвөөс алслагдсан байдал зэргээс хамаарч Гавилууд, Баян багийн малчид нэг газарт нутагладаг нь бэлчээрийн даацыг дээрх хэмжээнд хүртэл хэтрүүлэн ашиглах шалтгаан болж байна. Бэлчээрийг цаашид сэлгэн ашиглах, эсвэл тухайн бэлчээр ашиглалтын хэсэгт байх хонин толгойг бэлчээрийн даацад тохируулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Харин багийн нийт нутгийн хэмжээнд бэлчээрийн даацыг тооцож үзэхэд Баян багт 1.5 дахин хэтэрсэн байна. Энэ нь багуудийн нийт нутгаар /усжуулагдаагүй, алслагдсан бэлчээрт/ мал бэлчээдэггүйтэй холбоотой юм.

Нийт бэлчээрийн 9.7 хувь буюу 142286.46 га нь их талхлагдсан, 6.8 хувь буюу 99730.07 га нь сул талхлагдсан, 0.06 хувь буюу 947.9 га нь автогений нөлөөнд орсон байна. “Оюутолгой” ХХК-ий гаргасан олон цооногоос үүдэн гүний усны хомсдол бий болж байгаа бөгөөд хөрөнгө санхүү дутмаг байгаагаас алслагдсан бэлчээрт худаг гаргаж ашиглаж чадахгүй байна.


3.2.2.2. Бэлчээр усжуулалт

Баян багт 35615.1 га газар, Гавилууд багт 27239.5 га газар, Жавхлант багт 42710.5га газар, Номгон багт 24092.4 га усжуулах шаардлагатай байна.

Ханбогд сумын хэмжээнд усжуулагдсан бэлчээрийн талбай 370000 га ба энэ нь нийт бэлчээрийн 33.4 хувийг эзэлж байна. Цаашид гидрологийн судалгааны материалд үндэслэн

сумдад бэлчээр усжуулалтын техник эдийн засгийн үндэслэл боловсруулж, усжуулах шаардлагатай, усжуулагдаагүй сумын урд хэсэг буюу хилийн зурваст бэлчээрийн газрын усны хайгуул судалгаа явуулж, инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг зохион байгуулах хэрэгтэй. Цаашид сумын хэмжээнд бэлчээрийн усан хангамжийг сайжруулахад судалгаагаар эхний ээлжинд 43 худаг гаргах шаардлагатай байгаа хэдий ч ган зуд болж цаг хүндрэхэд нөөц бэлчээртэй байх нь чухал. Тийм учраас тухайн худаг гаргах боломжтой бэлчээрийн нийт нутаг дэвсгэрт худаг гаргах нь буруу юм.

Зураг 39. Бэлчээрийн усжуулалтын зураг



Хүснэгт 50. Гүний усны нөөц, тархалт

Гүний устай талбайн дугаар	Томъёолол	Гүний усны нөөц, тархалт	Талбай /га/	Нийт талбай /га/
1	Голын элс, хайрга, элсэнцэр, шавранцар	Үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг	53.66	86766.52
	Судаг бэлийн элс, хайрга, элсэнцэр		2761.99	
	Суурилаг бялхамал чулуулаг		179.35	
	Хүчиллэг, дундаж хүчиллэг, бялхамаг		4876.26	
	Хүчиллэг, дундаж хүчиллэг, түрмэлин		627.68	



	Шавар, элс, элсжин	Газрын доорх локал, хязгаарлагдмал нөөц бүхий устай чулуулаг	1509.26	
		Үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг	654.89	
	Элс, элсжин, хөрзөн, хайрга	Газрын доорх локал, хязгаарлагдмал нөөц бүхий устай чулуулаг	849.15	
		Үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг	75254.28	
2	Голын элс, хайрга, элсэнцэр, шавранцар	Газрын доорх локал, хязгаарлагдмал нөөц бүхий устай чулуулаг	10350.67	17734.59
	Судаг бэлийн элс, хайрга, элсэнцэр	Үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг	2193.57	
	Хувирмал чулуулаг		2135.05	
	Элс, элсжин, хөрзөн, хайрга		3055.3	
3	Голын элс, хайрга, элсэнцэр, шавранцар	Газрын доорх локал, хязгаарлагдмал нөөц бүхий устай чулуулаг	11896.38	55004.05
	Хувирмал чулуулаг	Үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг	3682.52	
	Шавар, элс, элсжин		1869.96	
	Элс, элсжин, хөрзөн, хайрга		32972.24	
	Элсжин, зануужин, хөрзөн, нүүрс, шавар		4582.95	

3.2.2.3. “Оюутолгой” ХХК-ний үйл ажиллагаанаас үүдэн гаргасан усны цооногуудын мэдээлэл

1. Битүүмжилсэн цооногууд

Ханбогд сум нь Галба-Үүш Долоодын Говийн Сав Газарт хамаарагдана. “Оюутолгой” ХХК-ний 2017 оны 05 сарын 01 өдрийн №1449/1156 дугаартай Галба-Үүш Долоодын Говийн Сав Газрын Захиргаанд өгсөн “Газар доорх усны мониторингийн цооног өрөмдөх, хайгуулийн цооногуудыг битүүмжлэх тухай” бичигт нийт 18 цооног 2015, 2016, 2017 онд өрөмдсөн. Шүүрэлттэй болон хайгуулын битүүмжлэх шаардлагатай нийт 40 худаг байна. Үүнээс одоогоор 12 шүүрэлттэй цооногийг битүүмжилсэн байна. Битүүмжилсэн 12 цооногуудыг Хүснэгт 51-т харуулав.

Хүснэгт 51. Битүүмжилсэн цооногууд

№	Цооногийн дугаар	Байршил	Цооногийн гүн, м	Цооногийн дүлий яндангийн диаметр, мм
1	GHTPM01	X-107 ⁰ 10'33.01" Y-43 ⁰ 19' 19.96"	345	152
2	GHW5x2	X-107 ⁰ 10'33.93" Y-43 ⁰ 19' 18.45"	338	152
3	GHW6x2	X-107 ⁰ 14' 6.92" Y-43 ⁰ 21' 23.36"	348	152
4	GHW14x2	X-107 ⁰ 20' 02.84" Y-43 ⁰ 24' 19.38"	355	152
5	GHW15x4	X-107 ⁰ 23' 3.70" Y-43 ⁰ 25' 48.34"	286	152
6	GHTPM03	X-107 ⁰ 26' 16.47" Y-43 ⁰ 24' 13.82"	380	152
7	GHW15x1	X-107 ⁰ 26' 7.82" Y-43 ⁰ 24' 13.21"	355	152
8	GHW15x2	X-107 ⁰ 27' 09.76" Y-43 ⁰ 27' 42.66"	343	152
9	GHEB06	X-107 ⁰ 28' 6.46" Y-43 ⁰ 28' 45.58"	400	152
10	GHEB07	X-107 ⁰ 29' 3.36" Y-43 ⁰ 29' 23.49"	400	152
11	GHEB04	X - 107 ⁰ 31' 15.10" Y - 43 ⁰ 24' 12.08"	393	152
12	GHEB05	X - 107 ⁰ 31' 28.15" Y - 43 ⁰ 22' 21.25"	396	152

Зураг 40. Цооногийг битүүмжилсэн байдал



**2. Усны хайгуулын цооногууд**

Ханбогд сумын нутагт одоогийн байдлаар “Оюутолгой” ХХК-ний гаргасан 317 усны цооног байгаа ба 2003-2004 онд нийт 141 цооног, 2007 онд 48 цооног, 2011-2012 онд 100 цооног өрөмдсөн. Хүснэгт 53, 54, 55, 56-д усны цооногийн дугаар, байрлал, гүн, цооногийн өргөнийг харуулав. Эх сурвалж: Говийн газар шороо ТТБ, тэргүүн Л. Батцэнгэл

Хүснэгт 52. “Оюутолгой” төслийн усны эрэл хайгуул, усны мониторингийн зорилгоор өрөмдсөн цооногуудын дэлгэрэнгүй /2003-2004 он/

№	Цооногийн дугаар	Координат		Үнэмлэхүй өндөр, м	Гүн, м	Цооногт суулгасан шүүрийн яндангийн диаметр, мм	Тайлбар
1	GH1x1	656543	1143.2	1143.2	198.0	50	
2	GH2x3	662132	478497	1113.6	298.0	50	
3	GHW2x3	662155	4787918	1143.2	286.0	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
4	GH2x3s	662176	4784903	1113.6	8.5	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
5	GH2x4	659074	4794080	1114.4	248.8	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
6	GH3x1	666927	4788096	1099.5	168.8	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
7	GH3x1s	666955	4788092	1099.2	30.0	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
8	GH3x2	665117	4791417	1085.4	200.0	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
9	GH3x2S	665140	4791434	1085.2	28.0	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
10	GH4x2	668635	4802977	1077.0	276.3	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
11	GH4x3	667837	4806188	1081.1	200.0	50	
12	GH4x4	670826	4794520	1060.3	196.8	50	
13	GH4x5	673615	4787064	1102.4	339.0	50	
14	GH4x6	672274	4790706	1074.6	273.4	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
15	GHW4x6	672270	4790746	1074.4	255.6	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
16	GH4x6S	672252	4790722	1074.4	20.5	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
17	GH5x1	677431	4794564	1039.2	320.8	50	Улсын хэмжилтэнд



							хамрагдаж байгаа
18	GHW5x1	677460	4794566	1039.1	320.0	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
19	GH 5x1-11	677471	4794552	1039.1	15.0	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
20	GH5x1-53	677486	4794558	1039.1	55.0	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
21	GHWS5x1	677516	4794550	1039.0	12.0	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
22	GH5x1-10R	677526	4794546	1039.2	12.0	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
23	GH5x1-30R	677541	4794565	1038.8	11.0	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
24	GH5x2-10R	676424	4798852	1055.3	345.0	50	
25	GHW5x2	676444	4798850	1054.9	338.0	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
26	GH5x2-30R	682394	4798849	1055.1	348.0	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
27	GH6x1	682394	4798539	1038.1	303.6	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
28	GHW6x1	682402	4798510	1037.7	255.0	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
29	GH6x1-14	682402	4798527	1037.8	15.0	50	
30	GH 6x1-43	682410	4798542	1038.0	50.0	50.0	
31	GH6x2	681357	4802854	1069.7	300.0	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
32	GHW6x2	682402	4798510	1037.7	255.0	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
33	GH6x2-21	681350	4802863	1069.8	21.0	50	
34	GH6x2-60	681341	4802667	1070.0	60.0	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
35	GH14x1	689220	4803021	1026.0	299	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
36	GHW14x1	689246	4803021	1026.0	297	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
37	GH 14x1-14	689257	4803204	1025.8	15.0	50	
38	GH14x1-34	689275	4803025	1025.7	55.0	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
39	GH14x2	689006	4808508	1016.0	341.8	152	Улсын



							хэмжилтэнд хамрагдаж байгаа
40	GHW14x2	688998	4808480	1017.0	355.5	50	
41	GH14x2-41	688998	4808512	1015.9	41	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
42	GH15x1	967446	4808507	968.4	248.6	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
43	GHW15x1	697439	4808531	968.3	355	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
44	GH15x1-15					50	
45	GH15x1-48					50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
46	GH15x1-242					50	
47	GH15x180					50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
48	GH15x2	698394	4815012	963.0	393	50	
49	GHW15x2	698416	4815027	962.9	343	152	
50	GH15x2-30R	698476	4815032	962.9	41	50	
51	GHWS15x2					50	
52	GH15x2-10R					152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
53	GH15x2-24					50	
54	GH15x3	696628	4804534	976.9	300.6	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
55	GH15x4-10	693670	4811369	982.1	300	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
56	GH15x4-30R	693683	4811385	982.5	320	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
57	GHW15x4	693662	4811359	981.9	286	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
58	GH10x1	651560	4803100			50	
59	GH15x5	706377	4821679	945.3	360	50	
60	GH15x6	713923	4828415	977.6	250	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
61	GH16x1	712659	4796026	925.7	348.4	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
62	GH16x2	717357	4804021	911.5	231.9	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
63	GH16x2-34	717338	4804042	911.6	34	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
64	GHW16x2	717352	4804047	911.7	235	152	Улсын



							хэмжилтэнд хамрагдаж байгаа
65	GG1	691321	4723724	938.3	240	50	
66	GG1s	691315	4723721	935.3	53	50	
67	GGW1	691336	4723749	936.5	232	152	
68	GG2	676594	4713335	930.9	295	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
69	GG2s	676630	4713310	930.9	12	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
70	GGW 2	676594	4713335	930.9	362	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
71	GG3	704711	4723731	994.0	360	50	
72	GG4	699508	4731100	1003.3	375	50	
73	GG5	670096	4730674	998	400	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
74	GG6	675102	4724204	966.5	473	50	
75	GG6s	675107	4724195	966.5	53	50	
76	GGW6	675082	4724192	966.5	349	152	
77	GG7	666098	4727487	1001.0	306	50	
78	GG8	668797	4708491	914.2	253	50	
79	GG8s	668804	4708485	914.2	27	50	
80	GGW8	658751	4708499	914.6	254	152	
81	GG9	664498	4713741	949.0	402	50	
82	GG10	642648	470457	924.6	228	50	
83	GG12	657309	4723908	949.0	129	50	
84	GG14	683250	4741005	924.6	519	50	
85	GG15	581270	4719677	977.5	347	50	
86	GG16	649506	4697564	1005.2	145	50	
87	GG17	690600	4744599	939.1	447	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
88	GG18	704993	4742011	876.8	314	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
89	GG18s	704989	4742019	982.0	29.5	50	
90	GGW 18	705003	4741993	949.8	303	152	
91	GG19	700175	4749997	949.7	396	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
92	GG19s	700181	4749989	949.8	44	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
93	GGW 19	700195	4749981	951.1	338	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
94	GGW20	659080	4702581	951.1	282	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
95	GG20s	659090	4702580	951.1	36.3	50	
96	GG21	674994	4715999	941.2	366	50	
97	GG26	687991	4727970	944.3	357	50	



98	GGW 26s	687991	4727970	944.3	48	50	
99	GGW 26	687971	4727976	944.2	315	152	
100	GGWS 26	687968	4727959	944.3	42	152	
101	GG 26-10	687958	4727957	944.3	41	50	
102	GG 26-30	687940	4727956	944.2	41	50	
103	GG29	717965	4750993	930.2	198	50	
104	GG29s	717955	4750991	930.3	43	50	
105	GGW 29	717970	4750980	930.3	193	152	
106	GGWS 29	717995	4750968	930.13	41	152	
107	GG 29-10	717995	4750957	930.4	41	50	
108	GG 29-30	717990	4750939	930.7	41	50	
109	GG30	670470	4720786	951.6	423	50	
110	GG30s	670481	4720784	951.5	57	50	
111	GG32	694342	4741608	965.4	388	50	
112	GGW 32	694345	4741618	955.3	220	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
113	GG 33	700244	4746246	948.2	372	50	
114	GG 33s	700237	4746241	948.3	42	50	
115	GG 34	659796	4720599	966.7	213	50	
116	GG 34s	659787	4720602	966.5	31	50	
117	GG35	681156	4736663	996.9	398	50	
118	GGW35	681158	4736651	996.9	304	152	
119	GG40	724547	4778511	869.8	380	50	
120	GGW40	724514	4778498	869.5	352	50	
121	GG40s						
122	GG41	731794	4768069	919.3	279	50	
123	GGW41	731799	4768031	919.1	350	152	
124	GG41s	731787	4768079	918.8		50	
125	GG42	733135	4783699	874.2	400	50	
126	GGW42	733133	4783676	874.4	342	152	
127	GG42s	733146	4783669	874.5	24	50	
128	GG43	736980	4778743	883.3	300	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
129	GGW43	736973	4778800	883.1	227	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
130	GGW43s	736996	4778750	883.3	60	152	
131	GG43-10R	737009		883.4	41	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
132	GG43-30R	737027	4778758	883.5	41	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
133	GG43s	735948	4776727	883.2	24	50	
134	GG44	748524	4778893	88 6.8	215	50	
135	GG45	743003	4785996	8 76.7	370	50	
136	GG46	735011	4798004	872.9	202	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
137	GG47	723417	4763000	900.8	280	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа



138	GGW47	723387	4763007	900.6	267	152	
139	GG48	739590	4791493	861.4	347	50	
140	GGW48	739576	4791498	861.5	265	152	
141	GGW48S	739602	4791497	861.3	73	50	

Хүснэгт 53. “Оюутолгой” ХХК төслийн усны эрэл хайгуул, усны мониторингийн зорилгоор өрөмдсөн цооногуудын дэлгэрэнгүй /2007 он/

№	Цооногийн дугаар	Координат		Үнэмлэхүй өндөр, м	Гүн, м	Яндан суулгасан шүүрийн яндангийн диаметр, мм	Цооногт суулгасан шүүрийн яндангийн диаметр, мм	Тайлбар
		Өргөрөг	Уртраг					
1	СНЕВ-07	701999	4818247	994	400	396	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
2	СНЕВ-06	700082	4817019	962	400	400	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
3	СНЕВ-01	691306	4814147	971	208	208	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
4	СНЕВ-08	685439	4806037	1048	393	391	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
5	СНЕВ-02	686831	4810911	1021	360	360	152	
6	СНЕВ-03	700002	4806395	944	317	315	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
7	СНЕВ-05	704523	4805285	950	396	396	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
8	СНЕВ-04	704126	4808695	956	393	393	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
9	GHTRM02	682361	4798529	1031	250	250	152	
10	GHTRM01	676422	4798896	1046	345	345	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
11	GHTRM03	697407	4808549	962	380	380	152	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
12	GHTRM04	693652	4811316	972	321	321	152	
13	GHTR04	693660	4811346	971	299	286	152	
14	GHTR03	697425	4808523	959	353	309,5	350	
15	GHTR02	682388	4798515	1031	266	254	350	
16	GHTR01	676418	4798866	1047	327	310,5	350	



17		681348	4802834	1059	400	372	350	
18	WATPO8	692370	4805109	1003	383	371	350	
19	WATPO7	694898	4806700	971	371	354	350	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
20	WATPO5	700749	4810707	955	365.5	329	350	
21	WATPO2	696006	4813517	963	281	269	350	
22	WATPO1	691389	4810205	981	312	290,5	350	
23	GH02PB03	693475	4808012	986	389	374	350	
24	WATPO4	703975	4813297	935	400	388	250	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
25	WATP10	708135	4805523	924	353	343	250	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
Малчдын худгийн дэргэд хяналтын заориулалтаар гаргасан цооног								
27	HW01L	705575	4812091	931	50	50	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
28	HW01S				15	14	50	
29	HW02L	661079	4804806	1110	51	50	50	
30	HW02S				12	11	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
31	HW03L	666859	4806645	1080	47	10,5	50	
32	HW04L	671084	4812628	1075	50	50	50	
33	HW04S				7	7	50	
34	HW05L	680220	4817789	1034	51	50	50	
35	HW05S				24	23	50	
36	HW06L	698028	4819128	974	50	50	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
37	HW06S				6	5	50	
38	HW07L	715846	4808124	933	51	50	50	
39	HW07S				6	5	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
40	HW10L	696313	4799185	969	51	50	50	
41	HW10S				5	5	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
42	HW11L	686351	4796918	1000	50	50	50	
43	HW11S				5	4	50	
44	HW13L	672035	4791836	1057	51	50	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа



								байгаа
45	HW13S				5	5	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
46	HW14L	673982	4794011	1047	51	50	50	
47	HW14S				6	5	50	Улсын хэмжилтэнд хамрагдаж байгаа
48	HW18L	682052	4795016	1012	54	52,5	50	
49	HW18S				6	5	50	

Хүснэгт 54. Ашиглалтын худаг

№	Цооногийн дугаар	Координат		Үнэмлэхүй өндөр, м	Гүн, м	Цооногт суулгасан шүүрийн яндангийн диаметр, мм	Тайлбар
1	GH01-POB02	697390	4812090	956.5	376	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
2	GH01-POB03	699500	4812000	950.5	315	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
3	GH01-POB04	699500	4810000	972.7	358	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
4	GH01-POB05	695500	4812000	963.5	273	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
5	GH01-POB06	696004	4813515	965.22	269	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
6	GH01-POB07	700754	4810706	958.93	329	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
7	GH02-POB01	691339	4810180	988.44	290.5	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
8	GH02-POB02	693654	4811370	981.48	286	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
9	GH02-POB03	693477	4808001	986	374	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
10	GH02-POB04	695085	4609210	977.75	348	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
11	GH02-POB06	697500	4810000	972.76	367	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
12	GH02-POB07	697436	4808530	967.46	309.5	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
13	GH03-PB01	689500	4806000	1016.3	394	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
14	GH03-PB02	691500	4806000	993.81	365	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
15	GH03-PB03	691110	4805555	1019	372	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
16	GH03-PB04	689500	4804000	1027.9	390.2	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
17	GH03-PB05	692367	4805108	1008.28	371	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
18	GH03-PB06	693500	4806300	994.25	354	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг



19	GH04-PB01	681400	4801010	1038.1	379	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
20	GH04-PB03	681347	4802834	1069.762	372	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
21	GH04-PB04	682387	4798516	1037.104	254	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
22	GH04-PB05	684500	4802000	1056.2	367	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
23	GH04-PB06	685000	4804500	1068.9	407.2	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
24	GH05-PB01	673500	4797000	1059.3	246	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
25	GH05-PB02	676418	4798865	1058.2	310	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
26	GH05-PB03	675490	4796630	1045.6	299	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
27	GH05-PB05	678161	4797735	1038	329	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг
28	GH05-PB06	679000	4800000	1050	388	323.9	Гүний хоолойн ашиглалтын худаг

Хүснэгт 55. “Оюутолгой” ХХК-ний төслийн усны эрэл хайгуул, усны мониторингийн зорилгоор өрөмдсөн цооногуудын дэлгэрэнгүй /2011-2012 он/

№	Цооногийн дугаар	Координат		Үнэмлэхүй өндөр, м	Гүн, м	Яндан суулгасан шүүрийн яндангийн диаметр, мм	Цооногт суулгасан шүүрийн яндангийн диаметр, мм
		Өргөрөг	Уртраг				
1	ОТМВ11-1	641669.7	4771202.4	1225.87	9.1	5	50
2	ОТМВ11-2	641670.6	477193.1	1225.71		21	50
3	ОТМВ11-3	641670.5	477193.0	1225.71	60.0	60	50
4	ОТМВ11-4	642987.2	4764887.1	1205.6	5	5	50
5	ОТМВ11-5	642980.4	4764885.4	1205.6	30.0	30	50
6	ОТМВ11-6	646746.9	4768666.1	1195.5	6.5	6	50
7	ОТМВ11-7	646751.8	476860.5	1195.54		20	32
8	ОТМВ11-8	646751.8	4768660.5	1195.54	61.0	60	50
9	ОТМВ11-9	647847.5	4767241.6	1188.28	5.5	5	50
10	ОТМВ11-10	647854.7	4767244.9	1188.32	24.0	24	50
11	ОТМВ11-11	648314.6	4765153.3	1178.98	5.5	4.5	50
12	ОТМВ11-12	648307.8	4765149.9	1178.86		42	50
13	ОТМВ11-13	648307.8	4765149.9	1178.86	69	69.50	50
14	ОТМВ11-14	652051.2	4768809.1	1173.74	5.5	5	50
15	ОТМВ11-15	652043.9	4768813.8	1173.97		20	50
16	ОТМВ11-16	652043.9	4768813.8	1173.97	60.0	60	50
17	ОТМВ11-17	647667.5	4759373.3	1164.15	7.5	5	50
18	ОТМВ11-18	647676.4	4759373.5	1164.14	30.0	30	50
19	ОТМВ11-19	651362	4758138	1143.87	5.5	5	50
20	ОТМВ11-20	651369.9	4758148.0	1144.18		25	50
21	ОТМВ11-21	651369.9	4758148	1144.18	60	60	50
22	ОТМВ11-22	657413.4	4760787.7	1131.08	5	5	50
23	ОТМВ11-23	654890.1	4756380.5	1127.93		22	50
24	ОТМВ11-24	654890.2	4756380.4	1127.93	60	60	50
25	ОТМВ11-25	657413.4	4760784.7	1131.08	5	5	50
26	ОТМВ11-26	657422.1	4760775.6	1131.17	30.0	30	50



27	OTMB11-27	659503	4761406.5	1138.35	5	5	50
28	OTMB11-28	659509.8	4761411.5	1138.33	30.0	30	50
29	OTMB11-29	662762.8	4764527.1	1160.10	56	42	50
30	OTMB11-30	658419.1	4757934	1121.29	5	5	50
31	OTMB11-31	658429	4757929.5	1121		33	50
32	OTMB11-32	658429	4757929.5	1121.5	60.0	60	50
33	OTMB11-33	660751	4750292.4	1092.55	5	5	50
34	OTMB11-34	660758.3	4750281.9	1092.62		21	50
35	OTMB11-35	660758.2	4750282	1092.62	50.0	50	50
36	OTMB11-36	649987	4762005.1	1166.97		35	32
37	OTMB11-37	649987	4762005.1	1166.97		140	50
38	OTMB11-38	650301.5	4761985.9	1160.63		31	50
39	OTMB11-39	650301.5	4761986.0	1160.63	61.0	61	50
40	OTMB11-40	649088.7	4761408.6	1163.90		29	32
41	OTMB11-41	649088.7	4761408.6	1163.90	150	150	32
42	OTMB11-42	650586.1	4761961.7	1161.46		42	32
43	OTMB11-43	650586.1	4761961.7	1161.46	150	150	50
44	OTMB11-44	650093.8	4761806.9	1163.88	119.0	119	50
45	OTMB11-44B	650298.9	4761990.9	1160.65	5	5	50
46	OTMB11-45	651575.7	4759452.1	1148.69	5	5	50
47	OTMB11-46	649499.3	4762997.0	1167.39		28	32
48	OTMB11-47	649499.3	4762997.0	1167.39		150	50
49	OTMB11-48	649499.3	4762997.0	1167.73		38.5	32
50	OTMB11-49	653242.7	4760569.1	1149.73	146.0	146	32
51	OTMB11-50	648693.0	4763359.4	1170.42		26	50
52	OTMB11-51	648693.0	4763359.4	1170.42	150.0	150	50
53	OTMB11-52	651572.6	4759458.2	1148.69		24	50
54	OTMB11-53	651572.6	475958.1	1148.69	150	150	50
55	OTMB11-54	651401.6	4765309.0	1161.45		40	32
56	OTMB11-55	651401.6	4765309.0	1161.45	150.0	150	50
57	OTMB11-56	650193.7	4764759.1	1176.48		26	32
58	OTMB11-57	650793.8	4764759.1	1176.48	150	150	50
59	GHMB11-01	694402	4809103		52		
60	GHMB11-02	694402	4809103		249.43		
61	GHMB11-03	694417	4809075		122		
62	GHMB11-04	694417	4809075		166		
63	WAMB-A1-1	694417	4809092		80		
64	WAMB-A1-2	694433	4909099		250		
65	GHMB11-5	678804	4799436		77.65		
66	GHMB11-6	678804	4799436		319		
67	GHMB11-7	678795	4799404		165		
68	GHMB11-8	678795	4799404		210		
69	WAMB-A2-1	679905	4799415		100		
70	WAMB-A2-2	679792	4799420		320		
71	GHMB11-17	686271	4798457		39.4		
72	GHMB11-18	686271	4798457		172		
73	GHMB11-19	686245	4798460		115		
74	GHMB11-20	686245	4798460		140		
75	GHMB11-13	682054	4795990	1020.38	74		
76	GHMB11-15	682062	475966	1020.84	18		
77	GHMB11-21	673213	4824408	1090.69	28		
78	GHMB11-02	681232	4820103	1045.83	83		
79	GHMB11-23	681223	4820078	1045.94	35		



80	GHMB11-25	688536	4816013	994.53	136		
81	GHMB11-04	693723	4813048	971.68	220		
82	GHMB11-27	693727	4813072	971.35	213.7		
83	GHTP11-05	680293	4809787	1062.48	300		
84	GHMB11-29	680318	4809782	1062.62	140		
85	GHTP11-06	704069	4800995	949.73	334		
86	GHMB11-31a	704094	4801011	950	220.9		
87	GHTP11-07	711381	4817675	918.33	196		
88	GHMB11-32	711361	4817696	919.09	114		
89	GHMB11-33	711376	4817704	918.89	197.5		
90	GHTP11-08	718921	4816509	902.43	242		
91	GHMB11-34	718932	4816537	902.16	130		
92	GHTP11-09	719194	4829254	936.33	186		
93	GHMB11-36	719192	4829284	937.1	81.6		
94	GHTP11-10	725983	4832412	909.6	220		
95	GHTP11-12	707262	4838782	1020.33	146		
96	GHMB11-42	707256	4838754	1019.8	70		
97	GHTP11-13	659468	4791902	1111	206		
98	GHMB11-44	659494	4791899	1109	98		
99	GHTP11-14	653392	4791309	1141			
100	GHMB11-46	653392	471309	1141	58		

3.2.2.4. Ундай Голын Гольдролын Өөрчлөлттэй холбоотой Гомдол

Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд сөрөг өөрчлөлтүүд гарч байна. “Оюутолгой” төслийн үйл ажиллагааны улмаас Ундайн голын голдиролыг өөрчилж байна. 2012 оны 10 дугаар сард Монгол улсын Өмнийн Говьд буй Оюутолгой төслийн нөлөөлөлд өртсөн гэж үзэж буй нутгийн малчид үндэсний Төрийн Бус Байгууллага Оюутолгой Хяналт ба орон нутгийн Говийн Газар Шороо Төрийн Бус Байгууллагын туслалцаатай Олон Улсын Санхүүгийн Корпорацийн төслүүдийн нөлөөлөлд өртсөн хүмүүс гомдол гаргадаг бие даасан гомдлын механизм–Эрх Зүйн Хяналт Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газарт гомдол гаргажээ. Гомдол гаргагчид төсөл газар, ус ашиглаж байгаа нь тэдний нүүдлийн аж төрөх ёсыг алдагдуулан, тэдний уугуул соёл, амьжиргаанд аюул учруулж байна хэмээжээ. Гомдол гаргагчид тэдэнд зохих ёсоор нөхөн олговор олгоогүй буюу эсвэл нүүлгэн шилжүүлээгүй гээд төслийн зохист байдлын магадлан шинжилгээ хэрхэн хийгдсэн, ялангуяа хуурайшилттай бүс нутагт усыг тогтвортой ашиглахтай холбоотой асуудлаар нэхэмжлэл гаргасан. 2013 оны 2 дугаар сард төслийн ойролцоо амьдарч, амьжиргаагаа залгуулдаг нутгийн малчид, иргэд хоёр дах гомдлыг гаргажээ. Гомдол гаргагчдын тавьсан гол асуудал нь төслөөс Ундай голыг өөрчлөлттэй холбоотой. Гомдол гаргагчид голын гольдролыг өөрчилснөөр тэдний уламжлалт нүүдлийн аж төрөх хэв маяг, амьжиргаанд аюул учруулна гэж үзсэн. Тэд голын гольдролын өөрчлөлт хэд хэдэн усны сүлжээг хуурайшуулж, бэлчээрийн гарцыг муутган, хайлаас модны төглүүд усаар хангагдахгүй болох ба мөн ариун



дагшин гэж тэд шүтдэг голд нь соёлын нөлөөлөл учирна хэмээн онцгой санаа зовж буйгаа илэрхийлсэн байна. Иймээс хөндлөнгийн шинжээчдийн судалгааг явуулсан.

“Ундай Голын Гольдролыг Өөрчилсөн талаарх Гомдол” 1-р шатны Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн тайлангаас

Тус судалгаа нь Оюутолгой компанийн үйл ажиллагаанаас нөлөөлсөн болохыг тодорхойлох, уурхайн нөлөөллийн нөхөн олговрын хөтөлбөр зохистой байсан эсэх мөн Ундай, Халив Дугатын голын гольдрол өөрчлөлтийн улмаас бүс нутгийн ус, бэлчээрийн нөөцөд учирч болох хуримтлагдах нөлөөлөл, Оюутолгойн хаягдлын далангийн нөлөөллийг үнэлэх зорилготой байсан. Судалгааг Олон талт мэргэжлийн шинжээчдийн баг болон Хөндлөнгийн шинжээчдийн баг 2016 онд хийж 2017 оны 1-р сард Ханбогд сумын Гурван Талт Зөвлөлд хүлээлгэн өгсөн байна.

Ундайн голын гольдролыг өөрчилсөн нөлөөллийг товч оруулав. Ундайн гол нь 120 км урт, түр зуурын олон салаа цутгалантай, ус хураах талбай нь 1080 км² газрыг хамардаг Ундай гол нь Оюутолгой төслийн нөлөөллийн бүст буй гидрологийн тун чухал ач холбогдолтой тогтолцоо юм.

Ундай голын аллювын хурдас дах усны алдагдлыг хоёр өөр газарт, нэг нь А бүс буюу үндсэн урсгалыг өөрчилсөн хэсгийн эхэнд уурхайн лицензит талбайн баруун хойно, нөгөө нь Б бүс буюу уурхайн лицензит талбайн дотор ил уурхайн орчим/өмнөд хэсгийн байдлаар тайлбарлажээ. Алдагдлын шалтгаан нь: а) ус шавхагдсан б) хоёр газрын аль алинд аллювын хурдсаас ул чулуулгын уст давхарга руу босоо нэвчилт явагдаж байгаагаас үүдэлтэй. Ундай голын аллювын хурдас нь ул чулуулгын ус нэвчих давхарга, бүтэцтэй холбоотой тул Ундай голын аллювын хурдсаас хонхор цүнхэл рүү гадаргын доорх ус алдагдаж байгаад үргэлжлүүлэн мониторинг хийх шаардлагатай. “Ундай голын ойр орчим, ил уурхайгаас баруун, хойд зүгт байгаа мониторингийн худгуудын усны түвшин буурсан (OTD 195, OHLGBH-40, OTRC131, OTRC047 дугаарт худгууд). Байгалийн зарим усны түвшин өөрчлөгдсөн нь ялангуяа 2011 онд бороо хурын хэмжээ дунджаас доогуур байснаас шалтгаалсан. Харин дээрх мониторингийн цэгүүдэд усны түвшин доошилсон нь зарим талаар ил уурхайн өргөжилттэй холбоотой. Хонхор цүнхэлийн ойр тойронд гүехэн гүний усны түвшин доошилсон нь Бор Овоон задгай болон Ундай голын орчим 1-2 км газар усгүй болоход хүргэжээ. Энэ нь уурхай орчмын гүний усны байдал төлөв хэрхэх тухай таамаглалтай таарч байгаа бөгөөд 2011 оноос хойш сүүлийн 3 жилийн хугацаанд Ундай голын дагуух усны нөөц (гар худгууд) огцом өөрчлөгдөж буй талаарх малчдын ажиглалттай мөн тохирч байна.

Усны хүрэлцээ, чанарт нөлөөлсөн байдал

А). Ундай гол нь Оюутолгойн уурхайн лицензит талбайн баруун талаар дайран зүүн урд зүг рүү чиглэн, Оюутолгойн уурхайгаас өмнө зүгт ойролцоогоор 60 км-т байрлах тэгш гадарга бүхий Галбын говийн нууруудын ай сав газарт очин сарнидаг байна. Ундай голын хаялбарын сүлжээн дотор олон тооны дэд бүтцийг барьж байгуулсан, хиймэл дагуулын зургаас харахад барилгын ажил ид явж буй нь харагдана. Гадаргын хаялбарын сүлжээ, Халив-Дугатын цутгаланд учруулсан нөлөөллүүдийг хөндлөнгийн шинжээчдийн багийн ажлын хоёр дах шатанд авч үзэх болно. Уурхайн барилгын ажилд ус ашигласан, ус шавхсан болон ил уурхайн улмаас гүехэн гүний ус доошилсон байна. Ундай голын аллювын хурдас ус нэвчих үе давхаргатай холбоотой нь илэрхий тул ил уурхайн хонхор цүнхэлийн орчим гүехэн гүний ус доошилсноор Ундай голын аллювын хурдас, Бор Овоогийн задгайн ус Ундай голоос 1-2 км газарт алдагджээ. Нүүрсний зам болон төмөр замын барилгын ажилд ус авч ашигласан, ус зайлуулах байгууламж муугаас үерийн урсгал болон Ундай голын ай савын ундаргад нөлөөлжээ. Энэ нь хэдийгээр Оюутолгойн уурхайн үйл ажиллагаа эсвэл Ундай голын өөрчлөлттэй шууд холбоогүй ч хөндлөнгийн шинжээчдийн багийн 1-р шатны тайланд малчдын усны эх үүсвэр, бэлчээрийн хуваагдлын хам нөлөөллийн дүн шинжилгээний нэг хэсэг болгон авч үзсэн болно. Ундай голын үндсэн урсгалыг өөрчилснөөс малчдын усны хүрэлцээнд учирсан хамгийн илт нөлөөлөл бол Ундай голын гольдролыг өөрчилсөн хэсгийн дагуу үе үе тохиох үерээр бий болдог Ундай голын гадаргын усны хүртээмж алдагдсан, мөн энэхүү өөрчилсөн хэсэгт Ундай голын аллювын уст давхарга үерийн усаар тэтгэгдэж чадахгүй болсон явдал юм.





Б). Бор Овоогийн задгайг шилжүүлэхээр төлөвлөсөн байршлийн талаар


Бор Овоогийн задгайг нүүлгэснээр малчдын усны хүрэлцээ, усны чанарт учруулсан шууд нөлөө бол задгай бүрмөсөн үгүй болсон явдал юм Уурхайн лицензит талбайн хашааны өмнөд хэсэг дэх усны түр эх үүсвэр усаар хангаж байгаа хэдий ч энэ нь Бор Овоон задгайн мал маллагаа болон зэрлэг ан амьтанд үзүүлж байсан экологийн үйлчлэлүүдийн аль алиныг нь нөхөж чадахгүй байна. Бор Овоон задгай үгүй болсноор малчид шилжүүлэн байршуулсан хоолойгоор гарч буй усанд малаа хүргэхийн тулд урт зам туулах болсон; Уурхайн лицензит талбайг сүүлийн байдлаар хашаалснаас хойш бүр ч их зам туулах болжээ. Мөн түүнчлэн сүүлийн үед үерийн урсац цөөрснөөр малчдын худгийн усны ундрага багасч голын дагуу нутагладаг малчдад нөлөөлж байна.




Үүнээс үүдэн дараах байдал илт болж байна. Оюутолгой уурхай болон дэд бүтцийн барилгын ажил (нүүрсний замыг оролцуулан) усны хагалбарт өргөнөөр нөлөөлснөөр зуны бэлчээрийн хүрэлцээ, усны эх үүсвэр алдагдаж, Ханбогд сумын ялангуяа Жавхлант багийн





уламжлалт нүүдлийн мал маллагааны хэмнэлийг ноцтойгоор, эргэлт буцалтгүй бусниулан, нийт малчин түмэнд нөлөөлөл учруулж байна [49].

Хүснэгт 56. Ундайн гол дагуух задгай уст цэгүүдийн одоогийн байгаа байдал

№	Нэр	Өндөршил	Тайлбар	Зураг
1	Эргэн шанд-1	4136	Ширгэсэн	
2	Эргэн шанд-2	4107	Ширгэсэн	
3	Улаан Толгой	4053	Ширгэсэн	
4	Дундан	3991	Ширгэсэн	

5	Дээд хөх хад	3928	Ширгэсэн	
6	Бумбат	3914	Жаахан нойтон шорооноо гарсан	
7	Шар хушуу			Оюутолгой уурхайн хашаан дотор
8	Хар хошуу			Оюутолгой уурхайн хашаан дотор
9	Бор овоо			Оюутолгой уурхайн хашаан дотор
10	Долгон			Оюутолгой уурхайн хашаан дотор
11	Хужирт	3717	Жаахан устай	
12	Будагт	3705	Ширгэсэн	
13	Доод хөх хад	3671	Ширгэсэн	

14	Ар задгай	3661	Ширгэсэн	
15	Хөөрхөн овоо	3652	Ширгэсэн	
16	Буурал	3658	Ширгэсэн	
17	Хүүрт	3535	Ширгэсэн	
18	Мааньт	3539	Устай	

19	Дунд бурхант	3518	Жаахан устай	
20	Сондуул	3463	Бараг усгүй	
21	Сайхан овоо	3450	Жаахан устай	
22	Наймаа ус	3426	иргэсэн	

“Ундай Голын Гольдролыг Өөрчилсөн талаарх Гомдол” зориулсан зөвлөмжүүд

1. Усны мониторингийн ил тод байдлыг сайжруулан, Оюутолгойн олж мэдсэн зүйлсийг малчдын ажиглалттай уялдуулах. Аргачлал, олж илрүүлсэн зүйлсийг хамтдаа судлан хянах. Хамтын оролцоот мониторинг ба төлөвлөлтийг цаашид сайжруулах анхны алхам болгон малчдын ажиглалтуудыг хамтдаа судалж үзэхийг хөндлөнгийн шинжээчдийн баг санал болгож байна. Талууд: Орон нутгийн засаг захиргаа (Багийн засаг дарга, Сумын гидрологийн техникч), Оюутолгой ба нутгийн малчид өөр өөрсдийн мониторингийн арга ажиллагааг ярилцан хэлэлцэж, газар дээр нь очиж үзэн, мониторингийн аргачлалыг харилцан тохирч, мониторингийн хуваарийг гарган, түүнийг хэрэгжүүлэх.

2. Хөндлөнгийн шинжээчдийн баг урьдчилсан тайланг (2014 оны 4 сард) танилцуулсны дараа уурхайн лицензит талбайгаас 20 км-ын зайд буй малчдыг Оюутолгойн усаар (усны сав болон машинаар хүргэн) хангасан. Энэ чармайлтаа үргэлжлүүлэн, Ундай голын сав дах өрхүүдэд усны хомсдол учирсаар байвал шаардлагатай тохиолдолд ихэсгэх хэрэгтэй. Талууд: Багийн засаг дарга, Сумын мал аж ахуйн тасгийн холбогдох ажилтнууд, Сумын бэлчээр, газрын төлөвлөлт хариуцсан газрын мэргэжилтэн нутгийн малчидтай хамтран малчдын усны хэрэгцээг тодорхойлж, компанийн холбогдох хэлтсүүдтэй хамтран ажиллаж, компанийн туслалцааг зохицуулах. Усны эх үүсвэр бий болгох асуудлаар (гүний худаг) орон нутгийн засаг захиргаа Аймаг/Төв Засгийн газартай ажлаа уялдуулах.

3. Бэлчээрийн Мониторингийн тухайд: Нутгийн Түншлэлийн хийсэн Бэлчээрийн Хамтарсан Үнэлгээнд Ундай голын дагуух мониторингийн цэгүүдийг хамруулах; уурхайн лицензит талбайн доторх Оюутолгойн мониторингийн цэгүүдийг мөн тэрхүү системд оруулах хэрэгтэй.

4. Хамтын оролцоот (бэлчээрийн) мониторинг нь хүмүүсийн “сэтгэлийг тайвшруулах” төдийгээр зогсох бус харин хамтран шийдвэр гаргах, нөлөөллийг багасгах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд ашиглах хэрэгсэл болох ёстой.

“Ундай Голын Гольдролыг Өөрчилсөн талаарх Гомдол” 2-р шатны Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн тайлангаас

Халив -Дугатын голын гольдролыг өөрчилсөн эсэх, эсвэл хожим өөрчлөх эсэх, Ундай, Халив- -Дугатын голын гольдролыг өөрчилсний улмаас энэ бүс нутгийн ус, бэлчээрийн нөөцөд учирч болзошгүй хуримтлагдах нөлөөлөл; Хаягдал хадгалах байгууламж одоо шүүрч байгаа эсэх, ирээдүйд ингэж шүүрэх эрсдэл байгаа эсэх, энэ шүүрэл нь Халив-Дугатын гол болон малчдын, малын усны бусад аливаа эх үүсвэрт ямар нөлөөлөл(үүд) учруулах; мөн Халив-Дугатын голд учруулах нөлөөллөөс зайлсхийхийн тулд Төслийн хаягдал хадгалах байгууламжийг өөрчлөх боломжтой эсэх эсвэл холбогдох мониторинг, нөлөөллийг бууруулах төлөвлөгөө зэрэг нь хэр үндэслэлтэй болох гэсэн зорилготой хийгдсэн.

Гидрологийн нөхцөл

Халив-Дугатын гольдролыг даялуулан, усны хагалбарын хэд хэдэн хэсэгт өөрчилсөн байна. Гол ба/эсвэл түүний цутгалангууд ухагдаж, уурхай, замын дэд бүтцийн улмаас хэд хэдэн газарт таглагдан, боогджээ. Үүний улмаас усны хагалбарын энэ хэсэгт гадаргын болон хөрсний усны урсац өөрчлөгдсөн. Төслийг эхлэхээс өмнө усны хагалбарын энэ хэсгийн гидрологийн нөхцөл байдалд хангалттай мониторинг хийгдээгүй тул гадаргын болон хөрсний усанд гарсан өөрчлөлтийг тоогоор илэрхийлэх боломжгүй.

Хаягдал хадгалах байгууламж шүүрч байгаа нь баримтаар тогтоогдсон. Мониторингийн дийлэнх цэгүүдийн мэдээлэл тасалдалтай буюу тун бага байгаа нь шүүрэлтийг тоогоор хэмжихэд хүндрэл учруулж байна. Шүүрсэн усыг тогтоох систем нь шүүрсэн усыг уурхайн лицензит талбайн дотор барьж байхаар хийгдсэн бөгөөд шүүрэлтийг уурхайн лицензит талбай дотор барьж байгаа харагдаж байв. Ямартаа ч одоо байгаа мэдээллээс үзэхэд ирээдүйд мониторингийн хөтөлбөрийг маш дэлгэрэнгүй, нарийн ажиглалттай хэрэгжүүлэх шаардлагатай.

Голын гольдролыг аль хэдийн даялуулчихсан, хоёр хэсэг хоёулаа баригдаж байгаа, хаягдал хадгалах байгууламжийн 1-р хэсэг нь ашиглагдаж буй болохоор Халив-Дугатын голд нөлөөлөл учруулахаас зайлхийхийн тулд хаягдал хадгалах байгууламжид өөрчлөлт хийнэ гэдэг найдвартай биш.

Устай холбоотой зөвлөмжүүд

1. Оюутолгойн цоожилж болохооргүй, гүехэн гар худгууд барих хөтөлбөрийн хэлбэрээр нийтийн нөхөн олговор олгох ёстой (Оюутолгойгоос малчдад саяхан барьж өгсөн бетонон гүехэн худгууд шиг).

- Малчид нүүдлээ хийн, бэлчээрийн нөөцийг ашиглахыг хөхүүлэн, тэдэнд уламжлалт амьжиргаагаа үргэлжлүүлэн эрхлэх боломж олгохын тулд худгуудыг 4 багийн нутагт тараан байрлуулах.

- Шинэ худгуудыг бүтээмж сайтай, одоо байгаа худгуудад нөлөөлөхгүй байлгахын тулд тэдгээрийн байршлыг гүний усны судалгаанд үндэслэн гаргах шаардлагатай, мөн түүнчлэн зэрлэг амьтдад нөлөөлөл учруулах эсвэл тэднээс ирэх нөлөөллийн тухайд малчид санаа зовдог гэх мэт малчдын санаа бодлыг харгалзах.

Оюутолгой болон сум хамтран худгуудын нөхцөл байдлыг хянаж, засвар үйлчилгээ хийх хүмүүсийн баг байгуулах (хагас цагийн болон байнгын ажилчидтай байхаар). Хамтын ажиллагааны гэрээнээс санхүүжилт хүсэх хэрэгтэй.

2. Оюутолгой болон сум одоо байгаа малчдын худгууд болон дээр санал болгосон худгуудад засвар үйлчилгээ хийх сайн тогтолцоо бий болгох: доод тал нь 5 жилийн хугацаанд Хамтын ажиллагааны гэрээгээр үүнийг санхүүжүүлэхийг санал болгож байна.

3. Оюутолгой газар зүйн хувьд тараан байрлуулсан цэгүүд дээр аллювын уст давхаргын жишээ загварчлал гаргаж, мониторинг хийх, мөн Оюутолгойн өнгөрсөн, одоо, ирээдүйн нөлөөллийг хамгийн боломжит хугацаагаар тоон үзүүлэлтээр тооцсон аллювын нөөцөд чиглэсэн гидрологийн судалгаа явуулах хэрэгтэй. Ингэснээр малчид хараат байдаг гүехэн гүний усны динамикийн талаар илүү сайн ойлголттой болж, загварчлалыг сайжруулан, ирээдүйд усны нөөцийн өөрчлөлтийг хэмжиж чаддаг болно.

4. Малчдыг усаар хангаж байгаа нь түр зуурын арга хэмжээ бөгөөд зугуухан болих хэрэгтэй. Тодорхой хугацаа тохироод, одоо ус зөөж өгч байгаа газруудын усны нөөцөд үнэлгээ хийлгэх; хэрэв ажиллагаатай худаг тэнд нь байгаа бол хөтөлбөрийг зогсоох; худаггүй бол санал болгож буй худаг барих хөтөлбөрийн хүрээнд нэгийг барьж өгөх нь зүйтэй.

5. Элэгдлийг багасган, Халив-Дугатын үерийн усыг үр ашигтай урсгахын тулд Оюутолгой Халив-Дугатын голын өөрчлөлтийн сувгийн бүрэн бүтэн байдлыг сайжруулах хэрэгтэй. Үүнийг хийхдээ өөрчлөлтийн бат бөх байдлыг үнэлэх мөн эрэг ёроолыг бэхжүүлэн, ус тогтохоос аль болох сэргийлэх замаар засаж болох элэгдэл ихтэй газруудыг тодорхойлохын тулд хамтран баримт олж тогтоох судалгааг ашиглаж болно.


6. Усны хагалбарт тогтоол ус хуралдах, ууршихаас сэргийлэхийн тулд хаана ямар нь тохиромжтойгоос шалтгаалан нүхэн хоолой, нуман эсвэл хуягласан гарам зэрэг ус нэвтрүүлэн зайлуулах зохистой механизмийг Оюутолгой бий болгох хэрэгтэй. Эдгээр газрууд болон нөлөөллийг бууруулах боломжит арга техникүүдийг гурван талт зөвлөл хамтран хянан үзэж болох юм.

7. Оюутолгой Техникийн Хяналтын Хөндлөнгийн Зөвлөлөөр шүүрэлтийг хянан үзэж, Хаягдал Хадгалах Байгууламж ийн зураг төсөлд оруулах өөрчлөлтийг санал болгон, урсгалын доод руу гарч болзошгүй нөлөөллийг судлан, үр дүнг бүх талуудад тайлагнах [36].

3.2.3. Тариалангийн газрын ашиглалт

Сумын хэмжээнд 15 га газарт төмс, хүнсний ногоо тариалдаг. Тус сумын хувьд одоогийн нийт газар тариаланд идэвхитэй ашиглагдаж буй эргэлтийн талбай нь хангалтгүй байгаа бөгөөд сумын нийт хүн амын хэрэгцээний 20.0 хувийг хангах хэмжээнд байна.


Зураг 41. Тариалангийн газрын ашиглалтын зураг



3.2.4. Ойн сан бүхий газрын ашиглалт

Сумын нутаг дэвсгэрийн 10.0 хувийг заган ой эзэлдэг. Заган ойг жилийн дөрвөн улиралд нутгийн иргэд зөвшөөрөлгүйгээр түлшиндээ хэрэглэдэг байна.


Зураг 42. Заган ой тархсан газар нутгийн зураг



3.2.5. Уул уурхайн ашиглалт

Сумын хэмжээнд алтны болон нүүрсний ордын ашиглалтын лиценз бүхий 8 талбай, хайгуулын лиценз бүхий 43 талбай байна. Ашиглалтын лиценз бүхий талбайн хэмжээ 17152.46 га, хайгуулын лиценз бүхий талбайн хэмжээ 188583.09 га байна.

Зураг 43. Уул уурхайн газрын ашиглалтын зураг



Уул уурхайн үйлдвэрлэл хөгжиж байгаагийн хирээр дэд бүтэц барьж байгуулан иргэд ажлын байртай, орлоготой болж байгаа хэдий ч байгаль орчны бохирдол ихсэж, бэлчээрийн газар доройтож, булаг шанд ширгэж, тэдний амьдралд сөргөөр нөлөөлөх болсоноор малчид мал маллан амьдрах боломж нөхцөл багасаж байна.

Хүснэгт 57. Ашиглалтын зөвшөөрөлтэй талбай

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Газрын нэр	Талбай /га/
1	Ашиглалтын зөвшөөрөлтэй	Манхат	4533.32
2	Ашиглалтын зөвшөөрөлтэй	Хөх хад	1762.70
3	Ашиглалтын зөвшөөрөлтэй	Оюутолгой	8489.93
4	Ашиглалтын зөвшөөрөлтэй	Шивээ толгой	42125.80
5	Ашиглалтын зөвшөөрөлтэй	Жавхлант	20034.99
6	Ашиглалтын зөвшөөрөлтэй	Алтан од	101.71
7	Ашиглалтын зөвшөөрөлтэй	Үнэгтийн хүрэн толгод	1529.48
8	Ашиглалтын зөвшөөрөлтэй	Хацавч	5647.55
Нийт			84225.49

Хүснэгт 58. Хайгуулын зөвшөөрөлтэй талбай

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Газрын нэр	Талбай /га/
1	Хайгуулын зөвшөөрөлтэй	Хацавч	4593.76
2	Хайгуулын зөвшөөрөлтэй	Жавхлантын Уул	1586.83
3	Хайгуулын зөвшөөрөлтэй	Алтан од	15115.06
4	Хайгуулын зөвшөөрөлтэй	Хүрэнцав	39290.20
5	Хайгуулын зөвшөөрөлтэй	Баяннуур	913.82
6	Хайгуулын зөвшөөрөлтэй	Майхант	2066.90
7	Хайгуулын зөвшөөрөлтэй	Жавхлантын уул	3040.07
8	Хайгуулын зөвшөөрөлтэй	Тэрэгт	5214.51
9	Хайгуулын зөвшөөрөлтэй	Манлай-6	2271.71
10	Хайгуулын зөвшөөрөлтэй	Жавхлант	912.18
11	Хайгуулын зөвшөөрөлтэй	Сүүж уул	1706.33
12	Хайгуулын зөвшөөрөлтэй	Даравгайн худаг	7014.94
13	Хайгуулын зөвшөөрөлтэй	Соёот	11730.59
14	Хайгуулын зөвшөөрөлтэй	Баян хар уул	2740.29
15	Хайгуулын зөвшөөрөлтэй	Зүүн шарын ус	15318.95
16	Хайгуулын зөвшөөрөлтэй	Хүрэн	4675.49
17	Хайгуулын зөвшөөрөлтэй	Улаан хад	6862.71


18	Хайгуулын зөвшөөрөлтэй	Хөндлөн	5988.61
19	Хайгуулын зөвшөөрөлтэй	Улаан худаг	3954.36
20	Хайгуулын зөвшөөрөлтэй	Аз-2	5168.89
21	Хайгуулын зөвшөөрөлтэй	Аз-1	8465.31
22	Хайгуулын зөвшөөрөлтэй	Од-2	1815.17
23	Хайгуулын зөвшөөрөлтэй	Гал-2	372.09
24	Хайгуулын зөвшөөрөлтэй	Ханбаян	224.24
25	Хайгуулын зөвшөөрөлтэй	Баг	14573.83
26	Хайгуулын зөвшөөрөлтэй	Ямаат	0.29
27	Хайгуулын зөвшөөрөлтэй	Шавагтай	2026.98
28	Хайгуулын зөвшөөрөлтэй	Баян	333.00
29	Хайгуулын зөвшөөрөлтэй	Шавагтай	26988.46
Нийт			194965.58

Ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд зөвшөөрөл бүхий талбайг томсгож зөвшөөрөлгүй газарт үйл ажиллагаа явуулж байгаа нь сансрын зурагтай ашиглалтын талбайг давхцуулан шалгахад тодорхой байна.

3.2.6. Зам шугам сүлжээний газар

Тус сумын газар нутгийн 0.6 хувь буюу 10266.79 га талбайг зам шугам сүлжээний газар эзэлж байна.


Зураг 44. Зам шугам сүлжээний газрын ашиглалт



1.2.7. Усны сан бүхий газар

Тус сумын газар нутгийн 0.05 хувь буюу 807.0 га талбайг усан сангийн газар эзэлж байна.

Зураг 45. Усан сангийн газрын ашиглалт




3.2.6. Тусгай хамгаалалттай газар

Тус суманд орон нутгийн 535076.29 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авснаас 101.0 га газар нь байгалийн нөөц /Говийн бага дархан газар/, дурсгалт газар 25 га, тусгай хэрэгцээний газар 534380.16 га, түүх соёлын дурсгалт газар 570.13 га газар байна.

Ханбогд суманд орон нутгийн тусгай хамгаалалтанд авахаар Ханбогд уул, Дэмчогийн хийд 32280 га, Гурван зээрдийн агуй 19825 га шинээр хамруулахаар төлөвлөсөн байна.


Говийн бага дархан газар нь 1993 онд хулангийн (*Equus hemionus*) идээшил нутгийг хамгаалах нэн тэргүүний зорилготой байгуулагдсан. Энэ нутаг нь А, Б гэсэн 2 хэсгээс бүрдэх ба Өмнөговь аймгийн Номгон, Баян-овоо, Ханбогд сумдын нутаг болон Дорноговь аймгийн Хатанбулаг сумын өмнөд хэсгийн 1.839.176 га талбайг хамарна.

Зураг 46. Улсын тусгай хамгаалалттай газрын зураг



ГБДГ нь зүүн өмнөд говийн бүсийн экологийн шинж төрхийг төлөөлсөн бөгөөд байгалийн унаган тогтоц хэв шинжийг хадгалж үлдсэн нутаг юм. Мөн хулан (*Equus hemionus*), хар сүүлт (*Gazella subgutturosa*) зэрэг бүс нутгийн ховор болон нэн ховор зэрлэг амьтдын үндсэн идээшил газар болно. Тухайн газар нутагт ховор ургамал, амьтан, булаг шанд элбэгтэй цаашид байгалийн унаган төрхийг хадгалж хамгаалах шаардлагатай газар юм.

Зураг 47. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын зураг



Орон нутгийн тусгай хамгаалалтад Дэмчогийн хийд, Гурван зээрдийн агуйг хамруулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 59. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд

№	Газрын нэр	Төрөл	Зориулалт	Талбай /га/
1	Аймгийн урд талын сумдын улсын хил дагуу	Аймаг	Тусгай хэрэгцээний газар	122398.38
2	Цагаан толгойн хийд	Сум	Тусгай хэрэгцээний газар	24.3
3	Цогцолын хийдийн хөдөлдөг цохио	Сум	Тусгай хэрэгцээний газар	24.67
4	Байшин цав	Сум	Тусгай хэрэгцээний газар	1007.91
5	Эрээтийн хийд	Сум	Тусгай хэрэгцээний газар	23.99
6	Галбын гурван хийд	Аймаг	Тусгай хэрэгцээний газар	24977
7	Дэмчогийн хийд	Сум	Тусгай хэрэгцээний газар	24.55
8	Хот тосгон	Улс	Тусгай хэрэгцээний газар	7718.79
9	Хот тосгон	Улс	Тусгай хэрэгцээний газар	1131.78
10	Оюутолгой3	Засгийн газар	Тусгай хэрэгцээний газар	63491.65
11	Оюутолгой 1	Засгийн газар	Тусгай хэрэгцээний газар	85352.79
12	Оюутолгой 2	Засгийн газар	Тусгай хэрэгцээний газар	115295.15
13	Номгон баг, Баян баг хамарсан	Сум	Тусгай хэрэгцээний газар	112857.98
14	Мэлхий цохио	Сум	Тусгай хэрэгцээний газар	1.22
15	Мангасын хүрээ	Аймаг	Тусгай хэрэгцээний газар	50
16	Алаг баянгийн хийд	Сум	Түүх соёлын дурсгалт газар	65.61
17	Зүүн хацавч уулын хадны зураг	Сум	Түүх соёлын дурсгалт газар	475.04
18	Улаан тойромын чулуужсан мод	Сум	Түүх соёлын дурсгалт газар	4.49
19	Морьтон хужир	Сум	Байгалийн нөөц газар	100
20	Улаан булангийн рашаан	Сум	Байгалийн нөөц газар	1
21	Шийр уулын хадны зураг	Сум	Дурсгалт газар	25
22	Далайн дуулга уулын хадны зураг	Сум	Түүх соёлын дурсгалт газар	25
Нийт				535076.29



Хүснэгт 60. Уул уурхайн зөвшөөрлийн хүснэгт

Тусгай хамгаалалтын төрөл	Зориулалт	Огноо	Санал	Талбай /га/	Тайлбар	
Аймаг	Ерөнхий тусгай хэрэгцээний газар	9/8/1997	Улсын болон ОНТХ газар нутагтай давхцсан учир хил заагт өөрчлөлт оруулах	122398.4	АМГазрын кадастрын албанд шинэчлэн бүртгүүлэх	
Сум		12/24/2001	Координат буруу тодорхойлогдсон учир хил заагт өөрчлөлт оруулах	24.3	АМГазрын кадастрын албанд бүртгэгдсэн	
		12/24/2001		24.6		
		12/24/2001		1007.9		
		12/24/2001		23.9		
Аймаг			6/20/2008	АМ лицензийн болон ОНТХГ Нутагтай давхцсан учир хил заагт өөрчлөлт оруулах	24977	АМГазрын кадастрын албанд шинэчлэн бүртгүүлэх
Сум			12/24/2001		24.5	АМГазрын кадастрын албанд бүртгэгдсэн
Улс			6/2/2010		7718.7	Улсын тусгай хэрэгцээ
Улс			6/2/2010		1131.7	
Засгийн газар		Ерөнхий тусгай хэрэгцээ	6/8/2011	АМ лицензийн талбайтай давхцаж байгаа улсын тусгай хэрэгцээ	63491.6	АМГазрын кадастрын албанд шинэчлэн бүртгүүлэх
	6/8/2011		АМ лицензийн талбайтай давхцаж байгаа улсын тусгай хэрэгцээ	85352.7		
	6/8/2011		АМ лицензийн талбайтай давхцаж байгаа улсын тусгай хэрэгцээ	115295.1		
Сум	Ерөнхий тусгай хэрэгцээний газар	1/3/2011	АМ лицензийн талбайтай давхцсан учир хил заагт өөрчлөлт оруулах	112858		
Сум		4/9/2002		1.225		
Аймаг	Ерөнхий тусгай хэрэгцээ	12/28/2011		50.0		
Сум	Түүх соёлын	12/28/2011		65.6		
		12/28/2011		475.0		

	дурсгалт газар	12/28/2011		4.4	
	Байгалийн нөөц газар	12/28/2011		100	
		12/28/2011		1	
	Дурсгалт газар	12/28/2011		24.9	
	Түүх соёлын дурсгалт газар	12/28/2011		24.9	

3.2.7. Түүх соёлын дурсгалт газар

Сумын нутагт Чингисийн уурганы нүх, Хөдөлдөг цохио, Мэлхий хад, Гурван зээрдийн агуй, Сэвхүүлийн элс, Хаалганы рашаан, Данзанравжаагийн байгуулсан алдарт гурван хийдийн туурь, Цогцолын хийдийн туурь, Алтангэрэлийн дугуй, Ловончомбын баяжуулдаг Чавгын агуй, ходоод ба нүдний рашаан, цөсний чулуу зэрэг байгаль түүхийн дурсгалт газруудтай. Ханбогд суманд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаачид хүннү үеийн ваарны хагархай булц, хүннүгийн үеийн нүүдэлчидийн бууц суурингийн үлдэгдэл байгааг илрүүлсэн.

Хүснэгт 61. Түүх соёлын дурсгалт газрын судалгаа

№	Баг	Газрын нэр	Тайлбар	Төрөл
1	Номгон	Бүст	Бага бүстийн зэл чулуу	Байгалийн үзэсгэлэнт газар
2	Номгон	Замын хар толгод	Хүн чулуу	Байгалийн үзэсгэлэнт газар
3	Номгон	Баян модны сайр	Цогцолын хийд	Түүх соёлын дурсгалт газар
4	Номгон	Хоёр модны хоолой, Улаан тойром	Улаан тойромын чулуужсан мод	Байгалийн үзэсгэлэнт газар
5	Номгон	Чулуутын тойром	Партизан Довдой хөшөө	Түүх соёлын дурсгалт газар
6	Номгон	Хадан хошуу	Ханбогд сум анх байгуулагдсан газарт дурсгалын самбар	Түүх соёлын дурсгалт газар
7	Номгон	Даланшарын нуруу	Чулуун байгууламж	Түүх соёлын дурсгалт газар
8	Номгон	Агуй уул	Агуй уулын хийд	Сүм хийд
9	Номгон	Гурван зээрд уул	Гурван зээрдийн агуй хадны оршуулга, харуулын овоо	Түүх соёлын дурсгалт газар
10	Номгон	Зээрдийн хоолой	Мангасын хүрээ	Эртний туурь



11	Гавилууд	Гурван Гавилууд	Гавилууд хайрханы цогцолбор газрын муруй хадны зураг	Түүх соёлын дурсгалт газар
12	Гавилууд	Мөнх-Овоо	Мөнх-Овоо тахилгат хайрхан	Түүх соёлын дурсгалт газар
13	Жавхлант	Шийр уул	Шийр уулын хадны зураг	Хадны сүг зураг
14	Жавхлант	Ханбогд хайрхан	Ханбогд хайрхан	Түүх соёлын дурсгалт газар
15	Жавхлант	Байшинт уул	Байшинтын хадны зураг	Хадны сүг зураг
16	Жавхлант	Баян хушуу	Дэмчогийн хийд	Сүм хийд
17	Жавхлант	Элгэн хурийн булаг	Цагаан толгойн хийд	Сүм хийд
18	Жавхлант	Элгэн хурийн булаг	Эрээтийн хийд	Сүм хийд
19	Жавхлант		Хацавч толгодын чулуун зэвсгийн суурин	Эртний туурь
20	Жавхлант	Далайн дуулга уул	Далайн дуулганы хадны зураг	Хадны сүг зураг
21	Жавхлант	Хацавчын дуулга уул	Зүүн хацавчийн хадны зураг	Хадны сүг зураг
22	Жавхлант		Баг модны хийд	Сүм хийд
23	Жавхлант	Майхан улаан уул	Хүрдэт агуй	Түүх соёлын дурсгалт газар
24	Жавхлант	Оцон шандны цохио	Оцон мааньт цохио, чулуун зэвсэг	Хиригсүүр
25	Жавхлант	Зүрх уул	Зүрх уулын чулуун зэвсгийн дурсгал	Хиригсүүр
26	Жавхлант	Ямаат уул	Галаан дэлийн цогцолбор газар	Түүх соёлын дурсгалт газар
27	Жавхлант	Жавхлант уул	Жавхлант хайрханы хадны зураг	Хадны сүг зураг
28	Баян	Алаг баян хайрхан	Алаг баянгийн хийд	Сүм хийд
29	Баян	Шавагтайн заг	Байшин цав	Палеонтологийн дурсгалт газар
30	Баян	Шавагтайн заг	Хуурай цав	Палеонтологийн дурсгалт газар
31	Баян	Гүн саглагар	Өрөлбэ	Палеонтологийн дурсгалт газар



Хүснэгт 62. Түүх соёлын дурсгалт газрын тоо

№	Багийн нэр	Нийт	Хириг-сүүр	Хадны сүг зураг	Сүм хийд	Палеонтлог ийн дурсгалт газар	Байгалын үзэсгэлэнт газар	Эртний туурь	Түүх соёлын дурсгалт газар
1	Номгон						4	1	5
2	Гавилууд								2
3	Жавхлант		2	5	4			1	3
4	Баян				1	3			
Нийт		31	2	5	5	3	4	2	10

3.2.8. Ан амьтны тархалт

Тус сум нь Дорноговийн дэд бүсийн нам дор газар орших зүүн өмнөд хэсгээс бусад говийн баруун хэсгийн биологи, газарзүйн дэд бүс нутаг дотор байрлана. Газрын хэв шинж нь гүвээ дов толгод, уулын хяр, томоохон хөндий, түүний ёроолд улирлын шинжтэй үүсэх ус намгархаг хэдэн газруудтай. Хөрс нь гол төлөв чулуурхаг, өвс ургамал тарчиг нутаг юм. Говийн намхан уулархаг газар нь (1300 -1500 м өргөгдсөн) өндөр хадан хясаа цохио цаашлаад агуй гуу хавцалтай. Нам дор газартаа бага хэмжээний давсархаг намаг бүхий чулуурхаг элсэрхэг газрын хөрсөнд заг ургана. Багахан горхины дагуу хөндийд хайлаас тааралдана. Эдгээр янз бүрийн газрын хэвшинж нь олон төрөл зүйлийн зэрлэг ан амьтан нутагших боломж бүрдүүлнэ. Эндхийн хадан хясаа уулсаас эх авсан хэд хэдэн гүехэн булаг шанд байх бөгөөд шугуй, бут, нуга зэрэг илүү өтгөн ургамлан бүрхэвчийг үүсгэх бололцоотой. Энэ нь “Оюутолгой” ХХК-ны болон түүний ойр орчимд амьтдын гол идээшил нутаг болж өгдөг.

Энд ургамлан бүрхэвч нь ихэнхдээ тун сайн бөгөөд мал амьтны өвс тэжээл, бэлчээр бий болгох хангалттай хур тунадас орно. Ханбогд суманд ан амьтдын идээшил нутагт чухал экологийн янз бүрийн хэвшинж бий. Тухайлбал, мод буттай өвслөг тэгш тал хээр, өндөр хадан цохио, гол горхи, нуур, булаг шанд, хайлаас, шугуй төгөл цаашлаад тац мод бүхий өвслөг хөндий бий.

Оюутолгой төслийн газар нутгийн орчимд хэд хэдэн төрөл зүйл тэмдэглэгдээд байгаа боловч, ихэнх нь цөөн тоо толгойтой, амьдрах орчин нь асар өргөн нутгийг хамарч байна. Оюутолгой төслийн талбайн урдхан нь орших Бор Овооны булаг нь өргөн уудам нутагт идээшлэх амьтдын хувьд гол усны хангамжийн эх үүсвэр бөгөөд нүүдлийн олон шувууд ирж буудаллана.

Хөхтөн амьтан

Дөчин гурван зүйлийн хөхтөнг тогтоогоод байгаа бөгөөд үүнд шавьжаар хооллогч, сарьсан багваахай, туулай, мэрэгчид, махаар хооллогч амьтан, туурайтны аймаг орсон болно.

Дараах хөхтөн амьтдыг хамгаалах ач холбогдолтой байна:

- *Salpinctus crassicauda* (Өөхлөг атигдаахай);
- *Echoreutes naso* (соотон алагдаага);
- *Canis lupus* (Саарал чоно);
- *Vulpes vulpes* (шар үнэг);
- *Felis Silvestris* (Цоохондой);
- *Felix lynx* (шилүүс);
- *Vormela perseusna* (Эрээн хүрэн);
- *Equus hemionus* (Хулан адуу);
- *Gazella subgutturosa* (хар сүүлт);
- *Capra sibirica* (Янгир ямаа);
- *Ovis ammon* (Аргаль хонь).

Шувуу

Бүртгэгдсэн 65 зүйлийн шувуудаас дараах зүйл нь CITES-н Конвенцийн хавсралтад орсон байна. Үүнд:

- *Milvus migrans* (Сохор элээ);
- *Buteo hemilasias* (Шилийн сар);
- *Aquila nipalensis* (Steppe);
- *Gypaetus barbatus* (Ооч ёл);
- *Neophron percnopterus* (Дэлт бүргэд);
- *Accipiter nomachus* (Нохой тас);
- *Falco cherrug* (Идлэг шонхор);
- *Falco peregrinus* (Эгэл шонхор);
- *Falco subutyo* (Шууман шонхор);
- *Falco tinnunculus* (Начин шонхор);
- *Anthropoides virgo* (Өвөгт тогоруу);
- *Otus tarda* (Хонин тоодог);
- *Chlamydotis undulate* (Жороо тоодог);
- *Bubo bubo* (Шар шувуу);
- *Athene noctua* (Хотны бүгээхэй).

Жороо тоодог (*Chlamydotis undulate*) мөн хулан жороо (*Podoces hendersoni*) зэрэг шувууд нь Монголын “Улаан ном”-д бүртгэгдсэн. Хавсралт D-д Оюутолгойн лицензийн талбай болон ойр орчмын шувуудын зүйлийг хавсаргав.

Шавьж

Хээрийн судалгааны үеэр 79 зүйл ба 39, 7 овгийн 92 зүйлийн шавж бүртгэгдсэн. Эдгээр шавжуудаас 22 зүйл нь судалгаанд шинээр бүртгэгдсэн. Өмнөх жилийн судалгаанд 20 зүйлийн 12, 5 овгийн шавж бүртгэгдсэн байна. Хамгийн түгээмэл шавжийн зүйлд шулуун далавчтаны нэгэн анги болох *Bryodema gebleri*, *Mongolocum Zub.*, *Locusta Migratoria* шавж багтана.

Ерөнхийдөө, Оюутолгойд шавьжууд элсэрхэг, давсархаг хөрсөнд элбэг байдаг. Ялангуяа энэхүү талбайн хуурай амьсгал нь шавьжны амьдрах мөчлөг болон амьтдын хоол болохоос зайлсхийх зан төлөвийг төлөвшүүлэх орчинг бүрдүүлдэг. *Coleoptera* ангийн шовх хошуут цох, *Curculionidae* ангийн *Stephanocleonus potanini* (Foust), *S.helenae* (Ter-Min), *S. Gemellus approximatus* мөн *Anatolica potanini* (Reitt), *A. mucronata* (Bogol-Kat), *Blops rugosa* Gebel of *Tenebrionidae* ангийн хар цох нь энэ бүсэд элбэг тохиолдоно.

Өтгөн ургасан ургамалжилт нь хортон шавж олноор өсч үржихэд нөлөөлж байж болох юм. Олон тооны царцаа зарим зүйлийн ургамал дээрээс олдсон ба тэдгээр ургамлаар хооллож байсан. Тэнд буй олон тооны царцаа бударгана, улалж, хонин нүдэн шаралж гэх мэт ургамлаар хооллож байсан. Гэвч, энэ жил хур бороо элбэгтэй, чийглэг сайтай байсан нь тэдгээрийн тоо толгойг хязгаарлаж чадаагүй бөгөөд нь энэ нь ер бусын үзэгдэл байв. Тэдгээрээс царцааны овгийн голио (*Decacan bhina dercanbhoides*) нь энэ нутагт хамгийн элбэг нь тохиолдож байсан.

Говийн бүс нутагт аалз (*Araneada*), хилэнц (*Scorpionida*), хуурамч хилэнц (*Pseudoscorpionida*), загийн шар аалз (*Galeodes solipugida*), Урт хөлт Аалз (*Opilionida*), Хачиг (*Acarina*) – хачиг гэх мэт шавьжууд бүртгэгдсэн. Тэдгээрээс Оюутолгойд хилэнц болон загийн шар аалз зэрэг нь маш түгээмэл ба шөнийн амьдралтай шавьжууд юм. Гэвч, ихэнх аалз, хачиг, хувалзнууд тухайлбал, цагаан тэмээ (*Lycosa singoriensis*) нь өдрийн амьдралын дэглэмтэй. Хачиг нь хүн, малд маш хор хөнөөлтэй юм. Оюутолгойд *Jxodidae* хачиг өргөн тархсан байна. Тэд хүн, малын биед тодорхой хугацаанд амьдралынхаа туршид паразитлан өнгөрөөх ба паразитлан амьдарч буй хугацаандаа тэд аюултай өвчнүүд (хачиг-эсэргэнт балнад тээгч гэх мэт)-ийн бактерийг халдааж болно. Оюутолгойд нохой хачиг (*Dermacentor*) ба хатуу биет хачиг (*hyalomma*) төрлийн хачиг хувалз бүртгэгдсэн байна. Хачиг, хувалзны өнгө нь орчны амьдралыг даган өөрчлөгдөх боломжтой.

Хэвлээр явагч

Тус нутагт ховор ба олон улсын Конвенциор хамгаалагдсан мөлхөгчдийн зүйл олноогүй. Нарийн могой (*Columber spinalis*), ургамал идэшт могой (*Psammophis sp*) зэрэг могойнууд нь ерөнхийдөө ховор зүйлд тооцогдоно.

Оюутолгойн уурхайн зүгээс амьтны аймагт учрах сөрөг үр нөлөө нь ихэнхдээ уурхайг хөгжүүлэх болон уурхайн үйл ажиллагаагаатай хамааралтай саад тотгор юм. Байршил нутгийн алдагдал зөвхөн уурхайн зөвшөөрөл бүхий талбайд гарах ба үүнд уурхайн зориулалтаар ус татах ажиллагаа шууд бусаар нөлөөлнө. Голын голдирлыг өөрчлөх тохиолдолд Бор Овоогийн булаг хөрсөнд шургаж, энэ нутгийн амьтны аймагт сөргөөр нөлөөлж байна.

Хамгаалах ач холбогдол бүхий амьтны жагсаалтад орсон зүйлийн экологи, байршил нутгийн талаархи мэдээлэл хомс байна.

Оюутолгойн бүтээн байгуулалт болон уурхайн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл нь тэсэлгээ, дуу чимээ, гэрэл чийдэн болон онгоц, машин тэрэгний хөдөлгөөн зэрэг хүчин зүйлүүд байх бөгөөд магадгүй тухайн зэрлэг ан амьтныг үргээж, энэ орчимд байрших амьтдын тоог бууруулж болох талтай. Мөн тухайн орчинд ажиллаж, амьдрах хүний тоо нэмэгдсэнээр ан агнуур хийх явдал үүсэх, гэрийн тэжээвэр малын тоо нэмэгдсэнээр шууд бус нөлөөлөл учруулж болзошгүй.

Хүснэгт 63. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийн эрсдлийн зэрэглэл

Сөрөг нөлөөлөл үзүүлэх хэлбэрүүд	Үр дагавар	Магадлал	Эрсдлийн зэрэглэл
Ан хийх дарамт үүсэх	Бага	Магад болох	Бага
Уурхайн үйл ажиллагаа, дэд бүтэцтэй холбогдон байршил нутаг алдагдах	Дунд	Болзошгүй	Дунд
Чимээ шуугиан, гэрлийн нөлөөгөөр ан амьтан дайжих	Дунд	Болзошгүй	Дунд
Бор Овоогийн булаг дарагдах	Их	Магад болох	Их

Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

Оюутолгойн төслийн зүгээс амьтны аймагт учрах сөрөг нөлөөллийг уурхайг хашаажуулах болон хөрсийг сайжруулах төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх замаар хамгийн доод түвшинд байлгах аргаар үйл ажиллагаанд оруулсан. Ундайн голын голдирлыг өөрчилснөөр Бор Овоогийн булаг уствал уурхайн орчимд гадаргуугийн усны томоохон эх үүсвэр алдагдана. Уурхайн доод хэсгийн булаг шандуудыг хамгаалах хамгаалалтын талаар гадаргуугийн усны менежментийн төлөвлөгөөнд санал болгосон байгаа. Зэрлэг ан амьтад голын голдирлыг өөрчилсний дараа гадаргуугийн усаар хангагдах боломжийн талаархи судалгааны дүн нарийвчилсан төлөвлөлтөөр бэлэн болно.

Оюутолгойд байрлаж буй ажиллах хүчин орон нутагт ан хийхийг хориглож, галт зэвсэг болон бусад зэвсэг хэрэгсэл байхыг зөвшөөрөхгүй. Цаашид том хөхтөн амьтдын нүүдлийн популяци, тэдгээрийн ус, бэлчээр ашиглалтыг мэдэхийн тулд бүс нутгийн хэмжээнд зэрлэг ан амьтдын мониторинг судалгааг хийх шаардлагатай. Бүс нутгийн онцлог ач холбогдол бүхий зүйлүүдийн суурь судалгаа болон мониторинг хийх хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай. Шувууны төрөл зүйл, ялангуяа нүүдлийн шувуудад үзүүлэх ач холбогдлыг тодруулахын тулд байнгын болон түр зуурын гадаргуугийн усны нөөцийн судалгаа хийх, ижил төстэй хөтөлбөрийг боловсруулах нь зүйтэй.

Хавтгай, хулан, аргаль, янгир, ирвэс, хойлог зэрэг дархан цаазтай амьтдаас гадна шилүүс, үнэг, чоно, мануул, хярс, зараа зэрэг махчин амьтад, хар сүүлт, туулай гэх мэт хөхтөн туурайтан, ёл, тас, бүргэд, ятуу, ногтруу зэрэг 20 гаруй төрлийн жигүүртэн шувууд, төрөл бүрийн мэрэгчин амьтад, замба, могой, хонин гүрвэлүүд, сам хорхой, сарваалж, дэвхэргэ, голио, царцаа болон төрөл бүрийн аалз, жижиг шавьж хорхойнууд элбэг байдаг.

Зураг 48. Ховор ан амьтан



Ирвэс



Хойлог




Хавтгай



Аргаль

Зураг 49. Амьтны тархалтын зураг



3.3. АЖ АХУЙН ТӨРӨЛЖИЛТИЙН СУДАЛГАА

Худалдаа, үйлчилгээ, барилга, орон сууц, уул уурхай, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд дийлэнх хувийг эзэлж байна.

Орон нутагт ерөнхийдөө үйлдвэрлэл бага хөгжсөн ба үйлчилгээний чиглэлийн үйл ажиллагаа нийтлэг байгаа нь цаашид байгалийн тодорхой нөөцийг ашиглан үйлдвэрлэл эрхлэх зах зээл байгааг харуулж байна.

Суманд хоршоо 10, орон нутгийн өмчит аж ахуй нэгж 3, хязгаарлагдмал хариуцлагатай компани 150, төрийн бус байгууллага 5, нөхөрлөл 4, төсөвт байгууллага 14, жишиг татвар төлөгч 70, патент төлөгч 4 дараах үйл ажиллагааг явуулж байна. Дэлгүүр 25, талх нарын боовны цех 2, хэрчсэн гурилын цех 3, эсгийний цех 2, авто машин засварын 3 цэг, авто угаалгын 5 цэг, хувийн мал эмнэлэг 3, мужаан цех 1, гутал засвар 2, үсчин гоо сайхны 3 цэг, хивс угаалгын 1 цэг, 10 ортой буудал 12, цайны газар 7, жуулчны бааз 1, блокны цех 3, интернет үйлчилгээний төв 1, орон нутгийн телевиз ажиллаж байна.



IV. СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Иргэд, аж ахуйн нэгж нь газрыг хууль эрх зүйн дагуу албан болон албан бус хэлбэрээр ашиглаж, эзэмшдэг. Газар ашиглалтын олон хэлбэр үүсч байгаа цаг үед иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу, эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан үзэж эзэмшүүлж, ашиглуулах нь сумын хөгжил болон иргэдийн амьдрал ахуйд чухал юм.

Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд нутгийн иргэдийн оролцоо хамгаас чухал. Төлөвлөгөөнд орон нутгийн иргэд оролцож, тэдний санал тусгагдаж байж хэрэгжих боломж хангагдана. Мөн иргэдийн санал бодлыг нутаг дэвсгэрийн төлөвлөлтөнд тусгуулах, ашиглалтын олон хэлбэр бүхий газрын хэрэгцээг тодорхойлох нь сумын тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой. Иймээс төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангах үүднээс дараах аргуудыг ашиглав. Үүнд: нүүр тулсан уулзалт, уулзалт ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, асуулгын судалгаа, зорилтот бүлгийн саналаар хийгдсэн зураглал, хэмжилт г.м

Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд малчин, тариалан эрхлэгчдийн 90.0 хувь, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 30.0 хувь, сумын засаг даргын тамгын газрын ажилтнуудын 72.0 хувийг судалгаанд хамруулж санал авч хэлэлцүүлэг зохион байгууллаа. Үүнд:

- Ханбогд сумын төвийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа иргэдээс эхлэн хөдөөгийн малчдыг хамруулж саналын хуудсаар санал авсан.
- Сумын Засаг даргын тамгын газрын удирдлага, мэргэжилтнүүдээс уулзалт ярилцлагын аргаар санал авсан.

Сумын удирдлага, багийн засаг дарга нар, нийгмийн ажилтнууд зэрэг ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүдтэй уулзан хэлэлцүүлэг зохион байгуулж тэдгээрийн санал болон сум орондоо мөрдөж ажиллаж байгаа хөтөлбөр, хөгжлийн баримт бичигт үндэслэн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулав.

Дөрвөн багийн Иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулж төлөвлөгөөний загвар төслийг танилцуулж, тэдний саналыг авч тусган сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг сайжруулан боловсруулж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд уг хурлаас гарсан саналыг төлөвлөгөөнд тусгасан.

Ханбогд сумын нийгэм-эдийн засгийн байдалд SWOT шинжилгээ хийж газар, байгалийн нөөц эдэлбэрийг хэрхэн үр ашигтай ашиглах, үүгээр дамжуулж нийгэм, эдийн засгийн хөгжлийг оновчтой сайжруулах арга хэмжээг төлөвлөв.

Ханбогд сумын ерөнхий SWOT шинжилгээ

Хүснэгт 64. Сумын SWOT шинжилгээ

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
<ul style="list-style-type: none"> - Олон улсын жуулчдын хувьд аялахад хамгийн тохиромжтой, сонирхолтой, байгаль орчин, соёл нь унаган төрхөөрөө гэж хүлээн зөвшөөрөгдсөн Монгол дах цорын ганц нь Говь юм. - Монголын аялал жуулчлалын бусад газрууд одоогоор олон улсын аялал жуулчлалын зах зээлд хараахан танигдаж, нийтээр зөвшөөрөгдөөгүй байна. - Монголын хөдөө орон нутагт уул уурхайн үйлдвэрлэлийг дагасан тодорхой өөрчлөлт, шинэ сорилт, бэрхшээлүүд тулгарч байгаа ч, уул уурхайн үйл ажиллагаа, түүнтэй холбоотой шилжин суурьшилт нь эерэг өөрчлөлтүүдийг авчирч байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дурьдсан зарим эерэг өөрчлөлт, үр нөлөөг дурьдвал: - Гаднаас хүмүүс шилжин ирснээр хүүхдийн хөгжилд тустай буюу хотын хүүхдүүд хөдөөгийн хүүхдүүдэд шинэ мэдлэг мэдээллийг зааж өгч байна. - Хөдөө мал малладаг хүмүүс уул уурхайд ажилд орсноор хүүхдүүд нь цэцэрлэгт хамрагдах боломж нэмэгдэж байна. 	<ul style="list-style-type: none"> - Аймгийн төвөөс сум хүртэл засмал зам тавигдаагүй - Газар, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглаж, хамгаалах мэдлэг боловсрол муу - Уул уурхайн олборлолт их явагдаж байгаагаас байгалийн тэнцвэрт байдал алдагдаж, усан хангамж багасаж бэлчээрийн даац, ачаалал муудсан. - Гар аргаар байгалийн нөөц баялгийг олборлосноос ухагдаж эвдэрсэн газар ихээр бий болж байгаа бөгөөд үүнийг технологийн дагуу нөхөн сэргээдэггүй. - Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төсөв санхүү хүндрэлтэй - Сум орон нутгийн удирдлагууд улс төржилт ихтэй учраас нийтийг хамарсан зөв шийдвэр гаргаж орон нутгийг хөгжүүлэх боломж муу.
Боломж	Саад бэрхшээл

<ul style="list-style-type: none">- Компаниуд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнийхөө талаар жил бүр тайлагнаж, уг төлөвлөгөөг хэрхэн сайжруулах талаар саналаа ирүүлэх ёстой.- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тухайд бол засгийн газар уурхайн хаалтын үйл ажиллагаанд нэмэлт шаардлага тавих талаар зарцуулдаг болсон.- Төсөл хөтөлбөрт хамрагдах боломжтой	<ul style="list-style-type: none">- Байгалийн эрс тэс уур амьсгалтай- Ган, зуд ихтэй- Бэлчээрийн хүрэлцээ муу- Ашиглалтын болон хайгуулын лицензийг олноор олгосон- Чонын тоо толгой ихсэж байгаа- Уул уурхайг дагаж хөдөлгөөнт хүн ам ихэссэнээр гэмт хэрэг ихээр гардаг- Шороон замын ойр орчимд байгаа хөрс, ургамлын бохирдол ихсэж хүн малын эрүүл мэндэд муугаар нөлөөлж байгаа.
--	--

Дээрх SWOT шинжилгээний үр дүнг үндэслэн нэн тэргүүнд дараах авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг төлөвлөв.

Нүүрс тээвэрлэлтээс үүдсэн шороон замуудаас тоосжилт бий болж байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсч байгаа хэдий ч гол замын хучилт хийснээр тухайн орчинд тоос босохгүй болсон. Гэвч сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд автомашины олон зам гарсан. Үүнийг зохицуулах арга хэмжээ аваагүй байна. Энэ нь бэлчээрийн талбай багасах бас нэг шалтгаан болж байна. Хайрган болон хатуу хучилттай замууд бэлчээр, амьтны нүүдлийн коридорыг хуваан мал амьтны хөдөлгөөнд саад учруулдагаас тэмээ болон бусад зэрлэг амьтад ихэнхдээ шөнө зам гардаг байна.

4.2. БЭЛЧЭЭРИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

Бэлчээрийн газар ашиглалт нь сумын үндсэн газар ашиглалт бөгөөд цаашид бэлчээрийг өнө удаан хугацаанд тогтвортой ашиглахын тулд улирлын сэлгээг сайн хийх, бэлчээрийн даац багтаамжид тааруулж малаа өсгөх, хамгаалах, тордох, эзэнтэй болгох, нөхөн сэргээдэг байх хэрэгтэй. Иймд бид энэхүү сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд бэлчээр ашиглалтын хэсэг гэсэн бэлчээр ашиглалтын хэлбэрийг тогтоож төлөвлөгөөнд тусгалаа. Энэхүү бэлчээр ашиглалтын хэсгийг малчдын саналыг үндэслэн тогтоосон ба багийн Иргэдийн нийтийн хурал болон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар тус тус хэлэлцүүлсэн. Бэлчээрийг оновчтой төлөвлөхийн тулд бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг 4 улирал, 5 хошуу малын төрлөөр шаардлагатай үзүүлэлтүүдийг харгалзан тодорхойлов.


4.2.1. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 тоот тушаалаар батлагдсан “Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээний арга зүйн дагуу Ханбогд сумын бэлчээрийн газрын тохиромжтой газрын үнэлгээг тодорхой шалгуур үзүүлэлтүүдээр хийж, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний чиг хандлагыг тодорхойлов.

Диаграм 12. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд




Зураг 50. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг



Хүснэгт 65. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн талбай

№	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	139034.51	9.3
2	Тохиромжгүй	24715.76	1.7
3	Дун зэрэг тохиромжтой	42656.48	2.9
4	Тохиромжтой	645370.03	43.1
5	Нэн тохиромжтой	644341.52	43.1
Нийт		1496118.3	100.0


Зураг 51. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд адуунд тохирох бэлчээр



Хүснэгт 66. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд адуунд тохирох бэлчээрийн талбай

№	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	139031.09	9.29
2	Тохиромжгүй	109192.26	7.30
3	Дунд зэрэг тохиромжтой	902471.55	60.32
4	Тохиромжтой	344965.45	23.06
5	Нэн тохиромжтой	447.47	0.03
Нийт		1496107.82	100.00


Зураг 52. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд үхэрт тохирох бэлчээр



Хүснэгт 67. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд үхэрт тохирох бэлчээрийн талбай

№	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	138875.68	9.28
2	Тохиромжгүй	621695.04	41.55
3	Дунд зэрэг тохиромжтой	716838.98	47.91
4	Тохиромжтой	18852	1.26
Нийт талбай		1496262	100


Зураг 53. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд хонинд тохирох бэлчээр



Хүснэгт 68. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд хонинд тохирох бэлчээрийн талбай

№	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	139048.51	9.3
2	Тохиромжгүй	114126.61	7.6
3	Дунд зэрэг тохиромжтой	697368.67	46.6
4	Тохиромжтой	340120.7	22.7
5	Нэн тохиромжтой	205451	13.7
Нийт талбай		1496262.8	100.0


Зураг 54. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг



Хүснэгт 69. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр зун-намрын улиралд ямаанд тохирох бэлчээрийн талбай

№	Үнэлгээ	Талбай /га /	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	138890.19	9.3
2	Тохиромжгүй	114091.87	7.6
3	Дунд зэргийн тохиромжтой	655829.48	43.8
4	Тохиромжтой	385148.98	25.7
5	Нэн тохиромжтой	202302.28	13.5
Нийт		1496262.8	100.0


Зураг 55. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд тэмээнд тохирох бэлчээр



Хүснэгт 70. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн талбай

№	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	139034.51	9.3
2	Тохиромжгүй	24715.76	1.7
3	Дун зэрэг тохиромжтой	42656.48	2.9
4	Тохиромжтой	645370.03	43.1
5	Нэн тохиромжтой	644341.52	43.1
	Нийт	1496118	100.1


Зураг 56. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд адуунд тохирох бэлчээр



Хүснэгт 71. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд адуунд тохирох бэлчээрийн талбай

№	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	139043.08	9.3
2	Тохиромжгүй	289926.59	19.4
3	Дунд зэрэг тохиромжтой	810401.75	54.2
4	Тохиромжтой	256735.64	17.2
Нийт		1496107.06	100.0


Зураг 57. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг



Хүснэгт 72. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд үхэрт тохирох бэлчээрийн талбай

№	Үнэлгээ	Талбай /га/	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	138875.7	9.28
2	Тохиромжгүй	621695	41.55
3	Дунд зэргийн тохиромжтой	716839	47.91
4	Тохиромжтой	18852	1.26
Нийт		1496262	100


Зураг 58. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд хонинд тохирох бэлчээр



Хүснэгт 73. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд хонинд тохирох бэлчээрийн талбай

№	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	139056.29	9.3
2	Тохиромжгүй	154715.71	10.3
3	Дунд зэрэг тохиромжтой	829082.63	55.4
4	Тохиромжтой	367529.9	24.6
5	Нэн тохиромжтой	5732.44	0.4
Нийт		1496116.97	100.0

Зураг 59. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд ямаанд тохирох бэлчээр



Хүснэгт 74. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээр өвөл-хаврын улиралд ямаанд тохирох бэлчээрийн талбай


№	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	139056.29	9.3
2	Тохиромжгүй	154715.71	10.3
3	Дунд зэрэг тохиромжтой	829082.63	55.4
4	Тохиромжтой	367529.9	24.6
5	Нэн тохиромжтой	5732.44	0.4
Нийт		1496116.97	100.0

4.2.2. Сумын бэлчээрийн газрын экологийн чадавхи

Өмнөговь аймгийн Ханбогд сумын бэлчээрийн чадавхийн зургийг зураглахдаа 2015 оны 8 дугаар сарын 3-наас 9 дүгээр сарын 13-ны өдрийн “Ландсат 8” хиймэл дагуулын 5 сценэ мэдээгашигласан болно. Хиймэл дагуулын мэдээнд Erdas Imagine, ENVI програм хангамжийг ашиглан боловсруулалт хийв. Бэлчээрийн чадавхийн байдлаар ангилан зураглахдаа ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/104 тушаалын хавсралтаар батлагдсан

“Бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварыг ашиглах зөвлөмж”-ийн дагуу монгол орны байгалийн бүс, бүслүүр бүрээр ангилсан 25 төрлийн бэлчээрийн ангиллыг ашиглаж, ArcGIS программ хангамжаар зурагласан.

Зураг 60. Бэлчээрийн чадавхийн зураг



Өмнөговь аймгийн Ханбогд сум нь Монгол орны байгалийн бүс бүслүүрийн цөлийн бүсэд оршдог бөгөөд ургамлын хэв шинж, газрын гадаргын байдал, хөрсний төлөв байдлаараа бэлчээрийн 7 төрөлд хуваагдаж байна. Бэлчээрийн чадавхийн зургаас харахад хамгийн их талбайг хайрган хучаас бүхий шавранцар хөрстэй тэгш тал, хөндийн баглуурт бэлчээр, хамгийн бага талбайг хужирлаг хотос газрын бударгана-хармаг-дэрст тойрмын бэлчээр эзэлж байна. Нутгийн хойд хагаст элсэнцэр хөрстэй сөөгт бэлчээр, зузаан элсэн хөрстэй хармагт болон цөл, загт бэлчээр зонхилсон олон хэв шинжтэй бэлчээртэй, элсэн манхан, толгод оршиж байгаа бол нутгийн урд хагаст хайрган хучаас бүхий шавранцар хөрстэй тэгш тал, хөндийн баглуурт бэлчээр дангаараа зонхилж, хад асгатай уул, хаднууд их хэмжээтэй тархсан байна.

Гавилууд, Баян, Жавхлант багуудын бэлчээрийн дийлэнх хэсгийг баглуурт бэлчээр эзэлж, Номгон багийн хувьд бударгана дэрст, холимог сөөгт, шар бударгана дэрст бэлчээр, болон баглуурт бэлчээр тархсан байна. Жавхлант, Номгон багийн хувьд хамгийн их талбайг эзэлж буй хайрган хучаас бүхий шавранцар хөрстэй тэгш тал, хөндийн баглуурт бэлчээр нь 85-90 хувийг эзэлж байгаа бол Баян багийн хувьд 59.8 хувийг эзэлж байна. Ханбогд сумын



бэлчээрийн газрын дийлэнх талбайг буюу 53.37 хувийг хайрган хучаас бүхий шавранцар хөрстэй тэгш тал, хөндийн баглуурт бэлчээр эзэлж, хамгийн бага талбайг буюу 0.03 хувийг хужирлаг хотос газрын бударгана-хармаг-дэрст тойрмын бэлчээр тус тус эзэлж байна.

Хүснэгт 75. Бэлчээрийн газрын талбайн хэмжээ /багуудаар/

Ангилал	Номгон баг		Гавилууд баг		Жавхлант баг		Баян баг	
	Талбай /га/	Эзлэх хувь	Талбай /га/	Эзлэх хувь	Талбай /га/	Эзлэх хувь	Талбай /га/	Эзлэх хувь
Говийн бор хөрстэй Монгол өвст бэлчээр		0.0	64928.4	32.7	16306.19	3.1	219.43	0.1
Говийн бор хөрстэй сөөгт бэлчээр	3131.92	0.6	105595	53.3	21242.76	4.0	45491.8	16.0
Элс		0.0	5650.94	2.8		0.0	55391.3	19.5
Мараатай хотгор хотос	9314.86	1.9		0.0	11746.22	2.2	5685.48	2.0
Говийн чулуурхаг бор хөрстэй баглуурт, бударганаг уул толгод	38305.3	7.9		0.0	93786.91	17.6	12933.6	4.6
Цөлийн чулуурхаг цайвар бор хөрстэй шар модот, тэсэгт уул толгод	63272.43	13.1		0.0		0.0		0.0
Цөлийн элсэнцэр цайвар бор хөрстэй заган ой	30711.58	6.4	6557.78	3.3	41765.47	7.8	68979.5	24.3
Цөлийн бор хөрстэй (баглуурт) бэлчээр	337761.9	70	15558.3	7.8	349197.9	65.4	94824.6	33.4
Нийт	482497.99	100.0	198291	100	534045.4	100.0	283526	100.0

4.2.3. Бэлчээрийн газрын эдийн засгийн үнэлгээ тооцох арга зүй

Бэлчээрийн газрын суурь үнэлгээг тооцохын тулд дараах 3 байдлаар үнэлж тооцлоо.
Үүнд

1. Хөрсний чанарын үнэлгээ /Хчү/
2. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ /БГбчү/
3. МАА үйлдвэрлэлийн бизнес тооцооллын аргаар үнэлсэн үнэлгээ /Окү/

Дээрх 3 үнэлгээгээр бэлчээрийн газрын суурь үнэлгээ/Гсү/ гарах юм.

$$\text{Гсү} = \text{Хчү} + \text{БГбчү} + \text{МААб}$$

Нэг. Хөрсний чанарын үнэлгээ

4.2.3.1 Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ бэлчээрийн багтаамжийг тооцох

Хүснэгт 76. Бэлчээрийн чадавхи

Бэлчээрийн нийт талбай /га/	1 га бэлчээрийн малд идэгдэх жилийн дундаж ургац /цн/	Тэжээлийн нөөц /цн/	Жилд идэх өвс /цн/	Бэлчээрийн чадавхи /хонин толгой/
1461591	0.85	1242352.3	4.2	295798.2

Хүснэгт 77. Бэлчээрийн даац

Нийт малын тоо	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Малын тоо / хонин толгойд шилжүүлснээр/	Жилд шаардагдах тэжээлийн нөөц мян/цн/	Даац ашиглалт /-+/
151446	8290	4368	25644	41916	71228	333114	1301497.758	5.3

Ханбогд сумын малын тоог 2016 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр авсан ба Монгол улсын газрын төлбөрийн тухай хуулийн 6.2-д зааснаар малын тоог хонин толгойд шилжүүлэхдээ тэмээ 5, адуу 6, үхэр 6, хонь 1, ямаа 0.9 гэсэн итгэлцүүр, говийн бүсэнд нэг хонины жилд идэх өвсний хэмжээ 470кг /МААЭШХ. 1983 он/-аар тус тус тооцох норматив баримтладаг. Тус сум нь нийт 1461591 га бэлчээрийн эдэлбэр газартай.

Бэлчээрийн даацыг сумын хэмжээнд авч үзэхэд 531.9 хувь байгаа нь бэлчээрийн даац хэтэрсэн, малын тоог цаашид тодорхой хэмжээгээр бууруулах эсвэл алслагдсан бэлчээрийг эргэлтэнд оруулбал бэлчээрийн даац багасах бөгөөд тэжээлийн нөөц хуримтлуулах боломжтой болно. Мөн зарим бэлчээрийн талбайд шинээр худаг ус гаргаж даацыг тэнцвэржүүлэх бүрэн боломжтой.

Хүснэгт 78. Бэлчээрийн газрын жилийн нийт ургац (в)-ыг дараах хүснэгтээр тооцно.

Багийн нэр	Бэлчээрийн талбай /га/	1 га-гийн ургац /цн/	Нийт ургац /цн/	Чадавхи /хонин толгой/
Номгон	482888.2	0.82	395968.3	94278.17
Гавилууд	198989.8	0.91	181080.7	43114.45
Жавхлант	531472.7	0.88	467696	111356.2
Баян	248239.9	0.82	203556.7	48465.88
Нийт	1461591	0.85	1248302	295798.2

Хүснэгт 79. Малын бэлчээрээс өдөрт идэх өвсний хэмжээ улирал тус бүрээр

Малын төрөл	Улирал ба өвсний хэмжээ /кг/			
	Зун	Намар	Өвөл	Хавар
Адуу	7.8	8.1	6.5	5.8
Тэмээ	14.1	13	8.4	9.9
Үхэр	8.7	9.7	7.4	7.4
Хонь	1.9	1.6	1.1	1.1
Ямаа	1.3	1.4	1	1

Бэлчээрийн газрын нийт ургацыг мал жилийн 4 улиралд идэх бөгөөд ургац зун ногоон, намар хагдарч эхлэх, өвөл, хавар хагд байдлаар мал идэгддэг билээ. Тиймээс нэг хонин толгойн жилд идэх ургацыг дараах байдлаар тооцно.

$$a1 = \frac{H \cdot NM_z}{100}, \quad a2 = \frac{H \cdot NM_n}{100}, \quad a3 = \frac{H \cdot NM_{\text{өх}}}{100},$$

$a1$ - нэг хонин толгойд идэгдэх ургац /Зун/

$a2$ - нэг хонин толгойд идэгдэх ургац /Намар/

$a3$ - нэг хонин толгойд идэгдэх ургац /Өвөл, хавар/

H - ногоон масстай байх хоногөөн тоо

NM - нэг өдөр идэх ургац

$$a1 = \frac{90 \cdot 1.9}{100} = 1.71 \text{ тн}, \quad a2 = \frac{45 \cdot 1.6}{100} = 0.504 \text{ тн}, \quad a3 = \frac{230 \cdot 1.1}{100} = 1.265 \text{ тн},$$

$$x1 = \frac{v \cdot a1^2}{a1^2 + a1 \cdot a3 + a1 \cdot a2} = \frac{817700.56 \cdot 2.9241}{2.9241 + 2.16315 + 0.86184} = \frac{2391038.21}{5.94909} = 401916.63$$

$$x2 = \frac{v \cdot a1 \cdot a2}{a1^2 + a1 \cdot a3 + a1 \cdot a2} = \frac{817700.56 \cdot 0.86184}{2.9241 + 2.16315 + 0.86184} = \frac{704727.05}{5.94909} = 118459.63$$

$$x3 = \frac{v \cdot a1 \cdot a3}{a1^2 + a1 \cdot a3 + a1 \cdot a2} = \frac{817700.56 \cdot 2.16315}{2.9241 + 2.16315 + 0.86184} = \frac{1768808.9}{5.94909} = 297324.29$$

Нийт ургацын хэмжээг дараах томъёогоор тооцож гаргав.

$$x1 + x2 + x3 = 401916.63 + 118459.63 + 297324.29 = 1022125.73 \text{ цн.}$$

Эндээс малд идэгдэх бодит ургац 20 хувиар багасгаж тооцоход 817700.56 цн байна.

Малд идэгдэх бодит ургацыг нэг хонин толгойн жилд идэх ургацтай харьцуулж үзэхэд тус сумын хэмжээнд нийт 23,503 хонин толгой бэлчээрлэх боломжтой байна.

4.2.3.2. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох /Хонин сүрэг/.

Хонины махны ашиг шимийг бий болгох боломжийг дараах томъёогоор бодож гаргана.

$$M_T = \frac{\left[\frac{A_{ЖТ}}{100} + (A_{ЖД} - A_{ЖТ}) \right] НГТ}{100}$$

M_T - Тухайн насны малын махны жилийн өсөлт буюу үйлдвэрлэгдэж буй махны хэмжээ

$A_{ЖД}$ - Дараах насны малын амьдын жин

$A_{ЖТ}$ - Тухайн насны малын амьдын жин

$НГ$ - Тооцож буй малын нядалгааны гарц

Хүснэгт 80. Нядалгааны гарц тооцох хүснэгт

№	Малын төрөл	Нядалгааны гарц, хувиар
1	Үхэр	55-65
2	Хонь, ямаа	44-48
3	Адуу	47-54
4	Тэмээ	55-65

Хүснэгт 81. Монгол хонины махны гарц

Насны ялгаа	Амьдын жин /кг/	Гулуузын жин /кг/	Гарц /хувь/
12 сартай	28.9	10.16	42.5
1.5 настай	43.78	21.07	48.13
2.5 настай	51.0	26.89	52.73
3.5 настай	58.27	32.22	55.28
4.5 настай	60.46	33.46	55.34
5.5 настай	70.95	38.75	54.61

Хүснэгт 82. Хонин сүргийн зохистой харьцаа

№	Нас	Сүрэгт эзлэх хувь	Бүгд
1	1.5	25.0	10479
2	2.5	15.0	6287
3	3.5	13.0	5449
4	Хээлтүүлэгч	2.0	838
5	Хээлтэгч	45.0	18862
Бүгд		100.0	41916

Хүснэгт 83. Хонины махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцож гаргавал дараах байдалтай байна.

Нас, хүйс	Амьдын жин	Зун-намрын улиралд нэмэгдэх жин /нэг хонин толгойд/				Малын тоо	Нийт нэмэгдэх мах /кг/
		Өвөл-хавар алдсан жин /кг/	Нас дэвших хүртлэх нэмэгдэх жин /кг/	Бүгд нэмэгдэх /кг/	Бүгд нэмэгдэл нядалгааны гарцаар /кг/		
1.5	43.8	13.1	7.2	20.3	9.7	10479	101646.3
2.5	51.0	15.3	7.3	22.6	10.8	6287	67903.9
3.5	58.3	17.5	2.2	19.7	9.5	5449	51766.2
Хээлтүүлэгч	57.0	17.1	14.0	31.1	14.9	838	12490.9
Хээлтэгч	47.0	14.1	13.5	27.6	13.2	18862	248981.04
Бүгд						41916	482788.5

Дээрх хүснэгтээр тооцсон хонины махыг хонин толгойд шилжүүлвэл дараах томъёогоор тооцно.

$$T_x = \frac{AШмах + (AШмах * НГх)}{AЖэ/х}$$

T_x - хонины тоо,

$AШмах$ - махан ашиг,

$НГх$ - нядалгааны гарцыг өсгөх хэмжээ ($\frac{46}{100} = 0.46$),

$AЖэ/х$ - хонины амьдын жин /дундажаар/

$$T_x = \frac{270695.9 + (270695.9 * 0.46)}{70.95} = 5570.3$$

Тухайн бэлчээрээс бий болсон махны нийт хэмжээг амьдын жинд шилжүүлж хонин толгойгоор гаргасан ба эр хонины амьдын жингийн дээд хэмжээ буюу 70.95 кг-аар тооцож гаргахад 5570.3 хонин толгой болж байна.

Хүснэгт 84. Хонины сүү бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцов.

Хүйс	Тоо, толгой	Нэгжээс авах сүү /л/	Бүгд /л/
Эм хонь	18946	30.0	568380

Хүснэгт 85. Хонины ноос бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцов.

№	Нас	Тоо, толгой	Нэгжээс авах ноос /кг/	Бүгд /кг/
1	1.5	10479	1.0	10479
2	2.5	6287	1.2	7544.4
3	3.5	5449	1.3	7083.7



4	Хээлтүүлэгч	838	1.7	1424.6
5	Хээлтэгч	18862	1.5	28293
Бүгд		41916		54824.7

Арьс нэхий, дайвар бүтээгдэхүүн /толгой, цувдай, өлөн/ бий болгох чадавхи нь нийт хонин сүргийн тоотой тэнцүү 5570.3 байна.

Хүснэгт 86. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг дараах хүснэгтээр тооцов.

Мах			Сүү			Ноос			Арьс			Дайвар бүтээгдэхүүн			Бүгд дүн /мян.төг /
Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /л/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	
482788.50	6422.0	3100467747.00	4568380	1200.0	682056000.00	54824.70	500.0	27412350.00	9934.70	800	7,947760.00	9934.70	2500.00	24836750.00	38178863.5

Ханбогд сумын 1 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг хонин сүргээр тооцож гаргахад 1513.29 төгрөг болж байна.

4.2.3.3. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох /Ямаан сүрэг/.

Бэлчээрийн газрын нийт ургацыг мал жилийн 4 улиралд идэх бөгөөд ургац зун ногоон, намар хагдарч эхлэх, өвөл, хавар хагд байдлаар мал идэгддэг билээ. Тиймээс нэг ямааны жилд идэх ургацыг дараах байдлаар тооцно.

$$a1 = \frac{H \cdot H_{M3}}{100}, \quad a2 = \frac{H \cdot H_{Mн}}{100}, \quad a3 = \frac{H \cdot H_{Mөх}}{100},$$

$$1 = \frac{90 \cdot 1.3}{100} = 1.17 \text{ тн}, \quad a2 = \frac{45 \cdot 1.4}{100} = 0.63 \text{ тн}, \quad a3 = \frac{230 \cdot 1}{100} = 1.15 \text{ тн},$$

$$x1 = \frac{v \cdot a1^2}{a1^2 + a1 \cdot a3 + a1 \cdot a2} = \frac{817700.56 \cdot 1.3689}{1.3689 + 1.3455 + 0.7371} = \frac{1119350.29}{3.4515} = 324308.35$$

$$x2 = \frac{v \cdot a1 \cdot a2}{a1^2 + a1 \cdot a3 + a1 \cdot a2} = \frac{817700.56 \cdot 0.7371}{1.3689 + 1.3455 + 0.7371} = \frac{602727.08}{3.4515} = 174627.58$$

$$x3 = \frac{v \cdot a1 \cdot a3}{a1^2 + a1 \cdot a3 + a1 \cdot a2} = \frac{817700.56 \cdot 1.3455}{1.3689 + 1.3455 + 0.7371} = \frac{1100216.10}{3.4515} = 318764.62$$



Нийт ургацын хэмжээ: $x_1+x_2+x_3 = 1,022,125.73$ цн. Эндээс малд идэгдэх бодит ургац 817700.56 цн

Малд идэгдэх бодит ургацыг нэг ямаанд жилд идэх ургацад харьцуулж үзэхэд тус сумын хэмжээнд нийт 27718 толгой ямаа болж байна.

Ямааны махны ашиг шимийг бий болгох боломжийг дараах томъёогоор бодож гаргана.

$$M_T = \frac{\left[\frac{AJ_T}{100} + (AJ_D - AJ_T) \right] НГТ}{100}$$

M_T - Тухайн насны малын махны жилийн өсөлт буюу үйлдвэрлэгдэж буй махны хэмжээ

AJ_D - Дараах насны малын амьдын жин

AJ_T - Тухайн насны малын амьдын жин

$НГ$ - Тооцож буй малын нядалгааны гарц

Хүснэгт 87. Нядалгааны гарц тооцох хүснэгт

№	Малын төрөл	Нядалгааны гарц, хувиар
1	Үхэр	55-65
2	Хонь, ямаа	44-48
3	Адуу	47-54
4	Тэмээ	55-65

Хүснэгт 88. Монгол ямааны махны гарц

Насны ялгаа	Амьдын жин /кг/	Гулуузын жин /кг/	Гарц /хувь/	Тухайн насны малын махны жилийн өсөлт
12 сартай	25.48	12.13	47.60	1.7
1.5 настай	28.89	13.37	49.58	2.5
2.5 настай	29.28	15.98	49.45	6.5
3.5 настай	34.00	19.13	49.09	7.5
4.5 настай	48.85	21.97	50.39	11.4
5.5 настай	70.95	38.75	54.61	



Хүснэгт 89. Ямаан сүргийн зохистой харьцаа

№	Нас	Сүрэгт эзлэх хувь	Бүгд
1	1.5	27.0	19232
2	2.5	10.0	6767
3	3.5	28.0	19943
4	Хээлтүүлэгч	0.5	356
5	Хээлтэгч	35.0	24930
Бүгд		100.0	71228

Хүснэгт 90. Ямааны махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцож гаргавал дараах байдалтай байна.

Нас	Амьдын жин	Гулуузны жин	Нядлагын		Малын нэмэгдэх махны хэмжээ /кг/	Малын тоо	Нийт нэмэгдэх махны хэмжээ /кг/
			жин	хувь			
1.5	36.93	15.98	18.29	47.60	1.7	19232	32694.4
2.5	42.85	19.13	21.07	49.58	2.5	6767	16917.5
3.5	48.85	21.97	24.65	49.45	7.5	19943	149572.5
Хээлтүүлэгч	52.2	24.70	26.85	49.09	11.4	356	4058.4
Хээлтэгч	37.93	14.10	15.98	50.39	6.5	24930	162045
Бүгд						71228	365287.8

Дээрх хүснэгтээр тооцсон махыг ямаан толгойд шилжүүлвэл дараах томъёогоор тооцно.

$$T_x = \frac{AШмах + (AШмах * НГх)}{АЖэ/х}$$

T_x - ямааны тоо,

$AШмах$ - махан ашиг,

$НГх$ - нядалгааны гарцыг өсгөх хэмжээ ($\frac{46}{100} = 0.46$),

$АЖэ/х$ - ямааны амьдын жин /дундажаар/

$$T_x = \frac{141597.2 + (141597.2 * 0.46)}{52.2} = 3960.4$$

Тухайн бэлчээрээс бий болсон махны нийт хэмжээг амьдын жинд шилжүүлж ямаагаар гаргасан ба эр ямааны амьдын жингийн дээд хэмжээ буюу 52.2 кг-аар тооцож гаргахад 3960 толгой ямаа болж байна.

Хүснэгт 91. Ямааны сүү бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцно.

Хүйс	Тоо, толгой	Нэгжээс авах сүү /л/	Бүгд /л/
Эм ямаа	32266	25.0	806650

Хүснэгт 92. Ямааны ноолуур бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцно.

№	Нас	Тоо, толгой	Нэгжээс авах ноолуур /кг/	Бүгд /кг/
1	1.5	19232	0.19	3,654.08
2	2.5	6767	0.21	1,421.07
3	3.5	19943	0.30	5,982.90
4	Хээлтүүлэгч	356	0.35	124.60
5	Хээлтэгч	24930	0.22	5,484.60
Бүгд		71228		16,667.25

Арьс нэхий, дайвар бүтээгдэхүүн /толгой, цувдай, өлөн/ бий болгох чадавхи нь дээрх хүснэгтэнд тооцсон нийт ямаан сүргийн тоотой тэнцүү 3960 байна.

Хүснэгт 93. Бэлчээрийн газрын газрын бүтээгч чадавхийг дараах хүснэгтээр тооцов.

Мах			Сүү			Ноолуур			Арьс			Дайвар бүтээгдэхүүн			Бүгд дүн /төг/
Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /л/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	
365287.8	4,968.70	1,815,006,485.60	806,650.00	500.00	403,325,000.00	16,667.25	55000	916,698,750.00	10217	8000	81,736,000.00	10,217.00	1,500.00	15,325,500.00	3,216,767.7

Ханбогд сумын 1 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг ямаан сүргээр тооцож гаргахад 855.7 төгрөг болж байна.

4.2.3.4. Тэмээн сүргийн ашиг шим, эдийн засгийн судалгаа
Хүснэгт 94. Тэмээн сүргийн бүтэц

№	Нас	Сүрэгт эзлэх хувь	Тоо, толгой
1	12 сартай	12.7	3257
2	1.5	14.3	3667
3	2.5	10.8	2770
4	3.5	10.8	2770
5	Нас гүйцсэн	20.6	5282
6	Хээлтүүлэгч	1.1	282
7	Хээлтэгч	29.7	7616
	Бүгд	100.0	25644

Тэмээ нь 2.6-8.1 кг ноосны гарцтай. 21.6-26.7 хувь ширүүн ноос эзэлнэ. Тэмээнийноос нь сор үс, завсрынүс, ноолуураас тогтоно. Сор үс 5.1-5.6 хувь, завсрын үс 20.8-25.3 хувь, ноолуур 69.5-73.6 хувийг эзэлнэ. Тэмээний ноосны ширхэгийн голч сор үс 59.1-66.4 мкм, завсрын үс 30.7-44.9 мкм, ноолуур 14.3-23.1 мкм байна.

Монгол тэмээний ноосны гарц нас, хүйсний байдлаас болж харилцан адилгүй байдаг. Б.Лувсангийн тогтоосноор нэг настай тэмээ 2647-2814 гр, хоёр наст 3696-3923 гр, гурван наст 4595.2-4703 гр, дөрвөн наст 4701-5162 гр, зургаа ба түүнээс дээш насны ат 5285 гр, ингэ 5228 гр, бүдүүн буур 8135 гр ноос өгнө. Тэмээний ноосны гарцнь байгаль, цагуурын нөхцөл, бэлчээрийн өвс ургамлын шимт чанар, арчилгаа маллагааны байдлаас мөн тэмээний удамшлын чанараас шууд хамаарах боловч 1-ээс 5 нас хүртэл тэмээний биеийн өсөлт, хөгжилтийн зүй тогтлын дагуу нэмэгддэг.

Хүснэгт 95. Тэмээний ноолуурын дундаж гарц /нас, хүйсээр/

№	Нас	Нэг тэмээнээс гарах ноос /гр/	Бүгд	Нийт ноосны хэмжээ /кг/
1	12 сартай	2,730	3257	8891610
2	1.5	3,810	3667	13971270
3	2.5	4,650	2770	12880500
4	3.5	4,931	2770	13658870
5	Нас гүйцсэн	5,285	5282	27915370
6	Хээлтүүлэгч	8,135	282	22294070
7	Хээлтэгч	5,228	7616	39816448
	Бүгд	100	25644	139428138.0

2015 оны дундаж үнээр, бараан өнгийн боловсруулаагүй тэмээний ноосны дундаж үнэ 3964.0 төгрөг байна. Нийт тэмээний ноосны үнэ 121917973.2 төгрөг болж байна.

Говь нутгийн малчид дээр үеэс ингэийг саалинд ашиглаж ирсэн уламжлалтай бөгөөд ингэний сүүг хөөрүүлж уух, цай сүлэх, ингэний ундаа, айраг, хоормог, аарц, ааруул хийх зэргээр хүнсэнд өргөн хэрэглэдэг. Ингэний саалийн хугацаа 14-18 сар үргэлжилж энэ хугацаанд дунджаар 180-600 л сүү өгдөг. Б.Лувсангийн (1975) судалгаагаар говийн нөхцөлд ингэний саалийн хугацаа дунджаар 528 хоног үргэлжилж хээл авсныхаа дараа таван сар болоод ширгэнэ. Саалийн 17 сард сүүний гарц дунджаар 320 л болдог ба нийт сүүний 67.1 хувийг саалийн эхний 6 сард саадаг байна. Ингэний сүүний гарц тухайн малын хувьслын онцлогоос хамаарахаас гадна арчилгаа, маллагааны байдал, бэлчээрийн ургац, өвс ургамлын төрөл, бүрэлдэхүүн шимт чанараас нэлээд шалтгаалдаг. Б.Лувсангийн судалгаагаар ингэний сүүнд хуурай бодис 14.56 хувь, тослог 5.65 хувь, сүүний чихэрлэг 3.87 хувь, үнс 0.67, витамин С - 6.95 мг байдаг аж. Р.Индра (1983) ингэний сүүний тослогийн хэмжээ зуны саруудад багасаж, харин өвөл хаврын саруудад (10-р сараас 3-р сар) нэмэгддэгийг, мөн сүүний бусад бүрэлдэхүүн хэсгүүд, тухайлбал сүүний уураг, чихрийн хэмжээ саалийн хугацаанд нэлээд тогтвортой байхын хамт хуурай бодис 15.54 хувь, тос 5.45, уураг 4.39, сахар 4.76 хувь байдгийг тогтоожээ.

Диаграм 13. Ингэний саалийн хугацааны хуанли



Хүснэгт 96. Ингэний сүүний эдийн засгийн үнэлгээ

Хүйс	Тоо, толгой	Нэгжээс авах сүү /л/	Саалийн хугацаа /Сар/	Бүгд /л/	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Ингэ	8488.2	320	17	2716224	1500	4074336000

Ханбогд сумын нийт тэмээн сүргээс 17 сарын хугацаанд авах ашиг шимийг зөвхөн ноос, сүүний чиглэлээр тооцож үзэхэд 1,063.1 сая төгрөгийн бодит орлогын нөөц, боломжтой байна.

4.2.3.5. Ямааны ашиг шим, эдийн засгийн судалгаа

Монголчууд эрт дээр үеэс өсгөн үржүүлж ирсэн таван хошуу малын нэг бол ямаан сүрэг Төв Азийн цаг уурын нөхцөлд бэлчээрээр маллахад зохиолдсон, биологи аж ахуйн өвөрмөц онцлогтой, ялангуяа говь, цөлөрхөг хээр, уулархаг нутгийн бэлчээр чадамгай ашиглаж, хөнгөн, хүнсний үйлдвэрийн чухал түүхий эд бүтээдэг аж ахуй билээ. Ямааны мах, ноолуур ба түүний сүүг өргөн ашигладаг. Сүүгээр нь бяслал ба олон төрлийн цагаан идээ хийнэ. Цагаан болон хар ямааны сүүг эмчилгээний зориулалтаар болон эмийн бэлдмэл хийхэд ашигладаг.

Хүснэгт 97. Нийт ямаан сүргийн тоо, толгой /2016 оны эцсийн байдлаар/

№	Нас, хүйс	Тоо, толгой
1	1.5	19232
2	2.5	6767
3	3.5	19943
4	Хээлтэгч	356
5	Хээлтүүлэгч	24930
Нийт		71228

Ямааны махны талаар:

Ямааны махыг бусад малын махны адил хүнсэнд хэрэглэдэг ба онцлог нь ямаа мах булчиндаа гадар өөх багатай, өөхөн сүүлгүй, харин дотор өөхний хуримтлал ихтэй, ямааны мах өөхний нядлагын гарц 40.0-45.0 хувь байдаг. Ямааны өлөн гэдэс хиамны үйлдвэрийн чухал түүхий эд болох ба эврээр нь жижиг сам, цаасны хутга зэрэг эдлэл, туурайгаар нь цавуу хийдэг байна. Ямааны ясаар янз бүрийн ясан эдлэл хийж болохоос гадна нунтаглаж малын тэжээлийн хольц, газар тариалангийн сайн бордоо бэлтгэдэг.

Ямааны маханд нийтдээ 15 нэрийн амин хүчил илэрсэн ба борог маханд агуулагдах үл орлогдох амин хүчлийн хэмжээ өөхтэй махныхаас харьцангуй их тодорхойлогдсон байна. Ямааны мах олон нэрийн хүчлээр баялаг, ханаагүй тосны хүчлийн агууламж өндөн (45.7-49.1хувь) төдийгүй уургийн үл орлогдох амин хүчил (44.0-39.0хувь) ихтэй чанартай мах хэмээн тодорхойлжээ.

Монгол ямаа бэлчээрээр таргалах чадвар сайтай бөгөөд намар бүдүүн ухна 55-58, эм ямаа 37-41, шүдлэн ухна 35-38, охин шүдлэн 29-31 кг жин дардаг.

**Хүснэгт 98. Ямааны мах бэлтгэсэн хэмжээ болон орлогыг зах зээлийн ханшаар тооцов.**

Төрөл	Тоо, толгой	Нэгжээс гарах дундаж махны хэмжээ /кг/	Нийт махны хэмжээ /тн/	Дундаж үнэ /төг/	Нийт үнэ /мян.төг/
Ямаа	8923	45872	4969	227937.9	8923

2016 оны аймгийн статистикийн мэдээгээр нийт зах зээлд махны чиглэлээр борлуулсан ямааны тоо 8923 үүнээс гарах махны гарц нь 45.872 тн, зах зээлийн ханшаар 227937.9 мянган төгрөг болж байна.

Ямааны сүүний талаар:

Ямааны сүүний ашиг шимийг Д.Цэрэнсодном нэлээд сайн судалж, говийн нөхцөлд ямааны саалын хугацаа 225 хоног үргэлжилж, 60-70 литр сүү саалгадаг, сүүний гарц саалийн эхэн үед бага, дунд үеэр ихсэж, сүүл үе рүүгээ дахин багасдаг, харин ямааны сүүний гарц зургаа, долдугаар саруудад ихсэж, дээд хэмжээндээ хүрэх ба хоногийн саам 108-412 гр, сарынх 3.24-12.36 литр хүрнэ. Р.Индра нарын судалгаагаар говийн ямааны сүүний хуурай бодис 15.44-0.06 хувь, тос 5.81-0.03 хувь, нийт уураг 3.87-0.03 хувь, лактоз 4.87-0.29 хувь, үнс 0.89-0.019 хувь байжээ.

Ямааны саалийн хугацаа 7 сар үргэлжилж, 60-70 литр сүү өгдөг. Сүү ашиглах гол үе нь 6-р сарын 1-нээс 8-р дугаар сарын 15-ныг хүртэлх хугацаа бөгөөд ямаа бүрээс таваарын 20-30 литр сүү ашиглана.

Хүснэгт 99. Ямааны сүү нөөц, чадавхийг доорх хүснэгтээр тооцов.

Хүйс	Тоо, толгой	Нэгжээс авах сүү /л/	Бүгд /л/
Эм ямаа	32266	25.0	806650

Ямааны ноолуурын талаар:

Ямаан сүргийн тархалт дэлхийн өндөр уудам нутгийг хамрах учир тухайн улс орны цаг агаарын эрс халуун эсвэл бүр сэрүүн байдлаас хамаарч ямаа элгэн халцгай эсвэл хэт ноосорхог, зарим нь ноолууртай байдаг. Нэг ямаанаас дунджаар 250 гр ноолуур гардаг. Нэг грамм цэвэр ноолуураар 9-10 метр утас ээрдэг. Монгол улс нь дэлхийн нийт ноолуурын 35-40 хувь гаруй хувийг бэлтгэдэг. Монгол ямааны ноолуурын ширхэгийн голч 13.0-16.5 мкм дундаж урт 38-45 мм бөгөөд Монголын эрс тэс цаг ууртай холбогдон дулаан хадгалах чанараараа бусад орны ямааны ноолуураас давуу байдаг. Ямааны ноолууран бүтээгдэхүүн нь хөнгөн, уян зөөлөн, дулаан хадгалах болон хэлбэрээ хадгалах чадвар онцгой сайн, тансаг бүтээгдэхүүн бөгөөд зах зээлд байнгын эрэлт хэрэгцээтэй байдаг.

Ухна 250-350, эм ямаа 240-270, борлон ухна 200-240, охин борлон 200-230, эр ямаа 240-380 гр ноолуур өгдөг.

Хүснэгт 100. Ямааны ноолуур бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцов.

№	Нас	Тоо, толгой	Нэгжээс авах ноолуур /кг/	Бүгд /кг/
1	1.5	19232	0.19	3,654.08
2	2.5	6767	0.21	1,421.07
3	3.5	19943	0.30	5,982.90
4	Хээлтүүлэгч	356	0.35	124.60
5	Хээлтэгч	24930	0.22	5,484.60
Бүгд		71228		16,667.25


2016 оны эцсийн байдлаар Ханбогд сумын нийт ямаан сүргийн ашиг шимийг мах, сүү, ноолуур, арьс, дайвар бүтээгдэхүүнээр тооцож үзэв. Ноолуур, сүүний ашиг шимийг нийт сүргийн хэмжээнд авч үзсэн, харин мах, арьс, дайвар бүтээгдэхүүний хэмжээг тус онд бэлтгэсэн арилжаалсан /3,164/ болон өрх гэрийн хүнсэнд хэрэглэсэн /12,910/ ямааны нийлбэр тоогоор авч үзэхэд 2.981.1 сая төгрөгийн нөөц, орлогын эх үүсвэр байгааг харуулж байна.

Хүснэгт 101. Ямаан сүргээс олох орлогын нийт нөөцийг дараах хүснэгтээр тооцов.

Мах			Сүү			Ноолуур			Арьс			Дайвар бүтээгдэхүүн			Бүгд дүн /төг/
Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /л/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	
45872.0	4969	227937968	806,650.00	500.00	403,325,000.00	16,667.25	55000	916,698,750.00	1283	8000	10264000	1283	1500	1924500	122520000.0

2016 оны эцсийн байдлаар Ханбогд сумын нийт ямаан сүргийн ашиг шимийг мах, сүү, ноолуур, арьс, дайвар бүтээгдэхүүнээр тооцож үзэв. Ноолуур, сүүний ашиг шимийг нийт сүргийн хэмжээнд авч үзсэн, харин мах, арьс, дайвар бүтээгдэхүүний хэмжээг тус онд бэлтгэсэн арилжаалсан дүнгээр авсан бөгөөд нийт 122.5 сая төгрөгийн нөөц, орлогын эх үүсвэр байгааг харуулж байна.


Зураг 61. Багуудын бэлчээрийн даац ашиглалт



4.2.4. Бэлчээрийг улирлаар сэлгэн ашиглах төлөвлөгөө

Бэлчээрийн газрыг улирлаар сэлгэн бог, бод малаар ялгаж ашиглахаар төлөвлөв. Уулархаг нутгаар малчид өвөлждөг бөгөөд энэ байдлыг хэвээр үлдээж харин уулын хөндийн ус багатай бэлчээрийг 4 улирлын бод малын бэлчээр, уулархаг нутгийн ар, өврийн бэлчээрийг зун намрын бог малын бэлчээр болгож сэлгэн ашиглана.


Зураг 62. Бэлчээр сэлгэн ашиглах төлөвлөгөөний зураг




4.2.5. Бэлчээр ашиглалтын хэсэг

Бэлчээрийг доорх зурагт үзүүлснээр малчдын одоогийн мал бэлчээж байгаа газрыг өөрсдийн саналын үндсэн дээр 65 бэлчээр ашиглалтын хэсэг болгов. Нэг бэлчээр ашиглалтын хэсэгт хэдэн ч айл өрх малаа бэлчээх боломжтой хэдий ч тухайн хэсэгт байх малын тоо хязгаартай байна.

Зураг 63. Бэлчээр ашиглалтын хэсгийн төлөвлөлт




Зураг 64. Бэлчээр ашиглалтын хэсгийн даац



4.2.5. Бэлчээрийн усжуулалт

Гадаргын усны судалгааг гаргасны үндсэн дээр Ханбогд сумын хэмжээнд усжуулагдсан талбай 370000 га бөгөөд харин усжуулах шаардлагатай 131657,58 га. Үүнээс Баян баг 37615,1 га, Гавилууд 27239,51 га, Жавхлант 42710,58 га, Номгон 24092,39 га газрыг усжуулах шаардлагатай байна.

Зураг 65. Усжуулах шаардлагатай бэлчээрийн төлөвлөлтийн зураг



Хүснэгт 102. Усжуулах шаардлагатай бэлчээр


Багын нэр	Газрын нэр	Талбай /га/
Баян	Үнэгт уул-Нарийн элс-Эмээл толгой, Элсэн толгой-Хар толгой-Сүүжийн бор толгой	37,615.10
Гавилууд	Цахиуртын толгой-Сүүжийн эхэн ус-Дуулгат уул, Цахиуртын толгой-Сүүжийн эхэн ус-Дуулгат уул, Хөтөл тойром-Цагаантолгой-Их бууцны хяр	27,239.51
Жавхлант	Тахилгат уул-Уртын сайр-Байшинт уул, Бор хошууны хяр-Оцонгийн шийр уул, Үнэгт уул-Хөөврийн тал-Өлзийт хоолой	42,710.58
Номгон	Цэцэрлэгийн сайр-Хүрээгийн тал, Үзүүр заг-Хүрэн сайрын хошуу-Овоот толгой	24092,39



Хүснэгт 103. Усжуулах шаардлагатай, ашиглалт багатай бэлчээрийн гүний усны нөхцөл

Гүний устай талбайн дугаар	Томъёолол	Гүний усны нөөц, тархалт	Талбай /га/	Нийт талбай /га/
1	Голын элс, хайрга, элсэнцэр, шавранцар	Үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг	53.66	86766.52
	Судаг бэлийн элс, хайрга, элсэнцэр		2761.99	
	Суурилаг бялхамал чулуулаг		179.35	
	Хүчиллэг, дундаж хүчиллэг, бялхамаг		4876.26	
	Хүчиллэг, дундаж хүчиллэг, түрмэлин		627.68	
	Шавар, элс, элсжин	Газрын доорх локал, хязгаарлагдмал нөөц бүхий устай чулуулаг	1509.26	
		Үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг	654.89	
	Элс, элсжин, хөрзөн, хайрга	Газрын доорх локал, хязгаарлагдмал нөөц бүхий устай чулуулаг	849.15	
		Үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг	75254.28	
2	Голын элс, хайрга, элсэнцэр, шавранцар	Газрын доорх локал, хязгаарлагдмал нөөц бүхий устай чулуулаг	10350.67	17734.59
	Судаг бэлийн элс, хайрга, элсэнцэр	Үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг	2193.57	
	Хувирмал чулуулаг		2135.05	
	Элс, элсжин, хөрзөн, хайрга		3055.3	
3	Голын элс, хайрга, элсэнцэр, шавранцар	Газрын доорх локал, хязгаарлагдмал нөөц бүхий устай чулуулаг	11896.38	55004.05
	Хувирмал чулуулаг	Үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг	3682.52	
	Шавар, элс, элсжин		1869.96	
	Элс, элсжин, хөрзөн, хайрга		32972.24	
	Элсжин, зануужин, хөрзөн, нүүрс, шавар		4582.95	

Зураг 66. Усжуулах шаардлагатай бэлчээрийн гүний усны нөхцөлийн зураг



Бэлчээрийг гэрээгээр ашиглах нь: Газрын тухай хуулийн 52.2-т заасан “Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг талхлагдлаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, даац, чадавхийг харгалзан, багийн Иргэдийн нийтийн хурлын саналыг үндэслэн сумын засаг дарга малчдад болзол гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно” гэсэн заалтын дагуу бид гэрээгээр бэлчээрээ ашиглах боломжтой малчдын хуваарийг гаргаж төлөвлөгөөнд тусгалаа. Ханбогд сумын хэмжээнд тогтоосон өвөлжөө, хаваржааны нутаг бэлчээрийг хэсэгт хуваасан ашиглалтыг үндэслэн 65 бэлчээр ашиглалтын хэсэгт хуваарилж төлөвлөсөн. Цашид малчин өрхүүд нэгдэж бүлэг байгуулан энэхүү хуваарыг хэлэлцэн тохиролцож бэлчээрийн газраа гэрээгээр ашиглаж болно.


4.2.6. Газар тариалан, мал аж ахуй, /хосолсон/ эрчимжсэн фермерийн аж ахуйн ТӨЛӨВЛӨЛТ

Бид эрчимжсэн фермерийн аж ахуйн төлөвлөлтийг хийхдээ Өмнөговь аймгийн “Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө” 2014 төлөвлөгөөг баримтлан гаргав. Үүнд: Эрчимжсэн мал аж ахуйг Ханбогд сумын Номгон багт төлөвлөв. Тус газарт одоогоор төмс

хүнсний ногоо тариалдаг бөгөөд цаашид тус тариалангийн газарт эрчимжсэн мал аж ахуйн малын тэжээлийн ургамлыг 10 га тариална хэмээн төлөвлөв.

Нийт 4268.7 га газар төлөвлөсөн бөгөөд бэлчээрт 4243.7, тариалан тарих 15 га газрыг төлөвлөсөн.

Зураг 67. Эрчимжсэн мал аж ахуйн төлөвлөлтийн зураг



4.3. ТАРИАЛАНГИЙН ГАЗРЫН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ


ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 тоот тушаалаар батлагдсан “Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээний аргазүй”-н дагуу Ханбогд сумын тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг тодорхой шалгуур үзүүлэлтүүдээр хийв.

Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, газар ашиглалтын онцлогоос хамаарч тохиромжтой байдлыг үнэлэх үндсэн болон дэд үзүүлэлтүүдийг сонгон үнэлэх ба эдгээр үзүүлэлтүүдийг нэгтгэсний үндсэн дээр тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг боловсруулав.


Диagram 14. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд



Зураг 3. Уур амьсгалын хүчин зүйлийн үнэлгээ



Зураг 68. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг



Хүснэгт 104. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

№	Үнэлгээ	Талбай /га /	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	390337.64	26.1
2	Нэн тохиромжгүй	15595.29	1.0
3	Тохиромжгүй	722963.17	48.3
4	Хязгаарлагдмал тохиромжтой	367301.16	24.5
Нийт		1496197.25	100.0

Уг үнэлгээгээр сумын хэмжээнд тариаланд тохиромжтой, нэн тохиромжтой газар байхгүй, 95118.94 га газар хязгаарлагдмал тохиромжтой, 938836.1 га газар тохиромжгүй, 357184.34 га газар нэн тохиромжгүй гэж үнэлэгдсэн байна.

Сумын хэмжээнд 12.5 га газарт төмс, хүнсний ногоо тариалдаг. Тус сумын хувьд одоогийн нийт газар тариаланд идэвхитэй ашиглагдаж буй эргэлтийн талбай нь хангалтгүй байгаа бөгөөд сумын нийт хүн амын хэрэгцээний 20.0 хувийг хангах хэмжээнд байна.

Хүн ам өсөн нэмэгдэж байгаагийн хирээр газар тариалангийн бүтээгдэхүүний хэрэгцээг хангахын тулд тариалангийн газрын 1 га-аас авах ургацыг нэмэгдүүлэх, тариалалт хийж буй талбайг нэмэгдүүлэх 2 үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Морфологийн бичиглэлүүдээс үзэхэд сумын хөрсний ялзмагт үе нь гол төлөв цайвардуу хүрэн өнгөтэй, гүн нь 12 см-ийн орчим, үрлэн бүтэцтэй, ургамлын үндсээр тиймч баялаг биш, хөрсний 15 см-ээс давсны хүчлийн уусмалд буцалж байгаа нь хөрс үүсгэгч эх чулуулаг нь карбонатлаг болохыг харуулж байна. Хөрсний шингээгдсэн сууриудын нийлбэр 100 г хөрсөнд 280мг-экв байх ба түүний дотор калцийн агууламж 50.0-аас дээш хувийг эзэлж байгаа нь хөрсний бүтцэнд сайн нөлөө үзүүлнэ. Ялзмагт үе давхаргадаа ялзмагийн агууламж 1.1-2.8 хувь хүрэх ба харин азотын хангамжаар төдийлэн сайнгүй, хөрсний хөдөлгөөнт фосфор, калиар дунд зэрэг хангагдсан, 100 г хөрсөнд 1.8 - 2.2 мг фосфор, 12-20.5 мг кали агуулна. Механик бүрэлдэхүүний хувьд ихэвчлэн элсэнцэр болон хөнгөн шавранцар байна.

Хүн амын хүнсний жилийн хэрэгцээт байдал

Ханбогд сумын суурин хүн амын хүнсний жилийн хэрэгцээт байдлыг урьдчилсан байдлаар тодорхойлов.

Хүснэгт 105. Жилийн хүнсний хэрэгцээ

Он	Төрөл	Жилийн хүнсний хэрэгцээ /кг/
2016 он	Хүнсний тос	13040.3
	Мах махан бүтээгдэхүүн	438146
	Сүү	328909.6
	Сүүн бүтээгдэхүүн	438146.0
	Гурил	219073.0
	Гурилан бүтээгдэхүүн	481960.6
	Төрөл бүрийн будаа	171057.0
	Саахар, чихрийн зүйл	50416.8
	Төмс	306702.2
	Хүнсний цлүүдногоо	438146.0
	Жимс, жимсгэнэ	394331.4
	Өндөг	41413.8

4.4. УУЛ УУРХАЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

“Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөрт (2010-2020) уул уурхайн үйлдвэрлэлийн талаар дараах гол зорилтуудыг дэвшүүлэн тавьсан байна.

1. Өмнөговь аймгийн аль ч бүс нутагт байгалийн баялгийг ашиглаж байгаа нөхцөлд тухайн орон нутгийн байгаль орчинд эерэг нөлөө үзүүлдэг байх, хөгжлийн сангаар дамжуулан ойжуулах, цэцэрлэгжүүлэх, усжуулах хөтөлбөрүүдийн санхүүжилтэд дэмжлэг үзүүлдэг байх. Байгалийн нөөцийг ашиглагч нь нөхөн сэргээгч байдаг зарчим бий болгох.

2. Өмнөговь аймгийн “Байгаль орчны мастер төлөвлөгөө”-нд заагдсан хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, орон нутгийнхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцвэртэй уялдуулах, өнөө болон ирээдүй хойч үеийнхний эрх ашгийн үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэхэд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын чармайлт, тэмцэл, санаачлагын чиглүүлэх;

3. Говийн бүсийн экологийн тэнцлийг хангах, хүний хүрээлэн буй орчинг эрүүл аюулгүй байлгах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хүний буруутай үйл ажиллагаа болон уул уурхайн хайгуул, олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрлэлээс байгаль орчинд үзүүлэх



сөрөг нөлөөллийг бууруулах гэсэн шаардлагууд нь Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийг гурван бүсэд /баруун, зүүн, төвийн бүс/ хуваасан.

4. Уул уурхайн компаниудын хайгуул буюу олборлолтын үйл ажиллагааны явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж, орон нутгийг удирдлагад нь хүлээлгэн өгсөн байдалд тавих хяналтыг сайжруулж, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний хэрэгжилтэнд жил бүр үнэлэлт дүгнэлт өгч ажиллах;

5. Иргэдийн гар аргаар алт олборлосон газруудыг нөхөн сэргээх, хөрсний эвдрэл, бохирдлыг арилгахад хандивлагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах;


Ханбогд суманд уул уурхайн ашиглалт, хайгуул хийж байгаа компаниудын үйл ажиллагааг очиж судалсны үндсэн дээр иргэдийн санал, хөгжлийн хөтөлбөрүүдийн чиг хандлагыг харгалзан дараах арга хэмжээнүүдийг төлөвлөв.

- Уул уурхайн зориулалтаар дахиж ашиглалт, хайгуулын зөвшөөрөл олгохгүй байх;
- Уурхайн талбайгаас илүү гаргаж ашигласан талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт тухайн уул уурхайн үйл ажиллагаа явууж байгаа байгууллагаар хийлгэх;
- Уурхайн эдэлбэр газрын хил заагт техникийн хяналтын хэмжилт хийх;
- Уул уурхайн эдэлбэр газруудад газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх;
- Уурхайн нөлөөллийн бүсэд байгаа айл өрхүүдэд хохирол гарсан тохиолдолд хариуцагч этгээдээр нөхөн төлбөр олгох ажлыг зохион байгуулах г.м

Энэ үүднээс ашиглалтын лиценз бүхий аж ахуйн нэгжүүдтэй орон нутаг хамтран дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөв.

1. Усжуулалтгүй бэлчээрт худаг гаргах
2. Элэгдэж эвдэрсэн газрыг нөхөн сэргээх
3. Цөлжиж байгаа газарт мод тарих
4. Булаг шандыг хашиж хамгаалах

Зураг 69. Уурхайн нөлөөллийн бүс



Тухайн суманд үйл ажиллагаа явуулж буй Оюутолгойн уурхайн олон улсын стандартын шаардлага хангасан хог хаягдлыг технологийн дагуу булшлах төв баригдаж дуусаад 2014 оны 6 дугаар сараас ажиллаж эхэлжээ. Хог булшлах байгууламж нь нийт 21000м² талбай, 190 000 м³ эзлэхүүнтэй.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн 2016 оны тайландаа хог хаягдал шатаах зуухнаас гарах хийг цэвэрлэх болон шатаах зуухыг тэжээх төхөөрөмж хаягдал төмөр болон хуванцарыг дахин ашиглах байгууламжийг Ханбогд суманд барьж байгуулах судалгааг “Оюутолгой” ХХК-иас хийж байгаа бөгөөд энэ нь урт хугацааны төлөвлөгөөг төлөвлөж байна. Богино хугацаанд төмөр болон хуванцар дахин ашиглах гэрээг байгуулан 2016 оны 8 сараас эхлэн үйл ажиллагааг эхлүүлээд байгаа.

Идэвхигүй хаягдлын цэгт уурхайн үйл ажиллагаанаас гарч буй үнс, бетон зуурмагны хаягдал болон бусад барилгын хаягдал зэрэг хими, физик, биологийн нөлөөгөөр өөрчлөгдөхгүй идэвхигүй хаягдлыг ил уурхайн хаягдлын овоолгын төлөвлөлттэй уялдуулан бий болгосон талбайд булж устгаж байна. 2016 оны 10 сарын 31-ны байдлаар нийт 3579.98 тн (үнс 3108,5 тн, бетон зуурмагны хаягдал 471,5 тн) идэвхигүй хаягдлыг 472 м² талбайд хаяж байна.


Идэвхигүй хаягдлын цэгийн үйл ажиллагааг илүү цэгцтэй, хяналттай болгох мөн зориулалтын бус хог хаягдал хаягдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2016 оны 11 сард хөдөлгөөн мэдрэгч камер байрлуулсан боловч цаашид анхааралдаа авч хог хаягдлын менежментийг нарийн тодорхой үр дүнтэй болгох зайлшгүй шаардлагатай байна.

4.5. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ

ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 тоот тушаалаар батлагдсан “Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээний аргазүйн дагуу Ханбогд сумын аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээг тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг харьцуулан хийв.


Диаграм 15. Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын схем



Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхэд хүчин зүйлүүдийн зураг нь 1: 500000-1:1000000 масштабтай байгаа тул сумын хэмжээнд хэт ерөнхий, мөн зарим үзүүлэлтүүд нь нарийн судлагдаагүй гарч байна. Иймд үнэлгээг хийхдээ дараах үзүүлэлтүүдээр хийсэн. Үүнд:

- Гадаргын налуу
- Гадаргын хэрчигдлийн шигүү
- Агаарын дундаж температур
- Жилд нар гийгүүлэх хугацаа
- Нэгж талбайд ноогдох голын урт
- Голын нийлбэр урсац
- Гол, нуур
- Рашаан
- Ой модны зонхилогч зүйл
- Ойн цоорхой ба зах
- Түүх соёлын дурсгалт газрууд
- Сум, багийн төвд ойрхон эсэх

Зураг 70. Аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг



Хүснэгт 106. Аялал рекреацийн тохиромжтой байдлын үнэлгээ

№	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	178954.71	11.96
2	Тохиромжгүй	432.03	0.03
3	Дунд зэрэг тохиромжтой	1187845.5	79.4
4	Тохиромжтой	128783.68	8.61
Нийт		1496015.9	100

Ханбогд сумын нутагт орших 800 м өндөр, 150 км үргэлжилсэн Хонгорын голын үзэсгэлэнт элсэн уул, хэдэн арван км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг сүүжийн алдарт их говиуд, эртний хүмүүсийн амьдарч байсан ул мөр, сүг зураг, бичигт болон гэрэлт хөшөө, хүн чулуу зэрэг түүх соёлын ховор нандин үзмэрүүд, 50-120 сая жилийн тэртээ амьдарч байсан эртний үлэг гүрвэлийн чулуужсан яс, өндөг, чулуужсан мод зэрэг эртний үлэг гүрвэлийн чулуужсан яс, дэлхийд ховордсон ан амьтан, ховор төрлийн ургамлаараа гадаадын жуулчин, аялагчдын сонирхлыг ихээхэн татаж байна.

Уг бүс нь Өмнөговь аймгийн нутгийн зүүн өмнөд хэсгийг хамаарах буюу Ханбогд сумын нутаг дэвсгэр дэх түүх соёл, байгалийн үзмэрүүд орно. Ханбогдын бүсэд орших түүх, соёлын дурсгалуудыг ашиглан тусгайлан аялалын хөтөлбөр маршрутыг бий болгон эдийн засгийн

эргэлтэнд оруулах шаардлагатай байна. Энэ бүсэд шашин мөргөлийн холбогдол бүхий сүм хийд 3 байгаа бөгөөд байгалийн өвөрмөгц сонин тогтоцийг түшиглэсэн нь аялал жуулчлалд идэвхитэй оролцох боломж нөхцөлийг илэрхийлж байна.

Ханбогдын дэд бүсэд жуулчдын сонирхол татахуйц дараах үзмэрүүд байна.

- Дэмчогийн хийд
- Улаан сахиусын хийд
- Үнстийн хийд
- Галбын уулын үзэсгэлэнт газар
- Баяжихын агуй
- Оцон мааньт
- Гурван зээрдийн агуй
- Говийн бага дархан газрын А хэсэг
- Говийн бага дархан газрын Б хэсэг
- Ловончомбо агуй
- Оюутолгойн уурхай зэрэг болно.

Уг бүсэд Галбын гурван хийдийг түшиглэн Үртийн булгийн жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байна.

“Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөрийн (2010-2020)-д, “Өмнөд хөршийн аялал жуулчлалын сүлжээтэй холбогдон, дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн Орхоны хөндий, өөрийн орны бусад түүхэн болон байгалийн өвөрмөгц тогтоц, аялал жуулчлалын сүлжээгээр дамжуулан ОХУ, Байгаль нуур орчмын аялал жуулчлалын бүсүүдтэй холбож, Хятад болон Оросын хооронд дамжин өнгөрөх олон улсын гарцыг бий болгох бодлогыг баримтлах” гэж тусгасны дагуу болон байгалийн үзэсгэлэнт газар, түүх солын дурсгалт газар олон байдгийг харгалзан дараах байдлаар төлөвлөж байна.

Уг бүсэд Галбын гурван хийдийг түшиглэн Үртийн булгийн жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байна.

Ханбогд сумын Дэмчогийн хийд, Баяжихын агуй зэрэг түүх, соёлын дурсгалт газруудаар, мөн Номгон сумын Сангийн далай хийд, Уртын амралт, Борзонгийн говиор аялалын шинэ маршрут төлөвлөв.


Хүснэгт 107. Ханбогд сумын дэд бүсэд хөгжүүлэх жуулчлалын замнал аялал жуулчлалын газрыг төлөвлөв.

№	Чиглэл	Туулах зай	Үзэх үзмэр
1	Маршрут 1	56.4	Палеонтологийн дурсгалт газар
2	Маршрут 2	129.5	Түүх соёлын дурсгалт газар
3	Маршрут 3	79.1	Түүх соёлын дурсгалт газар
4	Маршрут 4	159.1	Байгалийн дурсгалт газар

Аялал жуулчлалыг төрөлжсөн байдлаар төлөвлөсөн. Үүнд:

1. Байгалийн үзэсгэлэнт газар, зэрлэг, ховор ан амьтадыг харах аялал,
2. Эртний үлэг гүрвэлийн талаар судалгаа шинжилгээ, танин мэдэхүйн палеонтологийн аялал,
3. Эртний хүн, улс үндэстний түүх, соёлыг судлах түүх соёлын дурсгалт газруудаар аялах зэрэг нийт 3 төрлийн аялалын маршрутыг төлөвлөсөн.

Зураг 71. Аялал жуулчлалын газрын төлөвлөлтийн зураг



БНХАУ манай орныг өөрсдийн жуулчид өөрийн зардлаар жуулчлах орны жагсаалтад оруулснаар бүлэг жуулчдыг хүлээн авах эрхтэй болсон байна. БНХАУ-д ирэх гадаадын жуулчдын тоо жил бүр 8 хувиар өсөх төлөвтэй байгаа нь Монголд ирэх гадаадын нийт жуулчдын тоог нэмэгдүүлэх таатай боломж юм. 2015 оны байдлаар, Монгол улсад 386204 гадаадын жуулчин ирснээс хамгийн олон буюу 145029 жуулчин БНХАУ-аас иржээ. Монгол

улсын байгаль орчин, аялал жуулчлалын яамны аялал жуулчлалын газар болон БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орны Аялал жуулчлалын товчоо хамтран 2006 оноос хойш жил бүр “Хилийн бүсийн аялал жуулчлалыг зохицуулах хурал” зохион байгуулж, тогтмолжуулсан байна. Тус хурлын үеэр БНХАУ-ын талаас хилийн бүсэд аялал жуулчлалыг цогцолбороор нь хөгжүүлэхэд хамтран ажиллах санал тавьж байгаа бөгөөд Зүүн хатавч, Ар хашаат боомтод Монголын хилийн бүсийн аялал жуулчлалын маршрут бий болгох саналаа 2010 он илэрхийлсэн байна. Ийнхүү хөрш орнуудтай аялал жуулчлалын зах зээл дээр идэвхтэй хамтран ажиллах шаардлага гарч байгааг хоёр талын хүчин чармайлт, хамтын ажиллагаагаар шийдвэрлэх, орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагуудын үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай байна.

Орон нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт бага шаардсан үндэсний уламжлал, ёс заншлыг түшиглэсэн эко цогцолборыг бий болгох, аялал жуулчлалын дагалдах бизнес болох гар урлал, бэлэг дурсгал, орон нутгийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрөөс дэмжих, экспортын үйлдвэрлэлд үзүүлэх хөнгөлөлтөд хамруулах нь салбарын эдийн засгийн боломжийг сайжруулах нөхцөл болох аж.

4.6. ХОТ СУУРИН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

Шинээр хот, суурин байгуулахад тохиромжтой газар

ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 тоот тушаалаар батлагдсан “Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээний аргазүйн дагуу Ханбогд сумын нутаг дэвсгэрт шинээр хот суурин байгуулахад тохиромжтой эсэхийг тодорхой шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэв.

Шинээр байгуулах хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээг өгөхдөө нийт 4 үндсэн, 43 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.

Хот, суурины барилгажсан газар нутагт хүрээлэн буй орчны (нэгдсэн экосистем) нөхцөлийг нарийвчлан эерэг ба сөрөг талыг илрүүлж, 3 шатлалтай ангиллаар үнэлгээний 4 бүлэг үзүүлэлтээр тогтоож, 3 баллын системийн аргыг хэрэглэж дараах хүснэгтүүдийн дагуу боловсруулна. Үүнд:

1. Байгаль орчны үнэлгээ

- Байгалийн нөхцөл, нөөцийн үнэлгээ;
- Байгаль-экологийн үнэлгээ;
- Инженер-экологийн үнэлгээ;


2. Нийгэм-эдийн засгийн үнэлгээ

3. Дэд бүтцийн үнэлгээ

4. Архитектур - орон зайн төлөвлөлт, ландшафтын үнэлгээ

- Байгаль орчны үнэлгээнд газар нутгийг тохиромжтой, хязгаарлагдмал тохиромжтой, тохиромжгүй;
- Нийгэм-эдийн засгийн үнэлгээнд хүн амын соёл, ахуйн үйлчилгээний хэрэгцээ, хангамжийн түвшинг, өндөр, дунд, доогуур;
- Дэд бүтцийн хүчин зүйлсээр тохиромжтой, хязгаарлагдмал тохиромжтой, тохиромжгүй;
- Архитектур, орон зайн төлөвлөлт- ландшафтын хүчин зүйлсээр байгалийн болон хотын элементүүдийн шинж чанарт өндөр, дунд, доогуур гэсэн 3 шатлалыг баримтлан 3 баллын үнэлгээг тус тус өгсөн байна.

Зураг 72. Шинээр хот, суурин байгуулахад тохиромжтой газар



Хүснэгт 108. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ


Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	390639.13	26.11
Тохиромжгүй	15605.38	1.04
Дунд зэрэг тохиромжтой	322595.5	48.29
Тохиромжтой	367438.34	24.56

Одоогийн газар ашиглалтыг хасаж тооцоход сумын хэмжээнд шинээр хот суурин байгуулахад тохиромжтой газар 0.02 хувийг эзэлж байна.

Цаашид сумын төвийг суурьшлын болон түр суурьшлын бүс болгон тэлэх замаар хөгжүүлэхээр төлөвлөв. Гэр хороолол 139 га, жижиг дунд үйлдвэрийн бүс 2.4 га, захиргаа, соёл үйлчилгээний бүс 126.4 га, ногоон байгууламж, нийтийн талбай 5.7 га, орон сууцны нөөц газар 106.8 га, тариалангийн талбай 15.0 га, төлөвлөж буй гэр хороолол үйлдвэр

139.8га, нийтийн аж ахуйн бүс 5.4 га, худалдааны холимог бүс 0.5 га, эдэлбэр газартай амины орон сууцны бүс 415.3 га, эдэлбэр газартай амины орон сууцны нөөц бүс 30.7 га газар тус тус ТӨЛӨВЛӨВ.


Зураг 73. Сумын төвийн газар ашиглалтын бүсчлэлийн зураг



“Цагаан хад” гаалийн хяналтын бүс нь Ханбогд сумын Номгон багийн нутагт “Гашуун сухайт” хилийн боомтоос хойш 23 км-т байрладаг. Энд Таван толгойн уурхайгаас ачсан нүүрсийг буулгаж, дамжуулан ачих, гаалийн бүрдүүлэлт хийх үйл ажиллагаа явагддаг.

Энэхүү суурьшилын бүс нь улсын тусгай хэрэгцээний газартай давхцаж байна. Мөн Засгийн газраас 2017.08 сард “Цагаан хад” гаалийн хяналтын бүсийг татан буулгах шийдвэрийг гаргасан.


Зураг 74. Цагаан хад суурин газар нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцаж байгаа байдлын зураг



Гэвч орон нутгийн удирдлагын зүгээс “ Цагаан хаданд олон хүмүүс цуглардаг, гэмт хэрэг зөрчил гарах, хилээр хууль бусаар бараа бүтээгдэхүүн гаргадаг гэсэн үүднээс хаасан. Гэхдээ энэ асуудлыг цэгцлэх бүрэн боломжтой. Өмнө нь Засгийн газраас 30 хүний орон тоотой цагдаагийн хэлтэс байгуулах тогтоол гарсны дагуу цагдаагийн тасаг ажиллаж байна. Эмч, сувилагчдыг ажиллуулах төсөв нь батлагдсан. Багийн дарга нь томилогдсон гээд яг энэ асуудлуудыг шийдэхээр төлөвлөөд, ажлаа эхлүүлсэн” гэсэн мэдээллийг олон нийтэд өгсөн байна.

Мөн Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар, тухайн суурьшлын хэсэгт дахин төлөвлөлт, тохижилтын ажлын зураг төсөл боловсруулахаар ажиллаж байгаа учраас тус газарт дараах байдлаар газар ашиглалтын үүргийн бүсчлэлийн ерөнхий схемыг боловсруулав.

Зураг 75. Цагаан хад суурингийн газар ашиглалтын бүсчлэлийн зураг



Тухайн суурьшлын хэсэгт цаашид нийт 1554,67 га газрыг ашиглах бөгөөд их хэмжээний тоосжилт, хөрс бохирдолт үүсч байгаль орчин, оршин суугчдад маш их сөрөг нөлөө үзүүлдэг учраас талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх бодлого баримтлав.

Хүснэгт 109. Цагаан хад суурингийн газар ашиглалтын бүсчлэлийн талбайн хэмжээ

№	Газар ашиглалтын бүс	Талбайн хэмжээ
1	Суурьшлын бүс	458.39
2	Үйлдвэр, үйлчилгээний бүс	669.41
3	Орон сууц, олон нийтийн бүс	233.42
4	Зам, ногоон бүс	75.6
5	Ногоон байгууламж	7.51
6	Нийт	1444.33

Газар ашиглалтын үүргийн бүсчлэлийг одоогийн газар ашиглалт, газрын гадарга, салхины чиглэл, зам зэргийг харгалзан Хот байгуулалтын тухай хуульд заасан бүсчлэлийн дагуу ерөнхий байдлаар схемчлэн үзүүлэв. Тухайн газар ашиглалтын бүсчлэлийн хүрээнд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ба нэгж талбарын байршил, зам, ногоон

байгууламж, орц гарц болон бусад хот байгуулалтын асуудлуудыг нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх боломжтой.

Зам, ногоон бүс: Авто зам, явган хүний зам байх ба замын 2 талаар ногоон бүс байгуулна. Энэ нь гаалийн хяналтын талбайд хийх үйл ажиллагаанаас үүдэн гарах агаар, хөрсний бохирдлыг багасгах, суурьшлын бүсээс хязгаарлах үүрэгтэй.

Ногоон байгууламж: Олон нийтийн салхилах, чөлөөт цагийг өнгөрүүлэх хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд эерэг нөлөө бүхий ногоон бүрхэвч бүхий орон зай.

Орон сууц, олон нийтийн бүс: Суурьшлын бүс дэх албан контор, эмнэлэг, орон сууц, цэцэрлэг сургууль, бөөний ба жижиглэн худалдаа, үйлчилгээний газрууд, бизнесийн төв байна.

Суурьшлын бүс: Нам болон дунд давхарын орон сууц, хуваарьт эдлэнт хувийн сууц, гэр төлөвлөнө.

Үйлдвэр, үйлчилгээний бүс: Гаалийн хяналтын талбай, агуулахын зориулалттай барилга байгууламж, тэдгээрийн үйл ажиллагааг хангах инженерийн болон зам тээврийн дэд бүтцийн барилга байгууламжийг холбогдох норм ба дүрэмд заасны дагуу төлөвлөнө.

“Цагаан хад” суурьшлын бүсэд цаашид зохион байгуулах үйл ажиллагаа:

1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж үүний дагуу холбогдох арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авах.
2. Газрын төлөв байдал, чанарын хянан баталаагааг хийлгэх
3. Газар ашиглагч нартай гэрээ байгуулж, газрын төлбөр тооцох, газрыг нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээг тухай бүр авч байх.

4.7. ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ


Хувийн хэвшлийн хөрөнгөөр Өмнөговь аймгийн Оюутолгойн хатуу хучилттай нисэх буудал ашиглалтанд орсон бөгөөд нисэх буух зурвас нь хатуу хучилттай, агаарын тээврийн нислэгийн зурвас болон нислэгийн аюулгүй байдлыг хангах байгууламж бүхий нисэх буудал нь тус суманд байрладаг. Тус буудал газар нь нислэгийн стандартын дагуу байгуулагдсан учраас ашиглалт хамгаалалт нь сайн байна.

Оюутолгой-Гашуун сухайтын 90 км хатуу хучилттай замууд уул уурхайн тээвэрт ашиглагдаж байна. Оюутолгой-Ханбогд-Ханги чиглэл 435км, Оюутолгой-Ханбогд чиглэлийн 35 км хатуу хучилттай замуудыг төлөвлөгөөнд тусгасан байна.


Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

ХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 тоот тушаалаар батлагдсан “Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээний аргазүйн дагуу Ханбогд сумын шугаман байгууламж барьж байгуулахад тохиромжтой газрын үнэлгээг доорх үзүүлэлтүүдээр хийв.

Диagram 16. Шугаман байгууламжийн тохиромжтой байдлын үнэлгээний схем



Зураг 76. Авто болон төмөр замын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг



Хүснэгт 110. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

№	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Нэн хүндрэлтэй	95682.31	6.4
2	Хүндрэлтэй	600382.04	40.1
3	Хэвийн	800125.16	53.5

Тус сумын авто замын төлөвлөлтийг дараах байдлаар тусгав.

1. Монгол орны ихэнх аймгуудын адил энэ бүс нутгийн хувьд авто зам тэргүүн зэргийн ач холбогдолтой. Авто замын хэтийн хэрэгцээг төлөвлөхдөө “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтот суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод Мянганы замын хэвтээ, босоо тэнхлэгүүдийг барьж дуусгах, бүсийн болон аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай замаар, дараагийн шатанд өөр хооронд нь холбох” гэсний дагуу Өмнөговь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгаснаар төлөвлөлтийг хийлээ.

- Хатуу хучилттай авто замын 2015-2020 хэтийн төлөвлөлтөд:

- Оюутолгой-Ханбогд-Ханги чиглэл /Өмнөговь аймгийн уул уурхайн түүхий эдийг хилийн боомт хүргэх/435.0 км урт замын 77.98 км зам холбогдоно.

- Оюутолгой-Ханбогд /Оюутолгой, Ханбогд сум хооронд зорчиход хялбар болно/49.4 км урт зам холбогдоно.


- Манлай – Оюутолгой чиглэл 44.34 км зам холбогдоно.

2. Таван толгойн нүүрсийг БНХАУ болон гуравдагч зах зээлд нийлүүлэх шаардлагын дагуу Ухаа худаг-Гашуун сухайтын төмөр зам баригдаж байна. Энэ зам 2016 оноос ашиглалтанд орж тээвэр хийж эхлэхээр төлөвлөгдөж байна.

Шинээр баригдах төмөр замын зурвас газрын тооцоо үүнд:

- Ухаа худаг-Оюутолгой- Гашуун сухайт, нийт урт 270 км үүнээс118.3.км төмөр зам тавигдана.

Зураг 77. Авто замын төлөвлөлтийн зураг



Уул уурхайн үйл ажиллагааны улмаас шороон замын хэрэглээ хэт ихэссэнээр хөрсний элэгдэлд нөлөөлж байна. Тус суманд Гашуун сухайтын хилийн боомт байрлах бөгөөд Таван толгойн нүүрсний бүлэг орд, Оюутолгой болон усад уурхайгаас гарч буй нүүрс, зэсийн баяжмал болон бусад экспортын түүхий эдийг хилийн боомтоор гаргах зорилгоор хүнд даацын машинууд ердийн шороон замаар тээвэрлэлт хийж байна. Үүнээс болж малчин иргэдийн малын бэлчээр сүйдэх, говийн эмзэг хөрс, ургамал авто замын тоос шороонд дарагдан, хөрс их хэмжээгээр эвдэрч, ургамлын бүрхэвч өөрчлөгдөж, байгаль-экологи их хэмжээгээр сүйтгэгдэх болсноос гадна зэрлэг болон ховор ан амьтан орон нутгаас дайжих, хорогдох зэрэг сөрөг нөлөөлүүд гарсаар байна. Энэ ноцтой байдалд дүгнэлт хийж, уул уурхайн тээврийн авто замуудыг хатуу хучилттай болгох улмаар ихээхэн хэмжээний олборлолт хийж түүнийг авто тээврээр хийж байгаа уурхайн тээврийг /Таван толгой г. м./ төмөр замын тээврээр солих, түүнийг хөгжүүлэх ажил хийгдэж эхлээд байна. Мөн засгийн газраас “Таван толгой” уурхайгаас Гашуун сухайт боомт руу нүүрс тээвэрлэх хатуу хучилттай замаас шороон зам руу буух хэсгүүдийг хаасан. Шороон замаар нүүрс тээвэрлэхийг таслан зогсоохын тулд тус сумын удирдлага, албан хаагчид, малчид, иргэд, цагдаа хамтран ээлж ээлжээр эргүүлд гарах болжээ. Засгийн газрын ээлжит хуралдаанаар уртын урт буюу уурхайн амнаас шууд тээвэрлэн хилээр гардаг тээврийг цуцалж, урт-богинын тээвэрт шилжих шийдвэр гаргасан. Ханбогд сумын Засаг даргын Тамгын газраас мэдээлснээр ‘Оюутолгой’ компанид хүсэлт тавин, техник хэрэгслийн тусламж авч, малчидтай зөвлөлдөн нүүрс тээврийн зам дагуу гарц, малын гармуудыг хаахаар болжээ. Улмаар гарц, гармуудыг нүүрс тээврийн машин зорчихгүй байхаар хааж, шуудуу татан эргүүлийн пост ажиллуулж эхэлсэн байна.

4.8. ОЙН САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ


Ой тарьж ургуулахад тохиромжтой газар

Байгалийн ой ургах тохиромжтой газрын үнэлгээг хийхэд шаардагдах үндсэн хүчин зүйлүүдийг гадаргын төрх байдал, хөрсний физик - химийн шинж чанарын үзүүлэлт, газар ашиглалт зэрэг хүчин зүйлийн дотроос сонгон авч шалгуур үзүүлэлтийг боловсруулж өөрсдийн боловсруулсан арга зүйг бодит нөхцөлд туршин үзэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлсэн. **Үүнд:**


- *Гадаргын хүчин зүйлийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээг боловсруулах*
 - Гадаргын хэвгий
 - Зүг зовхис
 - Гадаргын өндөршил
- *Хөрсний физик-химийн хүчин зүйлийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээг боловсруулах*

- Хөрсний механик бүрэлдэхүүн
- Ялзмагт үеийн зузаан
- Хөрсний ус нэвчүүлэх чадвар
- Хөрсний ялзмагийн агууламж
- Хөрсний урвалын орчин
- Кальцийн карбонат
- Хөрсний цахилгаан дамжуулах чадвар
- Хөрсний чийг
- Газар ашиглалтын нөхцөл
 - Хот суурины эдэлбэр газар
 - Тариалангийн газар
 - Ашиглаж буй уул уурхайн газар
 - Зам шугам, сүлжээний газар
 - Гол горхи, нуур
 -

Диаграм 17. Ой тарьж ургуулахад тохиромжтой байдлын үнэлгээний схем



Зураг 78. Ойн сангийн тохиромжтой газрын нэгдсэн үнэлгээ




Хүснэгт 11. Ойн сангийн тохиромжтой газрын талбайн хэмжээ

№	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	650,900.92	23.26
2	Тохиромжгүй	2,142,031.5	76.54
3	Хязгаарлагдмал тохиромжтой	5,683.7	0.20
4	Тохиромжтой	0	0.00
5	Нийт талбай	2,798,616.2	100.00

Ой тарьж ургуулахад тохиромжтой газрын нэгдсэн үнэлгээний үр дүнгээс одоо ашиглагдаж байгаа газар ашиглалтын суурь нөхцөлүүдийг хасаж тооцоо хийхэд Ханбогд сумын нийт нутаг дэвсгэрт ой тарьж ургуулахад тохиромжтой газар байхгүй, 0.2 хувь хязгаарлагдмал тохиромжтой, 76.5 хувь нь тохиромжгүй байна.

Зураг 79. Хамгаалах ой бүхий газар




4.9. УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

Уул уурхайн олборлолт, уур амьсгалын өөрчлөлтөөс болж зарим булаг шанд ширгэж үгүй болж гадаргын усны нөөц багасаж байна. Мөн малчид мал услах задгай усгүй болж байгааг дурьдсан бөгөөд уг төлөвлөгөөгөөр булаг шандыг хашиж хамгаалах талаар тусгаж байгалийн тэнцвэрт байдлыг хадгалах зайлшгүй шаардлагатай байгаа тул дараах арга хэмжээг төлөвлөв. Усны асуудал эрхлэсэн нэгжээр дамжуулан гадрагын болон гүний усны нөөц, ашиглалт, бохирдолтод хяналт, мониторинг хийх шаардлагатай дээр ажиллагаатай болон ашиглалтгүй эвдэрсэн, ундарга багассан худгийн тооллогийг төлөвлөх шаардлагатай байна. Өмнөговь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тус сумын 22 булгийг хамгаалалтад авахаар төлөвлөсөн бөгөөд Дэрсэн хөв гэсэн газрыг хөв байгуулах боломжтой гэж төлөвлөсөн байна. Бид энэхүү тайланд дараах байдлаар төлөвлөв.

- Гадаргын усны хамгаалалтын бүсүүдийг татаж өгөх;
- Иргэдийн санал хүсэлтийг үндэслэн бэлчээрийн газрын дарагдсан худгуудыг сэргээн засварлах;
- Оюутолгойн уурхайн ашиглалтын зориулалтаар ашигласан усаа 80 хувийг буцаан ашигладаг гэж тайлан гаргадаг. Үүнийг нарийвчлан шалгаж хяналт тавих;

- Гүний хоолой орчмын гоожиж буй бүх цооногуудыг бөглөж багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж малчдаас ирсэн хүсэлтэд тулгуурлан оргилж буй 2 цооногуудыг малчдын ахуйн зориулалтаар ашиглуулах;
- Гүний хоолой Галбын говь дах Оюутолгойн усны хайгуулын цооногуудаас орон нутгийн малчдын бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар ашиглах боломжтой 12 цооногийг Ханбогд суманд хүлээлгэн өгч цаашид уул уурхайн зориулалтаар ашигласан цооногуудын үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- Урд урдын хийсэн Оюутолгойн цооногийн судалгаануудаас гүний хоолой шүүрэлттэй гарсан бөгөөд битүүмжлэх ажил явагдаж байгаа. Энэ нь хайгуулын болон мониторингийн цооногууд нь бүтэцийн хувьд буруу хийгдсэн /цементээр хийгдэх ёстой байтал хайргаар дүүргэсний улмаас хөрсөн доорх гүехэн усыг гүнрүү шүүрүүлэх алдаа гаргасан/ бөгөөд битүүмжилж эхлээд байна. Үүнийг стандарт технологийн дагуу хийх шаардлагатай.
- Мөн Оюутолгойн бүх цооногуудад шинжилгээ хийгдээгүй байна. Энэ нь малчдын ундны усыг хөрсний гүнрүү алдуулж болзошгүй юм. Иймээс яаралтай цооногийн үнэлгээ хийх шаардлагатай. Мөн усны нөхөн олговрыг тооцуулах хэрэгтэй.

Зураг 80. Усан сан бүхий газрын төлөвлөлтийн зураг



4.10. ГАЗАР, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ


“Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь 2010-2020” аймгийн хөгжлийн хөтөлбөрт дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

- ✓ Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг дахин хийх;
- ✓ Байгаль хамгаалж, байгалийн нөөцийг зохистой ашиглахад чиглэгдсэн малчдын бүлэг, хоршооны үйл ажиллагааг дэмжих;
- ✓ Хот орчмын газрын менежментэд тоосжилт, түүнийг бууруулах талаар зорилтууд тусгаж, хэрэгжүүлэх;
- ✓ Ашигт малтмалын хайгуул, олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхлэх үед бий болдог хөрсний бохирдлын хэмжээг багасгах, нөхөн сэргээлт хийх;
- ✓ Ургамалын нөмрөгийн хамгаалалтыг байгалийн бүслүүр, тусгай хамгаалалттай газрын хил, бэлчээрийн газрын ангилалтай уялдуулан хамгаалах арга хэмжээг төлөвлөх;

Өмнөговь аймгийн хөгжлийн хөтөлбөрт заасан арга хэмжээний хүрээнд дараах байдлаар газар, байгалийн нөөцийг хамгаалахаар төлөвлөв.

1. Малчдын бүлэг, хоршооны үйл ажиллагааг дэмжиж газар, байгалийн нөөцийг ашиглах зүй ёсны эрхийг баталгаажуулах замаар байгалийн баялаг, газар нутгаа хамгаалах.
2. Уул уурхайн эдэлбэр газарт хянан баталгаа, биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх


Зураг 81. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг



Хүснэгт 112. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ


№	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	119800208.0	80
2	Хадгалан хамгаалахад тохиромжтой газар	300339.8	20
3	Нийт талбай		100

Зураг 82. Нөхөн сэргээлт хийх газар



Ханбогд сумын хувьд усны эдврэлтэй, бохирдсон, элсний нүүлттэй газруудад нөхөн сэргээлт хийх шаардлагатай байна. Газар ашиглалтын зориулалт бүрээр хамгаалалтын бүсийг **ТӨЛӨВЛӨВ.**

Зураг 83. Хамгаалалтын бүсийн төлөвлөлтийн зураг



Хүснэгт 13. Хамгаалалтын бүсийн хэмжээ, талбайн хэмжээ

Хамгаалалтын бүс	Хамгаалалтын бүсийн өргөн	Талбай, га	Үндэслэл
Булгийн онцгой хамгаалалтын бүс	50 м	88.3	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам. 2009 он.
Булгийн энгийн хамгаалалтын бүс	200 м	1266.7	
Голын онцгой хамгаалалтын бүс	50	559.1	
Голын энгийн хамгаалалтын бүс	200	1615.3	
Нуурын онцгой хамгаалалтын бүс	100 м	454.6	
Нуурын энгийн хамгаалалтын бүс	200 м	153.9	
Худгийн эрүүл ахуйн хориглох бүс	50 м	518.8	
Худгийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүс	200 м	7285.3	
Хамгаалалтын бүсийн ой	Тусгай хамгаалалтай газарт байгаа ой	621809.0	Ойн тухай хууль, 2012 он
Эрчим хүчний шугамын хамгаалалтын зурвас	15 м	389.3	Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм. Засгийн газрын 1996 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт


4.11. ГАЗАР, БАЙГАЛИЙН НӨӨЦ ЭДЭЛБЭРИЙН ЗҮЙ ЁСНЫ ЭРХ

Байгалийн нөөц баялаг, газар нутгийн онцлог, иргэдийн саналыг харгалзан дараах төрлийн газар, байгалийн нөөц ашиглалтын зүй ёсны эрхийг¹ бий болгохоор төлөвлөв.

Хүснэгт 114. Бий болох зүй ёсны эрх

№	Багийн нэр	Газрын нэр	Зориулалт
1	Жавхлант, Номгон	Галбын говь орчим	Монгол бүйлс, Грубовын хөөндий, Феддийн аргамжин цэцэг, Танамал махирс. Говийн хотир
2	Гавилуут	Номгон уулын ар хөндий, Дайчингийн заг	Потаниний улаан тулам


Зураг 84. Зүй ёсны эрх



¹Газар, байгалийн нөөц ашиглах зүй ёсны эрх гэж уламжлалт мал аж ахуйд голлон түшиглэж тухайн нутаг дэвсгэр дахь байгалийн бүхий л төрлийн нөөцийг түүний нөхцөлд дасан зохицож, арвижуулан, өсгөж, хамгаалж зүй зохистойгоор хэрэглэж ирсэн хараахан баталгаажаагүй байгаа уламжлалт эрх, албан бус эрх (төрийн болон иргэдийн хэрэглэж буй эрхүүд), тэдгээрийн дагалдах эрхүүдийг ойлгоно.

4.12. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

Зураг 85. Дүйцүүлэн хамгаалах газар



Хүснэгт 115. Дүйцүүлэн хамгаалах газар

№	Аргачлал	Газрын нэр	Хэмжээ, га
1	Дүйцүүлэн хамгаалах	Говийн бага "В" өргөтгөл	74547.8
2		Шанхайн нуруу	24055.66
3		Говийн бага "А" өргөтгөл	107990.2
4	Эрдэмтэдийн тогтоосноор	Галбын говь	686639

**АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ**

1. Аваадорж Д. Хөрс судлал. 2014 он, УБ.
2. Ариунсүрэн П., Миеэсүрэн Ж., Адъяасүрэн Б. Их газрын чулуу” Байгалийн Цогцолборт газрын ургамалжлын судалгааны тайлан. –Улаанбаатар,2014; -93 х.
3. Б.Баянхишиг, Г.Дугаржав, Д.Нямсамбуу, Х.Цэнд-Аюуш. Цөлжилттэй тэмцэх арга судалгааны тайлан. – Улаанбаатар, 2006, -150 х.
4. Буян-Орших Х. Геоботаник, геоботаникийн судалгааны арга зүй. –Улаанбаатар,2005; - 110 х.
5. БНМАУ-ын Байгалийн үнэлгээ. ШУА-ийн Газарзүй цэвдэг судлалын хүрээлэн, Улаанбаатар, 1984.
6. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндэсний Атлас. –Улаанбаатар,1990; - х. 66-68.
7. Базаргүр Д. Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй. 1998 он, УБ.
8. Грубов В.И. Монголын гуурст ургамал таних бичиг. – Улаанбаатар: 2008. - 502 х.Бэлчээр судлал 50 жилд. –Улаанбаатар,2011; -345 х.
9. Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага-MNS 5546:2005” стандарт. –Улаанбаатар,2005; -15 х.
10. Бадарч Н. Монгол орны уур амьсгал. 1971 он, УБ.
11. Доржготов.Д. Монгол орны хөрс. 2003 он, УБ.
12. Доржготов Д., Батбаяр Д.БНМАУ-ын хөрсний ангилал зүй. 1986 он, УБ.
13. Доржготов Д. Монгол орны хөрс-газарзүйн мужлал.1976 он,УБ.
14. Жамбаажамц Б. Монгол орны газарзүйн асуудлууд. 1964 он, УБ, 100 хууд.
15. Жамбаажамц Б. Монгол орны уур амьсгал. 1989 он, УБ.
16. Жигжидсүрэн С., Дуглас А.Жонсон. Монгол орны малын тэжээлийн ургамал. – Улаанбаатар,2003; -563 х.
17. Жигжидсүрэн С. Бэлчээрийн менежмент. –Улаанбаатар, 2005; - 266 Х.
18. Жигжидсүрэн С. Бэлчээр ашиглах алтан дүрэм. –Улаанбаатар, 2011; - 70 Х.
19. ШУА. Газарзүйн хүрээлэн, Монгол улсын үндэсний атлас. 2009
20. Монгол орны ашигт ургамлын зурагт лавлах. –Улаанбаатар: 2003. –257 Х.
21. Монгол орны ашигт ургамлын зурагт лавлах. –Улаанбаатар: 2005. –240 Х.
22. Монгол орны нэн ховор ургамлын зурагт лавлах. –Улаанбаатар: 2008. –209 Х.
23. Монгол орны ховор ургамлын зурагт лавлах. –Улаанбаатар: 2009. –388 Х.
24. Монгол улсын Улаан ном. - Улаанбаатар: 2013. – х. 269-445.
25. Монголын ургамлын Улаан данс, -Улаанбаатар. 2012, х.

26. Монгол орны газарзүйн асуудал. ШУА-ийн Газарзүй цэвдэг судлалын хүрээлэн, улаанбаатар, 1975.
27. Мөнхөө Н., Энхмаа Б., Болормаа Д. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт хийж, үр дүнг үнэлэх заавар. - Улаанбаатар. 2013. – 36 б.
28. Мягмарсүрэн Д., Намхай Н. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг. - Улаанбаатар. 2012: -Х 407.
29. Монгол Улсын Статистикийн хороо. Монгол Улсын статистикийн эмхэтгэл. 2010-2016 он, УБ.
30. Өлзийхутаг Н. Монгол орны ургамлын аймгийн тойм. –Улаанбаатар, 1989. – 208 х.
31. Өлзийхутаг Н. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын бэлчээр дэх тэжээлийн ургамал таних бичиг. –Улаанбаатар, 1985. – 556 х.
32. Нансалмаа Ч. Өмнөговь аймгийн уур амьсгал. Улаанбаатар, 1977.
33. Нямхүү М. Бэлчээр ашиглалт болон бэлчээрийн ачааллыг тооцоход газрын гадаргын онцлогийг харгалзан үзэх нь. 2015 он, УБ.
34. Өмнөговь аймгийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөний суурь тайлан, 2014
35. Өлзийхутаг.Н. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын бэлчээр, хадлан дах тэжээлийн ургамал таних бичиг. 1985 он, УБ.
36. Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гурван талт зөвлөл ОТМШБ, ХШБ-ийн судалгааны эцсийн тайланг. 2017. Монгол Улс Өмнөговь аймаг Ханбогд сум
37. Өмнөговь аймгийн Ханбогд сум “ Эко галба” ТББ “Маунтэйн хантинг” ХХК “Цанхи” Агнуурын бүс нутгийн нарийвчилсан агнуур зохион байгуулалт, 2017.
38. Пүрэвцэрэн Г. Газрын Сангийн Менежмент. 2000 он, УБ, 36-45 хууд.
39. Цэрэнбалжид Г. Монгол орны хөл газрын ургамлын өнгөт цомог. –Улаанбаатар, 2002. – 251 х.
40. Цэгмэд Ш. Монгол орны физик газарзүй. 1986 он, УБ, 67-90 хууд.
41. Цэрэндаш С., Алтанзул Ц. Бэлчээрийн газрын менежментийн гарын авлага. 2013 он, УБ.
42. Цэрэндаш С., Алтанзул Ц. Бэлчээрийн менежментийн гарын авлага. 2006 он, УБ, Хуудас 13-22.
43. Чогний О. Монголын нүүдлээр ашиглагдсан бэлчээрийн өөрчлөгдөх, сэргэх онцлог. 2001 он, УБ.
44. Цэрэндаш С. Бэлчээр ашиглах онолын үндэс (Тэргүүн дэвтэр). —Улаанбаатар,, 2006; -96Х.
45. Цэрэндаш С., Алтанзул Ц. Бэлчээр ашиглах онолын үндэс (II дэвтэр). –Улаанбаатар,, 2006; -52Х.

46. Цэрэндаш С., Алтанзул Ц., Ариунболд Ц. Тэжээлийн зарим ургамлын өнгөт цомог. – Улаанбаатар,, 2007; -247Х.
47. Цэрэндулам Р. Монгол орны малын тэжээл. –Улаанбаатар, 2011; -276Х.
48. Цэгмид Ш. Монгол орны физик газарзүйн мужлалт. –Улаанбаатар,; 1969. -301-304 Х.
49. Ундай Голын Гольдролыг Өөрчилсөн талаарх Хөндлөнгийн шинжээчдийн багийн 1-р шатны тайлан. 2015 он. Ханбогд сум, Монгол Улс.
50. Юнатов А.А. БНМАУ-ын хадлан бэлчээр дэх тэжээлийн ургамлууд. – Улаанбаатар,1954; -309 Х.
51. Юнатов А.А. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ургамлан нөмрөгийн үндсэн шинжүүд. –Улаанбаатар,1978; -203 Х.


Гадаад хэвлэл

52. Proceeding of the international conference., Ecosystems of Central Asia under current conditions of socio-economic development 8-10 September, 2015, Ulaanbaatar, Mongolia.
53. Ronald R. Rindfuss, Stephen J. Walsh, B.L. Turner II, Jefferson fox, and Vinod Mishra. Developing a science of land change: Challenges and methodological issues. PNAS. 2004, Vol. 101, No. 39, p 13976-13981.
54. Y. Shi, F. Baumann, Y. Ma, C. Song,*, P. K`uhn, T. Scholten, and J.-S. He., Organic and inorganic carbon in the topsoil of the Mongolian and Tibetan grasslands pattern, control and implications., Biogeosciences, doi:10.5194/bg-9-2287-2012.
55. Wakene Negassa Chewaka, Heluf Heluf Gebrekidan. The Impact of Different Land Use Systems on Soil Quality of Alfisols of Western Ethiopia., Deutscher Tropentag, 2004, October 5-7, Berlin.
56. Willy Verheye. Land use management. Land use, land cover and soil sciences. 2006, Vol. IV.
57. <http://www.definitions.net/definition/landxuyвь20use>

ХАВСРАЛТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын ургамлын аймагт бүртгэсэн бэлчээрийн ба эмийн ургамлын жагсаалт, 2017 он

БЭЛЧЭЭРИЙН УРГАМАЛ	
Gramineae Juss. Хялгана овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p><i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i></p> <p>Gramineae Juss. Хялганы овог</p> <p>Дэрсний төрөл (<i>Achnatherum</i> P. B.)</p> <p>Зүйл: <i>Achnatherum splendens</i> (Trin.) Nevski-Гялгар дэрс</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Нягт том дэгнүүлтэй, иш 3 үетэй, 50-250 см эгц шулуун, навч шугамархуу, доод гадаргуу нь гөлгөр, хэлхэн 1-7 мм урт, сийрэгдүү саглагар залаа баг цэцэгтэй, түрүүхэйдээ нэг цэцэгтэй, цэцгийн доод хайрс 5-11 мм урт сортой. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Ургамал газар зүйн бүх тойрогт. Өмнөговь дахь тархалт: Мандал-Овоо сумын Ханан уул. Ургах орчин: Марзаг элс, хужирлаг тойром, гол горхи, булаг шандны хөвөө, хотос цайдамд ургана. Ашигт чанар: Жилийн дөрвөн улиралд таван хошуу мал, ялангуяа адуу, үхэр, тэмээ маш сайн иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Хужир мараалаг хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p><i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i></p> <p>Gramineae Juss. Хялганы овог</p> <p>Хялганын төрөл (<i>Stipa</i> L.)</p> <p>Зүйл: <i>Stipa glareosa</i> P.Smirn.-Сайрын хялгана</p> <p>Статус: Элбэг ургамал.</p> <p>Биологийн онцлог: 10-15 см өндөр иштэй, сахлаг үндэстэй, жижиг шигүү бутаар ургадаг, хуурайсаг ургамал. Навчны илтэсний ар нь сийрэг өргөсөнцөрийн улмаас ширүүн, шивээний сор 4,5-7 см урт, нэг нугархай, доод ба дээд нугархай нь бүхэлдээ 5 мм өдөрхүү урт үстэй, Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Өмнөговь дахь тархалт: Бүх сумын нутагт тархана. Ургах орчин: Хайргархаг ба элсэрхэг тэгш тал, уул толгодын чулуурхаг хажуу, бэл хормойгоор ургана. Ашигт чанар: Жилийн дөрвөн улиралд таван хошуу мал маш сайн иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн чулуурхаг бор, цайвар бор хөрсөнд.</p>

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)</p> <p><i>Gramineae</i> Juss. -Үетэний овог</p> <p>Хазаар өвсний төрөл (<i>Cleistogenes</i> Keng.)</p> <p>Зүйл: <i>Cleistogenes squarrosa</i> (Trin.)Keng.-Дэрвээн хазаар өвс</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Элсэн дугтуй бүхий сахлаг үндэстэй, жижиг сийрэг бутаар ургадаг, иш 5-10 үетэй, 15-30 см өндөр, навч хавтгай шугаман, юлдэрхүү, ширүүн, залаа баг цэцэг нь 5-7 см, 3-10 мм өргөн, түрүүхэй 2-4 цэцэгтэй, бор ногоон өнгөтэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.</p> <p>Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт. Өмнөговь дахь тархалт: Цогтцэцийд. Ургах орчин: Уулын чулуурхайг хайргархаг хажуу, хээр талаар ургана. Ашигт чанар: Тэмээнээс бусад мал зундаа сайн иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Хайргархаг бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)</p> <p><i>Gramineae</i> Juss. -Үетэний овог</p> <p>Хазаар өвсний төрөл (<i>Cleistogenes</i> Keng.)</p> <p>Зүйл: <i>Cleistogenes songorica</i> (Roshev.) Ohwi.-Зүүнгарын хазаар өвс</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Элсэн дугтуй бүхий сахлаг үндэстэй, жижиг нягт бутаар ургадаг, иш 7-9 үетэй, 15-60 см өндөр, навч хавтгай шугаман, ирмэгүүд нь дотогшоо хумираа, залаа баг цэцэг нь сийрэг, түрүүхэй 2-6 цэцэгтэй, хүрэн бор өнгөтэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алт.өвөр., Зүүнгар., Алаш. Өмнөговь дахь тархалт: Баруун сайханд. Ашигт чанар: Жилийн аль ч улиралд бод мал дунд, бог мал сайн иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Хайргархаг бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)</p> <p><i>Gramineae</i> Juss. -Үетэний овог</p> <p>Биелэгийн төрөл (<i>Poa</i> L.)</p> <p>Зүйл: <i>Poa botryoides</i> Trin.-Цацаглаг биелэг өвс</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Газар доор мөлхөө найлзуургүй, нягт дэгнүүл үүсгэдэг, иш 25-55 см өндөр ургадаг, 3 хүртэл цөөн үетэй, ишний 1/2-1/4 хүртэл навчтай, навч нарийн шугаман, хумираа, навчны хэлхэн 1-2 мм урт, давхар шүдлэг, залаа урт нарийн, шигүү, хүрэн ягаан туяатай ногоон, цэцгийн доод хайрс 5 бүдэг судалтай, хянга 1/2, захын судал 1/3 хүртэл богино зөөлөн үслэгтэй, каллус цөөн урт багц үстэй, амуу жимстэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хевс., Хэнт., Ханг., Монг. Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар. Өмнөговь дахь тархалт: Их Шанхын нуруунд,Зүүнсайхан, Дундсайханд. Ургах орчин: Уулын чулуурхайг хайргархаг хажууд ургана. Ашигт чанар:</p>

	<p>Бог мал хавар сайн, зун дунд зэрэг, адуу, үхэр зун сайн иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Уулын цайвар хүрэн хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i></p> <p>Gramineae Juss. -Үетэний овог</p> <p>Ерхөгийн төрөл (<i>Agropyron Gaertn.</i>)</p> <p>Зүйл: <i>Agropyron cristatum (L.) P.V.-Саман ерхөг</i></p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Сахлаг үндэсний системтэй, иш 25-75 см өндөр, сийрэг дэгнүүлтэй, ишиндээ 2-3 үетэй, навчис цөөн, нарийн шугаман, ихэвчлэн ишний уг орчимд байрладаг, навчны өвөр тал сийрэг зөөлөн үстэй, ардаа үсгүй, сам хэлбэрийн нийлмэл түрүү баг цэцэгтэй, нэг түрүүхэндээ 3-7 цэцэгтэй, түрүү, түрүүхэй, цэцгийн доод хайрс ноосорхог үсжилттэй, амуу жимстэй. Монгол дахь тархалт: Хевс., Хэнт., Ханг., Монг. Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их.н., Олон.н., Дорн говь., Говь-Алт., Зүүнгар., Алт.Өвөр. Өмнөговь дахь тархалт: Их Шанх., Сэврэй уул. Ургах орчин:Тэгш тал, хуурай нуга, элс, чулуурхаг хажуу, эргийн хайрга, байц хадны ёроолоор ургана. Ашигт чанар: Адуу, бог мал хавар маш сайн, бүх төрлийн мал бусад улиралд сайн иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Уулын цайвар хүрэн хөрсөнд</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i></p> <p>Gramineae Juss. -Үетэний овог</p> <p>Ерхөгийн төрөл (<i>Agropyron Gaertn.</i>)</p> <p>Зүйл: <i>Agropyron desertorum (Fisch. Ex link.) Schult.- Цөлийн хиаг</i></p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Сахлаг үндэсний системтэй, иш 20-50 см өндөр, нягт дэгнүүлтэй, иш 3 үетэй, навчис шугаман, үсгүй, ширүүн, богино бортого хэлбэрийн нийлмэл түрүү баг цэцэгтэй, нэг түрүүхэндээ 3-7 цэцэгтэй, цэцгийн доод хайрс 2-5 мм урт сортой, амуу жимстэй.</p> <p>Монгол дахь тархалт: Ханг., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Олон.н., Дорн говь., Говь-Алт.</p> <p>Өмнөговь дахь тархалт: Цогтцэцийд Ургах орчин:Шаварлаг чулуурхаг хөрстэй газарургана. Ашигт чанар: Бүх төрлийн мал бусад улиралд маш сайн иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн бор хөрсөнд</p>

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)</p> <p><i>Gramineae</i> Juss. -Үетэний овог</p> <p>Эмзэг түрүүн төрөл (<i>Psathyrostachys</i> Nevski.)</p> <p>Зүйл: <i>Psathyrostachys juncea</i> (Fisch.) Nevski.-Гололждуу эмзэг түрүү</p> <p>Биологийн онцлог: Тархалт: Ханг., Ховд., Монг.-Алт., Их. н., Дорн. Говь, Говь- Алт., Зүүнгар, Алт. Өвөр.. Өмнөговь дахь тархалт: Манлай сумын худаг. Ургах газар, орчин нөхцөл: Хээржүү бэл, чулуурхаг хажуу, элс, хайрга, цайдам, заримдаа булаг шанд, зам дагуу ургана.Ашигт чанар: Хавартаа үхэр маш сайн, адуу, тэмээ сайн, бусад улиралд мал дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Татмын нугын хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)</p> <p><i>Gramineae</i> Juss. -Хялгана овог</p> <p>Сульхиагын төрөл (<i>Elymus</i> L.)</p> <p>Зүйл: <i>Elymus secalinus</i> (George) Bobr. -Хөх тариархуу цагаан суль</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Сийрэг дэгнүүл үүсгэдэг, бүдүүн иштэй, шугамархуу шулуун навчтай, том бүдүүн түрүү баг цэцэгтэй, түрүүхэй дунд хэсэгтээ 4-6, дээд ба доод хэсэгтээ нэг дороосоо 2-3-аараа гардаг, түрүүхэйн хайрс шугаман юлдэрхүү хэлбэртэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.</p> <p>Монгол дахь тархалт: Ханг., Хянг., Ховд., Дунд. Халх., Дорн. Монг., Их.н., Олон.н., Дорн говь., Говь-Алт.</p> <p>Өмнөговь дахь тархалт: Мандал-Овоо сумын Ханан уулын сайраар. Ургах орчин: Элсэрхэг хөрстэй нугад ургана. Ашигт чанар: Аль ч улиралд бод мал сайн, бог мал дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Элсэрхэг бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)</p> <p><i>Gramineae</i> Juss. -Үетэний овог</p> <p>Түнгийн төрөл (<i>Leymus</i> Hochat.)</p> <p>Зүйл: <i>Leymus chinensis</i> (Trin.) Tzvel.- Нангиад түнгэ</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Үндэслэг иштэй, сийрэг дэгнүүл үүсгэдэг, шугамархуу шулуун навчтай, 15 см хүртэл урттай түрүү баг цэцэгтэй, түрүүхэй 1-2 (3), цэцгийн доод хайрс үсгүй юмуу богино өргөсөнцөртэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.</p> <p>Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. –Даг., Хянг., Дунд. Халх., Дорн. Монг., Их.н., Олон.н., Дорн говь., Говь-Алт. Өмнөговь дахь тархалт: Ханбогд сумын Бага мод. Ургах орчин: Нуга, цайдам,</p>

	<p>элс хайргатай тойромд ургана.</p> <p>Ашигт чанар: Бүх төрлийн мал өвөл дунд зэрэг, адуу, үхэр хавар, зун маш сайн, тэмээ, бог мал сайн иднэ.</p> <p>Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Тойром цайдамын элсэрхэг хөрсөнд</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)</p> <p><i>Gramineae</i> Juss. -Үетэний овог</p> <p>Түнгийн төрөл (<i>Leymus</i> Hochat.)</p> <p>Зүйл: <i>Leymus racemosus</i> (Lam.) Tzvel. -мөчирлөг түнгэ</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Үндэслэг иштэй,сийрэг дэгнүүл үүсгэдэг, бүдүүн иштэй элсний ургамал. Шугамархуу шулуун 4-15 см өргөн навчтай, 10-35 см хүртэл урттай бүдүүн түрүү баг цэцэгтэй, түрүүхэй 3 –аараа , дунд хэсэгтээ 4-6 -аараа гардаг, цэцгийн дээд хайрсны хянга нүцгэн, гөлгөр эсвэл жижиг ргөсөнцөртэй.</p> <p>Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.</p> <p>Монгол дахь тархалт: Ханг., Дунд. Халх., Их.н., Олон.н., Дорн говь., Говь-Алт., Дорн. говь. Өмнөговь дахь тархалт: Ханбогд сумын Булан сухайт.</p> <p>Ургах орчин: Элсэрхэг хээрт ургана.</p> <p>Ашигт чанар: Бод мал аль ч улиралд сайн, бог мал муу иднэ.Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Элсэрхэг хөрсөнд</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)</p> <p><i>Gramineae</i> Juss. -Хялгана овог</p> <p>Хианы төрөл (<i>Elytrigia</i> Desv.)</p> <p>Зүйл: <i>Elytrigia repens</i> (L.) Desv. ex Nevski.-Мөлхөө хиаг</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог:Урт мөлхөө найлзууртай, 20-100 см өндөр ургадаг, навчис тэнэгэр хавтгай, өргөн шугамархуу, түрүүхэйн хайрс хөх ногоон, 3-7 тод судалтай, түрүү бүортгорхуу, түрүүхэйнүүд жид цувраа байрлалтай.</p> <p>Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар, Алт. –өвөр. Өмнөговь дахь тархалт: Их Шанхын нуруунд, Зүүн сайхан, Дунд Сайхан, Баруун Сайханд. Ургах орчин: Нугархаг хауу хээрээр ургана. Ашигт чанар: Үхэр хавар маш сайн, өвөл дунд зэрэг, адуу, бог мал, тэмээ аль ч улиралд сайн иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Уулын цайвар хүрэн хөрсөнд.</p>
<p>Cyperaceae Juss. - Улалжийн овог</p>	



	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)</p> <p><i>Cyperaceae</i> Juss. - Улалжийн овог</p> <p>Улалжийн төрөл (<i>Carex</i> L.)</p> <p>Зүйл: <i>Carex stenophylloides</i> V.Krecz.-Утсан навчит улалж</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Урт нарийхан үндэслэг иштэй, навчис нарийхан, өтгөн багц найлзуур үсгэдэг, түрүүнцэр нарийн, уутанцар өргөн өндгөрхүү бөгөөд ажжим нарийссан шонтонтой, судалтай, шадар хайрс бор хүрэн.</p> <p>Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Монг.-Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн.говь., Говь –Алт., Алт-Өвөр., Алаш. Өмнөговь дахь тархалт: Тавантолгой, Хонгорын элсэнд. Ургах орчин: Элсэрхэг газар, хээржүү элсэрхэг цөл, уулын хээр, нам дор газрын марзлаг нугад ургана. Ашигт чанар: Зун, өвөл бог мал сайн, адуу дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Элсэнд ургана.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)</p> <p><i>Cyperaceae</i> Juss. - Улалжийн овог</p> <p>Улалжийн төрөл (<i>Carex</i> L.)</p> <p>Зүйл: <i>Carex duriuscula</i> С.А.Мей.-Ширэг улалж</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Урт нарийхан үндэслэг иштэй, өтгөн багц найлзуур үсгэдэг, түрүүнцэр нарийн, уутанцар өргөн өндгөрхүү, шадар хайрс цайвар хүрэн.</p> <p>Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.</p> <p>Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт, Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн.говь., Говь –Алт. Өмнөговь дахь тархалт: Цогт-Овоод, Зүүн сайханы ар хажуугаар. Ургах орчин: Элсэрхэг газар, хээржүү хажууд ургана. Ашигт чанар: Зун, намар адуу, бог мал маш сайн, үхэр сайн, тэмээ дунд зэрэг иддэг. Хөрс хучигч ургамал. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн бор хөрсөнд</p>
<p><i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)</p> <p><i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог</p> <p>Тэсэгийн төрөл (<i>Eurotia</i> Adans.)</p> <p>Зүйл: <i>Eurotia ceratoides</i> (L.) С.А.Мей-Орог тэсэг</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Сууриасаа эхрэн өтгөн салаалсан, нэг наст найлзуур өтгөн эсгийлэг үсээр хужигдсан, навчис сууриадаа шаантгархуу юмуу дугуй, юлдэрхүү хэлбэртэй, мөчрийн үзүүрт байрлах түрүүрхүү баг цэцэг нь сэгсгэр урт зөөлөн цайвар үслэгтэй, үр жимс урт багц үстэй. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөг. Тархалт: Хөвс., Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Дунд.</p>

	<p>Халх., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алт.-өвөр., Алаш., Ургах орчин: Элс хайргархаг тэгш талаар ургадаг сөөгөрхөг цөлийн шинж бүрдүүлэгч ургамал. Ашигт чанар:Жилийн дөрвөн улирлын турш бүх төрлийн мал иддэг, сайн чанартай тэжээлийн ургамал. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар саарал хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Chenopodiaceae Vent. - Луулийн овог</i> Баглуурын төрөл (<i>Anabasis L.</i>) Зүйл: <i>Anabasis brevifolia</i> С.А.Меу.-Ахар навчит баглуур Статус: Элбэг Биологийн онцлог: Модожсон, дээд хэсгээрээ салаалсан иштэй, бутархуу жижигхэн дэгнүүл үүсгэдэг ургамал, бүх навчис булцгар бөөрөхий бөгөөд унамтгай, өргөс хатгууртай, ишний дээд ба дунд хэсгийн навчис 100 мм хүртэл урт, доош нугарсан, хамгийн доод навчис хайрсархуу, ишээдээ налсан, цэцэг нь навчиб өвөрт 1-3-араа байрласан, шадар эрхтэн жимслэх үедээ хурц улаан шар өнгийн далбантай болдог. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр. Тархалт: Ховд., Монг.-Алт., Их н., Олон н., Дорн.-Говь., Говь-Алт., Зүүнгар, Алт.өвөр, Алаш. Өмнөговь дахь тархалт: Бүх сумдын нутагт тархана. Ургах орчин: Хайргархаг тэгш тал,, сайрын ёроол, уул толгодын хээрийн бутарамхай чулуурхаг хажууд Ашигт чанар: Тэмээ жилийн турш сайн иддэг. Бусад мал их идвэл хортой. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Чулуурхаг бор, бор саарал хөрсөнд.</p>
Rosaceae Juss. - Сарнайн овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Rosaceae Juss. - Сарнайн овог</i> Бүйлэсний төрөл (<i>Amygdalus L.</i>) Зүйл: <i>Amygdalus pedunculata</i> Pall.-Бариулт бүйлэс Статус: Элбэг ургамал Биологийн онцлог: Өргөсгүй мөчиртэй, 0,5-1,5 м хүртэл өндөр ургадаг, навчис гонзгойдуу тонгоруу өндгөрхүү юмуу зууван хэлбэртэй, хөрөөн шүдлэгтэй, сийрэг тачир үсэрхэг, цэцэг тод ягаан, суумал, навчлахын өмнө дэлгэрдэг, хатуу яст жимсгэнэ жимстэй, урт бариултай, гадуураа өтгөн тачир үсэрхэг. Амьдралын хэлбэр: Сөөг. Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Дунд.Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь –Алт., Зүүнгар., Алаш., Алт. өвөр. Өмнөговь дахь тархалт: Бүх сумдын нутгаар, Ургах орчин: Уул толгодын чулуурхаг хажуу, байц хад, ам хавцал, элсэрхэг хээр, сайр садрагаар ургана. Ашигт чанар: Зун, хавартаа навч цэцгээр нь бог мал сайн, бод мал тааруу идээшлэнэ. Адуу, үхэр огт хөндөхгүй. Хөрсний бүтэц бүрэлдэхүүн: Говийн чулуурхаг бор хөрсөнд.</p>
Leguminosae Juss. - Буурцагтаны овог	



	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p><i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i></p> <p><i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог</p> <p>Харганын төрөл (<i>Caragana</i> Lam.)</p> <p>Зүйл: <i>Caragana leucophloea</i> Rojark. - Алтан харгана</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Холтос цайвар шар, цайвардуу ногоон, хааяа бараавтар, навчис дэвүүрэрхүү, навчинцар нарийн, тонгоруу юлдэрхүү хэлбэртэй мохоо оройтой, цэцэг шар, далбаа завь, сэлүүрээс бүтсэн бойтгорхуу хэлбэртэй, сэлүүр богинохон, нэг наст найлзуурууд намартаа ихэд улайдаг. Амьдралын хэлбэр: Сөөглөг ургамал. Монгол дахь тархалт: Ханг., Монг. -Даг., Ховд., Монг.-Алт., Дунд Халх., Их н., Олон н., Дорн. говь., Говь. -Алт., Алт.-өвөр., Зүүнгар., Алаш., Өмнөговь дахь тархалт: Цогт-Овоо, Цогт цэций, Ханбогд, Гурвансайхан, Ончын хяр, Ургах орчин: Цөлийн элсэрхэг хээр, хуурай чулуурхаг, хайргархаг хажуу, бэсрэг уулс, толгодын хормой, доод хэсэг, голын хайрга, сайр, садрагын зах, ирмэг, тойрмын захаарт ургана. Ашигт чанар: Бог мал, тэмээ жилийн турш дунд зэрэг иддэг. Цэцэг, үрийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p><i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i></p> <p><i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог</p> <p>Хунчирын төрөл (<i>Astragalus</i> L.)</p> <p>Зүйл: <i>Astragalus laguroides</i> Pall.-Туулайн хунчир</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Ишгүй дэвсмэл, өндиймөл ургамал, навчинцар 4-8 хос, юлдэрхүү зуувгар, ширүүн үсэрхэг саарал мөнгөлөг өнгөтэй. Цэцэг бойтгорхуу, хондон улаан юмуу нил хөх өнгөтэй, цацаг толгойрхуу, буурцаг 7-8 мм урт. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хэнг., Ханг., Монг. -Даг., ховд., Монг. Алт., Дунд Халх., Их н., Олон н., Говь-Алт., Дорн. говь., Алаш., Өмнөговь дахь тархалт: Номгон, Цэций уул, Баруун Хөх нуруу, Зүүнсайханд, Ургах орчин: Уулын хайргархаг чулуурхаг хажуу, бэл, сайрын ирмэг, чулуу асга, нураг, хад чулуу болон элсэрхэг хээрт ургана. Ашигт чанар: Ногоон үед нь бог мал дунд зэрэг, адуу үхэр муу иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p><i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i></p> <p><i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог</p> <p>Хунчирын төрөл (<i>Astragalus</i> L.)</p> <p>Зүйл: <i>Astragalus macrotrichus</i> Peter-Stib.- Бүдүүн хялгаст хунчир</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: 3-5 см хүртэл өндөр ургадаг, жижиг сийрэг дэгнүүлтэй, үндэс орчимдоо байрладаг гурван навчтай, зуувгар, ширүүн налархай үсэрхэг, цэцэг бойтгорхуу, цайвар шаргалдуу өнгөтэй, буурцаг уртавтар, дугуйрсга үзүүртэй, цагаан юмуу шаргал сэгсгэр үсэрхэг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Дорн. говь., Алт.-өвөр., Зүүнгар., Алаш. Өмнөговь дахь тархалт: Галбын говьд. Ургах орчин: Хайрга</p>

	<p>чулуутай элсэрхэг цөлд ургана. Ашигт чанар: Бог мал ногоон үед нь дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн цайвар бор хөрсөнд.</p>
<p>Zygophyllaceae R. Br. -Хотирын овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> Zygophyllaceae R. Br. -Хотирын овог Хармагын төрөл (<i>Nitraria L.</i>) Зүйл: <i>Nitraria sibirica</i> Pall.- Сибирь хармаг Статус: Элбэг ургамал Биологийн онцлог: 50 см хүртэл өндөр задгай саравгар сөөг. 1 м хүртэлх урт дэвсгэл мөчиртэй, марзлаг элсэн дээр 1 м хүртэл өндөр довон үүсгэдэг, махлаг юлдэрхүү навчтай, өтгөн улаан өнгийн өндгөрхүү юумуу бөөрөнхий шүүслэг яст жимстэй. Амьдралын хэлбэр: Олон наст саравгар сөөглөг ургамал. Монгол дахь тархалт: Монг.-Алт., Дунд. Халх., Дорн. Монг., их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар., Алт. -өвөр., Алаш., Өмнөговь дахь тархалт: Уртын гол, Номгон сумын Борзонгийн говьд Ургах орчин: Марзлаг овгор элс, хужир мараа, тойрмын зах, дэрс, сайрын элсэрхэг хөвөөгөөр ургана. Ашигт чанар: Тэмээ, Бог мал навч жимс, залуу мөчрийг дунд зэрэг иддэг. Жимсийг хүнсэнд болон Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Хужир мараалаг хөрсөнд.</p>
<p>Tamaricaceae Link. - Сухайн овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> Tamaricaceae Link. - Сухайн овог Сухайн төрөл (<i>Tamarix L.</i>) Зүйл: <i>Tamarix gracillis</i> Willd.-Гоолиг сухай Статус: Элбэг Биологийн онцлог: 2.5-3 м хүртэл өндөр сөөг, улаан хүрэн, хүрэн ягаан холтостой, навч хайрсархуу бөгөөд зүймэл, нүцгэн, цэцэг улаан ягаан, 4-5 гишүүнтэй, дохиурын утас сууриадаа өргөссөн, цацаг 1-4 см урт, сийрэг богинохон залаа үүсгэдэг. Амьдралын хэлбэр: Сөөг Монгол дахь тархалт: Их н., Говь-Алт., Зүүнгар, Алт. -өвөр., Өмнөговь дахь тархалт: Ханбогд, Баяндалай сумын сухайт. Ургах орчин: Молцог элс, тойрмын зах, элсэрхэг хээрээр ургана. Ашигт чанар: Тэмээ, бог мал өвөл тэжээл хүрэлцэхгүй үед бага зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Хужир мараалаг хөрсөнд.</p>
<p>Primulaceae Vent. -Хаварсалын овог</p>	

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)</p> <p><i>Primulaceae</i> Vent. -Хаварсалын овог</p> <p>Цэгээлжийн төрөл (<i>Glaux</i> L.)</p> <p>Зүйл: <i>Glaux maritima</i> L.- Марцны цэгээлж</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: 4-20 см өндөр ургадаг, цайвар ногоон ургамал. Навчис суумал, махлаг, бүтэн захтай, зууван юмуу цүлхэгэр өндгөрхүү хэлбэртэй, цэцэг ягаавтар өнгийн дэлбэрхүү цоморлигтой, жижигхэн цэцгүүд эсрэг суусан навчны өвөрт байрладаг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Дунд. Халх., Дорн-Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алаш., Алт.-өвөр., Өмнөговь дахь тархалт: Уртын гол, Хонгорын элсний Сэрүүн булаг. Ургах орчин: Гол горхийн эрэг, нуур цөөрмийн хүрээ, тойром, цайдам дагаж ургана. Ашигт чанар: Бог мал зун, намар дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чийглэг татмын нугын хөрсөнд.</p>
<p><i>Convolvulaceae</i> Juss. - Сэдэргэнийн овог</p>	
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>)</p> <p>Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>)</p> <p>Овог: <i>Convolvulaceae</i> Juss. - Сэдэргэнийн овог</p> <p>Сэдэргэнийн төрөл (<i>Convolvulus</i> L.)</p> <p>Зүйл: <i>Convolvulus fruticosus</i> Pall.- Сөөгөн сэдэргэнэ</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Саравгар, хатуу өргөслөг, сийрэг мөчиртэй, цэцэг ягаан, юүлүүрэхүү, ганц нэг, цоморлигийн навчинцар өтгөн үсэрхэг.</p> <p>Амьдралын хэлбэр: Сөөг</p> <p>Тархалт: Монг. Алт., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Зүүнгар., Алт.-өвөр., Алаш., Өмнөговь дахь тархалт: Ханбогд, Хонгорын элсний арын хөндий, Баянзаг. Ургах орчин: Дов толгод, үйрмэг чулуурхаг цөл, чулуурхаг хажуу, тойрмын захаар ургана. Ашигт чанар: Зундаа тэмээ дунд, бог мал бага иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн цайвар бор хөрсөнд.</p>
<p><i>Asteraceae</i> Dumort. -Голгэсэртэний овог</p>	
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>)</p> <p>Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>)</p> <p>Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae</i> Dumort.)</p> <p>Согсоолжийн төрөл (<i>Heterorappus</i> Less.)</p> <p>Зүйл: <i>Heterorappus hispidus</i> (Thunbg.) Less.-Арзгар согсоолж</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Иш ногоон, 30-100 см өндөр ургадаг, урт шулуун сэрэвгэр</p>


	<p>үслэгтэй, навч уртавтар зууван, сагсны хэл цэцэг цагаан, ороолт навчинцар өвслөг. Амьдралын хэлбэр: Хоёр наст өвслөг ургамал. Тархалт: Хэнт., Ханг., Монг-Даг., Хянг., Ховд., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Говь – Алт., Алаш., Өмнөговь дахь тархац: Ханбогд сумын Булан сухайт, Ургах орчин: Үйрмэг чулуу бай чулуутай хээржүү хажуу, хад чулуу, эргийн хайга, сайрын оёрт ургана. Ашигт чанар: Хонь, ямаа сайн иддэг, Адуу, үхэр дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ:</i> Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) <i>Анги:</i> Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) <i>Овог:</i> Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>) <i>Лавайн төрөл</i> (<i>Asterothamnus Novopokr.</i>) Зүйл: <i>Asterothamnus heterorappoides Novopokr.</i>-Согсооторхуу лавай Статус: Элбэг Биологийн онцлог: Уг орчмын модожсон богино салаа мөчрөөс гарсан олон эгц босоо иш бүхий өтгөн дэгнүүл үүсгэн ургадаг, 5-12 см өндөр ургамал. Навч шугаман гонзгой шигүү суусан, нягт эсгийрхэг үслэгтэй, сагс захаараа цагаан, цайвар ягаан хэлэрхүү цэцэгтэй, голдоо шар хоолойрхуу цэцэгтэй. Цомцог бор шарга. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр. Тархалт: Ховд., Их н., Алаш., Өмнөговь дахь тархац: Номгон сумын Жаал шанд, Ургах орчин: Тооройн төгөлд ургана. Ашигт чанар: Бог мал ногоон үед нь дунд зэрэг, хатахаар нь сайн иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Хужир мараалаг хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ:</i> Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) <i>Анги:</i> Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) <i>Овог:</i> Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>) <i>Төрөл:</i> Зоосон цэцэг (<i>Inula L.</i>) Зүйл: <i>Inula salsoloides (Turcz.) Ostenf.</i>-Марцны зоосонцэцэг Статус: Элбэг Биологийн онцлог: Иш бараг сууриасаа салаалсан, олон, шигүү навчирхаг мөчиртэй, навч жижиг, зузаан, 3-10 мм урт, зүрхэрхүү суурьтай, өндөгрхүү юмуу өргөн өндгөрхүү хэлбэртэй, шамирсан захтай, сагс шар, жижигхэн, 1,5 см голчтой, мөчрийн үзүүрт ганц нэгээрээ байрладаг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Дунд. Халх., Олон н., Дор.говь., Алт.-өвөр., Алаш., Өмнөговь дахь тархац: Цагаан хад, Битүүтийн заг, Онгийн голийн хөндийд. Ургах орчин: Тойрмын зах, марцлаг элсэнд ургана. Ашигт чанар: Тэмээ ногоон үед нь сайн, хатахад нь дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Хужир мараалаг хөрсөнд.</p>

	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i></p> <p><i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i></p> <p><i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i></p> <p><i>Боролзын төрөл (Ajania Poljak.)</i></p> <p>Зүйл: <i>Ajania fruticulosa</i> (Ldb.) Poljak.-Сөөгөн боролз</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Навч гурвантаа юмуу хошоод гурвантаа өдлөг цуулбар, сагс шар, бамбайд нэгддэг, сагсны ороолтын гаднах навчинцар нүцгэн.</p> <p>Амьдралын хэлбэр: Жижиг заримдаг сөөгөнцөр. Тархалт: Ханг., Ховд., Монг. Алт., Их н., Олон н., Дорн. говь., Говь – Алт., Алаш., Алт. –өвөр., Зүүнгар. Өмнөговь дахь тархац: Дэмчог, Хүрэн Ханангийн нуруунд. Ургах орчин: Уул толгодын хажуу хормой, сайрын хөвөө, чулуурхаг осор, хаданд ургана. Ашигт чанар: Тэмээ, бог мал дунд зэрэг, адуу тааруу иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i></p> <p><i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i></p> <p><i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i></p> <p><i>Төрөл: Шарилж (Artemisia L.)</i></p> <p>Зүйл: <i>Artemisia globosoides</i>.-Шардуу шарилж</p> <p>Статус: Элбэг ургамал.</p> <p>Биологийн онцлог: Хүчтэй хөгжсөн олон наст модожсон найлзууртай, иш саваархуу, голдуу бараг угаасаа эхлэж салаалсан, навч хошоод өдлөг цуулбар, нарийн залаанд нэгддэг. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр ургамал.</p> <p>Тархалт: Говь – Алт. Алт. –өвөр., Алаш. Өмнөговь дахь тархац: Цогт –Овоо, Ханбогд, Цогтцэций, Манлай сумдаас бусад сумдын нутагт Ургах орчин: Жалга, сайрын оёорт ургана. Ашигт чанар: Голдуу тэмээ иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг цайвар бор хөрсөнд.</p>
<p>ХӨЛ ГАЗРЫН УРГАМАЛ</p>	
<p><i>Gramineae</i> Juss. -Луулийн овог</p>	



	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)</p> <p>Gramineae Juss. Луулийн овог</p> <p>Хоног будааны төрөл (<i>Setaria</i> P. B.)</p> <p>Зүйл: <i>Setaria viridis</i> (L.) P.B.-Ногоон хоног будаа</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: 20-60 см өндөр, ширүүвтэр ногоон навчтай ургамал, залаа баг цэцэгтэй, залааны мөчир 2-оос олон түрүүхэйтэй, түрүүхэй зуувгар, өөрөөсөө 2-3 дахин урт хялгасархуу иржгэр өргөсөөр хүрээлэгдсэн. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Бүх тойрогт тархана. Өмнөговь дахь тархалт: Баруун Сайханд Ургах орчин: Уулын бэл хормой, чулуурхаг ба хайргатай хажуу, сайраар ургана. Ашигт чанар: Таван хошуу мал зундаа сайн иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн бор, цайвар бор хөрсөнд</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)</p> <p>Gramineae Juss. Луулийн овог</p> <p>Бөөдийн төрөл (<i>Aristida</i> L.)</p> <p>Зүйл: <i>Aristida Heymannii</i> Rgl.-Гейманын бөөдий</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: 10-20 см өндөр буг үүсгэн ургадаг, сахлаг үндэстэй, шугаман навчтай, нарийхан сийрэг залаа баг цэцэгтэй, түрүүхй нарийн шугамархуу, 1,5 см урт 2 салаа саравгар сортой. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Их н, Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алт-өвөр., Алаш. Өмнөговь дахь тархалт: Номгон уул, Борзонгийн говь. Ургах орчин: Уул гүвээний үйрмэг чулуут ба элсэрхэг хажуу, хормой, элсэрхэг хайргархаг цөлд ургана. Ашигт чанар: Бог мал, тэмээ зун, намар, өвөлдөө сайн иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн цайвар бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p>Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)</p> <p>Gramineae Juss. Луулийн овог</p> <p>Булган сүүлийн төрөл (<i>Chloris</i> Sw.)</p> <p>Зүйл: <i>Chloris virgata</i> Sw.-Саваан булган сүүл</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Өндиймөл иштэй, 10-20 см өндөр ургадаг ургамал. Навч шугаман юлдэрхүү, хавтгай түнтгэр угларгатай, баг цэцэг өтгөн, сарвуулаг, 4 см хүртэл урт, 4-10 түрүүрхүү салаа мөчиртэй. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал.</p> <p>Монгол дахь тархалт: Дунд. Халх., Дорн. Монг., Их.н., Олон н., Дорн.говь., Говь-Алт., Алт-өвөр., Алаш. Өмнөговь дахь тархалт:</p>




	<p>Бага мод, Урт, Онгийн голын хөндий. Ургах орчин: Элсэрхэг хайргархаг эрэг ургана. Ашигт чанар: Зун, хавар бог мал сайн, намар тааруухан иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Хужир мараалаг хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i> Gramineae Juss. Луулийн овог Оготнын сүүлийн төрөл (<i>Enneapogon</i> Desv. ex P.B.) Зүйл: <i>Enneapogon borealis</i> (Griseb). Honda.-Умардын огтонын сүүл Статус: Элбэг Биологийн онцлог: Жижигхэн, 5-15 см өндөр, бут үүсгэн ургадаг, навч хуйларсан хатуу, түрүүрхүү залаа баг цэцэг нягт, өтгөн, зууван хэлбэртэй, саарал өнгөтэй, түрүүхэй нэг цэцэгтэй, цэцгийн доод хайрс үзүүртээ 9 сортой. Тэдгээр нь хайрснаасаа 1,5-2 дахин урт. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Ховд., Монг.Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их.н., Дорн.говь., Говь-Алт., Алт-өвөр., Алаш. Өмнөговь дахь тархалт: Мандал-Овоо сумын Хана ууланд. Ургах орчин: Бутармаг чулуут цөл, уул толгодын хормой, элсэрхэг, хайргархаг ба ус урсдаг сайрын оёор, эргийн хайрганд ургана. Ашигт чанар: Үхрээс бусад мал зун сайн, өвөл дунд зэрэг иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг цайвар бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i> Gramineae Juss. -Үетэний овог Хургалжийн төрөл (<i>Eragrostis</i> Wolf.) Зүйл: <i>Eragrostis minor</i> Host-Бага хургалж Статус: Элбэг Биологийн онцлог: Сахлаг үндэстэй, газар налсан 10-30 см өндөр, нумраа юмуу өндиймөл иштэй, навч хавтгай шугаман, ирмэгээрээ дагасан урт сормостой, залаа баг цэцэг нь сийрэг, саравгар, түрүүхэй 5-15 цэцэгтэй, ногоон өнгөтэй. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хевс., Хэнт., Ханг., Монг. Даг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алт.өвөр., Зүүнгар., Алаш. Өмнөговь дахь тархалт: Их уул, Ургах орчин: Уулын чулуурхайг хайргархаг хажууд ургана. Ашигт чанар: Тэмээ зун, намар дунд, хавар өөлдөө бага, бусад мал зундаа дунд иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн бор хөрсөнд.</p>
<p>Chenopodiaceae Vent. Луулийн овог</p>	

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Chenopodiaceae Vent. - Луулийн овог</i></p> <p>Луулийн төрөл (<i>Chenopodium L.</i>)</p> <p>Зүйл: <i>Chenopodium album L.</i>-Цагаан лууль</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: 15-100 см өндөр, салаалсан эгц иштэй, навчис 2-6 см урт, 2-3.5 см өргөн, гурвалжин өндгөрхүү юмуу гонзгойвтор хэлбэртэй, цэцгүүд нийлж түрүүхүү баг цэцэг болж, тэдгээр нь нийлж залаа баг цэцэг үүсгэдэг, цэцгийн шадар эрхтэн өнгөрлөг хучаастай, жимс нь цэцгийн шадар эрхтэнтэйгээ цуг байх бөгөөд ерөнхийдөө эрхэрхүү байдалтай, нуруун талаасаа бөмбөгөрдүү, нөгөө тал нь хотгор, цайвар саарал өнгөтэй..Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал.Тархалт: Хөвс., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд, Монг.-Алт., Дунд. Халх, Дорн.-Монг., Говь-Алт.Ургах орчин: Суурин газар болон талхлагдсан доротйосн газар ургана. Өмнөговь дахь тархалт: Ханбогд, Цогт-Овоо, Ханхонгор, Мандал-овоо сумдын нутагт. Ашигт чанар: Ногоон ба хатсан үед нь тэмээ дуртай, хонь, үхэр дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Chenopodiaceae Vent. - Луулийн овог</i></p> <p>Луулийн төрөл (<i>Chenopodium L.</i>)</p> <p>Зүйл: <i>Chenopodium aristatum L.</i> - Сортой лууль</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: 5-30 см өндөр, ёзоороосоо эхлэн салаалж бөмбөгөр бут үүсгэдэг, намар улаавтар өнгөтэй болдог, навчис юлдэрхүү, бүтэн захтай, мухар оройтой, баг цэцгийн мөчрөнцөрийн үзүүр сортой. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал.Тархалт: Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд, Монг. Алт., Дунд. Халх, Дорн.-Монг., Их н., Дорн. Говь., Говь Алт., Алт. Өвөр., Алаш. Өмнөговь дахь тархалт: Дэмчог хийд орчимд, Зүүнсайханд, Дундсайханд. Ургах орчин: Чулуурхаг хайргархаг хажууд ургана. Ашигт чанар:Ногоон байхад нь тэмээ дунд зэрэг иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг цайвар бор хөрсөнд</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Chenopodiaceae Vent. - Луулийн овог</i></p> <p>Луулийн төрөл (<i>Chenopodium L.</i>)</p> <p>Зүйл: <i>Chenopodium acuminatum Willd.</i>- Шоргор лууль</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Олон салаалсан иштэй, 10-70 см өндөр ургадаг ургамал. Навчис өндгөрхүү, бүтэн, зах нь улаан хүрээтэй.</p> <p>Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Ханг., Монг.-Даг., Ховд, Монг.-Алт., Дунд. Халх, Дорн.- Монг., Их н., Олон н.,</p>

	<p>Дорн говь., Говь-Алт., Алаш.</p> <p>Өмнөговь дахь тархалт: Номгон, Зурамтай уул. Ургах орчин: Уул толгодын чулуурхаг хайргархаг хажуугаас гадна зам харгуй, доройтсон газраар ургана. Ашигт чанар:Ногоон байхад нь тэмээ сайн, хонь, ямаа хатсан үед нь тааруу иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p><i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i></p> <p><i>Chenopodiaceae Vent. - Луулийн овог</i></p> <p>Шорнойн төрөл (<i>Atriplex L.</i>)</p> <p>Зүйл: <i>Atriplex sibirica L.</i>-Сибирь шорной</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: 15-60 см өндөр, эгц босоо юмуу дэлхээ иштэй, саарал ногоон нэг наст ургамал. Навчис гурвалжин юмуу гурвалжин өндгөрхүү, жигд биш ухмал, том том шүдлэг захтай, навчны суганд бөөгнөрсөн , богинохон түрүүрхүү баг цэцэгтэй. Үр жимс дагавар цэцгэндээ ороолттой. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Монг. Алт., Дунд. Халх, Ховд., Дорн.-Монг., Их н., Олон н., Дорн. Говь., Говь Алт., Дорн. Говь., Зүүнгар., Алт. Өвөр., Алаш. Ургах орчин: Шавартай болон элсэрхэг хужир марцтай хотгор, тойром бүрд, сайр садрага, дэрсэтэй хөндий дагаж ургана. Өмнөговь дахь тархалт: Бага мод, Баяндалай сумын Бүгтий заган ойд. Ашигт чанар:Ногоон үед нь тэмээ тааруу иддэг. Ногоон шорной идсэн тэмээний гэдэс дүүрч мх идвэл үхэх аюултай. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Хужир мараатай хөрсөнд</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)</p> <p><i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i></p> <p><i>Chenopodiaceae Vent. - Луулийн овог</i></p> <p>Манан хамхагын төрөл (<i>Bassia All.</i>)</p> <p>Зүйл: <i>Bassia dasyphylla (Fisch.et Mey.) Ktze.</i>- Үслиг манан-хамхаг</p> <p>Биологийн онцлог: Ёзоороосоо дөрвийж салаалсан бөөрөнхий бут үүсгэдэг. 8-50 см өндөр иштэй, туждаа цайвар үсээр хучигдмал. Навчис мухар оройтой, махлаг, шулуун булархуу. Шадар эрхтний илтэс үслэг, жимслэхээрээ таван хошуу шиг шовх сэртэнтэй. Амьдралын хэлбэр: Нэг наст ургамал. Тархалт: Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд, Олон н., Их н., Дорн говь., Говь Алт., Зүүнгар, Алт.өвөр, Алаш.. Өмнөговь дахь тархалт: Бүх сумдын нутагт тархана. Ургах орчин: Шорвогжсон элс, элсэн хурдас, элсэрхэг ба хайргархаг бэл хормой, элсэрхэг хээр, тэгш талд ургана. Ашигт чанар:Тэмээ хавар зун тааруу иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Хужир мараатай хөрсөнд</p>

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Chenopodiaceae Vent. - Луулийн овог</i></p> <p>Бударганын төрөл (<i>Salsola L.</i>) <i>Salsola pestifera Nels.-Өргөст бударгана</i></p> <p>Статус: Элбэг.</p> <p>Биологийн онцлог: 5-80 см өндөр, эгц босоо ширүүвтэр иштэй, навчис шугаман бортгорхуу, үзүүртээ өргөстэй, цэгцүүд иш мөчрийн үзүүрий навчны суганд гурав гурваараа байрлаж түрүү баг цэцэг үүсгэдэг, цэцгийн дагавар шөвгөрхүү урт өргөслөг, шадар эрхтэний навчинцар хальсархаг, далавч нь улаан ягаан. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Хэнг., Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Дунд.Халх, Дорн.-Монг., Их н., Олон н., Дорн.-Говь., Говь-Алт., Зүүнгар., Алт.-өвөр., Алаш., Өмнөговь дахь тархалт: Манлай сумын Урт хар уул. Ургах орчин: Уулын чулуурхаг бэл, сайр садрагын ёроол, дэрсэн шугуй, ургсууриан газар ургана. Ашигт чанар: Адуу, үхэр хавар, намар тааруу, хонь ямаа ногоон үед нь тааруу, өвөл, хавар эрт сайн иддэг. Тэмээ жилийн турш сайнаас онц сайн иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Chenopodiaceae Vent. - Луулийн овог</i></p> <p>Хамхуулын төрөл (<i>Corispermum L.</i>) <i>Зүйл: Halogeton glomeratus (M.B.)C.A.Мey.-Баг хуш-хамхаг</i></p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Зэвгэр, зайдасархуу махлаг навчистай ба ягаавтар улаан иштэй, дэлгэмэл, хааяа марцлаг элстэй хөрсөнд 20 см хүртэл ургадаг, жижигхэн ургамал.</p> <p>Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Их н., Олон н., Зүүнгар., Алт. өвөр. Өмнөговь дахь тархалт: Цогт-Овоо, Цогтцэций, Ханбогд, Баян Төхөм нуур. Ургах орчин: Цөлийн хайргархаг чулуурхаг бэл, хормой, тогтворгүй элс, сайрын ёроол, сийрэг дэрсэн шугуй, доvon ба ээвсгэр марцанд ургана. Ашигт чанар: Тэмээ, бог мал тааруухан иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Мараалаг хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Chenopodiaceae Vent. - Луулийн овог</i></p> <p>Хуш өвсний төрөл (<i>Micropeplis Bge.</i>) <i>Зүйл: Micropeplis arachnoidea (Moq.) Bge. -Аалзны хуш-өвс</i></p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: 30 см хүртэл өндөр ургадаг, цагаан юмуу цайвар иш мөчиртэй, эгц босоо тод ногоон ургамал. Иш нь эхлээд аалзны шүлээрхүү үсэрхэг байснаа сүүлдээ бөөн бөөн үс болдог. Навчис шүүслэг бортгорхуу, үзүүртээ өргөсгүй.</p> <p>Амьдралын хэлбэр: Нэг наст ургамал. Тархалт: Монг.-Даг., Монг.-Алт.,</p>

	<p>Дунд.Халх, Дорн.-Монг., Их н., Олон н., Дорн.-Говь, Говь-Алт., Зүүнгар., Алт-өвөр., Алаш. Өмнөговь дахь тархалт: Ханбогд, Мандал-Овоо сумд. Ургах орчин: Марз мараалаг газар, хотгорын марцлаг шавартай ёроол ургана. Ашигт чанар: Тэмээ, бог мал ногоон үед нь тааруу иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Мараалаг хөрсөнд.</p>
<p>Polygonaceae Juss. - Тарнын овог</p>	
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Polygonaceae Juss. - Тарнын овог</i> Тарнын төрөл (<i>Polygonum L.</i>) Зүйл: Polygonum aviculare L.-Шувуун тарна Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: 10-60 см урт, өндиймөл, навчирхаг иштэй, навчис жижигхэн, юлдэрхүү зуувгар, цэцэг цагаан, навчны сугаанд 2-5 –аараа байрладаг. Амьдралын хэлбэр:Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Монг. Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дор. Говь., Говь-Алт. Алаш. Өмнөговь дахь тархац: Цагаан хад, Дундсайханд. Ургах орчин: Чийглэг марзлаг нугад ургана.</p> <p>Ашигт чанар: Үхэр, хонь, ямаа сайн, адуу тэмээ дунд зэрэг иддэг. Газар дээрх бие, үндэсийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Мараалаг хөрсөнд.</p>
<p>Rapaveraceae Juss. -Намуугийн овог</p>	
	<p><i>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae)</i> <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Rapaveraceae Juss. -Намуугийн овог</i> Галуун тавгын төрөл (<i>Chiazospermum Bernh.</i>) Зүйл: Chiazospermum lactiflorum Kar.et.Kir.-Цагаалин галуун таваг Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Навч хошоод гурвантаа өдлөг цуулбар, нимгэн, дэвсгэр байрлалтай, цэцэг зөв бүтэцтэй, ягаавтар цагаан, бамбайрхуу диҳазид нэгддэг, гэрцэгийн таславч зузаан, эсрэг тал руугаа ээлжлэн хазайсан, амсар гэдрэг эргэсэн. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алт. өвөр., Зүүнгар., Алаш. Өмнөговь дахь тархалт: Ханхонгор сумын Хөх Хошуу худаг. Ургах орчин: Сайр, сувагын оёор, хайргат харгиа, голын эргийн марзлаг нугад ургана. Ашигт чанар: Тодорхойгүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Мараалаг хөрсөнд.</p>
<p>Geraniaceae Juss. - Шимтэглэйн овог</p>	

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i></p> <p>Geraniaceae Juss. - Шимтэглэйн овог</p> <p>Заан тавагын төрөл (<i>Erodium L.</i>)</p> <p>Зүйл: <i>Erodium stephanianum Willd.</i> - Стефаны заан таваг</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: 20-50 см өндөр иштэй, урт налархай сэрэвгэр үслэгтэй, хошоод өдлөг цуулбар навчтай, хөх ягаан жижигхэн цэцэгтэй. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал.</p> <p>Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Дунд.Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь –Алт., Зүүнгар., Өмнөговь дахь тархалт: Номгон, Цэций уул. Ургах орчин: Чулуурхаг хайргархаг хуурай бэл, эргийн элсэрхэг газар, хуурай сайрын ёроолд ургана. Ашигт чанар: Бог мал нэлээд иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i></p> <p>Geraniaceae Juss. - Шимтэглэйн овог</p> <p>Заан тавагын төрөл (<i>Erodium L.</i>)</p> <p>Зүйл: <i>Erodium tibetanum Edgew.</i> - Төвд заантаваг</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Дэвсмэл иштэй, өтгөн налархай үслэгтэй, өдлөг цуулбар навчтай, навчны салбан хүрээрхүү, мохоо, салбанлаг, цайвар ягаан жижигхэн цэцэгтэй, дэвсгэр навчтай, бяцхан саарал ургамал. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Дунд.Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь –Алт., Зүүнгар., Өмнөговь дахь тархалт: Номгоны Борзонгийн говь, Жаал шанд, Ургах орчин: Уулын үйрмэг чулуутай чулуурхаг хажуу, хормой, сайрын осор, суумал нимгэн элсэнд ургана. Ашигт чанар: Бог мал, ялангуяа ямаа дуртай иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Бор саарал хөрсөнд.</p>
<p><i>Euphorbiaceae Juss.</i> - Сүүтэний овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i></p> <p><i>Euphorbiaceae Juss.</i> - Сүүтэний овог</p> <p>Сүүтэний төрөл (<i>Euphorbia L.</i>)</p> <p>Зүйл: <i>Euphorbia humifusa Willd.</i> - Налчигар сүүт өвс</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Ацан салаатай, дэвсмэл нарийхан найлзууртай жижигхэн ургамал. Навчим 5-10 мм урт, ташуу өндгөрхүү, чагталсан, дагавар навчтай, циатий найлзуурын салаанд ганц нэгээр байрладаг.</p> <p>Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал.</p>

	<p>Монгол дахь тархалт: Ханг., Монг.-Даг., Дунд. Халх., Дорн.-Монг., Дорн. говь., Олон н., Говь-Алт., Их н., Олон н., Алт. өвөр. Өмнөговь дахь тархалт: Дайчингийн заг, Баянзаг. Ургах орчин: Үйрмэг чулуутай элсэрхэг хуурай хажуу, бэл хормой, эргийн хуурай хайрга, сайрын оёрт ургана. Ашигт чанар: Бог мал зундаа муу иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор хөрсөнд.</p>
--	--

Asclepiadaceae R. Br. - Ерөндгөнийн овог



	<p><i>Хүрээ:</i> Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae) <i>Анги:</i> Хос талт үрт ургамлын (Dicotyledonae) <i>Овог:</i> Asclepiadaceae R. Br. - Ерөндгөнийн овог Ерөндгөнийн төрөл (Synanchum L.) Зүйл: <i>Synanchum pubescens</i> Bge. - Ноорхой ерөндгөнө Статус: Элбэг ургамал</p> <p>Биологийн онцлог: Иш урт ороодог, навчис өргөн зүрхэрхүү, дүгэрэг гүдэн хажуутай, нарийхан ухмал суурьтай, богинохон шовх үзүүртэй, ургамал бүхэлдээ богинохон атираат үслэгээр өвч хучигдсан, цэцэг шаравтар хүрэн. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Дорн. говь. Өмнөговь дахь тархалт: Ханбогд Бага мод. Ургах орчин: Суумал овгор товгор, нимгэн давхараат марзлаг элс, их сайрын хөвөө, оёрт ургана. Ашигт чанар: Тодорхойгүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Мараалаг хөрсөнд.</p>
--	--

Convolvulaceae Juss. - Сэдэргэнийн овог

	<p><i>Хүрээ:</i> Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae) <i>Анги:</i> Хос талт үрт ургамлын (Dicotyledonae) <i>Овог:</i> Convolvulaceae Juss. - Сэдэргэнийн овог Сэдэргэнийн төрөл (Convolvulus L.) Зүйл: <i>Convolvulus arvensis</i> L.- Чөдөр буюу хөдөөгийн сэдэргэнэ Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Ороодог юмуу дэвсмэл, өөр хоорондоо орооцолдсон, 1 м хүртэл урт иштэй, навчис суман зэвэрхүү, бариултай, цэцэг ягаан, юүлүүрэрхүү, 1-3-аараа навчны өвөрт байрладаг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал</p> <p>Тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Дунд Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дрн. Говь., Говь-Алт., Зүүнгар, Алт.-өвөр., Өмнөговь дахь тархалт: Даланзадгад, Оюутолгой</p> <p>Ургах орчин: Үйрмэг чулуутай хажуу, дэрсэн шугуй, гуу жалганд ургана. Ашигт чанар: Бүх төрлийн мал намар дунд, тэмээ, бог мал зун бага зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор хөрсөнд.</p>
--	---

Cuscutaceae Dum. - Ороонгын овог

	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i></p> <p><i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i></p> <p><i>Cuscutaceae Dum. - Ороонгын овог</i></p> <p>Ороонгын төрөл (<i>Cuscuta L.</i>)</p> <p>Зүйл: <i>Cuscuta europaea L.</i>- Европ ороонго</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Иш урт ороодог, улаан юмуу улаавтар, 2,5 мм хүртэл бүдүүн, их салаархаг, навчгүй, цэцэг юулүүрэрхүү хоолойтой, ягаан, бөөрөнхий бөөнөг баг цэцэгт нэгддэг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Ханг., Монг.-Даг., Хянг., Говь-Алт. Өмнөговь дахь тархалт: Бага мод, Зүүнсайханд. Ургах орчин: Татмын нуга, зугархаг хажуу, ам хөндийн оёорт гүүн хөх дээр шимэгчлэн ургадаг. Ашигт чанар:Тариалан ба бэлчээрийн хог ургамал. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Ургамлын шимэгч.</p>
<p><i>Boraginaceae Juss. - Ноцоргонын овог</i></p>	
	<p><i>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae)</i></p> <p><i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i></p> <p><i>Boraginaceae Juss. - Ноцоргонын овог</i></p> <p><i>Эргүүлэн цэцгийн төрөл (Tournefortia L.)</i></p> <p>Зүйл: <i>Tournefortia sibirica L.</i>- Сибирь эргүүлэн цэцэг</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: 10-20 см өндөр, сэрэвгэр үсэрхэг, салаархаг, навчис шугаман гонзгой,налчгар үсэрхэг, цэцэг нилээд том, цагаан, багана нь үрэвчний дээд оройноос гарсан, цацаг баг цэцэгтэй.</p> <p>Амьдралын хэлбэр: Олон наст ургамал</p> <p>Монгол дахь тархалт: Хянг., Дор. Монг., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алаш., Өмнөговь дахь тархалт: Номгон сумын Дэрсэнэ ус, Ханбогд сумын бага мод, Булан сухайт. Ургах орчин: Элсэрхэг хээр, элсэн дов, загын шугуй, марзтай газар, дэрсэн шугуй, хайлаасан төгөлд ургана. Ашигт чанар: Тэмээ намартаа дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цөлийн бор саарал хөрсөнд.</p>
	<p><i>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae)</i></p> <p><i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i></p> <p><i>Boraginaceae Juss. - Ноцоргонын овог</i></p> <p><i>Ноцгонын төрөл (Lappula Fabr.)</i></p> <p>Зүйл: <i>Lappula stricta (Ldb.) Gurke</i> - Цэх ноцоргоно</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Сууриасаа салаархаг, ширүүн сэрэвгэр эсвэл налчгар үсэрхэг ургамал. Навч гонзгой, урт үсэрхэг, цэцэг цэнхэр, дэлбэ 4-5 мм голчтой, мушгиа баг цэцэгтэй, самранцар гурвалжин, өргөс нь сууриадаа өргөссөн, 12-14 ширхэг.</p> <p>Амьдралын хэлбэр: Нэг наст ургамал. Монгол дахь тархалт: Монг. Алт.,Их</p>

	<p>н., Олон н., Зүүнгар., Алт. өвөр. Өмнөговь дахь тархалт: Номгон, Хөрхийн нуруу. Ургах орчин: Сайрын оёор, цөлийн уулын чулуурхаг хажуу, хад асганд ургана. Ашигт чанар: Тодорхойгүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн чулуурхаг бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Boraginaceae</i> Juss. - Ноцоргонын овог Ноцоохойн төрөл (<i>Hackeria</i> Opiz.) Зүйл: <i>Hackeria thymifolia</i> (DC.) M. Pop.- Ганган навчит ноцоохой Статус: Элбэг Биологийн онцлог: 20 см өндөр ургадаг, навчис хатуувтар, шугаман гонзгой, налчгар шиүүн үстэй, дэлбэ цагаан, цайвар хөх, 2 мм орчим, юлүүрэрхүү, мушгиа баг цэцэгтэй, самранцар өргөсгийн хамт 2 мм орчим урт. Амьдралын хэлбэр: Нэг наст ургамал Монгол дахь тархалт: Ханг., Монг. Алт., Дунд. Халх., Олон н., Дор.говь., Говь – Алт., Зүүнгар., Алт. өвөр. Өмнөговь дахь тархалт: Зөөлөнгийн нуруу, Ханбогд Ургах орчин: Чулуурхаг, үйрмэг чулуутай цөлжүү хажуу, хад асга, нураг, сайрын элс хайрган оёорт ургана. Ашигт чанар: Тодорхойгүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн бор хөрсөнд</p>
<p><i>Labiaceae</i> Lindl.- Уруул цэцэгтэний овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) Уруул цэцэгтэний овог (<i>Labiaceae</i> Lindl.) Бивлэнцэрийн төрөл (<i>Schizonepeta</i> Briq.) Зүйл: <i>Schizonepeta annua</i> (Pall.) Schischk. - Нэг наст бивлэнцэр Статус: Элбэг Биологийн онцлог: Нэг юмуу цөөн тооны иштэй, ихэвчлэн сууринаасаа мочирлөг, эгц босоо, энгийн үсэрхэг, доод хэсэгтээ урт сэрэвгэр үсэрхэг ба цайвар өнгийн толгойрхог булчирхайлагтай, 9-40 см өндөр ургадаг, суганы мочир навчирхаг ба баг цэцгээр төгсдөг. Навч, өргөн юмуу уртавттар өндгөрхүү хэлбэртэй, уртавттар-өндгөрхүү бүтэн захтай салбангуудад давхар өдлөг цуулбар юмуу шугаман гүн хэрчигдсэн, үсэрхэг, Дэлбэ цайвар өнгөтэй, дохиур хөхөвтөр өнгийн тоосовчтой, хойд 2 дохиур дэлбээс дөнгөж цухуйсан. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Ховд., Монг. -Алт, Дунд. Халх., Дорн. -Монг., Их н., Олон ., Дорн. говь., Говь –Алт., Алаш. Өмнөговь дахь тархалт: Дэмчог, Зүүн, дунд, баруун сайхан, Их Хачиг, Их Аргалант. Ургах орчин: Хад цохиотой цөлөрхөг хайргархаг хажуу, хормой бэл, нураг, сайрын ёроолоор ургана. Ашигт чанар: Тэмээ намар дунд, бог мал тэмээ зун тааруухан иддэг. Үр, цэцгийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> Уруул цэцэгтэний овог (<i>Labiaceae</i> Lindl.) Шимэлдэгийн төрөл (<i>Dracocephalum</i> L.) Зүйл: <i>Dracocephalum foetidum</i> Vge. - Үмхий шимэлдэг Статус: Элбэг Биологийн онцлог: Голлосон үндэстэй, 5-15 см өндөр ургадаг, ихэвчлэн сууриасаа энгийн мөчирлөсөн эгц босоо иштэй, улаавтар өнгийн тачир үсэрхэг. Навч өндгөрхүү юмуу уртавтар өндгөрхүү хэлбэртэй, ягаавтар хөх өнгийн цэцгүүд, цэцгийн богино хөлөн дээр хуурамч тойруулган байрлалаар (6 цэцэг) түрүүрхүү багццэг бүрдүүлдэг. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. -Даг., Ховд., Монг. -Алт, Дунд. Халх., Дорн. -Монг., Их н., Олон., Дорн. говь., Говь -Алт., Алаш. Өмнөговь дахь тархалт: Зүүн, дунд, Баруун сайханд, Дэмчог, Ургах орчин: Хайраг, ам хавцал, сайрын адаг, ирмэг хажуу, хад асганы бэл хормой, нурагаар ургана. Ашигт чанар: Тэмээ зундаа дунд зэрэг иддэг. Цэцгийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> Уруул цэцэгтэний овог (<i>Labiaceae</i> Lindl.) Нохойн хэлийн төрөл (<i>Panzeria</i> Moench.) Зүйл: <i>Panzeria lanata</i> (L.) Vge. - Үсхий нохойн хэл Статус: Элбэг Биологийн онцлог: Бүдүүн, голлосон, модожсон үндэслэг иштэй, олон наст ургамал. Олон тооны иштэй, 15-30 см өндөр, хэсэг хэсэг тунгалаг ноосорсон торгомсог үслэгээр өтгөн бүрхэгдсэн. Навч дугариг хэлбэртэй, тавчилсан цуулбар ба дахин өөрөө мохоо юлдэн салбанд хэрчигдсэн, нарийхан бариултай. Түрүүрхүү хэлбэрийн өтгөн багццэгтэй. Дэлбэ шар өнгөтэй, дээд уруулдаа өтгөн торгомсог үслэгтэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг, Ховд., Монг.-Алт., Дунд. Халх, Дорн. -Монг., Их н., Олон., Дорн. говь Говь Алт., Зүүнгар, Алаш. Өмнөговь дахь тархалт: Зүүн, дунд, баруун сайхан, Номгоны Гурамсингийн талд. Ургах орчин: Хайрга чулуутай хээржүү хажуу, хадны ёроол, нуранги асга, хуурай ам хавцал, сайрын адаг ба элсэрхэг хээрт ургана. Ашигт чанар: Адуу, тэмээ, бог мал зундаа тааруухан иддэг. Газар дээрх биенийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
<p>Scrophulariaceae Juss. -Иршимбийн овог</p>	



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)

Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)

Scrophulariaceae Juss. - Иршимбийн овог

Иршимбийн төрөл (*Scrophularia L.*)

Зүйл: *Scrophularia incisa* Weinm.- Ухмал иршимбэ

Статус: Элбэг

Биологийн онцлог: Богино үндэслэг иштэй, 20-70 см өндөр ургадаг, ихэд салаархаг иштэй, ишний навч өндгөрхүү юлдэн, том шүдэрхэг, эсрэг суусан, суурийн навч лийрэрхүү, өдлөг хагалбар, дэлбэ бөөрөнхий саахуураархуу, 2 уруултай, хүрэн улаан өнгөтэй. Хонхорцгон жимстэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. **Монгол дахь тархалт:** Ханг., Монг. –Даг., Ховд., Монг. –Алт., Дунд. Халх., Дорн. -Монг., Их н., Олон н., Говь –Алт., **Өмнөговь дахь тархалт:** Оюутолгой орчимд, Зүүнсайхан. **Ургах орчин:** Хад чулуутай болон чулуурхаг хажуу, ам хавцал, сайрын оёор, хөвөө, нураг, эргийн хайрга, элсэхэг хуурай хээрээр ургана. **Ашигт чанар:** Газар дээрх биенийг хоолой ам өвдөх, хамрын үрэвсэл, хорт хавдар, идээ бээр бүхий яр шарх, өтгөн хатах зэрэгт хэрэглэнэ. **Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:** Уулын цайвар хүрэн хөрсөнд

Plantaginaceae Juss. - Тавансалааны овог



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)

Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)

Plantaginaceae Juss. - Тавансалааны овог

Тавансалааны төрөл (*Plantago L.*)




Зүйл: *Plantago minuta* Pall.- Бага таван салаа


Статус: Элбэг

Биологийн онцлог: 2-7 см ургадаг, жижигхэн ургамал. Шугаман юлдэрхүү навчтай, сэгсгэр үсэрхэг навчис суман иштэйгээ бараг чацуу, хавтгай нарийхан, хонхорцог 2 үүртэй. **Амьдралын хэлбэр:** Нэг наст өвслөг ургамал.

Монгол дахь тархалт: Ханг., Монг. -Алт, Их н., Олон н., Дорн. говь., Говь –Алт., **Өмнөговь дахь тархалт:** Тавантолгойн тал, Сэврэйн шар тал. **Ургах орчин:** Цөлийн үйрмэг чулуут болон чулуурхаг хажуу, хормой, сайрын оёор, элсэрхэг хээр талд ургана. **Ашигт чанар:** Идэмж тодорхойгүй. **Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:** Цайвар бор хөрсөнд.

Asteraceae Dumort. -Голгэсэрэгтэний овог



	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i></p> <p><i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i></p> <p><i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i></p> <p>Борлоны төрөл (<i>Cancrinia</i> Kar. et. Kir.)</p> <p>Зүйл: <i>Cancrinia discoidea</i> (Ldb.) Poljak.-Зээрэнцэг борлон</p> <p>Статус:</p> <p>Биологийн онцлог: Нарийн үндэстэй, 5-20 см өндөр, иш ба навч сийрэг бөөн нэвсгэр эсгийрхэг үслэгтэй, навч урт бариултай, дэвсээ, өдлөг ухалбар, сагс тод шар, тал бөмбөлөг, нарийхан гоо иштэй, нэг ургамал дээр 1-5-6 аараа байрладаг. Амьдралын хэлбэр: Хоёр наст өвслөг ургамал. Тархалт: Олон н., Дорн. говь., Говь – Алт., Алт. өвөр., Алаш. Өмнөговь дахь тархац: Ханбогд, сумдын нутагт. Ургах орчин: Элсэрхэг хайргархаг цөл сайрын оёор адгаар ургана. Ашигт чанар: Идэмж тодорхойгүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Бор саарал хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i></p> <p><i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i></p> <p><i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i></p> <p><i>Төрөл: Шарилж (Artemisia L.)</i></p> <p>Зүйл: <i>Artemisia pectinata</i> Pall.-Шүлхий шарилж</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Навч гол судлаа хүртэл саман өдлөг цуулбар, сагс зууван 3-5 мм урт, суумал, түрүүрхүү залаанд нэгддэг, булчиррхайт ургамал.</p> <p>Амьдралын хэлбэр: Нэг наст ургамал. Тархалт: Хэнт., Ханг., Монг-Даг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алаш., Өмнөговь дахь тархац: Зэрэгцээ толгой, Их Аргалант ууланд. Ургах орчин: Уулын хажуу, нуранга асга, хормой, хээрээр ургана. Ашигт чанар: Дунд зэргийн тэжээлтэй ургамал. Ногоон үед нь мал иддэггүй. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i></p> <p><i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i></p> <p><i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i></p> <p><i>Төрөл: Шарилж (Artemisia L.)</i></p> <p>Зүйл: <i>Artemisia anethoides</i> Vge.-Божмогорхуу шарилж</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Өтгөн эсгийрхэг үслэгтэй тул саарал өнгөтэй, навч гонзгой, хошоод өдлөг цуулбар, сагс зууван нягт залаанд нэгддэг, ороолт навчинцар өтгөн үслэгтэй, урт сормууслэг ирмэгтэй.</p>

	<p>Амьдралын хэлбэр: Нэг наст өвлөг ургамал.</p> <p>Тархалт: Дорн. говь., Говь – Алт., Алаш., Өмнөговь дахь тархац: Гурвансайханд, Ханбогд. Ургах орчин: Нам уулсын хажуу, нимгэн давхараат элс, элсэрхэг хээрт ургана. Ашигт чанар: Ногоон үед нь мал иддэггүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i></p> <p><i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i></p> <p><i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i></p> <p><i>Төрөл: Шарилж (Artemisia L.)</i></p> <p>Зүйл: Artemisia Sieversiana Willd.-Сиверсийн шарилж</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Иш 20-100 см өндөр, навчис өргөн гурвалжин, анхдагч сегмент өдлөг, үзүүрийн салбанцар гонзгой өндгөрхүү, сагс 4-7 мм өргөн, сийрэг залаа үүсгээг. Амьдралын хэлбэр: Нэг наст өвлөг ургамал. Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Ховд., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Дорн говь., Говь-Алт. Өмнөговь дахь тархац: Хөрхийн нуруунд. Ургах орчин: Уулын чулуурхаг хажууд ургана. Ашигт чанар: Ногоон үед нь мал иддэггүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i></p> <p><i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i></p> <p><i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i></p> <p><i>Төрөл: Шарилж (Artemisia L.)</i></p> <p>Зүйл: Artemisia palustris L.-Намгийн шарилж</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Навчис хошоод гурвантай цуулбар, ишний навчны үзүүрийг салбанцар нарийн шугамархуу, сагс бөмбөлөгөрхүү, 2,5-4 мм өргөн, сумал, нарийн нягт цацаг юмуу залаа баг цэцэгт нэгддэг. Амьдралын хэлбэр: Нэг наст өвлөг ургамал.</p> <p>Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Говь – Алт., Дорн. говь. Өмнөговь дахь тархац: Ханбогд уул, Зүүнсайханд. Ургах орчин: Уулын чулуурхаг хажуугаар ургана. Ашигт чанар: Мал ногоон ба хатсан үед нь муу иддэг. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Уулын цайвар хүрэн хөрсөнд.</p>

	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i></p> <p><i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i></p> <p><i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i></p> <p><i>Төрөл: Шарилж (Artemisia L.)</i></p> <p>Зүйл: <i>Artemisia scoparia</i> Waldst. et Kit.-Ямаан шарилж</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: 30-70 см өндөр ургадаг, иш ганц юмуу 2-5, дундаасаа дээш мөчирлөн салаалсан, хошоод өдлөг цуулбар, үзүүрийн салбанцар шугамархуу утаслаг нарийн, сагс өргөн зууван, жижигхэн, унжиж гудайдаг, цацгархуу залаа баг цэцэгт нэгддэг. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал.</p> <p>Тархалт: Ханг., Монг.-Даг., Хянг., Монг. Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Говь – Алт., Дорн. говь., Зүүнгар., Алт. өвөр., Алаш. Өмнөговь дахь тархац: Бүх сумдын нутгаар ургана. Ургах орчин: Уулын чулуурхаг хажуу, элсэрхэг хээрээр ургана. Ашигт чанар: Хонь, ямаа, тэмээ ногоон үед нь дунд зэрэг иддэг, хатсан үед нь сайн иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг ба цайвар бор хөрсөнд.</p>
--	--

Өмнөговь аймгийн Ханбогд сумын ургамлын аймагт бүртгэсэн нэн ховор, ховор, үлдэц, унаган, бэлчээрийн, эмийн ашигт, хөл газрын ургамал, 2017

<p style="text-align: center;">НЭН ХОВОР УРГАМАЛ</p>	
<p style="text-align: center;"><i>Salicaceae</i> Mirb. – Бургасны овог</p>	
	<p><i>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae)</i></p> <p><i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i></p> <p><i>Salicaceae</i> Mirb. - Бургасны овог</p> <p><i>Улиасны төрөл (Populus L.)</i></p> <p>Зүйл: <i>Populus diversifolia</i> Schrenk.-Элдэв навчит улиас</p> <p>Тоорой</p> <p>Статус: Нэн ховор ургамал.</p> <p>Биологийн онцлог: Навч өсөлтийн найлзуурынх нарийн юлдэрхүүгээс өндгөн юлдэрхүү бүтэн, сүүлчийн найлзуурынх гурвалжин, өндгөрхүүгээс дүгрэг ба бөөрөрхүү, өргөн дүгэрэг, тайрмал юмуу зүрхэн суурьтай, арьсархуу бүдэг саарал өнгөтэй. Амьдралын хэлбэр: Мод. Монгол дах тархалт: Говь-Алт., Зүүнгар, Алт. -өвөр., Өмнөговь дах тархалт: Ханбогд сумын Уртын гол, Орвог гашуун, Жаал шанд, Халзан сондог, Чонын боом, Эхэн зулганай, Цагаан хад, Улаан бав, Цайлан, Цагаан уул, мухар хулсанг, Улаан толгой, Хар балгас, Орвог гашуун, Онч хайрхан, Гурван сондог, гурван худаг, Олон тооройт. Ургах орчин: Баянбүрдэд ургана. Ашигт чанар: Тэмээ навч, мөчрийг тун сайн иддэг.</p>
<p style="text-align: center;"><i>Rosaceae</i> Juss. - Сарнайн овог</p>	

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Rosaceae</i> Juss. -Сарнайн овог Хойргын төрөл (<i>Potaninia</i> Maxim.) Зүйл:<i>Potaninia mongolica</i> Maxim.-Хулан хойрго Статус: Нэн ховор, үлдэц, унаган ургамал Биологийн онцлог: Үндэсний хүзүүвч орчимдоо салаалдаг, мөчирлөг бүдүүн гол иштэй, навчис жижигхэн, өдлөг нийлмэл, 3-5 бүтэн ногоон навчинцартай, навчныхаа суганд жижигхэн цагаан цэцэгтэй. Амьдралын хэлбэр: Намхан сөөгөнцөр. Монгол дах тархалт: Олон н., Дорн. говь., Говь –Алт., Алаш. Өмнөговь дах тархалт: Ханбогд сумын Номгон уулын ар хөндий, Дайчингийн заг, Хүрмэн сум, Мандал-овоо сумын хойд дэнж, Сэврэйн шар тал, Гурвантэс Овоот, Сүмбэр орд. Ургах орчин: Хайргархаг цөл, том ширхэгт элсэрхэг хөрс, жижиг хайргатай садрагаар ургана. Ашигт чанар: Адуу 4 улирлын турш сайн, хонь, ямаа өвлөөс бусад улиралд дунд зэрэг, тэмээ зундаа дунд зэрэг, бусад үед тааруу иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн цайвар бор хөрсөнд.</p>
<p>Leguminosae Juss. –Буурцагтаны овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог Харганын төрөл (<i>Caragana</i> Lam.) Зүйл:<i>Caragana brachypoda</i> Rojark.-Хойрог харгана Статус: Нэн ховор, Монголын унаган ургамал. Биологийн онцлог: Бор шаргалдуу холтостой цөлийн ургамал. Навч дэвүүрэрхүү юмуу багсархуу, бойтгорхуу шар цэцэгтэй, цоморлиг нарийн хоолойрхуу, буурцаг гонзгойвтор. Амьдралын хэлбэр: Сөөглөг ургамал. Монгол дах тархалт: Дорн. говь., Говь-Алт., Өмнөговь дах тархалт: Цогт-Овоо, Цогт цэций, Ханбогд сумын Дэмчог хийд, Оцон Мааньт, Хөрх уул, Дуйаг уул, Хүрмэн уул, Аргалант ууланд. Ургах орчин: Хайргархаг элсэрхэг цөлөрхөг хээрт ургана. Ашигт чанар: Хонь, ямаа навч, цэцэг, жижиг мөчрийг дунд зэрэг, тэмээ зун, намартаа сайн, өвөл, хавартаа бага зэрэг иддэг. Үхэр, адуу идэхгүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цөлийн бор саарал хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог Ортуузын төрөл (<i>Oxytropis</i> DC.) Зүйл:<i>Oxytropis grubovii</i> Ulzj.- Грубовын ортууз Статус: Нэн ховор, Монголд байгаа завсарын унаган, эртний саваннын үлдэц ургамал. Биологийн онцлог: Жижгэвэр дэрэрхүү хэлбэртэй, өргөстэй сөөгөнцөр. Цацаг хоёр цэцэгтэй, цэцэглэх иш богинохон. Цоморлиг хоолойрхуу, ягаан судалтай, жимслэх үед цэврүүтэж хөөдөг, дотроо буурцаг агуулдаг. Навчинцар гонзгой юмуу гонзгой-юлдэрхүү, 5-10(12) мм урт, 2-2.5 мм өргөн, урт, сэврэгэр торгомсог үсэрхэг. Амьдралын хэлбэр: Сөөгөнцөр ургамал. Монгол дах тархалт: Дорн. говь., Алаш., Өмнөговь дах тархалт: Галбын говь, Борзон говь, Ургах орчин: Цөлийн толгодын элсэрхэг хормой, сайрын ирмэг, ёроолоор ургана. Ашигт чанар: Ямаа зөвхөн навчийг түүж иддэг, хөнөөлт ургамал. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор</p>

	хөрсөнд.
Zygophyllaceae R. Br. -Хотирын овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Zygophyllaceae R. Br. -Хотирын овог</i> Хотирын төрөл (<i>Zygophyllum L.</i>) Зүйл:<i>Zygophyllum Potaninii Maxim.- Потанины хотир</i> Статус: Нэн ховор, Монголд байгаа завсарын унаган ургамал. Биологийн онцлог: Газраар зулж ургадаг, 10-25 см өндөр ургадаг, дэлхээ иштэй, навчинцар 1-2 хос, тэгш бус хэмтэй, тонгоруу өндгөрхүү хэлбэртэй, хонхорцог 5 далавчтай.Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.Монгол дах тархалт: Говь-Алт., Зүүнгар, Алт. -өвөр., Алаш., Өмнөговь дах тархалт: Галбын говь, Борзонгийн говь, Загсүүжийн говь, Зулганай, Дайчингийн заг, Их Хачиг, Баянтөхөм нуур. Ургах орчин: Хайргархаг бэл, сайрын элс, хайрган ёроол, чулуурхаг хажууд ургана. Ашигт чанар: Газар дээрх биеийг архаг усан хаван, элэгний өвчинг эмнэнэ. Тэмээ тааруухан иддэг, бог мал иддэг эсэх нь тодорхойгүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Бор саарал хөрсөнд.</p>
Plumbaginaceae Juss. - Хорголжингийн овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Plumbaginaceae Juss. - Хорголжингийн овог</i> Бэрмэгийн төрөл (<i>Limonium Mill.</i>) Зүйл:<i>Limonium aureum (L.) Hill ex Ktze.-Алтан бэрмэг</i> Статус: Нэн ховор ургамал. Биологийн онцлог: 5-20 см өндөр ургадаг, сууриасаа их салаалсан, тахиралдсан, дэвсмэл иштэй, суурьтаа навчны бараан хүрэн үлдэгдлээр хучигдсан, үндэсний холтос хар хүрэн, цэцэг хурц алтлаг шар.Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Ховд., Дунд. Халх., Дорн. -Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алт. -өвөр., Алаш., Өмнөговь дах тархалт: Ханбогд сумын Бага мод, Дэрсэнэ ус, Онгийн голын хөндий, Улаан нуур, Бүгтийн заг, Жаал шандын Тооройн төгөлд, Гурвантэс суманд. Ургах орчин: Цөлөрхөг хээрийн үйрмэг чулуут хажуу, бэл хормой, марзлаг цөл, голын эргийн хужир, марцтай хуурай элс, хайрга, тойрмын ухаар ургана. Ашигт чанар: Бог мал зун, намар дунд зэрэг иддэг. Цэцгийн Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Мараалаг хөрсөнд.</p>
Boraginaceae Juss. - Ноцоргонын овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> Boraginaceae Juss. - Ноцоргонын овог Бэрээмэгийн төрөл (Arnebia Forsk.) Зүйл:<i>Arnebia guttata Vge.- Толболт ба шар бэрээмэг</i> Статус: Нэн ховор ургамал. Биологийн онцлог: 5-20 см ургадаг, ширүүн үсэрхэг саарал ногоон ургамал. Дэлбэ шар, заримдаа дэрвэн дээрээ хүрэн толботой, хадаасархуу, нарийн хоолойтой,салбан бүтэн захтай. Амьдралын хэлбэр: Хоёр наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Монг. Алт.,Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алаш., Алт. өвөр. Өмнөговь дах тархалт: Номгон сумын Дуйнаг уул, Сэврэйн тал, Галбын говь, Борзонгийн говь, Гурвантэсийн Сүмбэр, Овоот орд. Ургахорчин: Сайрын элс хайрган оёор, үйрмэг чулуут, чулуурхаг бэл хормой, нимгэн давхараат</p>

	<p>элсэнд ургана. Ашигт чанар: Өвлөөс бусад улиралд тэмээ сайн, бог мал дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цөлийн бор саарал хөрсөнд.</p>
<p>Asteraceae Dumort. -Голгэсэртэний овог</p>	
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> <i>Лавайн төрөл (Asterothamnus Novopokr.)</i> Зүйл: Asterothamnus centrali-asiaticus Novopokr.-Төв Азийн лавай Статус:Нэн ховор ургамал.</p> <p>Биологийн онцлог: Модожсон, 25-50 см өндөр ургадаг, их салаархаг, шугаман гонзгой навчтай, залуу найлзуур ба навч тачир ноосорхог үслэгтэй, сагс цагаан 4-10 хэлэрхүү, 12 хоолойрхуу цэцэгтэй, мөчрийн үзүүрт бамбайд нэгддэг. Амьдралын хэлбэр: Том заримдаг сөөгөнцөр. Тархалт: Монг. Алт., Дунд Халх., Олон н., Дорн. говь, Говь – Алт., Алт.-өвөр., Алаш., Өмнөговь дах тархац: Ханбогд сумын Бага мод, Манлай сумын Их Өлзийт уул, Цэций уул, Хөнжлийн нуруу, Баян-Овоо зурамтай, Их Аргалант Номгон сумын Дуйнаг ууланд, Тост, Нэмэгт, Сэврэй ууланд. Ургах орчин: Сайрын зах ба оёроор ургана. Ашигт чанар: Тэмээ өвөл хавар сайн, зун дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> <i>Шардалангийн төрөл (Tugarinovia Iljin.)</i> Зүйл: Tugarinovia mongolica Iljin.- Монгол шар далан Статус:Нэн ховор, Монголын унаган ургамал.</p> <p>Биологийн онцлог: Өргөс ихтэй 5-10 см өндөр ургамал. Ишний навчгүй, бүдүүн дээд хэсгээрээ цагаан ноосорхог каудкстэй, гонзгой хатуу арьслаг, долгионтсон хар ногоон, бариултай өдлөг цуулбар, захаараа өргөслөг дэвсгэр навчтай ба 1-3 нарийхан цэцэглэх иштэй, ганц сагстай. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.</p> <p>Тархалт: Олон н., дорн. говь., Говь – Алт., Алаш. Өмнөговь дах тархац: Ханбогд сумын Номгон уул, Номгон сумын Дуйнаг уул, Дэмчог хийд. Онч хайрхан. Ургах орчин: Цөлийн үйрмэг чулуутай ба чулуурхаг хажуу, хаданд ургана. Ашигт чанар: Хонь, ямаа, тэмээ ногоон үед нь дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> <i>Тостын төрөл (Brachanthemum DC.)</i> Зүйл: Brachanthemum gobicum Krasch.-Гөвийн тост Статус:Нэн ховор ургамал.</p> <p>Биологийн онцлог: Угаасаа эхлэн салаалж мөчирлөсөн, 15-40 см өндөр сөөгөнцөр. Навч гурвалсан шугаман салбанцаруудтай, навчны салбанцар мохоо, сагс хэл цэцэггүй, өндөгрхүү шар, ороолт навчинцар нуруун талдаа том хонхорхойт булчирхайтай. Амьдралын хэлбэр:Заримдаг сөөгөнцөр.</p> <p>Тархалт: Дорн. говь., Говь – Алт., Алаш. Өмнөговь дах тархац: Баян-Овоо сумын шар бударганын хонхор, Ханбогд, Булган суманд. Ургах орчин: Сул бэхлэгдсэн цөлийн элс, цөлийн үйрмэг чулуу, хайрганд ургана. Ашигт чанар:Тэмээ, бог мал зундаа дунд зэрэг, өвөл илүү иддэг. Хөрсний бүтэц,</p>

	<p>бүрэлдэхүүн: Бор саарал хөрсөнд.</p> <p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> <i>Төрөл: Шарилж (Artemisia L.)</i> Зүйл: Artemisia xanthochroa Krasch.-Шар шарилж Статус: Нэн ховор ургамал. Биологийн онцлог: сулавтар хөгжсөн олон наст модожсон найлзууртай, иш саваархуу, голдуу бараг угаасаа эхлэж салаалсан, навч хошоод өдлөг цуулбар, нарийн залаанд нэгддэг. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр ургамал. Тархалт: Монг-Даг., Монг. Алт., Дунд. Халх., Дор. Монг., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт. Өмнөговь дах тархац: Цогт –Овоо, Цогтцэций, Манлай сумдад. Ургах орчин: Жалга, сайрын оёорт ургана. Ашигт чанар: Голдуу тэмээ иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг цайвар бор хөрсөнд.</p>
ХОВОР УРГАМАЛ	
Gramineae Juss. -Үетэний овог	
	<p><i>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae)</i> <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i> Gramineae Juss. –Үетэний овог <i>Нишингийн төрөл (Phragmites Adans.)</i> Зүйл: Phragmites communis Trin.-Эгэл нишингэ Статус: Ховор ургамал Биологийн онцлог: Урт үндэслэг иштэй, мөлхөө найлзууртай, иш 0,8-4 м өндөр, хөндий, гөлгөр, шугамархуу юлдэн навчтай, өтгөн саглагар залаа баг цэцэгтэй, түрүүхэйн хайрс юлдэрхүү хэлбэртэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Ургамал газар зүйн бүх тойрогт Өмнөговь дах тархалт: Номгон сумын Их ба Бага Дэнгийн худаг, Ургах орчин: Мараалаг элс ба хөвсгөр сондуул, элсэн манханы хөвөөгөөр, голын нуурын эргийн нугад ургана.</p>
Chenopodiaceae Vent. - Луулийн овог	
	<p><i>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae)</i> <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Chenopodiaceae Vent. - Луулийн овог</i> <i>Цулихирын төрөл (Agriophyllum M. B.)</i> Зүйл: Agriophyllum pungens (Vahl) Link ex. A. Dietr.-Шивүүрт цулихир Статус: Ховор ургамал Биологийн онцлог: Хатуу өргөс хатгууртай, юлдэрхүү, үзүүртээ хурц өргөслөг навчтай, навч нь 3 тод тууш судалтай, толгойрхуу баг цэцэг навчны өвөрт байрладаг, цэцгийн дагавар шөвгөрхүү өргөстэй, шадар эрхтэн 1-3 хальсархаг навчинцараас тогтдог элсний ургамал. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Ховд., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алт.-өвөр., Алаш., Өмнөговь дах тархалт: Зурамтай уул, Хонгорын элс, Мандал-Овоо сумын Хана уулын сайрын элсэнд. Ургах орчин: Тогтворгүй болон нүүнги элсэн манхан, сэрвэн, элсэн довцог, сондуулд ургана. Ашигт чанар: Тэмээ 4 улирлын турш сайн</p>

иддэг, үр нь уураг, эслэг, тослог ихтэй тул Монголчууд эртнээс тэжээллэг чанартай, сульхирын гурил хийж хүнсэнд хэрэглэдэг. **Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:** Элсэнд ургана.

Rosaceae Juss. -Сарнайн овог



Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (*Angiospermae*)

Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)

Rosaceae Juss. -Сарнайн овог


Бүйлэсний төрөл (*Amygdalus* L.)

Зүйл: *Amygdalus mongolica* Maxim.-Монгол бүйлэс

Статус: Ховор, Монголын унаган ургамал.

Биологийн онцлог: Дэрэвгэр олон салаатай, саарал улаан хальстай мөчиртэй, богиносмол өргөстэй, 1,8 м хүртэл өндөр ургадаг, навчис зууван юмуу тонгоруу өндгөрхүү дугуйвтар хэлбэртэй, үл мэдэгдэх шүдлэгтэй, сарьслаг, нүцгэн, цэцэг цайвар ягаан, суумал, навчлахын өмнө дэлгэрдэг, хатуу яст жимсгэнэ жимстэй, суумал, гадуураа өтгөн тачир үсэрхэг. **Амьдралын хэлбэр:**Сөөг. **Монгол дах тархалт:** Говь –Алт., Алаш., **Өмнөговь дах тархалт:** Ноён, Нэмэгт, Тост, Ончин хяр, Борзонгийн говь, Галбын говь, **Ургах орчин:** Уул толгодын чулуурхаг бэл, хажуу хормой, байц ам хавцал, сайрын ирмэг дагаж ургана. **Ашигт чанар:**Зун, хавартаа навч цэцгээр нь бог мал сайн, бод мал тааруу идээшлэнэ. Адуу, үхэр огт хөндөхгүй. Үр жимсийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. **Хөрсний бүтэц бүрэлдэхүүн:**Чулуурхаг говийн хөрсөнд.

Leguminosae Juss. –Буурцагтаны овог



Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (*Angiospermae*)

Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)

Leguminosae Juss. - Буурцагтаны овог

Лидэрийн төрөл (*Sophora* L.)

Зүйл: *Sophora alopecuroides* L.- Үнэгэн сүүлхэй лидэр

Статус: Ховор ургамал.

Биологийн онцлог: 80-120 см өндөр ургадаг, салаалсан урт үндэстэй, 5-12 хос навчинцараас бүрдсэн өдлөг навчтай. Хурц үзүүртэй завь бүхий цагаан бойтгорхуу цэцэгтэй, тасалгаат буурцган жимстэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.

Монгол дах тархалт: Говь-Алт., **Өмнөговь дах тархалт:** Галбын говь, Цагаан хад, Булан сухайт, Хүрэн ханын нуруу, Овоот. **Ургах орчин:** Хужир марзтай, давстай нуга, булаг шандын эрэг, бут сөөгтэй газраар ургана. **Ашигт чанар:** Хортой ургамал, ардын эмнэлэгт хэрэглэнэ. **Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:** Хужир мараалаг хөрсөнд.



Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (*Angiospermae*)

Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)

Leguminosae Juss. - Буурцагтаны овог

Ортуузын төрөл (*Oxytropis* DC.)

Зүйл: *Oxytropis aciphylla* Ldb.-Өргөст ортууз



Статус: Ховор ургамал

Биологийн онцлог: Жижигхэн дэрэрхүү, өргөстэй ургамал. Навчис хос өдлөг, түүний үзүүрийн навчинцар эрт унадаг, навчны бариул хатуурч өргөс болдог, цэцэгт бойтгорхуу, ягаан өнгөтэй, цэцэглэх ишний үзүүрт 1-3 –аараа гардаг. **Амьдралын хэлбэр:** Сөөгөнцөр ургамал. **Монгол дах тархалт:** Ховд., Монг: Алт., Их н., Олон н., Дорн. говь., Говь. –Алт.,

	<p>Зүүнгар., Алаш., Өмнөговь дах тархалт: Хан-Уул, Сэврэй, Номгоны Гурамсингийн тал, Бөөн Загийн тал, Ургах орчин:Уулын бэл, чулуурхаг хажуу, элсэн дээр, заримдаг цөлд сайрын элсэрхэг, хайргархаг ёроолоор ургана.Ашигт чанар:Малын хоолой ам гэмтээдэг өргөс ихтэй хөнөөлт ургамал. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Говийн бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledoneae)</i> <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог Чихэр -өвсний төрөл (<i>Glycyrrhiza</i> L.) Зүйл:<i>Glycyrrhiza uralensis</i> Fisch.-Урал чихэр өвс Статус: Ховор ургамал</p> <p>Биологийн онцлог:Иш эгц босоо мөчирлөг бус, 40-100 см өндөр, навчис 4-8 хос, өндгөрхүү зуувгар, цавуулаг булчирхайтай, цэцэг том, цайбар нил, богинохон цацаг үүсгэнэ, буурцаг том хавчгар, мушгирч тахийсан. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Ханг., Монг.-Даг., Хянг., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар., Алт. өвөр., Алаш., Өмнөговь дах тархалт:Цагаан хад, Булан Сухайт, Наранбулаг, Улаан нуурын хөндий, Номгон сумын дэнгийн худаг, Ургах орчин: Чийглэг марцлаг нуга, марц, хужиртай элс, элсэрхэг хээр, нуур, голын хөндийд ургана. Ашигт чанар:Ногоон үед нь тэмээ сайн, хонь, ямаа дунд зэрэг иддэг. Эмийн гоц ашигт ургамал. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Хужир мараалаг хөрсөнд.</p>
Zygophyllaceae R. Br. -Хотирын овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledoneae)</i> Zygophyllaceae R. Br. -Хотирын овог Хотирын төрөл (<i>Zygophyllum</i> L.) Зүйл:<i>Zygophyllum gobicum</i> Maxim. –Говийн хотир Статус: Ховор, Монголд байгаа завсарын унаган ургамал.</p> <p>Биологийн онцлог: Газар дэвсэж ургасан иштэй, нэг хос тонгоруу өндгөрхүү юмуу гонзгойдуу навчинцартай, навчинцар мэдэгдэхүйц хэлтгий талтай, дагавар навчис хальслаг, хонхорцог далавчгүй, зууван мохоо, шүүслэг, жимсгэнэрхүү. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Говь-Алт., Алт. -өвөр., Алаш. Өмнөговь дах тархалт: Ханбогд сумын Уртын гол, Гурвантэс, Номгон сумын Жаал шанд. Ургах орчин: Толгодын үйрмэг чулуутай хажуугаар ургана. Ашигт чанар: Идэмж тодорхойгүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор саарал хөрсөнд.</p>
Asclepiadaceae R. Br. - Ерөндгөнийн овог	

	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Asclepiadaceae R. Br. - Ерөндгөнийн овог</i> Ерөндгөнийн төрөл (<i>Vincetoxicum</i> N. M. Wolf.) Зүйл: Vincetoxicum sibiricum (L.) Desne. - Сибирь тэмээн хөх Статус: Нэн ховор ургамал Биологийн онцлог: 15-20 см өндөр, саравгар салаархаг ургадаг, навчис шугамархуу юлдэн хэлбэртэй, чагталсан байрлалтай, цэцэг шаравтар цагаан, жижигхэн, тэмээний хөх мэт урт зууван хэтэвчин жимстэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Ханг., Монг.-Даг., Хянг., Монг. Алт., Дунд. Халх., Дор. Монг., Их н., Олон н., Дор. говь., Говь – Алт., Зүүнгар, Алт-өвөр., Алаш., Өмнөговь дах тархалт: Их Аргалант уул, Ханбогд сумын Бага мод, Цогтцэций уул, Их Хачигийн нуруу, Өгөөмөр уул, Баруунсайхан, Дундсайханд. Ургах орчин: Үйрмэг чулуутай болон чулуурхаг хажуу, жижиг сайрын оёор, элсэрхэг хээрээр ургана. Ашигт чанар: Хорт ургамал. Зундаа тэмээ, хонь, ямаа тааруу иддэг. Газар дээрх бие, үр жимсийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
Orobanchaceae Vent. - Гувшаахайн овог	
	<p><i>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae)</i> <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Orobanchaceae Vent. - Гувшаахайн овог</i> Аргамжинцэцгийн төрөл (<i>Cistanche</i> Hoffm. et Link.) Зүйл: Cistanche feddeana Hao - Феддийн аргамжин цэцэг Статус: Элбэг Биологийн онцлог: 15-30 см хүртэл өндөр ургадаг, 7-15 см урт баг цэцэгтэй, хатахдаа харладаг, цоморлиг 4 шугаман юлдэрхүү, жигд биш шүдлэг салбантай, цагаан ноосорхог, дэлбэ 13-18 мм урт, тоосовч нүцгэн. Амьдралын хэлбэр: Шимэгч ургамал. Монгол дах тархалт: Дорн. говь., Алаш., Өмнөговь дах тархалт: Галбын говьд. Ургах орчин: Элсэрхэг цөлд хармаг, заг дээр шимэгчилдэг. Ашигт чанар: Тодорхойгүй.</p>
Solanaceae Juss. - Чэсэнцэрийн овог	
	<p><i>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae)</i> <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Чэсэнцэрийн овог (Solanaceae Juss.)</i> Махирсын төрөл (<i>Lycium</i> L.) Зүйл: Lycium truncatum Wang – Танамал махирс Статус: Ховор, Монголын унаган ургамал. Биологийн онцлог: 1-1.5 см өндөр, цөөн тооны урт хатгууртай, зэгэл саарал өнгөтэй иштэй, юлдэрхүү, махлаг навчтай, хадаасархуу - бүдэг ягаан цэцэгтэй, цэцгийн дохиур дэлбээсээ урт, тод улаан бөөрөнхий жимсгэнэ жимстэй. Амьдралын хэлбэр: Сөөглөг ургамал. Монгол дах тархалт: Дорн. говь., Алаш. Өмнөговь дах тархалт: Галбын говь, Борзонгийн говь. Ургах орчин: Хужирлаг элс, элсэрхэг-хайргархаг цөл, эргийн хайрга, сайрын элс хайргатай ёроолоор дэрс хармагтай холилдон ургана. Ашигт чанар: Эмэнд хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Хужир мараатай хөрсөнд</p>

Asteraceae Dumort. -Голгэсэртэний овог

	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> <i>Төрөл: Шарилж (Artemisia L.)</i> Зүйл: Artemisia santolinifolia Turcz. ex Bess.-Хар шарилж Статус: Ховор ургамал Биологийн онцлог: Ишний доод хэсэг модожсон, дээд хэсэг нь саваархуу, заримдаг сөөг. Навч хошоод- гурвантаа өдлөг цуулбар, сагс тал бөмбөлөг, сагс юмуу залаа бан цэцэгт нэгддэг. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр. Тархалт: Хэнт., Ханг.(өмнөд), Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Ихн., Олонн., Дорноговь., ГовьАлт. Өмнөговь дах тархац:Ханбогд Номгон ууланд, Цогт-Овоо суманд, Ургах орчин: Ихэнхидээ өндөр уулын бүслүүрийн хээрт, уулын чулуурхаг хажуу, нуранга асга, ам хавцлын ёроол ба хад чулуу, эрэг орчим мараалаг нуга, хайрга, гол нуурын элсэрхэг эргээр, сайрын оёорт. Ашигт чанар: Хонь, ямаа, адуу сайн, үхэр, тэмээ дунд зэрэг иддэг.Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Чулуурхаг бор хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> <i>Төрөл: Шарилж (Artemisia L.)</i> Зүйл: Artemisia rutifolia Steph. ex Spreng.-Шаргал шарилж Статус: Ховор ургамал Биологийн онцлог: Үндэсний систем хүчирхэг, модожсон, нягт дэгнүүл үүсгэдэг, навч хошоод юмуу гурвантаа өдлөг цуулбар, сагс өргөн хонхорхуу, тал бөмбөлөг, 5-8 мм өргөн, цацаг юмуу нарийн залаанд нэгддэг, дэлбэ нүцгэн юмуу үсэрхэг, найлзуур цагаан торгомсог үслэгтэй саарал ургамал. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр. Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг.,Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Их н., Говь – Алт., Өмнөговь дах тархац:Ханбогд Номгон ууланд, Гурвансайханд, Ургах орчин: Уулын үйрмэг чулуутай ба чулуурхаг хээржүү хажуу, сайр, асга хаданд ургана. Ашигт чанар: Мал бараг иддэггүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Чулуурхаг бор хөрсөнд.</p>

ҮЛДЭЦ (РЕЛИКТ) УРГАМАЛ

***Ephedraceae* Dum. – Зээргэний овог**



Хүрээ: Нүцгэн үртэний хүрээ (*Gymnospermae*)

Ephedraceae Dum. - Зээргэнийн овог

Зээргэнийн төрөл (*Ephedra* L.)

Зүйл:*Ephedra Przewalskii* Stapf.-Пржевальскийн зээргэнэ

Статус:Ховор.

Биологийн онцлог:10-50 см өндөр ургадаг, заримдаг сөөгөнцөр.Мөчир шулуун ногоон, жимс хуурай боргоцойрхуу.

Амьдралын хэлбэр: Сөөг

Тархалт: Зүүнгар., Алт. Өвөр. **Өмнөговь дах тархалт:**Ханбогдын Галбын говь,

Дэрсэнэ ус, Гурван тэсийн Уушигийн тал, Зурамтай уулын өврөөр. **Ургах орчин:**

Элсэрхэг, хайргархаг цөлийн тэгш тал, уулын бэл хормойд ургана. **Ашигт**

чанар:Хортой. Ногоон мөчир, найлзуур, үндэсийг уламжлалт анагаах ухаанд

хэрэглэнэ. **Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:** Цайвар бор хөрсөнд.

***Ulmaceae* Mirb. –Хайласны овог**



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)

Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)

***Ulmaceae* Mirb. – Хайласны овог**

Хайлаасны төрөл (*Ulmus* L.)

Зүйл:*Ulmus pumila* L.-Одой хайлас

Статус: Ховор

Биологийн онцлог: Мөчрийн хоёр хажуугаар цуваж байрласан, богино бариултай, шүдлэг навчистай, улаавтар ногоон цэцэг навч гарахаас өмнө дэлгэрч бөөн бөөнөөр байрлах бөгөөд хавтгай эмжээр бүхий самранцар жимс үүсгэнэ.

Амьдралын хэлбэр: Мод

Монгол дах тархалт:Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Монг.-Алт., Дунд. Халх.,

Дорн. Монг., Говь-Алт., Зүүнгар., Алаш. **Өмнөговь дах тархалт:** Галбын говьд

Бага модонд.**Ургах орчин:** Сайр садрагаар ургана. **Ашигт чанар:** Навчийг хавар

тэмээ сайн, зун бог мал сайн, намар дунд зэрэг иднэ.**Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:**

Чулуурхаг бор саарал хөрсөнд.

***Chenopodiaceae* Vent. - Луулийн овог**



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)

Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)

Chenopodiaceae Vent. - Луулийн овог

Будраан төрөл (*Iljinia* Kozov)

Зүйл:*Iljinia Regelii* (Bge.) Kozov.-Регелийн будараа

Статус: Нэн ховор, Монголд байгаа завсарын унаган ургамал.

Биологийн онцлог: 10-20 см өндөр, хөх саарал, хатуу хугарамтгай иштэй, навчис махлаг, үзүүрээдээ зантгар бүдүүн, үзүүр нь мохоо, суумал, хатахдаа харалдаг, цэцэг ганц нэгээрээ байрладаг, жимс хуурай далбантай. **Амьдралын хэлбэр:**Заримдаг сөөгөнцөр.**Тархалт:** Зүүнгар., Алт.-өвөр., Алаш. **Өмнөговь дах тархалт:**Ханбогдын Галбын говь, Номгон сумын

Дэрсэнэ ус, **Ургахорчин:** Уул толгодын шохойжсон бутрамтгай чулуулаг хурдас,

элс хайргархаг хормойд ургана. **Ашигт чанар:**Зөвхөн тэмээ жилийн хатсан үед нь

иддэг гэдэг. **Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:** Бор саарал хөрсөнд.

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог Шар модны төрөл (<i>Sympegma</i> Bge.) Зүйл: <i>Sympegma Regelii</i> Bge.-Регелийн шар мод Статус: Монголд байгаа завсарын унаган , үлдэц ургамал.</p> <p>Биологийн онцлог: Өргөслөг навчистай ба мөчрийн үзүүрт толгойрхуу баг цэцэгтэй, зэвгэрдүү шар ногоон өнгөтэй, 15-25 см өндөр ургадаг. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр. Тархалт: Монг. –Алт., Их н.,Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар., Алт.-өвөр., Алаш. Өмнөговь дах тархалт:Ханбогдын Галбын говь, Номгон сумын Дуйнаг уул, Ургах орчин: Уул толгодын чулуурхаг хажуу, хормойн хайргархаг тэгш газар ургадаг, холимог сөөгөнцөрт болон загт цөлийн шинж бүрдүүлэгч ургамал. Ашигт чанар:Тэмээ жилийн 4 улирлын турш идээшилдэг, тэжээлийн сайн ургамал. Бог мал зундаа тааруухан иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Бор саарал хөрсөнд.</p>
--	--

Zygophyllaceae R. Br. -Хотирын овог

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Zygophyllaceae</i> R. Br. -Хотирын овог Хотирын төрөл (<i>Zygophyllum</i> L.) Зүйл: <i>Zygophyllum xanthoxylon</i> (Bge.) Maxim.- Шар хотир Статус: Элбэг Биологийн онцлог: Навчис шугаман гонзгой юмуу шугаман хүрээрхүү, махлаг, хонхорцог бөөрөнхийдүү, 4 далавчтай, том. Амьдралын хэлбэр:Сөөглөг ургамал. Монгол дах тархалт:Монг. –Алт., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар, Алт. -өвөр., Алаш.Өмнөговь дах тархалт: Галбын говь, Борзонгийн говь, Загсүүжийн говь, Номгоны Дуйнаг уул.Ургах орчин: Хайргархаг бэл, сайрын элс, хайрган ёроол, чулуурхаг хажууд ургана. Ашигт чанар: Газар дээрх биеийг архаг усан хаван, элэгний өвчинг эмнэнэ.Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Уулын чулуурхаг бор, бор саарал хөрсөнд.</p>
--	---




Tamaricaceae Link. - Сухайн овог

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Tamaricaceae</i> Link. - Сухайн овог Улаанбударганын төрөл (<i>Reaumuria</i> L.) Зүйл: <i>Reaumuria soongorica</i> (Pall.) Maxim.-Зүүнгарын улаан бударгана Статус: Эртний цөлийн үлдэц ургамал. Биологийн онцлог: 10-25 см хүртэл өндөр сөөг, дэвсмэл юмуу өндиймөл, өтгөн навчирхаг мөчиртэй,Газраар зулж ургадаг, 10-25 см өндөр ургадаг, дэлхээ иштэй, 1-5 мм урт бэлцгэрдүү саарал навчтай, сийрэг цацагт нэгддэг таван гишүүнт цагаан цэцэгтэй, үр үсэрхэг. Амьдралын хэлбэр: Олон наст сөөглөг ургамал. Монгол дах тархалт: Ховд., Монг.-Алт., Дунд Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь, Говь-Алт., Зүүнгар, Алт. -өвөр., Алаш., Өмнөговь дах тархалт: Галбын говь, Борзонгийн говь, Загсүүжийн говь, Зулганай. Ургах орчин: Үйрмэг чулуутай</p>
--	--

	<p>элсэрхэг, довцог, хайргархаг цөл, тойрмын зах, хужиртай газар, уулын бэлд ургана. Ашигт чанар: Хавар, зун тэмээ сайн, намар дунд, өвөл үхрээс бусад төрлийн мал дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Мараалаг хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Tamaricaceae</i> Link. - Сухайн овог Сухайн төрөл (<i>Tamarix</i> L.) Зүйл: <i>Tamarix ramosissima</i> Ldb.-Олон цэцэгт сухай Статус: Гуравдагчийн голын татмын ойн үлдэц ургамал. Биологийн онцлог: 2.5-3 м хүртэл өндөр сөөг, улаан хүрэн, хүрэн ягаан холтостой, навч хайрсархуу бөгөөд зүймэл, нүцгэн, цэцэг улаан ягаан, дохиурын утас сууриадаа өргөсөөгүй, нарийн шилбэтэй, цацаг 3-6 см урт, саравгар залаа үүсгэдэг. Амьдралын хэлбэр: Сөөг. Монгол дах тархалт: Их н., Говь-Алт., Зүүнгар, Алт. -өвөр., Өмнөговь дах тархалт: Гурвантэс сумын Олон сухайт, Мандал овоосум. Ургах орчин: Молцог элс, тойрмын зах, элсэрхэг хээрээр ургана. Ашигт чанар: Хортой гэх боловч тэмээ хавар зун дунд зэрэг, намар өвөл тааруухан иддэг. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Хужир мараалаг хөрсөнд.</p>
<p>Umbelliferae Juss. - Шүхэртэний овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Umbelliferae</i> Juss. - Шүхэртэний овог Хаврагын төрөл (<i>Ferula</i> L.) Зүйл: <i>Ferula bungeana</i> Kitag. - Бүнгийн хавраг Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал Биологийн онцлог: Голлосон том махлаг үндэстэй, 15-30 см өндөр ургадаг дэрэвгэр салаатай, үндэс орчмын навчис хатуу, илтэс нь гурвалжиндуу, гурвантаа цуулбар өдлөг салбантай, нийлмэл шүхэр баг цэцэгтэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Дунд. Халх., Дорн-Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алаш., Өмнөговь дах тархалт: Ончын хяр, Номгон, Цэций уул. Ургах орчин: Элсэрхэг хайргархаг цөлжүү бэл хормой, байц хаданд, элсэрхэг хээрт ургана. Ашигт чанар: Үндэсийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн бор, цөлийн саарал хөрсөнд.</p>
<p>МОНГОЛЫН УНАГАН УРГАМАЛ</p>	
<p>Chenopodiaceae Vent. - Луулийн овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог Бударганын төрөл (<i>Salsola</i> L.) Зүйл: <i>Salsola laricifolia</i> Turcz. ex Litv.- Шинэсэрхүү бударгана, Загсагал Статус: Монголын унаган ургамал. Биологийн онцлог: Өргөслөг, хатуу, сэрэвгэр мөчиртэй, 30-40 см хүртэл өндөр ургадаг, навчис хөх ногоон, багцалсан, богинохон булцгар бортгорхуу, цэцгийн шадар эрхтэн жимслэх үед гадагшаа одорхуу болж салдаг. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөг. Тархалт: Дорн. говь., Говь-Алт., Алаш., Өмнөговь дах тархалт: Номгон сумын Дуйнаг уул, Ханбогд сумын Номгон уул. Ургах орчин: Уул толгодын чулуурхаг хажуу, хад асганд ургана. Ашигт чанар: Залуу найлзуур, навчийг тэмээ, хонь, ямаа дунд зэрэг, гантай жил сайн иддэг. Хөрсний бүтэц,</p>

<p>бүрэлдэхүүн: Цайвар бор саарал хөрсөнд.</p>	
<p><i>Caryophyllaceae</i> Juss. -Баширын овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Caryophyllaceae</i> Juss. -Баширтаны овог Тайрын төрөл (<i>Gypsophila</i> L.) Зүйл: <i>Gypsophila desertorum</i> (Vge.) Fenzl -Цөлийн тайр Статус: Монголын унаган ургамал. Биологийн онцлог: 5-10 см хүртэл өндөр ургадаг, шугамархуу шөвгөн навчтай, маш их булчирхайт үсэрхэг ургамал. Цэцэг цагаан, ягаан хосолсон дэлбэтэй, цоморлиг хонхорхуу. Амьдралын хэлбэр: Олон наст ургамал Монгол дах тархалт: Монг. Алт., Дорн. Монг., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алаш. Өмнөговь дах тархалт: Хан уул. Ургах орчин: Цөлийн хайргат ба элсэрхэг тэгш тал, элсэрхэг ба хайргархаг хжуу хээр, уулын бэл, байц, хуурай хайрганд ургана. Ашигт чанар: Зун, намар бог мал сайн, тэмээ бага зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
<p><i>Cruciferae</i> Juss. – Тоонолжин цэцэгтэний овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) Овог: <i>Тоонолжин цэцэгтэний овог (Cruciferae Juss.)</i> Төрөл: <i>Багдайн төрөл (Dontostemon Andrz.)</i> Зүйл: <i>Dontostemon perennis</i> С.А.Мей.-Олон наст багдай Статус: Монголын унаган ургамал. Биологийн онцлог: 3,5 см өндөр ургадаг. Навч махлаг зузаан биш, шугамархуу, зөөлөн тачир налчгар, муригар үсэрхэг, цэцэг цэцэг 4 гишүүнт, цайвар ягаан, гэрцэг 2-2,5 см урт, 0,5-1 см өргөн. Амьдралын хэлбэр: Олон наст ургамал. Тархалт: Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алт. өвөр. Ургахорчин: Чулуурхаг ба хайргат хажуу, байц цохио, сайр садарга, хужирлаг элсэнд ургана. Ашигт чанар: Бог мал зун сайн, тэмээ дунд зэрэг иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулаархаг бор хөрсөнд.</p>
<p><i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог Хунчирын төрөл (<i>Astragalus</i> L.) Зүйл: <i>Astragalus Pavlovii</i> В. Fedtsch. et Basil.-Павловын хунчир Статус: Монголын унаган ургамал. Биологийн онцлог: Навчинцар 2-3 хос сондгой өдөлсөн нийлмэл, шонзгойдуу тонгоруу өндгөрхүү, үзүүртээ ухлаадас буюу оньтой, цэцэг бойтгорхуу, ягаан өнгөтэй, цоморлиг хонхондуу буурцаг гонзгой юлдэрхүү, гурван талтай. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Говь-Алт., Алт. өвөр., Алаш. Өмнөговь дах тархалт: Галбын говь, Бөгтөр хөөвөр худаг, Цогт-Цэций, Ханбогдын Дайчингийн заг. Ургах орчин: Уул толгодын хээржүү хажуу, марцлаг нугад ургана. Ашигт чанар: Мал дуртай идэж хорддог. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цөлийн бор саарал хөрсөнд.</p>

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог Хунчирын төрөл (<i>Astragalus</i> L.) Зүйл: <i>Astragalus Grubovii</i> Sancez.-Грубовын хунчир Статус: Монголын унаган ургамал. Биологийн онцлог: Бараг ишгүй, цэцэг цагаан шаргал өнгөтэй, навчис өрөөслөг өдлөг, навчинцар 4-12 хос, өргөн өндгөрхүү, ширүүн сэгсгэр үслэгтэй, буурцаг гонзгой-өндгөрхүү, 3-8 мм урт шонгонттой. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Дунд Халх., Олон н., Дорн. говь., Говь.-Алт., Алт. өвөр., Алаш., Өмнөговь дах тархалт: Дайчингийнзагийн зүүн хоолойд. Ургах орчин: Элсэрхэг хайргархаг цөлийн хээр, толгодын элсжүү сийрэг хайргажуу хормойгоор ургана. Ашигт чанар: Идэмж тодорхойгүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог Хунчирын төрөл (<i>Astragalus</i> L.) Зүйл: <i>Astragalus vellestris</i> R.Kam.-Хөндийн хунчир Статус: Монголын унаган ургамал. Биологийн онцлог: Бараг ишгүй, баг цэцэг үндэс орчимд байрладаг, суумал байрладаг, цэцэг цагаан, цайвар ягаан өнгөтэй, навчис ганц, юлдэрхүү хэлбэртэй, хоёр тал нь үсэрхэг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Олон н., Дорн. говь., Говь-Алт., Өмнөговь дах тархалт: Ханбогд, Цогт-овоо, цогт цэций, Цэций уул, Гурвансайханы нуруу, Баян-Овоо, Ургах орчин: Сайраар ургана. Ашигт чанар: Идэмж тодорхойгүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог Хунчирын төрөл (<i>Astragalus</i> L.) Зүйл: <i>Astragalus variabilis</i> Vge.ex Maxim.- Хувьсанги хунчир Статус: Монголын унаган ургамал. Биологийн онцлог: Үндэс модожсон, иш өндиймөл, навч сондгой өдөлсөн нийлмэл, цэцэг бойтгорхуу, улбар ягаан өнгөтэй, цоморлиг хонхондуу буурцаг шугаман гонзгойдуу, налчгар үсэрхэг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Олон н., Говь-Алт., Дорн. говь., Зүүнгар., Алт. өвөр., Алаш. Өмнөговь дах тархалт: Гурвансайханы нуруу, Тост уул, зурамтай уул, Буулган сум, Галбын говь, Бөгтөр хөөвөр худаг, Цогт-Цэций, Ханбогдын Дайчингийн заг. Ургах орчин: Хайргархаг бэл, марц хужиртай элс, сайрын ёроол, тойрмын эргэн тойронд ургана. Ашигт чанар: Мал дуртай идэж хорддог. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цөлийн бор саарал хөрсөнд.</p>
<p style="text-align: center;">Plumbaginaceae Juss. - Хорголжингийн овог</p>	




	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Plumbaginaceae</i> Juss. - Хорголжингийн овог Бэрмэгийн төрөл (<i>Limonium</i> Mill.) Зүйл:<i>Limonium erythrorhizum</i> Ik. -Gal. ex Lincz. - Улаан үндэст бэрмэг Статус: Элбэг Биологийн онцлог: 5-20 см өндөр ургадаг, сууриасаа их салаалсан, тахиралдсан, дэвсгэл иштэй, суурьтаа навчны бараан хүрэн үлдэгдлээр хучигдсан, үндэсний холтос улбар ягаан, цэцгийн цоморлиг цагаан, дэлбэ шар. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.Монгол дах тархалт: Дорн. говь., Говь-Алт., Алаш., Өмнөговь дах тархалт: Ханбогд, Номгон сумын Дуйнаг уулын сайр,Ургах орчин: Марзтай хөвсгөр газар, голын эргийн элс, хужиртай бэл хормойд ургана. Ашигт чанар: Цэцгийн Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Мараалаг хөрсөнд.</p>
<i>Verbenaceae</i> Jaume. - Догарын овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Verbenaceae</i> Jaume. –Догарын овог Догарын төрөл (<i>Caryopteris</i> Bge.) Зүйл:<i>Caryopteris mongolica</i> Bge.- Монгол Догар Статус: Элбэг Биологийн онцлог: Ихэд салаалсан, 20-40 см, өндөр сөөг. Залуу мөчир нь хүрэн улаан холтостой, навч, найлзуур нь тачир цагаан үсээр өвч хучигдмал. Навч эсрэг байрлалтай, суумал, юлдэрхүү, 2 үзүүрээдээ шувтан, өвөр тал нь ногоон, ар тал нь цайвар. Цэцэг хөх ягаан өнгөтэй, сагс баг цэцэгт нэгддэг. Жимс 4 далавчтай, торлог судалтай, бутрамтгай, самранцар. Амьдралын хэлбэр: Сөөглөг ургамал. Тархалт:хэнт., Ханг., Монг.–Даг., Монг. Алт., Дунд. Халх, Дор. Монг., Олон н., Говь - Алт., Алт.Өвөр., Алаш. Өмнөговь дах тархалт: Зөөлөнгийн нуруу, Зүүнсайхан, Дундсайхан, Баруунсайханд. Ургах орчин: Хайргархаг далавч ба цөлжүү хажуу, байц цохио, голын хаялга, элсэн хурдсан дээр өсдөг. Ашигт чанар:Газрын дээх биеийг гэдэс өвдөх, хоолны шингэц муудах, хий, чийгний гаралтай саа өвчин, шээс хаагдах, хавдар зэрэгт хэрэглэнэ.Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) Уруул цэцэгтэний овог (<i>Labiaceae</i> Lindl.) Гангын төрөл (<i>Thymus</i> L.) Зүйл:<i>Thymus gobicus</i> Tschern. - Говийн ганга Статус: Монголын унаган ургамал Биологийн онцлог: Иш дэлхмэл, цэцэглэх мөчир нягт үсэрхэг, багццэгийн дор арай илүү өтгөн. Ишний ба дагавар навч уртассан-юлдэн хэлбэртэй, доод талдаа нүцгэн, дээд талдаа олон эст урт үслэгээр бүх гадаргуудаа сийрэг юмуу доод хэсэгтээ шавааралдсан үслэгтэй, цэцгүүд толгойрхуу багццэцэгт нэгддэг, дэлбэ сарнайн ягаан өнгөтэй, 2 уруултай. Амьдралын хэлбэр:Заримдаг сөөгөнцөр ургамал. Монгол дах тархалт: Хөвс., Ханг., Монг. -Даг., Монг.-Алт., Дунд. Халх, Дорн.–Монг., Их н., Олон. н, Говь Алт., Өмнөговь дах тархалт: Зүүн, дунд, баруун сайхан. Ургах орчин: Хад, нуранги асга, чулуурхагхээржүү хажуу,</p>

	<p>цөлөрхөг хээр, голын хайргархаг эрэг, суумал элсэнд ургана. Ашигт чанар:Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Чулуурхаг говийн бор хөрсөнд</p>
Asteraceae Dumort. -Голгэсэртэний овог	
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>) Боролзын төрөл (<i>Ajania Poljak.</i>) Зүйл:<i>Ajania acheleoides (Turcz.) Poljak.-Төлөгчдүү боролз</i> Статус:Элбэг Биологийн онцлог: Навч хошоод гурвантаа өдлөг цуулбар, сагс шар, бамбайд нэгддэг, сагсны ороолтын гаднах навчинцар өтгөн үслэгтэй. Амьдралын хэлбэр:Жижиг заримдаг сөөгөнцөр. Тархалт: Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Их н., Олон н., Дорн. говь., Говь – Алт., Алаш.Өмнөговь дах тархац: Манлай, Ургах орчин: Уулын чулуурхаг ба үйрмэг чулуутай хажуу, хад, хайрга чулуутай сарын оёор ба садрагад ургана.Ашигт чанар:Бүх төрлийн мал намар, өвөл, хавар сайн иддэг, зун арай дутмаг иддэг. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>) Төрөл:<i>Шарилж (Artemisia L.)</i> Зүйл:<i>Artemisia gobica (Krasch.) Grub.-Говийн шарилж</i> Статус: Монголын унаган ургамал. Биологийн онцлог: Нарийхан модлог үндэстэй, 20-50 см өндөр ургадаг, навчис гурвантаа өдлөг цуулбар, цагаавтар эсгийлэг үсэрхэг ургамал. сагс 4-5 мм урт, 2-3 мм өргөн, цацагархуу залаанд нэгддэг. Амьдралын хэлбэр:Заримдаг сөөгөнцөр ургамал. Тархалт: Монг-Даг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дор. Монг., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Зүүнгар, Алт.өвөр., Алаш. Өмнөговь дах тархац: Сэврэй, Ноён сумдын нутагт. Ургах орчин:Ээлсэрхэг хээрт ургана. Ашигт чанар: Тэмээ, адуу, бог мал намар орой сайн, өвөл дунд зэрэг, хавар зун тааруу иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор ба элсэн хөрсөнд.</p>
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>) Төрөл:<i>Банздоо (Saussurea DC.)</i> Зүйл:<i>Saussurea laciniata Ldb.-Имт банздоо</i> Статус: Монголын унаган ургамал. Биологийн онцлог: Иш 10-30 см өндөр, уг өнгөрсөн оны навчны угларгын үлдэгдлээр хучигдсан, иш бага зэрэг далбанлаг, навч өдлөг цуулбар, салбангууд бие биенээсээ алслагдсан, мөгөөрслөг хурц үзүүртэй, сагс иш мөчрийн оройд бамбайрхуу залаа баг цэцэг үүсгэдэг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Ханг., Монг. –Даг., Монг. Алт., Дунд. Халх., Их н., Олон н., Говь – Алт.,Алт. өвөр., Алаш.. Өмнөговь дах тархац: Ханхонхор, Ханбогд суманд. Ургах орчин: Хужирлаг, нуга ба сайрын мараалаг адгаар ургана. Ашигт чанар: Тэмээ иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Хужир мараат хөрсөнд.</p>

	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> <i>Төрөл: Хависгана (Scorzonera L.)</i> Зүйл: Scorzonera pseudodivaticata Lipsch.-Хуурамч дэрэвгэр хависгана Статус: Монголын унаган ургамал. Биологийн онцлог: 50 см хүртэл өндөр ургадаг, доод хэсэгтээ модожсон, иш дээд ба дунд хэсгээрээ салаалсан, уг орчимдоо навчны хатсан угларга дугтуйтай. Ишний навч нарийн шугаман, ихэвчлэн дэгээрхүү нугархай үзүүртэй. Сагс хэлэрхүү шар цэцэгтэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Монг. Алт., Дорн.-Монг., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алт.-өвөр., Алаш., Өмнөговь дах тархац: Цогт-Овоо, Цогтцэций, Манлай зэрэг хойд талын сумдаар. Ургах орчин: Цөлд үйрмэг чулуутай ба чулуурхаг цөлийн хээрийн хажуу, хормой, нураг, сайр, ам хавцлын хөвөө, оёор, нимгэн элсэнд ургана. Ашигт чанар: Хонь, ямаа ногоон үед нь дундаас сайн иднэ. Газар дээрх биенийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> <i>Төрөл: Хависгана (Scorzonera L.)</i> Зүйл: Scorzonera mongolica Maxim.-Монгол хависгана Статус: Монголын унаган ургамал. Биологийн онцлог: Иш өндиймөл, бүдүүн, 6-10 см урт, хааяа эгц босоо, 30 см хүртэл өндөр ургадаг, цөөвөр сийрэг навчтай, уг орчимдоо хаьсан навчны бариулын хальслаг үлдэгдэлтэй, навч хөх саарал, үндэс орчмын навч урт бариултай, шугаман лодэрхүүгээс өргөн юлдэн. Сагс 20-25 см урт, хэлэрхүү шар цэцэгтэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Олон н., Дор.говь., Говь – Алт., Алт.-өвөр., Алаш., Өмнөговь дах тархац: Ханбогдын Номгон ууланд. Ургах орчин: Уул толгодын үйрмэг чулуутай мараалаг хажуу, хормойд ургана. Ашигт чанар: Хонь, ямаа, янгир намар, өвөл сайн иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> <i>Төрөл: Багваахай (Taraxacum Wigg.)</i> Зүйл: Taraxacum commixitiforme Soest.-Холимог хэлбэрт багваахай Статус: Монголын унаган ургамал. Биологийн онцлог: Иш навчгүй, голдоо хөндий, сүүн шүүстэй, Навч дэвсээ, жигд биш өдлөг хуваагдмалаас өдлөг цуулбар, урт шугаман, хурц хөндлөн салбан завсрын богино салбанцартай ээлжилдэг, төгсгөлийн салбан нарийн шугамархуу юмуу гурав хуваагдмал, үзүүртээ нэг шар өнгийн сагс баг цэцэгтэй, бүх ороолт эврэрхүү сэртэнтэй. Статус: Монголын унаган ургамал. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Монг. -Даг., Их н., Говь – Алт., Өмнөговь дах тархац: Ханбогдын уртын гол, Хөрхийн нуруунд. Ургах орчин: Эрэг орчмын ба булгийн ойролцоох мараалаг нугад ургана. Ашигт чанар: Идэмж тодорхойгүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Хайргархаг бор хөрсөнд.</p>

МОНГОЛД БАЙГАА ЗАВСАРЫН УНАГАН УРГАМАЛ
Gramineae Juss. Үетэний овог

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i></p> <p>Gramineae Juss. - Үетэний овог</p> <p>Сулийн төрөл (<i>Psammochloa Hitchc.</i>)</p> <p>Зүйл: <i>Psammochloa villosa (Trin.) Bor.</i> - Үсхий суль</p> <p>Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал.</p> <p>Биологийн онцлог: Урт үндэслэг иштэй, 10-20 см гүнд салбарласан мөлхөө урт найлзууртай, навч өргөн шугаман, хумираа, 30-40 см урт, цэцэгт иш 100-130 см өндөр, ооройдоо 20-25 см хүртэл урт, нарийвтар өтгөн залаатай, цэцгийн доод хайрс үсэрхэг, үр тариан жимс 0,5-0,8 см хүртэл урт, хөх ягаан туяа бүхий харавтар үртэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Дорн. Монг., Их н, Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алаш., Өмнөговь дах тархалт: Хонгорын элс, Жарангийн элс, Ургах орчин: Элсэн манханд ургана. Ашигт чанар: Жилийн дөрвөн улиралд бод мал маш сайн, бог мал дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Хужир мараалаг хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i></p> <p>Gramineae Juss. - Үетэний овог</p> <p>Хялганын төрөл (<i>Stipa L.</i>)</p> <p>Зүйл: <i>Ptilagrostis Pelloitii (Danguy) Grub.</i> - Пеллитын шивэлз</p> <p>Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал.</p> <p>Биологийн онцлог: Сахлаг үндэстэй, сийрээг бугаар ургадаг, хуурайсаг ургамал. Иш босоо боловч үе орчимдоо тахигар, доод үелэлийн нарийн шугаман навчтай, сагсгар сийрэг залаатай, цэцгийн доод хайрс бүхэлдээ үсэрхэг, сор нь өдөрхүү. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: ᠯᠡᠭᠡᠢ., ᠠᠶᠢᠳᠡ.ᠠᠶᠢᠠᠭᠢ., ᠠᠶᠢᠠᠭᠢ-ᠠᠶᠡᠳᠡ., ᠠᠶᠡᠳᠡ.ᠶᠡᠳᠡ., ᠴᠢᠴᠢᠶᠠᠳᠡ., Алаш. Өмнөговь дах тархалт: Баруун Сайханд. Ургах орчин: Уул, дов толгодын чулуурхаг хажуу, орой, байц хаданд ургана. Ашигт чанар: Жилийн дөрвөн улиралд тэмээнээс бусад мал сайн иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн чулуурхаг цайвар бор хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i></p> <p>Gramineae Juss. - Үетэний овог</p> <p>Хялганын төрөл (<i>Stipa L.</i>)</p> <p>Зүйл: <i>Stipa gobica Roshev.</i> - Говийн хялгана</p> <p>Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал.</p> <p>Биологийн онцлог: 7-15 см өндөр иштэй, сахлаг үндэстэй, жижиг шигүү бугаар ургадаг, хуурайсаг ургамал. Навч болон навчны угларга маш их үсэрхэг, цайвар саарал, шивээний сор 4,5-7 см урт, нэг нугархай, доод нугархай нь үсгүй, эрчлээстэй, дээд эрчлээсгүй хэсэг нь 5 мм өдөрхүү үрт үстэй, Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Ханг., Монг. Дэг., Ховд., Монг.Алт., Дунд. Халх., Их.н., Олон.н., Дорн.говь., Говь.Алт., Алт.өвөр., Зүүнгар., Алаш. Өмнөговь дах тархалт: Баян-Овоо, Хүрмэн, Баяндалай, Ноён, Гурвантэс, Сэврэй, Булган сумдын нутагт. Ургах орчин: Үйрмэг чулуутай хажуу ба уул толгодын хормой, хайрга чулуутай цөл, хайргатай сайрын адгаар ургана. Ашигт чанар: Жилийн дөрвөн улиралд таван хошуу мал маш сайн иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн чулуурхаг бор, цайвар бор хөрсөнд.</p>
<p>Liliaceae Juss. - Сараанын овог</p>	

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i> Liliaceae Juss. – Сараанын овог Хэрээ нүдэний төрөл (<i>Asparagus L.</i>) Зүйл: <i>Asparagus gobicus Ivanova.ex Grub.</i>-Говийн хэрээннүд Статус: Монголд байгаа завсарын унаган урамал Биологийн онцлог: Дээсэрхүү сахлаг үндэстэй, богино үндэслэг иштэй, иш 2-5, өвдөлгөж нугарсан боловч босоо, 10-35 см өндөр, кладоди бүдүүн, хатуу, 1-1,5 мм өргөн, 5-15 мм урт, багцандаа их сэрэвгэр, задгай, мөчрөөсөө шууд эгц гардаг, саарал ногоон ургамал. Цэцэг ногоовтор шаргал, хонхорхуу, мөчрөнцөрийн өвөрт ганц нэгээр ургадаг, жимс улаан, олон хар үртэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Монг. –Алт., Дунд. Халх., Их н., Олон н., Говь-Алт. Дорн. говь., Алаш., Зүүнгар, Алт.өвөр. Ургах орчин: Элсэрхэг цөл, уулын хормой, элсэрхэг чулуурхаг хөрсөнд ургана. Ашигт чанар: Хонь, ямаа хавар, зун тааруу намар муу иднэ. Адуу, үхэр идэхгүй. Жимсийг огт идэхгүй. Үндэс, газрын дээх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт мэдрэлийн гаралтай арьсны үрэвсэл, үе мөч хавдахад хэрэглэнэ.</p>
<p>Alliaceae -Сонгинын овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i> Alliaceae L.-Сонгинын овог Сонгинын төрөл (<i>Allium L.</i>) Зүйл: <i>Allium mongolicum Rgl.</i>- Хөмөл Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал. Биологийн онцлог: 10-20 см өндөр нарийн цоорон иштэй, хөрсөн дор хэвтээ байрлал бүхий үндэслэг иштэй, жижиг бугаар ургадаг, шаргалдуу сонгинолог булцуутай, навчис хөх ногоон өнгөтэй, утсархуу, 2 мм бүдүүн шүүслэг бэлцгэр, дотроо хөндий. Цэцэг улбар ягаан өнгөтэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Дунд.Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь –Алт., Алт. өвөр., Алаш., Зүүнгар. Өмнөговь дах тархалт: Бүх сумдын нутагт. Ургах орчин: Элсэрхэг чулуурхаг хээр, хайргархаг, чулуурхаг цөлд ургана. Ашигт чанар: Хүнс-тэжээлийн ургамал. Зоодой хийдэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн бор, цөлийн саарал хөрсөнд.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i> Alliaceae L.-Сонгинын овог Сонгинын төрөл (<i>Allium L.</i>) Зүйл: <i>Allium polyrrhizum Turcz. ex RgL.</i>-Таана буюу багалгарсонгино Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал. Биологийн онцлог: 10-25 см өндөр ургадаг, өтгөн сахлаг үндэстэй, сонгинолог булцуу бараг үл мэдэгдэм, тэдгээр нь навчны хүрэн хатсан угларгаар хучигдаж, товх маягийн тав үүсгэдэг, навчис 2-3, шүүслэг боловч бэлцгэр бус, тал бөөрөнхий, утсархуу, тал бөсбөлөг шүхэр баг цэцэгтэй, цэцэг цагаан, цайвар ягаавтар, бүдэг судалтай. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Монг.-Алт., Дунд.Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь –Алт., Алт. өвөр., Алаш. Өмнөговь дах тархалт: Цөлөрхөг хээрийн сумдын нутагт. Ургах орчин: Чулуурхаг, хайргархаг цөл, цөлийн хээрт ургана. Ашигт чанар: Шимт чанараар өндөр, зоодой, дарш хийдэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн бор хөрсөнд.</p>

Iridaceae Juss. - Цахилдагийн овог



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
 Нэг талт үрт ургамлын анги (*Monocotyledonae*)
 Iridaceae Juss.-Цахилдагны овог
 Цахилдагны төрөл (*Iris L.*)
Зүйл:*Iris Bungei Maxim.*- Бунгийн цахилдаг
Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал
Биологийн онцлог: 6-20 см өндөр ургадаг, жижигхэн намхан дэгнүүлтэй, навчис 4-8 мм өргөн, сэлмэрхүү зузаан, цэцэг хөх ягаан, хучаас навч түнтгэр, тод тууш судалтай. **Амьдралын хэлбэр:** Олон наст өвслөг ургамал. **Монгол дах тархалт:** Дунд.Халх., Олон н., Дорн. говь., Говь –Алт., **Өмнөговь дах тархалт:** Номгоны Гурамсингийн тал, Хөрхийн нуруу, **Ургах орчин:**Элсэрхүү, элс-хайрган цөлийн хээр, толгодын бутармаг-чулуурхаг хажуу, сайрын ёроолд ургана. **Ашигт чанар:** Хатсан үед нь тэмээ, бог мал сайн, үхэр, адуу муу иднэ. Үндэс, цэцэг, үрийг эмэнд хэрэглэнэ. **Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:** Цайвар бор хөрсөнд.


Chenopodiaceae Vent. - Луулийн овог






Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
 Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)
 Chenopodiaceae Vent. - Луулийн овог
 Хамхуулын төрөл (*Corispermum L.*)
Зүйл:*Corispermum mongolicum Cjin*-Монгол хамхуул
Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал.
Биологийн онцлог: Жимс маш жижигхэн, 1,5-2 мм, хааяа 2,5 мм урт, хавтгай-гүдгэр, зузаан эсвэл гонзгой- тонгоруу өндгөрхүү, аажим вмуу огцом сунаж шонтон үүсгэнэ, нуруун талдаа жижиг товруутай, харавтар, бараан-саарлаас бараг хар юмуу заримдаа шаравтар хүрэн, бүдэг юмуу бүүдгэр. Баг цэцэг голдуу урт, шугамархуу, сийрэг. Цэцгийн дагавар навчинцар юлдэрхүү, эрс хальсан эмжээртэй. **Амьдралын хэлбэр:** Нэг наст өвслөг ургамал. **Тархалт:** Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд, Олон н., Их н., Дорн говь., Говь Алт., Зүүнгар, Алт.өвөр, Алаш. **Ургах орчин:** Нүүнги болон тогтворгүй элс, элсэрхэг ба бутарамхай чулуурхаг хээр, сондуул, нуурын элс, хайргатай эрэг, сайрын ёроол, уул толгодын элсжсэн хажуу, эргийн дэрсэн дунд ургана. **Ашигт чанар:** Тэмээ зундаа дунд зэрэг, намар, өвөл сайн иддэг. Хонь, ямаа зундаа муу, өвөл дунд зэрэг иддэг.



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
 Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)
 Chenopodiaceae Vent. - Луулийн овог
 Бударганын төрөл (*Salsola L.*)
Зүйл:*Salsola passerina Vge.*-Бор бударгана
Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал.
Биологийн онцлог:Бөөрөнхий нахиагаар өвч хучигдсан мөчир бүхий хөх саарал өнгөтэй, найлзуур нахиа ь хоср үзүүртэй үсээр нягт бүрхэгдсэн. **Амьдралын хэлбэр:** Заримдаг сөөг
Тархалт: Их н., Олон н.,Дорн. говь., Говь-Алт., Алт.-өвөр., Алаш., **Өмнөговь дах тархалт:**Галбын говь, Номгон сумын Дуйнаг уул, **Ургах орчин:** Шавартай тойром, нуурын хужирлаг элс, хонхор газар, уул толгодын чулуурхаг хажууд ургана. **Ашигт чанар:**Тэмээ өвөл, намар, хавар маш сайн, зундаа тааруу, хонь ямаа өвөл, хавартаа сайн, зун намартаа дунд зэрэг иддэг. **Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:**Хужир мараалаг хөрсөнд.

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> Chenopodiaceae Vent. - Луулийн овог Бадарганын төрөл (<i>Kalidium</i> Moq.) Зүйл: <i>Kalidium caspicum</i> (L.) Ung.-Sternb.-Каспийн бадаргана Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал. Биологийн онцлог: Хөхөвтөр ногоон юмуу зэгэл, намартаа өнгө нь хувирдаггүй, өндөр эгц босоо иштэй, зөвхөн дээд хэсгээрээ салаалдаг, навчны илтэс огт байхгүй, цэцэг нь нарийхан, шугаман борбтгорхуу түрүү үүсгэдэг. Амьдралын хэлбэр: Сөөглөг ургамал. Монгол дах тархалт: Дорн. говь., Зүүнгар. Өмнөговь дах тархалт: Бага мод, Ханхонгор сумын Адаг Замын худаг. Ургах орчин: Марц мараа, хужир марцтай дэрсэн шигэги, хөрсний ус дээшлэн хужирлаг толбо үүссэн газраар ургана. Ашигт чанар: Тэмээ ногоон үед нь тааруу, өвөл, хавар дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Мараалаг хөрс.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> Chenopodiaceae Vent. - Луулийн овог Бадарганын төрөл (<i>Kalidium</i> Moq.) Зүйл: <i>Kalidium gracile</i> Fenzl.- Гоолиг бадаргана Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал. Биологийн онцлог: Гүн ногоон өнгөтэй, намар эхлээд улаан, дараа нь улбар шар болдог, их салаалсан гол иштэй, 50 см хүртэл өндөр ургамал. Навчны илтэс огт байхгүй, цэцэг нь ганц нэгээр байрладаг. Амьдралын хэлбэр: Сөөглөг ургамал. Монгол дах тархалт: Ханг., Монг.-Даг., Дунд. Халх, Дорн.-Монг., Их н., Олон н., Дорн.-Говь, Говь-Алт., Алт.-өвөр., Алаш. Өмнөговь дах тархалт: Бүх сумдын нутагт тааралддаг. Ургах орчин: Тойром, шавар болон хөвсгөр марцтай газар, гол нуурын хужир марцтай эрэг, хотгор хоолойд ургана. Ашигт чанар: Тэмээ ногоон үед нь тааруу, өвөл, хавар дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Мараалаг хөрс.</p>
<p>Cruciferae Juss. - Тоонолжинцэцэгтэний овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> Овог: Тоонолжин цэцэгтэний овог (Cruciferae Juss.) Төрөл: Багдайн төрөл (Dontostemon Andrz.) Зүйл: <i>Dontostemon senilis</i> Maxim.-Өглүүн багдай Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал. Биологийн онцлог: 3-5 см өндөр ургадаг. Навч махлаг зузаан биш, шугаман юлдэрхүү, урт хатуу сэрэвгэр үсэрхэг, цэцэг цэцэг 4 гишүүнт, цайвар ягаан, гэрцэг 2-6 см урт, 2-3 см өргөн. Амьдралын хэлбэр: Олон наст ургамал Тархалт: Ховд., Монг. Алт., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Зүүнгар., Алт. өвөр., Алаш., Өмнөговь дах тархалт: Номгон уул, Зурамтай уул. Ургах орчин: Уулын чулуурхаг ба үйрмэг чулуут бэл, хажуу, сайрын оёор хөвөө, хайргат чулуут цөлд ургана. Ашигт чанар: Бог мал зун сайн, тэмээ дунд зэрэг иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулаархаг бор хөрсөнд.</p>

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) Овог: Тоонолжин цэцэгтэний овог (<i>Cruciferae</i> Juss.) Төрөл: Багдайн төрөл (<i>Dontostemon</i> Andrz.) Зүйл: <i>Dontostemon crassifolius</i> Vge.-Зузаан навчит багдай Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал. Биологийн онцлог: 5-10 см өндөр, бяцхан нүцгэн ургамал. Навч махлаг зузаан, цэцэг 4 гишүүнт, ягаан өнгөтэй, гэрцэг бортгорхуу, нумархуу нугархай, 1,5-2 мм үрт шонгонтой. Амьдралын хэлбэр: Олон наст ургамал. Монгол дах тархалт: Их н., Дор.говь., Говь – Алт., Алаш., Өмнөговь дах тархалт: Галбын говь. Ургах орчин: Элсэрхэг хээр, сайр садрага, үйрмэг чулуут ба чулуурхаг хажуу, хад чулуунд ургана. Ашигт чанар: Бог мал зун сайн, намар дунд зэрэг иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулаархаг цайвар бор хөрсөнд.</p>
Leguminosae Juss. - Буурцагтаны овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог Хунчирын төрөл (<i>Astragalus</i> L.) Зүйл: <i>Astragalus monophyllus</i> Vge.-Ганцнавчит хунчир Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал. Биологийн онцлог: 5 см хүртэл өндөр ургадаг, ишгүй, модлог голлосон үндэстэй, үндэс орчимдоо байрладаг ганц навчтай, хааяа анхны навч гурвалсан, өргөн зуувгар, ширүүн налархай үсэрхэг, цэцэг бойтгорхуу, цагаан, буурцаг гонзгойдуу зуувгар, ноосорхог сэгсгэр үсэрхэг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Монг.-Алт., Дорн. говь., Өмнөговь дах тархалт: Даланзадгад, Цогт-Овоо, Ханбогдын Номгон уул, Булан сухайт. Ургах орчин: Үйрмэг хайрга шавартай цөлийн хээр, элс хайргатай дэнж, говийн хөндийн хавтгай ёроолоор ургана. Ашигт чанар: Бог мал ногоон үед нь дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн цайвар бор хөрсөнд.</p>
Zygophyllaceae R. Br. -Хотирын овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Zygophyllaceae</i> R. Br. -Хотирын овог Үмхий өвсний төрөл (<i>Peganum</i> L.) Зүйл: <i>Peganum nigellastrum</i> Vge. -Харлаг үмхий өвс Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал. Биологийн онцлог: 10-20 см өндөр, цөөн салаархаг, навчис хошоод юмуу гурвантаа сарвуулаг цуулбар, хурж салбантай, цэцэг цагаан ганц нэг, цоморлиг 5-7 шугаман салбанцартай. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Дунд Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алаш., Өмнөговь дах тархалт: Галбын говь, Борзонгийн говь, Загсүүжийн говь, Чингисийн далан, Зүүнсайханы ар хөндий. Ургах орчин: Элсэрхэг цөл, цөлөрхөг хээрээр ургана. Ашигт чанар: Ногоон үед нь мал идэхгүй, өвөл адуу, тэмээ, бог мал тааруу иддэг. Газар дээрх биенийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор хөрсөнд.</p>

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Zygophyllaceae</i> R. Br. -Хотирын овог Хармагын төрөл (<i>Nitraria</i> L.) Зүйл:<i>Nitraria sphaerocarpa</i> Maxim.- Арзгар үрт хармаг Статус:Монголд байгаа завсарын унаган ургамал. Биологийн онцлог: 40 см хүртэл өндөр ургадаг, навтгар сөөг. Мөчир нь хөрс рүү тахийж нугарсан, хурц хатгуур өргөстэй, шугаман юлдэрхүү навчтай, яст бөөрөнхий хуурай жимстэй, жимс нь сарьсархуу түнтгэр үсэрхэг бүрхүүлтэй. Амьдралын хэлбэр: Олон наст навтгар сөөглөг ургамал. Монгол дах тархалт: Говь-Алт., Алт. -өвөр., Алаш., Өмнөговь дах тархалт:Галбын говь, Номгон сумын Борзонгийн говьд Ургах орчин: Элстэй хайргархаг чулуурхаг цөл, уул толгодын элжсэн бэл хормойд ургана. Ашигт чанар: Тэмээ хавар, зун, намар дундаас сайн иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Бор саарал хөрсөнд.</p>
--	--

Boraginaceae Juss. - Ноцоргонын овог




	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> Boraginaceae Juss. - Ноцоргонын овог <i>Бэрээмэгийн төрөл (Arnebia</i> Forsk.) Зүйл:<i>Arnebia fimbriata</i> Maxim. - Цацагт ба хөх бэрээмэг Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал Биологийн онцлог: 10-30 см өндөр, сууриасаа салаархаг, өтгөн үсэрхэг саарал ургамал. Дэлбэ цагаан, хөх ягаан, цайвар ягаан, хадаасархуу, нарийн хоолойтой,салбан нь захаараа богино цацаглаг, долгионтсон. Амьдралын хэлбэр: Хоёр наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Олон н., Дор.говь., Говь – Алт., Алаш., Алт. өвөр., Өмнөговь дах тархалт: Номгон сумын Дэрсэнэ ус, Ургах орчин: Үйрмэг чулуут, чулуурхаг бэл хормой, хад асга, элсэрхэг хайрган оёороор ургана. Ашигт чанар: Тэмээ зун дунд зэрэг, бог мал тааруу иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цөлийн бор саарал хөрсөнд.</p>
--	--

Labiaceae Lindl.- Уруул цэцэгтэний овог

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүүрээ (<i>Angiospermae</i>) <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> Уруул цэцэгтэний овог (<i>Labiaceae</i> Lindl.) Ангалзуурын төрөл (<i>Lagochilus</i> Bge.) Зүйл:<i>Lagochilus ilicifolius</i> Bge. –Ямаан ангалзуур Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал. Биологийн онцлог: Модожсон хатуу үндэстэй, хатуу дэрэвгэр навчтай, навчны үзүүр, цоморлигийн шүд сийрэгдүү шөвгөр өргөстэй, заримдаг сөөгөнцөр. Цэцэг 2 уруултай, дэлбэ цагаан юмуу шаргал. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт:Ханг., Монг.-Алт., Дунд. Халх, Их н., Олон н., Дорн. говь, Говь Алт., Алт. өвөр., Алаш. Өмнөговь дах тархалт: Галбын говь,Зүүн, дунд, баруун сайхан. Ургах орчин: Үйпэрхэг, хайргархаг цөлөрхөг хээр, хад чулуутай хажуу, хайргархаг дэнж, сайрын хөвөө, оёрт ургана. Ашигт чанар: Зун намар бог мал сайн, адуу бага зэрэг, хавар тэмээ, бог мал дунд зэрэг иддэг. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг айбд°дбөнд.</p>
--	---

Asteraceae Dumort. -Голгэсэрэтэний овог

	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> <i>Төрөл: Шарилж (Artemisia L.)</i> Зүйл: Artemisia xerophytica Krasch.-Хуурайсаг шарилж Цагаан шаваг Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал Биологийн онцлог: 30-40 см өндөр ургадаг, модожсон, олон салаалсан найлзууртай, навч гурвантаа юмуу хошоод гурвантаа цуулбар, сагс 4-5 мм өргөн, сийрэг пирамид залаанд нэгддэг, дэлбэ ба цэцгийн суудал өтгөн торгомсог үслэгтэй ногоон саарал ургамал. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр. Тархалт: Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алт. –өвөр., Алаш., Өмнөговь дах тархац: Галбын говь, Борзонгийн говьд. Ургах орчин: Элсэрхэг үйрмэг чулуутай цөлд ургана. Ашигт чанар: Бог мал, тэмээ зун сайн идэж тарга авдаг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор, бор саарал хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> <i>Төрөл: Шарилж (Artemisia L.)</i> Зүйл: Artemisia caespitosa Ldb.-Дэгнүүлт шарилж Цагаан шаваг Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал Биологийн онцлог: Үндэсний систем сул хөгжсөн, богинохон дэгнүүл үүсгэдэг, навч гурвантаа юмуу хошоод гурвантаа цуулбар, сагс өргөн хонхорхуу, тал бөмбөлөг, 2-3 мм өргөн, цацаг юмуу нарийн залаанд нэгддэг, дэлбэ ба цэцгийн суудал нүцгэн, найлзуур цагаан торгомсог үслэгтэй саарал ургамал. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр. Тархалт: Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дор. Монг., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Зүүнгар. Өмнөговь дах тархац: Галбын говь, Борзонгийн говьд. Ургах орчин: Цөлийн үйрмэг чулуутай хормой, уулын доод хажуу, говийн улаан элс, хужир мараанд ургана. Ашигт чанар: Аль ч улиралд хонь, ямаа, тэмээ сайн, үхэр, адуу дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> <i>Төрөл: Шарилж (Artemisia L.)</i> Зүйл: Artemisia sphaerocephala Krasch.-Бөндгөр шарилж Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал Биологийн онцлог: Иш саваархуу, голдуу бараг угаасаа салаалдаг, доод хэсэгтээ модожсон, иш ба мөчир шаравтар цайвар, үндэсний систем хүчирхэг, модожсон, нягт дэгнүүл үүсгэдэг, навч хошоод гурвантаа өдлөг цуулбар, нүцгэн, урт бариультай, сагс өргөн зууван, бөхөгөр шилбэтэй. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр. Тархалт: Их н., Дорн. говь., Говь – Алт., Алт. өвөр., Алаш., Өмнөговь дах</p>

	<p>тархац: Галбын говь, Гурвантэс. Ашигт чанар: Голдуу тэмээ жилийн дөрвөн улиралд дунд зэрэг иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг цайвар бор хөрсөнд.</p>
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>) Төрөл: Хависгана (<i>Scorzonera L.</i>) Зүйл: <i>Scorzonera divaricata Turcz.</i>-Дэрэвгэр хависгана Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал Биологийн онцлог: 50 см хүртэл өндөр ургадаг, доод хэсэгтээ модожсон, иш угаасаа салаалж мөчирлөсөн, түүний үндэсний хүзүүнд үндэс орчмын навчны угларгын үлдэгдэл дугтуй байдаггүй. Ишний навч утаслаг шугаман, ихэвчлэн дэгээрхүү нугархай үзүүртэй. Сагс хэлэрхүү шар цэцэгтэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Монг. Алт., Дорн.-Монг., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алт.-өвөр., Алаш., Өмнөговь дах тархац: Урд цөлийн сумдаар. Ургах орчин: Үйрмэг чулуутай ба элсэрхэг цөлийн хээр, уул толгодын үйрмэг чулуутай хажуу, хормой, сайрын оёорт ургана. Ашигт чанар: Хонь, ямаа ногоон үед нь дундаас сайн иднэ. Газар дээрх биенийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор саарал хөрсөнд.</p>
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>) Төрөл: Хависгана (<i>Scorzonera L.</i>) Зүйл: <i>Scorzonera capito Maxim.</i>-Данхар хависгана Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал Биологийн онцлог: 3-10 см хүртэл өндөр ургадаг, цөөн гонзгой навчтай, үндэс орчмын навч өргөн юлдэнээс зууван хэлбэртэй, бүхэл ургамал орооцолдсон ноосорхог үсэрхэг, сагс нэг, хааяа 2, шар хэлэрхүү цэцэгтэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Дунд. Халх., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алт.-өвөр., Алаш., Өмнөговь дах тархац: Ханбогд сумын Номгон уул, Ургах орчин: Уул толгодын хад, үйрмэг чулуутай ба чулуурхаг хажууд ургана. Ашигт чанар: Хонь, ямаа, янгир намар, өвөл сайн иднэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
ЭМИЙН УРГАМАЛ	
Ephedraceae Dum. - Зээргэнийн овог	
	<p>Нүцгэн үртэний хүрээ (<i>Gymnospermae</i>) Зээргэнийн овог (<i>Ephedraceae Dum.</i>) Зээргэнийн төрөл (<i>Ephedra L.</i>) Зүйл: <i>Ephedra glauca Rgl.</i>-Хөх ногоон зээргэнэ Статус: Элбэг Биологийн онцлог: Газар дор мөлхөө найлзууртай, 3-20 см намхан нэлэмгэр ургадаг, гөлгөр мөчиртэй, хоёр үртэй улаан жимсгэнэ жимстэй. Амьдралын хэлбэр: Дэлхээ сөөгөнцөр ургамал. Монгол дах тархалт: Дорн. говь, Алт. өвөр., Өмнөговь дах тархалт: Их Шанхын нуруунд. Ургах орчин: Хайргархаг хажуу бэлээр ургана. Ашигт чанар: Малын идэмж тодруулах шаардлагатай. Ногоон мөчир, найлзуур, үндэсийг бэтэг хавдарыг номхотгоно, цус тогтооно. Хөрсний бүтэц,</p>

бүрэлдэхүүн: Чулуураг бор хөрсөнд.	
Liliaceae Juss. - Сараанын овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i></p> <p>Liliaceae Juss. - Сараанын овог Хэрээ нүдэний төрөл (<i>Asparagus L.</i>)</p> <p>Зүйл:<i>Asparagus trichophyllus</i> Vge.-Үслэг навчит хэрээн нүд</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Иш урт авирдаг ороодог, кладоди буюу ногоон мөчрөнцөр шугамархуу, хатуу, өргөслөг, 5-10 мм урт, 5-10-аараа багц үүсгэнэ. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Их н., Дорн. говь., Алаш. Өмнөговь дах тархалт: Ханбогд, Манлай, Цогт-овоо суманд. Ургах орчин: Ам хавцал ёроол ганга, дэрсэн шугуйд ургана. Ашигт чанар: Бүх мал тааруу иднэ. Жимсийг огт идэхгүй. Үндэс, газрын дээх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт мэдрэлийн гаралтай арьсны үрэвсэл, үе мөч хавдахад хэрэглэнэ.Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор хөрсөнд.</p>
Iridaceae Juss. – Цахилдагны овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i></p> <p>Iridaceae Juss.-Цахилдагны овог Цахилдагны төрөл (<i>Iris L.</i>)</p> <p>Зүйл:<i>Iris tenuifolia</i> Pall.-Нарийн цахилдаг</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Иш, найлзуурын уг навчны угларгын хүрэн ширхэглэгээр хучигдмал, үндэс орчимдоо 30-40 см урт утсархуу навчтай, жижигдэгнүүлтэй, богино сум иштэй, цайвар хөх өнгийн 2 цэцэгтэй.Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Монг.-Алт., Дунд.Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь –Алт., Зүүнгар.Өмнөговь дах тархалт: Их Шанхын нуурын өвөр талаар, Тавантолгойн талаар.Ургах орчин: Элсэрхэг бай хайргархаг цөлөрхөг хэрээр ургана. Ашигт чанар: Хонь, ямаа хавар сайн иддэг, үхэр, тэмээ иддэггүй. Үндэс, цэцэг, үрийг эмэнд хэрэглэнэ.Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор хөрсөнд.</p>
Polygonaceae Juss. - Тарнын овог	
	<p><i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i></p> <p>Polygonaceae Juss. - Тарнын овог Гишүүний төрөл (<i>Rheum L.</i>)</p> <p>Зүйл:<i>Rheum nanum</i> Sievers.-Намхан гишүүнэ</p> <p>Статус: Элбэг</p> <p>Биологийн онцлог: Том бүдүүн үндэстэй, иш навчгүй, улаан хүрэн бамбай баг цэцэгтэй, үндэс орчмын навч дэвсээ, дугариг, богино бариултай, тод гүргэр судалтай, гурвалжин самранцар жимстэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Монг. –Алт., Их н., Олон н., Дор. Говь., Зүүнгар., Алт. Өвөр., Алаш., Өмнөговь дах тархац: Бүх сумдын нутагт ургана. Ургах орчин: Хотос хөндийн элс хайрган хөрстэй ёроол, дов толгодын хайргархаг чулуурхаг хажуу, бэл хормой, асга, байц цохионд ургана. Ашигт чанар: Үндэсийг мазаалай иддэг, үндсэндээ цардуул ихтэй тул орон нутагт гурил хийж хүнсэнд хэрэглэдэг. Үндэсийг монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Говийн бор хөрсөнд.</p>

Rosaceae Juss. -Сарнайн овог



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)
Rosaceae Juss. -Сарнайн овог
 Гичгэнийн төрөл (*Potentilla* L.)
Зүйл:*Potentilla bifurca* L.-Имт гичгэнэ

Статус: Элбэг

Биологийн онцлог: Үндэслэг иштэй, ёзоороосоо эхлэн салаалсан 5-25 см өндөр иштэй, навчис сондгой өдлөг нийлмэл, навчинцарууд үзүүртээ им адил оньтой ухагдсан байдаг, өтгөн налчгар үслэгтэй ургамал. Цэцэг тод шар. **Амьдралын хэлбэр:**Олон наст өвслөг ургамал. **Монгол дах тархалт:** Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг.-Алт., Дунд.Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дор. Говь., Говь –Алт., Зүүнгар.**Өмнөговь дах тархалт:** Тавантолгойн тал, Хонгорын элсний Сэрүүн булаг. **Ургах орчин:** Марцлаг нуга, үйрмэг чулуурхаг хажуу, голын эргээрд ургана. **Ашигт чанар:** Бог мал ногоон үед нь сайн, үхэр, адуу тааруу, тэмээ дунд зэрэг иддэг. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. **Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:** Хайргархаг бор хөрсөнд.



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)
Rosaceae Juss. -Сарнайн овог
 Гичгэнийн төрөл (*Potentilla* L.)
Зүйл:*Potentilla supina* L.-Намхан гичгэнэ

Статус: Элбэг

Биологийн онцлог:15-40 см уртнарийхан, дэвсээ, өндиймөл ёзоороосоо салаалдаг иштэй, ишний дунд, доод хэсгийн навчис урт бариултай, 2-5 хос өдлөг нийлмэл шүдлэг навчтай, дээд ба доод гадаргуу нь ногоон, цэцэг тод шар. **Амьдралын хэлбэр:**Олон наст өвслөг ургамал. **Монгол дах тархалт:**Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг.-Алт., Дунд.Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Зүүнгар.,Алт. өвөр. **Өмнөговь дах тархалт:** Цагаан хад. **Ургах орчин:** Хужир марз, булгийн зах, нуур, гол, горхийн марзлаг эрэг, тойрмын зах, чийгтэй элсэрхэг газар ургана. **Ашигт чанар:** Бог мал хавар, зун сайн, тэмээ дунд зэрэг иддэг. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. **Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:** Хужир мараалаг хөрсөнд.



Zygophyllaceae R. Br. -Хотирын овог



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)
Zygophyllaceae R. Br. -Хотирын овог
 Зангууны төрөл (*Tribulus* L.)
Зүйл:*Tribulus terrestris* L.- Зэлэн буюу нохойн зангуу



Статус:Элбэг ургамал

Биологийн онцлог: Салаархаг, дэвсмэл,50 см хүртэл урт ургадаг, навчис 6-8 хос өдлөг, дээд тал нүцгэн, доороо ишний адил урт үсэрхэг, навчны өвөрт 5 гишүүнт шар цэцэгтэй, 2-4 хурц хатуу өргөстэй жимстэй. **Амьдралын хэлбэр:** Олон наст навтгар сөөглөг ургамал. **Монгол дах тархалт:** Ханг., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар, Алт. -өвөр., Алаш., **Өмнөговь дах тархалт:** Зурамтай уул, **Ургах орчин:** Чулуурхаг болон үйрмэг чулуут, марзлаг бэл хормой, элс, сайрын элсэн оёор, булагын марзлаг эрэг, тойромд ургана. **Ашигт**

	<p>чанар: Ногоон үед нь мал дунд зэрэг иддэг. Өргөстэй зангуу нь малын хоолой, ялангуяа тэмээнд гэмтэл учруулдаг хөнөөлт ургамал. Үрийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Хужир мараалаг хөрсөнд.</p>
<i>Plumbaginaceae</i> Juss. - Хорголжингийн овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Plumbaginaceae</i> Juss. - Хорголжингийн овог Бэрмэгийн төрөл (<i>Limonium</i> Mill.) Зүйл: <i>Limonium tenellum</i> (Turcz.) Ktze.- Нарийн бэрмэг Статус: Элбэг Биологийн онцлог: 5-30 см өндөр ургадаг, эгц босоо, үл мэдэг тахиралдсан, нарийхан гоолиг иштэй, навч дэвсээ, шугаман хүрээрхүү, баг цэцэг сийрэг, цэцнш цэнхэр ягаан. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дах тархалт: Дунд. Халх., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алт. -өвөр., Алаш., Өмнөговь дах тархалт: Цогт-Овоо, Цогтцэций, Манлай, Номгон сумын Дуйнаг уулын сайр, Баян-Овоо сумын Дах уул. Ургах орчин: Цөлийн үйрмэг чулуут болон чулуурхаг хажуу, бэл хормой, хайрга чулуутай цөлөрхөг хээр, асга хаданд ургана. Ашигт чанар: Бог мал зундаа тааруухан иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>
<i>Convolvulaceae</i> Juss. - Сэдэргэнийн овог	
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) Овог: <i>Convolvulaceae</i> Juss. - Сэдэргэнийн овог Сэдэргэнийн төрөл (<i>Convolvulus</i> L.) Зүйл: <i>Convolvulus Ammannii</i> Desr. - Аийаиу сүяүдүйү Статус: Биологийн онцлог: Иш дэвсмэл юмуу өндиймөл, 2-10 см урт ургадаг, навчис шугамрхуу юлдэн хэлбэртэй, өтгөн налархай мөнгөлөг үсэрхэг, цэцэг цагаан, юмц цайвар ягаан, юлүүрэрхүү, мөчрийн үзүүрт ганц нэгээрээ байрладаг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал Тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дор. Монг., Их н., Олон н., Дор. говь., Говь – Алт., Алаш. Өмнөговь дах тархалт: Дэмчог, Хан-Уул. Ургах орчин: Үйрмэг чулуут болон чулуурхаг хажуу, цөлийн хээрээр ургана. Ашигт чанар: Бог мал зун сайн, намар дунд зэрэг иддэг. Газар дээрх биенийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг ба цайвар бор хөрсөнд.</p>
<i>Orobanchaceae</i> Vent. - Гувшаахайн овог	

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) Orobanchaceae Vent. -Гувшаахайн овог Гувшаахайн төрөл (<i>Orobanche</i> L.) Зүйл:<i>Orobanche coerulescens</i> Steph. - Хөхөвтөр гувшаахай Статус: Ховор ургамал Биологийн онцлог: 8-30 см өндөр, орооцолдсон ноосорхог үсжилттэй, 1.5 см хүртэл урт хайрсаар хучигдмал, түрүүрхүү гонзгой, ишнээсээ богино баг цэцэгтэй, дэлбэ урагш нугараа, хөх ягаан, угруугаа бүдэг, цоморлиг урт шүдлэгтэй, орооцолдсон ноосорхог үслэгтэй. Амьдралын хэлбэр: Шарилж шимэгч ургамал. Монгол дах тархалт: Алаш. аас бусад бүх тойрогт, Өмнөговь дах тархалт: Ханбогд, Зүүнсайханд, Баян-Овоо, Гурвантэс сумдын нутагт. Ургах орчин: Хээр тал, хээржүү хажуу газар шарилжин дээр шимэгчлэн ургана. Ашигт чанар: Газар дээх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Цайны ургамал. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Шарилжин дээр шимэгч.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) Orobanchaceae Vent. -Гувшаахайн овог Гувшаахайн төрөл (<i>Orobanche</i> L.) Зүйл:<i>Orobanche cumana</i> Wallr.- Наранцэцгийн гувшаахай Статус: Ховор ургамал Биологийн онцлог: 10-40 см өндөр, баг цэцэг нүцгэн, бүхэл ургамлын бие үл мэдэгдэх төдий үсжилттэй, булчирхайлаг, сийрэг түрүүрхүү гонзгой баг цэцэгтэй, дэлбэ хоолойрхуу, урагш их бөхөгөр, нугархай дээрээ хөхөвтөр юмуу цайвар хөх ягаан өнгөтэй. Амьдралын хэлбэр: Шарилж шимэгч ургамал. Монгол дах тархалт: Алаш. аас бусад бүх тойрогт, Өмнөговь дах тархалт: Ханбогд, Баяндалай сумдын нутагт. Монгол дах тархалт: Дунд. Халх., Дорн. - Монг., Олон н., Дорн. говь., Говь –Алт., Алт. -өвөр., Ургах орчин: Хээр тал, хээржүү хажуу газар шарилжин дээр шимэгчлэн ургана. Ашигт чанар: Идэмж тодорхойгүй. Газар дээх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Шарилжин дээр шимэгч.</p>
<p>Asteraceae Dumort. -Голгэсэртэний овог</p>	
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae</i> Dumort.) Тайжинсийн төрөл (<i>Echinops</i> L.) Зүйл:<i>Echinops Gmelinii</i> Turcz.-Гмелиний тайжинс Статус:Элбэг Биологийн онцлог: Иш эгц босоо, үзүүрээдээ салаархаг, навч өдлөг хагалбар, ирмэгээрээ 5 мм урт зүүрхүү өргөс шивүүртэй, иш юмуу салааны үзүүрт нэг юмуу хэ хэдн цэнхэрдуу бөөрөнхий баг цэцэгтэй. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Ханг., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь – Алт., Зүүнгар, Алт. өвөр., Алаш. Өмнөговь дах тархац: Ханбогд, Бүгтий, Ургах орчин: Элсэн хурдас, элсэн манхан, уул толгодын бэл хормой, сайр садрага дагасан элс, цөлийн хээрт ургана. Ашигт чанар: Адуу, тэмээ зундаа зөвхөн сагсыг иддэг. Үндэсийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>

	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> Зираан төрөл (<i>Lactuca L.</i>) Зүйл: <i>Lactuca tatarica (L.) C. A. Mey.-Татаар зираа</i> Статус:Элбэг Биологийн онцлог: Эгц босоо үндэслэг иштэй, ишний навч суурьтаа нарийссан, өдлөг хэрлээстэй, гурвалжин салбантай, сагс хөх ягаан хэлэрхүү цэцэгтэй, бамбайрхуу залаанд нэгддэг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Олон н., дорн. говь., Говь – Алт., Алаш. Өмнөговь дах тархац: Ханбогд сумын Бага мод, Номгон сумын Дуйнаг уулын сайр, Ургах орчин: хужир мараатай элс, сайраар ургана. Ашигт чанар: Төрөл бүрийн мал нз бүрийн байдалтай иддэг мэдээ байдаг. Газар дээрх биенийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Хужир мараатай хөрсөнд.</p>
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> Төрөл:Юнги (<i>Youngia Cass.</i>) Зүйл: <i>Youngia tenuicaulis (Babc.et Stebbins) Czer.-Нарийн ишт юнги</i> Статус:Элбэг Биологийн онцлог: Иш олон, нарийхан, сууриасаа саравгар салаалсан, навчны сегмент нарийн шугаман, сагс шар, ороолт навчинцар үзүүртээ эврэрхүү сэртэнтэй, нүцгэн. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Дунд. Халх., Их н., Олон н., Дорн. Монг., Говь – Алт., Зүүнгар., Алт. өвөр. Өмнөговь дах тархац:Сэврэй уул. Ургах орчин: Үйрмэг чулуутай чулуурхаг хажуу, хаданд ургана. Ашигт чанар: Идэмж тогтоох шаардлагатай. Газар дээрх биенийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн:Чулуурхаг цайвар хүрэн хөрсөнд.</p>
АЛАГ ӨВС	
	<p><i>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae)</i> <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Caryophyllaceae Juss. -Баширтаны овог</i> <i>Ажиганын төрөл (Stellaria L.)</i> Зүйл: <i>Stellaria gypsophiloides Fenzl.-Тайрлиг ажигана</i> Статус: Биологийн онцлог: Модожсон бүдүүн үндэстэй, иш угаасаа ацлан салаалж бөөрөнхий бут үүсгэдэг, навч эсрэг байрлалтай, шугаман юлдэрхүү, суумал, дэлбэ цагаан, хэлтэс нь дундаа хүртэл хагалбар, цоморлигийн навчинцар өндгөрхүү, мохоодуу, өргөн цагаан эмжээртэй, үсжилт наалдамхай биш.Амьдралын хэлбэр: Олон наст ургамал. Монгол дах тархалт: Монг. Алт., Дорн. Монг., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алт. –өвөр., Алаш. Өмнөговь дах тархалт: Цэций уул, Номгон, Хөрхийн нуруу. Ургах орчин: Чулуурхаг хайргархаг хажуу, нурагт ургана. Ашигт чанар:Идэмж тодорхойгүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Чулуурхаг бор хөрсөнд.</p>

	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i> <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i> <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i> <i>Төрөл: Ягаан толгой (Acroptilon Cass.)</i> Зүйл: <i>Acroptilon repens</i> (L.) DC.-Мөлхөө ягаан толгой Статус: Биологийн онцлог: Голдосон үндэстэй, иш ган нэгээрээ юмуу хэд хэдээрээ, уг орчмоосоо эхлэн хүчтэй салаалж мөчирлөсөн, 15-70 см өндөр, хавиргалаг, орооцолдсон цагаан үслэгтэй, навч өдлөг хагалбар, сийрэг шүдлэгтэйгээс бүтэн ирмэгтэй, үслэгтэй, суумал, сагс ишний оройд цацгархуу бамбай, залаархуу баг цэцэг үүсгэдэг, сагсны ороолт хэд хэдэн эгнээ, цэцэг ягаан, цомцог ширүүн. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Ховд., Их н., Дорн говь., Говь – Алт., Алаш. Өмнөговь дах тархац: Галын говь, Хуршуут, Ургах орчин: Гол нуурын элсэрхэг, шаварлаг эрэг, хужир мараатай нугаар ургана. Ашигт чанар: Мал идэхгүй. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Хужир мараалаг хөрсөнд.</p>
ГОВИЙН ОЙ БҮРЭЛДҮҮЛЭГЧ МОД	
	<p><i>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae)</i> <i>Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae)</i> <i>Chenopodiaceae Vent.</i> - Луулийн овог <i>Загын төрөл (Haloxylon Bge.)</i> Зүйл: <i>Haloxylon ammodendron</i> (C.A.Mey.) Bge.-Зайсангийн заг Статус: Заган ой үүсгэдэг. Биологийн онцлог: 4 м хүртэл өндөр ургадаг, мөчир нь ногоон үеүдтэй, навчис бүр мөсөн үгүйрсэн юмуу найлзуурын үеийн ирмэгээр богинохон төвгөр үлдвэртэй, цэцэглэх мөчир салаа нь зөвхөн урд жилийн найлзуур дээр үүсдэг, цэцгийн шадар эрхтэн 5 навчинцартай, жимслэх үед өргөн далавч ургуулдаг. Амьдралын хэлбэр: Тагдгар мод. Монгол дах тархалт: Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар., Алт.-өвөр., Алаш., Өмнөговь дах тархалт: Сумдын заган ойд. Ургах орчин: Нүүдэг элс, сондог, элсэрхэг хайргархаг хооллойд ургана. Ашигт чанар: Залуу найлзуурыг жилийн турш тэмээ сайн, унасан найлзуур, жимсийг хонь, ямаа намар орой, өвөлдөө сайн иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Элсэн хөрсөнд.</p>